хичээлийн агуулгад тусгагдсан гэж үзэж болохоор байна. Дээрх хичээлүүд нь суралцагч, өсвөр үе, залуучууд өөрсдийн эрх, эрх чөлөөгөө мэдэж, шийдвэр гаргах үйл явцад оролцох, байр сууриа илэрхийлэх чадвараа хөгжүүлэхэд туслах, оролцоо бүхий нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх, залуучуудын ёс суртахууны ухамсар, ёс суртахууны зан байдлыг хөгжүүлэхэд чиглэж байна.

Түүхэн уламжлалаар дотоод сэтгэлийн боловсролыг сүм хийд олгож ирсэн байдаг. Дээрх азийн орнуудын хувьд өдгөө улсын ерөнхий боловсролын сургуульд шашны боловсрол олгох (Бутанаас бусад нь олгодоггүй) нь төдийлөн нийтлэг бус байх ба ёс суртахуун, иргэний боловсролын хичээл болон бусад хичээлийн хүрээнд шашны талаарх ойлголтыг өгдөг бол хичээлээс гадуурх хөтөлбөрийн хүрээнд, эсхүл хувийн сургуулиуд нь шашны сургалт явуулах эрхтэй байна.

Европын орнуудын хувьд Азийн орнуудтай харьцуулахад ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс суртахуун, иргэний боловсролын хичээлүүдээс гадна шашин судлалын хичээл орох нь харьцангуй түгээмэл байна. Судалгаанд хамрагдсан Европын 31 улсаас 14-т нь ёс суртахуун, зан суртахуунд чиглэсэн бие даасан хичээлийн хүрээнд заадаг бол 17 улс нь бусад хичээлийн судлах сэдвийн хүрээнд олгодог байна.

ОХУ нь хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны асуудлыг зохицуулах тусдаа хуульгүй, харин хүүхэд, гэр бүлийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулах хууль, дүрэм журам болон хөтөлбөрийн хүрээнд зохицуулдаг. ОХУ-ын Засгийн газар 2015 онд “2025 он хүртэл ОХУ-ын хүмүүжлийн боловсролын хөгжилд баримтлах стратеги”-ийг (Стратегия развития воспитания в Российской Федерации на период до 2025 года) батлан гаргасан. Стратеги нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, 1998 оны “Оросын Холбооны Улсын хүүхдийн үндсэн эрхийн баталгааг хангах тухай” хууль (“Об основных гарантиях прав ребёнка в Российской Федерации”), 2012 оны “Оросын Холбооны Улсын боловсролын тухай” хууль (“Об образовании в Российской Федерации”) болон бусад холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах зорилготой. Стратеги нь хүүхдийн хүмүүжлийн талаарх төрийн нэн тэргүүний бодлого, хүмүүжлийн боловсролыг хөгжүүлэх үндсэн чиг хандлага, уг стратегийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг тодорхойлох, түүнчлэн орос иргэнийг илэрхийлэх хувь хүнийг төлөвшүүлэх, нийгэм дэх ёс суртахууны үндэс суурийг

зохих мэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэх нь зүйтэй хэмээн судлаачид үздэг байна.

Дэлхийн улс орнуудад “Иргэний боловсрол”-ын агуулгыг олон хичээлийн хүрээнд багтаан олгодог. Тухайлбал, нийгмийн ухаан, нийгэм судлал, дэлхий судлал, хүн ба нийгэм, амьдралын ухаан, албан ахижүй, хүний эрхийн боловсрол, ёс зүйн боловсрол, эрх зүйн боловсрол зэрэг олон хичээлийн хүрээнд улс орнууд өөрийн иргэддээс орчин үеийн нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, ёс суртахууны харилцааны үндсийг заан сургаж, тэдгээр харилцаанд үр ашигтай оролцох талаар зохих чадвар, хандлагыг төлөвшүүлж иржээ. Түүнээс гадна иргэний боловсрол нь түүх, газар зүй, эдийн засаг, улс төр судлал, байгаль орчин судлал, шашин судлал, төрөлх ба гадаад хэл зэрэг бусад хичээлүүдээс харилцаан холбогдох, иргэдийг нийгмийн харилцаанд бэлтгэхэд дэмжлэг үзүүлдэг байна.

Иргэний боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг, Судалгааны тайлан, ННФ. УБ., 2011. 68-70 дахь тал

бэхжүүлэх, хүүхдийг үр дүнтэй нийгэмшүүлэх, Оросын Холбооны Улс дахь олон үндэстний үнэт зүйл болон ёс заншил, соёлыг судалж таних, хүндэтгэлтэй хандахыг зорилго болгосон байна.

Казахстаны хувьд хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны боловсролын тухай тусдаа хууль байхгүй, харин хөтөлбөрийн хүрээнд зохицуулсан байна. 2010 оноос хүүхэд, залуучуудад хүмүүжил, төлөвшил, ардын өв уламжлал, ёс суртахууны боловсрол олгох “Өөрийгөө таних” хөтөлбөрийг боловсролын системд нэвтрүүлэн хэрэгжүүлж эхэлсэн байна. Үүнээс өмнө тус хөтөлбөрийг цэцэрлэг, сургууль, коллеж, их, дээд сургуулийг хамарсан нийт 184 байгууллагад 9 жилийн туршилтын шугамаар хэрэгжүүлж, сайжруулан боловсруулж хангалттай сайн үр дүн гарсныг үндэслэн улсын хэмжээнд боловсролын системд нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

АНУ-ын хувьд ерөнхий боловсролын сургуулиудад Character education буюу Зан суртахууны боловсролын хичээлийг заавал судлах хичээлийн тоонд оруулсан (18) болон хөхиүлэн дэмжихээр (18) хуульчилсан 36 муж улс байгаа бол 7 муж улс нь хуулиар тогтоогоогүй боловч бусад баримт бичгийн хүрээнд дэмжихээр тогтоосон, 8 муж улс нь дээрхтэй холбоотой ямарваа нэгэн хууль эрх зүйн зохицуулалтгүй байна.

Ёс суртахуун ба өрнө, дорнын соёлын чиг хандлага

Ёс суртахууны боловсрол дахь зан заншил, уламжлал нь ёс суртахуун хийгээд, ёс суртахууны боловсролд юуг нийтээр хүлээн зөвшөөрсөн гэж үзэх вэ? юуг тухайн соёлд хамааралтай хэм хэмжээ гэж үзэх вэ? зэрэг суурь асуудлуудыг хөндөх юм. Үүнийг олон талаас, олон янзын онолоор тайлбарласан байдаг. Тухайлбал, нийгэм-танин мэдэхүйн онол, түүнчлэн бүтцийн хөгжлийн онолыг дэмжигчид нь ёс суртахуун нь нийтлэг шинж чанартай бөгөөд гүн ухааны ёс суртахууны ойлголтоос үүдэлтэй гэж тайлбарладаг. Тус онолоор ёс суртахуун гэж байдаг бол түүнийг олон бүлэг хүмүүс, үндэстэн, угсаатнуудын дунд тархааж болох үнэт зүйлсээс бүрдэнэ гэж тайлбарладаг. Нөгөө талаас, угсаатан зүй судлаачид нийгэмшлийн онолыг дэвшүүлдэг ба энэ нь угсаатнууд үнэт зүйлсээ удам дамжин өвлүүлдэг, мөн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлсийг үндэстэн, угсаатнууд бүлэг хүмүүс тайлбарлах байдал нь ялгаатай байдаг гэж үздэг байна. Тухайлбал, зарим судлаачид⁵¹ “ёс зүйн релятивизм” (ёс суртахууны ойлголт нь янз бүрийн цаг хугацаа, нөхцөлд харьцангуй шинжтэй) буюу янз бүрийн угсаатнууд, ёс суртахууны цар хүрээ, хязгаарыг харилцан адилгүй байдлаар тогтоодог гэж үздэг байна. Дээрхийн эсрэг түүхэнд хүмүүс аливааг нэг үндэстэн, угсаатанд хамаарах байдлаас үл хамааран дотоод итгэл үнэмшлээрээ шударга ёсны төлөө тэмцэж байсныг жишээ болгон ёс суртахууны нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг ёс суртахууныг соёлын уламжлалд хамааралгүй гэж үзсэн байдаг. Мөн зарим судлаачид соёлын уламжлал нь ёс суртахуунд бүхэлд нь бус харин ёс суртахууны үнэт зүйлсийн эрэмбэ дараалалд хамаарна гэж үзэж байна. Энэ “ёс суртахууны ойлголт”

⁵¹Шведер, Махапатра, Миллер зэрэг

(үнэнч, шударга гм) нь нийтлэг ойлголт боловч ёс суртахууны үнэт зүйлсийг үндэстэн, угсаатан, соёлоос хүлээн авах, чухал гэж үзэх эрэмбэ дараа нь ялгаатай байдаг гэж үздэг байна. Ёс суртахууны соёлын ялгаатай байдал нь мэдээллийг ялгаатай байдлаар хүлээн авч тайлбарладаг, мөн дэлхийн ертөнцийг үзэх үзлийн ялгаатай байдлын үр дунд үүснэ. Хүмүүс өөрсдийн үйлдэл, үйл ажиллагаанаас гарах үр дүнгийн талаарх ялгаатай ойлголттой байгаа нөхцөлд ёс суртахууны нэг хэм хэмжээний хүрээнд авч үзсэн хэдий ч тэдгээр үйлдэл, үйл ажиллагааны зөв, шударга гэж үзэх нь ялгаатай байж болно.

Ийнхүү хүүхдийн ёс суртахууны хүмүүжилд соёлын уламжлалыг тооцох, оролцуулах ёстой юу? гэдэг асуулт гарч ирэх ба үүний тулд “уламжлал”, “угсаатан” зэрэг ойлголтыг авч үзэх шаардлагатай болно. “Уламжлал” гэдэг ойлголт нь нэлээд өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд нийгмийн олон асуудлыг багтааж байдаг. Ихэнхдээ уламжлалыг удаан хугацааны турш тухайн угсаатан, нийгмийн бүлэгт үе дамжин уламжлагдаж ирсэн тухайн нийгэм болон соёлын өвийн нэгэн элемент гэж үздэг. Угсаатан болон үндэстэнг уламжлалт болон динамик гэж хоёр ангилах нь элбэг. Уламжлалт үндэстэн, угсаатан дунд үе солигдох болгонд амьдралын цикл буюу мөчлөгт томоохон өөрчлөлт гардаггүй. Энэ төрөлд анхдагч соёл иргэншлүүд болох эртний Египет, Энэтхэг, Хятад зэрэг орно. Энэтхэг, Хятад хоёр нь сүүлийн хэдэн мянган жилийн турш өөрсдийн нийгэм-соёлын тогтолцоог хэвээр хадгалж ирсэн байдаг. Дээрх соёлуудад уламжлалт ёс заншилаа дагах гүн үзэл, хөдөө аж ахуйн хэмнэлд суурилсан хөгжлийн мөчлөгт шинж чанар, байгалийн, эсхүл нэгэнт тогтсон тогтолцоо, хэв маягаа хадгалах байдал, “абсолют” буюу гол төлөв шашнаас гаралтай үнэт зүйлсийг баримжаа болгосон зэрэг шинжүүд ажиглагдана.

Харин динамик улс, үндэстэн нь инновацийг тухайн үндэстэн угсаатны соёлын тэргүүлэх/давамгайлж буй ойлголттой зөрчилдөхгүй нөхцөлд одоо мөрдөж буй уламжлалын хөгжил гэж үздэг байна. Бусад соёлын үзэл санааг амархан, эрчимтэй нутагшуулж, шингээж, өөрийн болгодог, эсхүл өөрийн өв соёлтой зөрсөн, зөрчилдсөн тохиолдолд эсэргүүцэн түлхдэг байна. “Динамик” улс, үндэстэнд ихэвчлэн үе хоорондын зөрчил ихээр ажиглагддаг ба залуу үе нь өмнөх үеэсээ ялгаатай байна. Энэ хэлбэрт хүмүүсийн амьдралын хэв маяг, цаг тооцоолол нь мөчлөг бус шугаман хэлбэртэй байх ба байгалиас үүсэлтэй хэв журмыг шаардлага гарвал, эсхүл зарим тохиолдолд шаардлагагүйгээр өөрчлөн сольж байдаг.

Орчин үеийн барууны соёл нь нэлээд динамик шинжтэй соёл юм. Энэ нь одоо байгаагаас илүү төгс төгөлдөр ирээдүйт хүсэмжилж буй хүлээлттэй холбоотой байх ба үүнтэй холбоотойгоор нийгмийн тогтвортой бус байдал үүсдэг. Уламжлалт нийгэмд уламжлалаа дагах нь өөрөө тогтвортой байдлыг бий болгодог байна. Статист нийгэм уламжлалаасаа хөндийрөх, тасрах нь улс, үндэстэн бүхэлдээ стресс, бухимдалд автах зэрэг нэлээдгүй сөрөг үр дагаврыг бий болгодог гэж үздэг байна.

Зүүн Азийн (Япон, Хятад, Солонгос, Тайланд зэрэг) зарим улс орнуудад ёс суртахууны боловсролыг хүүхэд, залууст олгоходоо ёс суртахууны үнэт зүйлс, нийгэмд ач тус болох, эрдэм мэдлэг, гэр бүлийн харьцаа, соёлын уламжлал зэргийг чухалчлан онцолсон Күнзийн гүн ухаан, уламжлалд тулгуурлан олгодог. Солонгост ёс суртахууны боловсролыг бага ангиас эхлэн тусдаа хичээлээр заадаг ба энэ нь эхэндээ нэлээдгүй маргаан дагуулж байсан бол өдгөө солонгосын нийгмийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан гэж үзэх нь элбэг. Энэ төрлийн хичээл нь өөрийгөө нийгмийн нэг хэсэг болохыг ухаарах, “national identity” үндэсний амин чанар, эх оронч үзэл зэргийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулдаг байна. Японы сургуулиудад мөн ёс зүйн хичээл орох ба тус хичээлийн үндсэн б зорилгын нэг нь тухайн сургач Япон орны үнэт зүйлийг таньж ойлгох, улмаар өөрийн орны соёл, уламжлалыг хадгалах, үнэт зүйлээ өвлүүлэн авч явах иргэнийг төлөвшүүлэх юм. Гэр бүл болон сургууль хоёр хослон нийтлэг үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд оролцдог нь тухайн бус нутгийн ёс суртахууны боловсролын нэг онцлог болдог байна.

Дорнын боловсролын нэг гол ялгаа нь сургууль дахь ёс суртахууны боловсрол нь гэр бүлийн үргэлжлэл буюу ихэнх сургууль, хүүхдийн гэр бүл нийтлэг үндсэн дээр суурилсантай холбоотой. Иймд сургуульд ёс суртахууны боловсролыг холбогдох хөтөлбөрийн хүрээнд олгосон ч гэр бүлд мөн адил ёс суртахууны ойлголт, ухагдахуун байхгүй, гэр бүл, эцэг эхийн оролцоогүй бол төдийлөн үр дүнд хүрч чаддагтгүй гэж үзэх нь элбэг. Учир нь гэр бүл буюу хүүхдийн ахуй орчин хүний ёс суртахууны төлөвшлийн анхан шат гэж үздэгтэй холбоотой байна. Хэдийгээр өндөр ёс суртахуунтай нийгмийг цогцлоон бүрдүүлэхэд гэр бүл, гэр бүлийн үнэт зүйлс чухал ч, сургуульд мөн ёс суртахуун, ёс зүйн боловсрол олгох шаардлага өндөр ба сургуульд олгож буй ёс суртахууны боловсрол нь гэр бүлд олж авсан ёс зүй, ёс суртахууны үндэс, мэдлэгээ “нийгэмшүүлэх”, олж авсан боловсролоо эхний байдлаар сургуульдаа, дараагаар нийгэмдээ хэрэглэж хэвшинэ гэх утгыг агуулдаг. Ёс суртахууны үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд “хиймэл” аргаар хичээл дээр судлах, зааварчилгаа хэлбэрээр олгох нь төдийлөн үр дүн муутай ба ёс суртахууныг төлөвшүүлэхэд хүүхэд гэр бүлийн орчинд олж авсан ёс суртахууны ухагдахууныг гэр бүлээс гаднах орчинд дэлгэрүүлэх байгалийн буюу хиймэл бус шилжилт шаардлагатай гэж үздэг байна. Энэ нь ёс суртахууны боловсрол олгох тал дээр гэр бүл ба сургууль хоёрын хооронд зарчмын ялгаа байх ёсгүй ба дээрх хоёр нь нэг үндэс, үүнд улс орны өөрийн соёлын уламжлал, онцлог зэрэгт суурилсан байхыг чухалчлан үздэг байна.

СУДАЛГААНЫ САН

1. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭНД ЁС СУРТАХУУН, ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ ОЛГОДОГ ТУРШЛАГА

1.1. Европын зарим улс орнуудын ёс суртахууны боловсрол олгож буй туршлага

Улс орнуудын хувьд ёс суртахуун, зан суртахууны боловсрол нь тухайн нийгэм, соёлын онцлог, хэрэгцээ шаардлагаас хамааран юунд ач холбогдол өгч, юуг чухалчилж байгаагаар ялгаатай байх ба хичээлийн хөтөлбөрт хэрхэн тусгаж буй байдлын хувьд мөн харилцан адилгүй байна. Судалгаанд хамрагдсан Европын зарим орнуудын ёс суртахуун, зан байдлын боловсролыг сургуулийн хөтөлбөрт хэрхэн тусгасан (заавал судлах, эсхүл сонгон судлах, бие даасан хичээлийн хүрээнд, эсхүл өөр бусад хичээлийн сэдвийн хүрээнд зэрэг) болон шашин судлалын хичээл ордог эсэх зэргийг харьцуулан Хүснэгт 1-т харуулсан болно.

Ёс зүй, зан суртахууны боловсролын хөгжлийн чиг хандлага, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг бүс нутгийн хүрээнд авч үзвэл, дараах байдалтай байна:

- a) Скандинавын орнууд - зан суртахууны боловсролд нэгдмэл, нийтлэг хандлага давамгайлсан (Дани, Финланд, Норвег, Швед);
- b) Баруун Европ - бүс нутгийн хэмжээнд олон загвар, хандлага бүрэлдэн тогтсон (Франц, Герман, Швейцар, Их Британи, Бельги, Люксембург, Нидерланд зэрэг);
- c) Баруун-Өмнөд болон Өмнөд Европ - шашны боловсрол давамгайлах байр суурийг эзэлсэн (Кипр, Итали, Мальта, Португал, Испани);
- d) Төв Европ болон Балтийн орнууд (Австриас бусад) - (пост-социалист орнууд) шашингүй үзэлд суурилсан ёс суртахууны боловсролын загвартай (Чех, Эстони, Унгар, Латви, Литва, Польш, Словак, Словени);
- e) Европын хөгжих буй болон Европын Холбооны шинэ гишүүн орнууд – зан суртахууны боловсролыг харьцангуй сүүлд хэрэгжүүлж эхэлж буй орнууд (Болгар, Румын, Серби, ОХУ).

Судалгаанд хамрагдсан Европын 31 улсаас 14 улс ёс суртахуун, зан суртахуунд чиглэсэн сургалтыг бие даасан хичээлийн хүрээнд судалдаг байна. Ингэхдээ дээрх хичээл сонгон судлах хичээлийн тоонд багтах бол шашин судлалын хичээл мөн сонгон судлах хичээлийн тоонд багтах нь түгээмэл байна. Практикт энэ нь хүүхдээ шашны сургалтад хамруулах сонирхолгүй эцэг эхчүүд шашин судлалын хичээлийн оронд шашин болон аливаа идеологиос ангид ёс суртахуун, ёс зүй, зан суртахууны боловсролын хичээлийг сонгох боломжоор хангаж өгдөг байна. 17 улс нь ёс суртахуун, ёс зүй, зан суртахууны боловсролыг бие даасан хичээлийн хүрээнд бус харин бусад хичээлийн судлах сэдвийн хүрээнд олгодог байна. Ингэхдээ хүүхэд, сурагчдын ёс суртахууны боловсролыг бусад хичээлийн (нийгэм судлал зэрэг) хүрээнд олгодог, эсхүл сургалтын агуулга нь бүхэлдээ сурагчдын ёс суртахууныг хөгжүүлэхэд чиглэсэн байх ба сэтгэл судлал, эсхүл гүн ухаан зэрэг хичээл нэмэгдэн ордог гэх 2

хэлбэр түгээмэл тархсан байна. Судалгаанд хамрагдсан орнуудын гуравны нэг нь зан суртахууны боловсролыг орлох/дүйцэх нэг хичээлийн сэдвийн хүрээнд судалдаг байна. Үүнд: Франц, Грек, Унгар, Серби, Словени, Испани, Австри болон Швейцарын зарим мужууд орж байна. Өөр нэгэн хосолсон загвар нь ёс зүйг шашин судлалын хичээл, эсхүл гүн ухааны хичээлтэй хослуулан *non-confessional* шашны хичээл дээр судлах юм.

Хүснэгт 1. Еөрөл дахь ёс суртахуун/ёс зүй, зан суртахууны боловсрол

Улс	Ёс суртахуун/ёс зүй, зан суртахууны боловсрол			Шашны боловсрол	Зан суртахууны боловсролд хамаарал бүхий/ дүйцэхүйц соёл хоорондын бусад хичээлүүд
	Бие даасан хичээлийн хүрээнд судалдаг	Зан суртахууны боловсролд чиглэсэн сэдвийг бусад хичээлийн хүрээнд судалдаг	Ёс зүй, зан суртахууны хичээлийн статус: C -Заавал судлах CE заавал судлах/сонгон судлах O -optional	Conf -confessional NConf - non-confessional. ⁵²	
1. Австри	Ес зүй, <i>SoKebeWe</i> (education toward social competences and ethically reasoned value attitudes	Vena: CE - <i>KER</i> (Studies of Culture, Ethics and Religions), <i>AKG</i> (Anthropology and Cultural Studies)	CE	C/CE - Conf (possibility of withdrawal)	Түүх, нийгэм судлал ба иргэншил, заавал судлах сэтгэл судлал ба гүн ухааны хичээл (ISCED 3)
2. Бельги	Ёс зүй		CE	CE - Conf	Social behaviour, social skills
3. Болгар	Ёс зүй		C	O - Conf	Humans and society, Social studies and Citizenship
4. Кипр	-		-	C - Conf	Moral education
5. Чех	Зан суртахууны боловсрол		O	O - Conf	Humans and their environment, Personal and social education Drama education
6. Дани	-	C – Studies of Christianity (integration of religion, philosophy of life and ethics)		C - NConf (integrated with ethics and philosophy as Studies of Christianity)	Social studies, Personal and social development, education towards democracy
7. Эстони	-		-	O - NConf	Citizenship
8. Финланд	Ёс зүй		CE	CE - Conf	

⁵²Conf.-confessional-Шашны нэг гол урсгалд чиглэх ба сургалтын хөтөлбөр (хичээлийн агуулга, сургалтын материал) боловсруулахад шашны нийзмлэгүүд голзох үүргийг гүйцэтгэн.

Nconf.-non-confessional-аль нэг шашны урсгалд чиглэхгүй, шашны талаарх ойлголтыг ерөнхий хүрээнд олгох ба тэр (сургуулиуд) нь төвийг сахисан байр сууринаас, хүний шашин шүтэс, эс шүтэх эрх чөлөөг хүндэтгэж, сургалтыг явуулна.

9. Франц	-	C – Civics and Moral Education		- (with the exception of Alsace and Lorraine CE - Conf)	Autonomy and initiative, Citizenship, legislative and social education
10. Герман	Ёс зүй / philosophy Life formation – Ethics/ Religious Studies Philosophising with children, values and norms, Humanistic Character Education		CE O	C, CE - Conf O - Conf C - NConf	
11. Грек	-	C - Social Studies and Citizenship		C - Conf	Environmental studies, Social Studies and Citizenship
12. Унгар	-	C - Studies of Society, Studies of Humans and Ethics		O - Conf	Humans and society
13. Итали	-	-	-	O - Conf	Planned alternative Citizenship and Human Rights
14. Ирланд	-		-	C - Conf	Social, personal and health education
15. Латвия	Ёс зүй		O (substitution of R.E.)	O - Conf.	Studies of ethics and religion, History of religions
16. Литва	Ёс зүй		CE	CE - Conf	Development of moral awareness
17. Люксембург	Ёс суртхуун ба нийгмийн боловсрол		CE	CE - Conf	
18. Малти	-		-	C - Conf	Social studies, Personal and social education
19. Нидерланд	Humanistic Ethics and Worldview Education		O	O - Conf C - NConf (integrated in Social studies)	Social studies, Personal and social education, including citizenship Humans and society Humans and nature

20. Норвег		C - Religion, Philosophy and Ethics <i>Religion, livssyn og etik (RLE)</i>		C - NConf (included in RLE)	Social studies, Religionistics and Ethics
21. Польш	Ёс зүй		CE	CE - Conf	History and Citizenship education
22. Португал	-		-	O - Conf (Moral and Religious Education)	Personal and social education, Citizenship
23. Румын	-		-	O - Conf	Human life and society (citizenship)
24. ОХУ	Зан суртахууны боловсрол		O (alternative of R. E. since 2010)	O- Conf (comparing Islam, Christianity, Judaism, Buddhism,)	Natural, Social and Cultural Environment, Social Studies (specific topics: Humans and society, Spiritual life)
25. Серби	-	CE - Citizenship		CE - Conf	
26. Словак	Зан суртахууны боловсрол		CE	CE - Conf	Humans and values, Personal and social education, Multicultural and medial education
27. Словени	-	O - Ethics and Religion (ER), C - Citizenship and Ethics		O - NConf (integrated with Ethics in ER)	Citizenship, Social sciences
28. Испани	-	C - Ethical and Citizenship Education (in 4 th grade ISCED 2)	-	O - Conf	Citizenship and Human Rights Education Social studies
29. Швейцар	Ёс зүй (зарим кантонд Шашны хичээлийг орлоно)	C - Ethics and Religions (in cantons: Aargau, Luzern, Nidwalden, Obwalden, Thurgau, Uri, Zug)	CE (alternative of R.E.)	C - NConf (in cantons with Ethics and religion, or Religion and culture, in others CE - Conf)	Citizenship
30. Швед	-	C - Social Studies (including ethics and religion)	-	C - NConf (included in Social studies); also O - Conf	Social Studies (Ethics, Religion, Geography and History), Citizenship

31. ИБУИНВУ:	-	-		a), b) C - NConf c) Religious and moral education - CE predominantly Conf - Christian d) C - Conf	a), b) Personal, social and Health education, citizenship; c) Personal and Social Development, Citizenship; d) Personal development +mutual understanding, Personal and social education
a) Англи b) Уэльс c) Шотланд d) Умарт Ирланд					

Улс орон бүрийн ёс суртахуун /ёс зүй/ ба зан суртахууны боловсролын сургалт нь ёс суртахууны ухамсыг дээшлүүлэх, сурагчдад иргэн бүр мэдэж байвал зохих улс төрийн тогтолцоо, эдийн засаг, нийгмийн асуудлуудын тухай мэдлэг, ойлголтыг өгөх зорилготой байдаг. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Итали, Франц, Бельги, Финланд, Норвег, Эстони зэрэг Европын зарим улсын ерөнхий боловсролын сургуульд ёс суртахууны болон иргэний боловсролын хичээлийг хэрхэн явуулж буй талаар товч дурдвал дараах байдалтай байна.

ХБНГУ: Дунд болон их сургуулиудын Иргэний боловсролын хичээлийн үндсэн зарчмыг 1950 оны 6 дугаар сарын 15-нд Боловсролын Ландер сайд нарын хуралдаанаас тогтоосон байна. Тэр нь: “Иргэний боловсрол нь сурагчдын ёс суртахууны ба нийгмийн хариуцлагатай гишүүний үйл үйлдлийн ухамсыг төрүүлэх ёстой” гэжээ.

ИТАЛИ: Боловсролын яамнаас эрхлэн хэвлүүлсэн бага сургуулийн хичээлийн хөтөлбөрт иргэний боловсрол хичээлээр “хүүхдэд рөнхий ёс суртахуун, шашны болон нийгмийн сургалтыг олгоход” чиглэнэ гэжээ. Мөн “шашны хичээлээр хүүхдэд ёс суртахуун, иргэний болон нийгмийн зан үйлдлийн, бас гэр орон, сургууль ба нийгэмдээ эрүүл ахуйтай байх үндсэн зан чанарыг бүрэлдүүлнэ. Мөн хүүхдэд хувийн хариуцлага ба бүлгийн гишүүн гэх ухамсыг төрүүлнэ” гэсэн байна. Харин бусад дээд ангийн сурагчдын иргэний боловсролын хичээлийн тухайд, “Эх орноо хайрлах сэтгэл нь гэр бүлээ хайрлах төрөлх сэтгэлээс үүдэн хөгжсөн байх, үндэстний үнэт зүйлсийн тухай ухамсар нь олон улсын өв тэгш ойлголттой уялдсан байх ёстой” гэжээ.

ФРАНЦ: Тус улсын Боловсролын яамнаас 1923 онд хэвлүүлсэн суурь боловсролын хичээлийн хуваарыт “ёс суртахууны боловсрол нь хүүхдийг сэтгэл хөдлөл, оюун ухаан ба итгэл үнэмшлийн тэнцвэртэй хөгжил бүхий хүн болж, өсөж хүмүүжихэд туслах ёстойг”, мөн “ёс суртахууны сургаал зааварчилгаа нь хүүхдэд зөвхөн нэг ёс суртахууны сэтгэлгээг төрүүлээд зогсохгүй бас энэхүү оюун санааг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэхэд хөтлөн жолоодох ёстой” хэмээн өгүүлсэн байна.

Францын бага сургуулиудад “civique et morale” хэмээх боловсролын хичээлийг дараах байдаар заадаг байна. Үүнд:

1 дүгээр ангц - Ихэвчлэн багш нарынхаа ярих үлгэрүүд (Жан Лафонтен болон Ганс Христиан Андерсоны үлгэрүүд) ба агуу хүмүүсийн намтрыг сонсох.

2-3 дугаар ангид - Ярилцлага болон ном зохиол унших арга хэлбэрээр сайн зан үйлд суралцахад нь хүүхдүүдийг дасал болгох. Гуравдугаар ангид хоёрдугаар ангид үздэгтэй ижил сэдвүүдийг илүү гүнзгийрүүлэн судална.

4-5 дугаар ангид - Хувь хүмүүсийн үйл хэрэг болон нийгмийн ёс суртахууны талаар тэвчээр, хүндэтгэл, эелдэг зан, эр зориг, өгөөмөр зан зэрэгтэй уялдуулсан өгүүллэг зохиол сонсох, эсхүл ярилцах.

Мөн хүүхдэд хөдөлмөрийн үнэ цэнийн тухай ойлголт, бусадтай хамтран ажиллах сайхан сэтгэл, амлалтаа биелүүлэх чанар, бусдыг ойлгох, гэр бүл болон улс нийгэмдээ хүлээх үүргээ ухамсарлах зэргийг сургах.

5 дугаар ангид - 4 дүгээр ангийнхтай адил сэдвээр боловч илүү гүнзгий судална.

6-8 дугаар ангид - Хүүхдийн ухамсарт хүнийг хүндэтгэх сэтгэл төрүүлэх, зөв зан чанарыг бүрэлдүүлэх, хувийн болон гэр бүл, улс нийгэмдээ хүлээх үүрэг хариуцлагыг ойлгуулах, эх оронч, үнэнч шударга, харилцан туслалцах, хөдөлмөрийг хүндэтгэх, Засгийн газрын бүтэц, үйл ажиллагаа, гэрээ ба өдөр тутмын амьдрал дахь хөдөлмөрийн хуулийн тухай үндсэн мэдлэг, эрх зүй, захиргааны болон шүүхийн тогтолцоо, иргэний эрх ба үүрэг, олон улсын ойлголт зэргийн тухай суурь анхдагч мэдлэгийг олгоно.

БЕЛЬГИ: Бельгийн дунд сургуульд (дунд боловсролын 3-4 дүгээр ангиудад, 14-15 насанд) “иргэншил ба эх оронч үзэл”-ийг дараах сэдвүүдийн хүрээнд заадаг байна. Үүнд:

- Иргэний эрх: ардчилсан болон парламентын тогтолцооны давуу тал. Бельгийн Үндсэн хуулиар баталгаажуулсан үндсэн эрх, эрх чөлөөний тухай;
- Иргэний үүрэг: сонгуульд оролцох, хуулийг сахин биелүүлэх, цэргийн алба хаах, татвар төлөх, шүүхэд гэрчийн мэдүүлэг өгөх;
- Эх оронч үзэл: эх орны нэр хүнд ба өв уламжлал, буруу эх оронч үзлийн аюул;
- Олон улсын тухай ойлголт: хүн төрөлхтний ахан дүүсийн ёсон, Европын улс орнуудын Иргэний боловсрол олгох арга хэлбэр зэрэг болно.

Нэлээдгүй улс оронд эдгээр хичээлд зориулсан тус тусын сурах бичгүүдийг хэрэглэхээс гадна аудио бичлэг, спайд, кино, радиогийн нэвтрүүлэг, телевиз гэх зэрэг туслах хэрэгсэл, сургалтын материалуудыг ашигладаг байна.⁵³

⁵³Moral education other countries- http://www.mext.go.jp/b_menu/hakusho/html/hpae196501/hpae196501_2_032.html

ФИНЛАНД: Ерөнхий боловсролын асуудал эрхэлсэн Боловсролын үндэсний зөвлөлөөс үндэсний хэмжээнд мөрдөх үндсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулдаг ба энэхүү хөтөлбөрт хичээлийн сэдвүүдийн ерөнхий агуулга болон зорилтуудыг тусгасан байдаг. Үндсэн сургалтын хөтөлбөрийн дагуу муж бүр сургалтын хөтөлбөрөө боловсруулна, мужийн сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сургууль бүр сургалтын хөтөлбөрөө боловсруулж мөрддөг.

Суурь боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлд Боловсролын агуулгыг дараах байдлаар томьёолсон байна.⁵⁴

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр нь 14-р зүйлд заасны дагуу батлагдсан байх ба, үүнд дараах гол хичээлүүд багтана: эх хэл, уран зохиол, хоёр дахь (фин/швед) эх хэл, гадаад хэл, хүрээлэн буй орчны судалгаа, эрүүл мэндийн боловсрол, шашны боловсрол болон ёс зүй, түүх, нийгмийн ухаан, математик, физик, хими, биологи, газар зүй, биеийн тамир, хөгжим, дүрслэх урлаг, гар урлал мөн өрхийн эдийн засаг зэрэг хичээлүүд.

Дээрх хуулийн зохицуулалтын дагуу Засгийн газраас нийтлэг сэдвийн хүрээнд тухайн жилийн 7 хоногт үзэх хичээл, цагийн хуваарийг баталдаг. Энэ хуваарь нь жишиг хуваарь бөгөөд Үндэсний сургалтын хөтөлбөрт нийцүүлэн муж болон сургуулиуд хичээл, цагийн хуваарияа өөрсдөө батлах эрхтэй байдаг.

Хүснэгт 2. Бага, дунд ангиid судлах хичээлийн цаg⁵⁵ (7 хоногт үзэх хичээлийн цаg)

ХИЧЭЭЛИЙН НЭР	АНГИ									Нийт цаг
	1	2	3	4	5	6	7	8	9	
Эх хэл, уран зохиол	14		18			10				42
Гадаад хэл			9			7				16
2 дахь албан ёсны хэл					2		4			6
Математик	6		15			11				32
Байгаль орчин	4		10							
Биологи, газар зүй							7			
Физик, хими							7			
Эрүүл мэнд							3			
Байгаль орчин, байгалийн судалгаа		14			17					31
Шашин, ёс зүй	2		5			3				10
Түүх, нийгэм			5			7				12
Хөгжим	2		4			2				8
Дүрслэх урлаг	2		5			2				9
Гар урлал	4		5			2				11
Биеийн тамир	4		9			7				20
Өрхийн эдийн засаг							3			3
Урлаг болон сонгон судлах хичээл сонгоход			6			5				11

⁵⁴Финландинд Суурь боловсролын тухай хууль <https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1998/en19980628.pdf>

⁵⁵Засгийн газрын тогтоол, 2012.06.28 http://www.oph.fi/download/179422_distribution_of_lesson_hours_in_basic_education_2012.pdf

Урлаг болон сонгон судалсан хичээлд нийтдээ			62
Зөвлөгөө өгөх		2	2
Нэмэлт сэдэв	9		9
Нэмэлтээр гадаад хэл		12	12
Нэмэлтээр 2 дахь эх хэл		4	4
Нийт хамгийн багадаа судалбал зохих цаг			222

НОРВЕГ: нь ерөнхий стандартад суурилсан сургуулийн нэг тогтолцоотой. Засгийн газрын тогтоосон сургалтын стандартыг хянахын тулд улсын сургалтын хөтөлбөрийг боловсруулан, мөрддөг байна. Заавал эзэмших боловсролын хөтөлбөрийн дагуу арван жилийн боловсрол эзэмших бөгөөд үүнд бага, бүрэн бус дунд, бүрэн дунд сургуулиуд багтана. Боловсролын байгууллагуудын үүрэг нь бүхий л хот, бус нутагт хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд тохирох боловсролоор хангах явдал байна. Орон нутгийн засаг захиргаа нь бага болон дунд сургуулиудын үйл ажиллагааг хариуцдаг бол бүрэн дунд сургуулийн удирдлага, зохион байгуулалтыг бус нутгийн түвшинд хариуцна. Норвегид ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгох ба үүнд бүрэн дунд боловсрол орно. Бие даасан хувийн сургуулиуд нь нэмэлт боловсрол олгодог.

Суурь боловсрол буюу 1-ээс 10-р анги нь үнэ төлбөргүй байна. Жилд 38 долоо хоног хичээллэдэг. Бага сургуульд долоо хоногт 20 цагийн хичээл судална. Математик - 4 цаг, норвег хэл - 6 цаг, байгалийн судлал - 1 цаг, англи хэл -1 цаг, зураг, хөдөлмөр, биений тамир, дуу хөгжим тус бүр - 1-2 цаг, шашин судлал- 2 цаг. Шашны хичээл нь Норвегийн сургуулиуд нь 250 жилийн өмнөөс сүм хийдийг даган байгууллагдаж байсантай холбоотой ба өдгөө библи судлах/ шашин судлах нь түүх судлахтай адил гэж тооцдог байна.

Норвегийн улсын ерөнхий боловсролын сургуулиуд дахь шашны боловсрол нь нэлээдгүй маргаан дагуулдаг. Тус улс нь Швед, Их Британийн адиллаар бүх сурагчдад, тэдгээрийн шашин шүтлэгээс үл хамааран шашны судлалын хичээл ордог. Христийн шашин, шашин судлал ба ёс зүйн хичээл (KRLE) 1997 онд батлагдсанаасаа хойш нэлээдгүй шүүмжлэл дагуулж, улмаар хичээлийн агуулгад хэд хэдэн удаа өөрчлөлт оруулсан. 2006 онд Европын Хүний эрхийн шүүхээс KRLE нь христийн шашинд давуу байдал олгосон гэх шүүхийн шийдвэр гаргасан байна.⁵⁶

⁵⁶<http://religiongoingpublic.com/archive/2016/religious-education-in-norway-distance-and-unease>

Хүснэгт 3. Шашин судлал хичээлийн агуулга (1997 он)

Судлах зүйл	Анхан шат 1-4 түвшин	Анхан шат 5-7 түвшин	Дунд шат 8-10 түвшин
Библи судлах	Библийн үндсэн өгүүллэгүүд	Библийн өгүүллэгүүд	Библийн төрлүүд, Библи – ариун судар, библийн түүх
Христийн шашны түүх	Христийн шашны түүхээс	Христийн шашны үүссэн түүх: хөгжил, хүмүүс, соёлын илэрхийлэл	Христийн шашны орчин үеийн түүх: хөгжил, хүмүүс, соёлын илэрхийлэл
Христийн шашин орчин үед	Христийн шашинтны баярууд, шашны бэлгэдлүүд, өдөр тутмын амьдрал дахь шашин	Христийн итгэл үнэмшил ба ёс зүй	Христийн шашны ургалууд, ижил болон ялгаатай талууд
Бусад шашин	Бусад шашнууд ба амьдралыг үзэх үзэл, түүх болон баяр наадмууд	Ислам, Жүүд, Хиндү, Буддын шашин, тэдгээрийн амьдралыг үзэх үзэл	Орчин үе ба шашин/орчин цагийн шашин шүтлэг
Ёс зүй/философи	Ёс зүйн талаарх ойлголт: миний ба чинийх, би ба бусад	Ёс зүйн талаарх ойлголт: үнэт зүйлс ба сонголтууд	Хүн төрөлхтөний философиийн тайлбар, үнэт зүйл ба хэм хэмжээ

1.2. Ази, номхон далайн зарим улс орнуудын ёс суртахууны боловсрол олгож буй туршлага

ЯПОН: Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, амьдрах орчин, хөгжим, зураг, гар урлал, биеийн тамир, гэрийн аж ахуй гэсэн хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр ёс суртахууны хичээл ордог.

Дунд ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, хөгжим, зураг, биеийн тамир, үйлдвэрлэлийн урлаг, гэрийн аж ахуй, гадаад хэл, сонгон судлах хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр ёс суртахууны хичээл орно.⁵⁷

1890 онд Эзэн хаан Боловсролын тухай зарлиг гаргасан ба энэхүү зарлигаар зайлшгүй эзэмших шинэ боловсролын тогтолцооны өөрчлөлтөд Японы үнэт зүйлийг гол болгон баримтална гэж тунхагласан байна. Энэ нь үнэнч зүтгэл, ахмадын хүндлэл, гэр бүлийн гишүүд, хань ижил, анд нөхөдтэй тогтоосон харилцаа зэрэг ёс суртахууны чанаруудыг чухалчлахыг сануулсан зарлиг байсан юм.

Японы суурь боловсролын тухай хуулиар ёс суртахуун, ёс зүйн боловсролыг заавал эзэмшүүлэх албан боловсрол гэж заасан ба энэ нь Японы үндэсний өв, соёлтой салшгүй холбоотой юм.

⁵⁷<https://www.nuffic.nl/en/publications/find-a-publication/education-system-japan.pdf>

Ёс зүйн боловсрол нь тухайн сургач Япон орны үнэт зүйлийг таньж ойлгох, улмаар өөрийн орны соёл, уламжлалыг хадгалах, үнэт зүйлээ өвлүүлэн авч явах иргэнийг төлөвшүүлэх зорилготой юм. Иймд ерөнхий боловсролын сургуульд ёс зүй, ёс суртахууны боловсрол олгоход маш их анхаардаг байна.

Ерөнхий боловсролын сургуульд ёс суртахууны хичээлийг дараах 4 төрлийн агуулгад тулгуурлан заадаг.⁵⁸

1. Өөрийнхөө тухай: Хүн бүр бие даасан байх, өөрсдийн хийж чадах зүйлээ хийх, хэм хэмжээтэй амьдрах;
2. Бусад хүмүүстэй харилцах харилцаа: Хүмүүстэй шударга харилцах, хүмүүстэй эелдэг харилцах;
3. Байгаль, эрхэм дээд зүйлтэй харилцах: Байгалийн гамшиг, байгаль, амьтны ач холбогдлыг мэдрэх;
4. Нийгэм болон бүлгүүдийн тухай: Олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, дүрэм журмаа дагах, амлалтаа биелүүлэх.

Хүснэгт 4. Бага болон дунд ангид судлах хичээлийн цаг⁵⁹

ХИЧЭЭЛИЙН ТӨРӨЛ	АНГИ								
	1	2	3	4	5	6	7	8	9
Япон хэл	272	280	235	235	180	175	140	140	105
Нийгэм судлал	-	-	70	85	90	100	105	105	140
Тоо бодлого	114	155	150	150	150	150	-	-	-
Математик	-	-	-	-	-	-	140	105	140
Шинжлэх ухаан	-	-	70	90	95	95	105	140	140
Амьдрах орчин	102	105	-	-	-	-	-	-	-
Хөгжим	68	70	60	60	50	50	45	35	35
Зураг, гар урлал	68	70	60	60	50	50	-	-	-
Өрхийн эдийн засаг	-	-	-	-	60	55	-	-	-
Биеийн тамир	90	90	90	90	90	90	-	-	-
Уран зураг	-	-	-	-	-	-	45	35	35
Эрүүл мэнд, биеийн тамир	-	-	-	-	-	-	105	105	105
Үйлдвэрлэлийн урлаг, гэрийн урлаг	-	-	-	-	-	-	70	70	35
Гадаад хэл	-	-	-	-	-	-	140	140	140
Ёс суртахуун	34	35	35	35	35	35	35	35	35
Дүгнэлт хичээл	-	-	105	105	110	110	50	70	70
Сонгон судлах хичээл	34	35	35	35	35	35	35	35	35
НИЙТ /ЖИЛД/	782	840	910	945	945	945	1015	1015	1015

ШИНЭ ЗЕЛАНД: Тус улс нь боловсролын салбартай ихээхэн анхаарал хандуулан ач холбогдол өгдөг ба нэг сургачид ногдох зардлын хэмжээгээр ЭЗХАХБЫН дунджаас доогуур байгаа ч боловсролын салбарт зарцуулж буй төсвийн зарцуулалтын (13,2%) хэмжээгээр дэлхийд дээгүүр байр эзэлдэг.⁶⁰

⁵⁸Moral education in Japan <https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303MED.pdf>

⁵⁹Moral education in Japan <https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303MED.pdf>

⁶⁰<https://data.oecd.org/eduresource/public-spending-on-education.htm>

Шинэ Зеланд нь 6-16 насны бүх хүүхдэд заавал эзэмших суурь боловсрол олгох ч ихэнх хүүхдүүд 5 наснаас сургуульд хамрагддаг байна. 5-19 насанд олгох боловсролыг үнэ төлбөргүй олгоно. Сургуулиуд нь улсын, шашны болон хувийн гэсэн 3 төрөлтэй. Улсын сургуулиуд нь үнэ төлбөргүй байх ба хүүхдүүд харьяаллын дагуу хамгийн ойр байрлах сургуульд хамрагдана. Энэ төрлийн сургууль нь үнэ төлбөргүй байх боловч сургуулийн хэрэглэл зэргийг сургачийн эцэг, эх хариуцна. Шашны сургалттай улсын сургууль (гол төлөв Католик сургууль) нь үнэ төлбөргүй байх, дээрхтэй адил зарим зардлыг сургачийн эцэг, эх хариуцна. Хувийн сургуулиуд нь шашны боловсрол, гүнзгийрүүлсэн сургалт зэргийг олгож болно.

Бага боловсролыг 5-аас дээш насны хүүхдэд олгож болох ч заавал эзэмших боловсролыг 6-16 насанд олгоно. Сургалтын үндэсний хөтөлбөр 1-10-р ангийг багтаах ба 1-8 анги нь бага боловсрол, 9-10 анги нь бага дунд боловсрол 11-13-р анги нь бүрэн дунд боловсрол олгоно. 11-13-р анги нь заавал эзэмших боловсролд хамаарахгүй боловч дээд боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардлагатай. Гадаад хэлийг 1-р ангиас эхлэн заана. (Common European Framework for Languages, Global Scale Level A1: Basic User; Council of Europe, 2001)

Сургалтын үндэсний хөтөлбөрийн хүрээнд дараах хичээлийг судална:

- англи хэл; урлаг; эрүүл мэнд ба биеийн тамир; гадаад хэл; математик; шинжлэх ухаан; нийгмийн ухаан; технологи.

БНСУ: Бага сургуулийн сургалтын хөтөлбөрт үндсэн хичээлүүд болох ёс зүй/ ёс суртхуун⁶¹, эх хэл, гадаад хэл, математик, шинжлэх ухаан, нийгмийн ухаан, биеийн тамир, дуу хөгжим болон урлагийн хичээлүүд ордог байна. Жилд 34 гаруй долоо хоногийн хичээл орох бөгөөд, бага ангийн 1-2 дугаар ангид 850 цаг, 3-4 дүгээр ангид 986 цаг, 5-6 дугаар ангид 1088 цагийн хичээл тус тус үздэг байна.

Сургалтын хөтөлбөрийг боловсролын нийгэмд гарч буй өөрчлөлтүүдтэй уялдан гарсан хэрэгцээ, шаардлага, шинээр гарч ирж буй мэдлэгийн салбар зэрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулах бөгөөд БНСУ-ын хувьд сургалтын хөтөлбөрөө нийт 7 удаа шинэчилсэн байна. 7 дугаар буюу хамгийн сүүлийн шинэчлэлийг 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталсан бөгөөд бага, дунд сургуульд 2000 оноос нэвтрүүлж эхэлсэн байна. Тус хөтөлбөрийг даяаршил болон мэдээлэлд суурилсан нийгмийн шаардлагад нийцүүлэхийг зорьсон ба уламжлалт сургалтын арга барил буюу мэдлэг, мэдээллийг “халбагадаж” олгодгоос бие даан суралцах, сургач тус бүрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон хэлбэрийг нэвтрүүлэх, өргөжүүлэх, хичээлийн ачааллыг бууруулах тал дээр анхаарсан байна.

⁶¹ethics/moral education

Шинэ хөтөлбөрийн хүрээнд бага сургуулийн 1 дүгээр ангиас ахлах сургуулийн 1 дүгээр анги (1-10-р анги)-н үндсэн хөтөлбөрөөр хичээллэх бол ахлах сургуулийн 2-3 дугаар анги (11-12-р анги)-д сургачид өөрсдийн ирээдүйн зорилго, зорилтод нийцүүлэн сурах хичээлүүдээ сонгон суралцах юм.

Хүснэгт 5. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилд үзэх хичээлийн цаг

Хичээл	Бага сургууль						Дунд сургууль			Ахлах сургууль		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Сургалтын хөтөлбөр	Эх хэл Урлаг	Эх хэл Урлаг	238	204	204	204	170	136	136	136	Сонгон судлах хичээл	
	Ёс зүй	210	238	34	34	34	34	68	68	34	34	
	Нийгмийн ухаан	Математик 120	Математик 136	102	102	102	102	102	102	136	170 (Түүх 68)	
	Математик	Ёс зүй 60	Ёс зүй 68	136	136	136	136	136	136	102	136	
	Шинжлэх ухаан	Ухаалаг амьдрал 90	Ухаалаг амьдрал 102	102	120	102	102	102	136	136	102	
	Практик сургалт	Хөгжилтэй амьдрал 180	Хөгжилтэй амьдрал 204	-	-	68	68	Техникийн боловсрол/Хөдөлмөр-гэр ахуй				
	Биеийн тамир			102	102	102	102	102	102	68	68	
	Дуу хөгжим			68	68	68	68	68	34	34	34	
	Урлаг			68	68	68	68	34	34	68	34	
	Гадаад хэл (Англи)	Бид 1-р анги 80		34	34	68	68	102	102	136	136	
Бие даан суралцах	60	68	68	68	68	68	136	136	136	204		
Тусгай арга хэмжээ	30	34	34	68	68	68	68	68	68	68	8 нэгж	
Жилд үзэх хичээл (Цаг)	830	850	986	986	1,088	1,088	1,156	1,156	1,156	1,156	144 нэгж	

Ёс зүй/ёс суртахууны ухагдахуун нь 1950-иад онд анх сургалтын хөтөлбөрт туссан бөгөөд цаг үе, нийгмийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагатай уялдан хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна.


БНСҮ-ын анхны бие даан баталсан Сургуулийн хөтөлбөрт (1955-1963) ёс зүйн боловсрол нь нийгмийн ухааны хичээлийн агуулгад багтаж байсан. Ёс зүйн хичээлийг Боловсролын яамнаас батлагдсан журмын дагуу зааж эхэлсэн бөгөөд ёс зүйн боловсрол нь иргэний боловсролд чиглэж байсан (АНУ-ын “ардчилсан иргэний боловсрол” дээр суурилсан).

- 1973 онд ёс суртахууны хичээл нь сургалтын хөтөлбөрт бие даасан хичээл болж орсон бөгөөд улмаар 1974 онд ахлах сургуульд ёс суртахууны хичээлээр үндэсний ёс зүйг⁶² судалж эхэлсэн. Тухайн үед ёс зүйн хичээл социализмын нөлөөг эсэргүүцэх, эдийн засгийг сэргээх, үндэсний уламжлалыг сэргээхэд чиглэгдэж байсан.

⁶²national ethics

- 1973-1982 онд ёс зүйн хичээл бага, дунд сургууль болон дээд сургуульд гэсэн турван үндсэн чиглэлээр орох болсон.
- 1982-1988 онд уг хичээл заах арга бүрэн шинэчлэгдсэн бөгөөд хэлэлцүүлэг хэлбэрээр хичээл заагдах болсон.
- 1989-1994 онд амьдралын ардчилсан байдал илүү тусгагдах болсон.
- 1995-1999 онд хүнлэг байдал, итгэл үнэмшил, ёс зүйн хүмүүжлийн үндсэн төлөвшил олгогдоход чиглэсэн. Энэ үеэс хоёр Солонгос нэгдэл ба Солонгос улс нэгдсэний дараа гэсэн хоёр үеийн амьдралын зорилтыг тусгайлан заах болсон, мөн “national identity” (үндэсний ондоошил/ үндэстний ижилсэл/амин чанар)-ын томьёоллыг тусгасан.
- 2000 оноос буюу одоо мөрдөгдөж буй 7 дугаар сургалтын хөтөлбөрт “ethnic identity” (үндэс угсаа) гэх ойлголт их орсон байна. 7-10-р ангийн ёс зүйн хичээлийн сурах бичиг нь 1) хувийн амьдрал, 2) гэр бүл, хөрш, сургууль дахь амьдрал, 3) нийгмийн амьдрал, 4) үндэсний болон хамт олны амьдрал⁶³ гэх 4 хэсгээс бүрдэж байна. Эдгээрт “national identity” гэж тусгайлан томьёолоогүй ч 8, 10-р ангийн сурах бичгийн 4 дахь хэсэг буюу “үндэсний болон хамт олны амьдрал”-д дээрх ойлголтыг тусгасан байна. Тухайлбал, 8-р ангийн ёс зүйн сурах бичгийн “үндэсний болон хамт олны амьдрал” хэсэг 4 бүлгээс бүрдэж байна. Үүнд:
 1. Солонгосын үндэсний хөгжил ба соёлыг эзэмшихүй (*Korean national development and cultural fluency*);
 2. Төрийн болон үндэсний хөгжлийн ач холбогдол (*The importance of the state and national development*);
 3. Төр, улс үндэстнийг зөв хайрлах (*Correct love of the state and nation*);
 4. Нэгдэл ба Хойд болон Өмнөд Солонгосыг нэгтгэх хүч чармайлт (*Unification and strong will for the reunification of the North and South (Korea)*).

7 дахь сургалтын хөтөлбөрт орсон ёс зүйн хичээлийг ерөнхийд нь үзвэл Солонгос үндэс угсаа, хоёр Солонгосын нэгдэл болон даяаршил гэсэн 3 асуудлыг хөндсөн байна. Хэдийгээр эдгээр асуудлууд нь өмнөх сургалтын хөтөлбөрүүдэд багтаж ирсэн хэдий ч шинэ хөтөлбөрт дээрх асуудлуудад харьцангуй их ач холбогдол өгсөн байна.



⁶³national and community life

Хүснэгт 6. Ёс зүйн хичээлийн агуулга

Хичээлийн өрөнхий агулга	3-р анги	4-р анги	5-р анги	6-р анги	7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги
"Би" ёс суртахуны субъект болох нь	"Ёс суртахуун"- ыг хэрхэн судлах вэ	Шударга амьдрал	Сэтгэл хөдлийн менежмент	Бардамнал ба ёөрийгөө хөгжүүлэх	(Хүн ба ёс суртахуун)	(Ажиллах, сурх)	(Амьдралын зорилго)	(Хүн ба эрх чөлөө)
Миний үнэ цэнэтэй амьдрал	Бие даасан амьдрал	Амьдралын тусгалууд	Өөрийнхөө зан авирт харгууллага хүлээх	Ёс суртахууны асуулт, асуудлууд	Ажиллах, зугацах	Сурх, ирээдүйн төвлөгөө	Аз жаригалтай амьдрал	Өрчүүлэх байгуулалт нарын жолбоодох
Өөр хоорондоо болон НИИГМИЙН харилцаа	Гэр бүлээ хайлрлах, биеэ зөв авч явах	Амплитдаа эзэн болох	Хөршүүдтэйгээ, зөв сайн харцаах	Хууль, дүрэм журам сахих	(Хүмүүжил ба ёс суртахуун)	(Өсвөр үеийнхэн ба ёс суртахуун)	(Хүний нэр тэр, хүний эрх)	(НИИГМИЙН шударга ёс ба ёс зүй)
Талархлаа илэрхийлэх	Олон нийтийн ёс зүй	Бие биедээ туслах	Ажиглалт	Гэр бул болон ёс суртахуун	Өсвөр үеийнхэн, хүн чанар алдагдах асудал	Хуний нэр тэр ба цөнхийн эрхийг хамгаалах	НИИГМИЙН институци ба ёс зүй	
Нөхөрлөл ба наиз нөхөдтэйгээ биен зөв авч	Интернэт ёс зүй	Харилцан ярилцан зөрчийг шийдвэрлэх	Найз болон нөхөлөлийн ута учир. Унэ цэнэ	Будад саннаа тавьж, ойтолцох	Хөршүүдээ энхийн замаар хамгаалах	Асуудлыг энхийн замаар шийдвэрлэх, хүчирхийг плээс урьдчилан сэргийлэх	Жандэрийн эрх тэш байдлыг ёс суртахууны оилголт	НИИГМИЙН ёс зүйн асудлалуд
			Компьютер тоглоомонд донтохоос сэргийлэх	Кибер орчин дахь ёс суртахуун			Өөр хүйстэнтэй нөхөрлөх	

Улс, Ундастэн болов дэлхийн хамтын нийгэмлэг	Улс Ундастний бэлтэг тэмдэг ба улсас хайрлахуй	Хойд Солонгос дахь амьдрал болон иргэдийг оийтох	Ул тээвчих байдал ба тэвчээр	Миний амьдрал ба эх орон	(Нээдэл ба ундастэн усаатны нэглийн ёс зүй)	(Дэлхийн энх тайван ба хүн терөлхтнийг хайлрах)	Улс, ундастний ёс зүй
Хоёр улс нэгдэх шавьгаадсаны шалтгаан	Хоёр улс нэгдэх шавьгаадлага	Гадаадад амьдарч буй Солонгос иргэдийт ойлгох	Нэгдлийн апсын хараа Тайван дээгүй	Улс болон өөрийгөө хөгжүүлэх	Нэгдлийн апсын хараа	Бусад соёл, ёс заншилыг оилжжээ хүндэтгэх	Ундаст усаагаа ба ёс зүй
Байгаль, хүрээлэн буй орчинтой харьцах харьцаа	Хүний амьдралын үнэ цэнэ	Байгаль орчин ба байгаль орчныг хадгалж, хамгаалах	Жинхэнэ гол үзэгэлэн	Хайр ба нигүүсэл	(Байгаль орчин ба ёс суртахуун)	(Соёл ба ёс суртахуун)	(Төгс амьдрал) Энх тайван амьдралын хязгаар Шашин ба ёс суртахуун Төгс хүн ба төгс нийэм

ЭНЭТХЭГ: нь ёс суртахуун, ёс зүй зэрэг дотоод сэтгэлийн боловсролын асар их уламжлал, соёлтой орон юм. Эртний Энэтхэгийн дотоод сэтгэлийн боловсрол нь буддын шашин, соёлтой салшгүй холбоотой бөгөөд боловсрол мэдлэгийн үндэс нь “мэдлэг” гэх угтатай Вед шастирт оршдог байжээ. Аливаа хүн эрдэм, боловсролд суралцахын өмнө Брахмачарья буюу “биеэ авч явах ёс, хүний ёсны эрдэмд суралцахын тулд эхлээд 4 ведийг судалдаг байсан байна.

Эдгээр 4 вед нь эртний Энэтхэгийн боловсролын тогтолцооны үндэс байсан ба хүний ёс суртахуун, амьдралын утга учир, зөв амьдрах ёс, сайн муу, зөв буруу зэргийг ухааруулж сургадаг сургаал юм. Эрт цагийн багш нарын эрхэм зорилго нь ч шавь нартаа Вед шастир болон туульсын зохиолуудаар дамжуулан ёс зүй ба ёс суртахууны үнэлэмжийг бүтээж, өвлүүлэн уламжлуулдаг байжээ. Ийнхүү уламжлалт ёсоор бол ёс суртахуун, ёс зүй, дотоод сэтгэлийн боловсролыг хүүхэд гэр бүл, соёлын ахуйгаасаа суралцаж олдог байсан нь орчин үеийн завгуй, хурдтай амьдралын дунд замхарч, уламжлал алдагдсан учраас ёс суртахууны үнэ цэнэ, үнэлэмжийн тухай асуудалд ихээхэн анхаарал хандуулж байна. Тухайлбал:

Энэтхэгийн Шарда Их Сургуулийн дэд профессор, доктор Урмила Ядавын “Ёс зүй, ёс суртахууны үнэлэмж ба Энэтхэгийн боловсролын тогтолцоо” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд⁶⁴ орчин үеийн Энэтхэгийн боловсролын тогтолцоо ба ёс суртахууны хүмүүжлийн нөхцөл байдлыг дүгнэхдээ: “Модернизаци, аж үйлдвэржилт, хотжилт, хувьчлал, даяаршил ба өрнөдийн соёлын нөлөөлөл зэрэг олон хувьсал өөрчлөлтөөс шалтгаалан Энэтхэгийн боловсролын систем дэх “ёс зүйн үнэлэмж”-ийг доройтуулсан олон зүйл асуудлууд гарах болжээ. Энэтхэгийн боловсролын систем бичиг үсэгт тайлагдсан хүмүүсийн хувь хэмжээг өсгөж байгаа нь сайшаалтай боловч улс нийгэмдээ жинхэнэ эрдэм боловсролтой хүмүүсийг төрүүлэх, улмаар төгс сайн иргэдийг боловсруулахад төдий л хангалтгүй байна. Энэ нь боловсролын эрхэм зорилго нь эх оронч сэтгэл, ёс зүйн үнэлэмжийг хайхралгүйгээр зөвхөн хэрхэн боловсролын зэрэг авах, мөнгө олох, ажил албандаа амжилт гаргахад л анхаарч байгаад оршиж байгаа юм” гэжээ.

Орчин үеийн Энэтхэгийн Боловсролын тухай хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн орчны хүрээнд судлан үзэхэд ёс зүй, дотоод сэтгэлийн боловсролыг олгох тухай тусгайлан зохицуулсан хууль, дүрэм, журам байхгүй хэдий ч боловсролын хөтөлбөрт тусгасан байдаг байна. Энэхүү боловсролын хөтөлбөр нь тав таван жилийн төлөвлөгөөнд хуваагдах ба Засгийн газраас ирэх таван жилийн зорилго, зорилт, сурлагын үр дүн, боловсрол сургалтын үйл ажиллагааны хөтөлбөр, зохион байгуулалтыг тодорхойлдог.

Тус улсын Засгийн газрын “12 дугаар төлөвлөгөө (2012-2017)-ний хөтөлбөр”-т⁶⁵ боловсролын хэд хэдэн асуудлыг шийдвэрлэхийг зорьсон байна. Жишээлэхэд: бичиг үсэггүй байдлыг бууруулах, сургууль завсардах

⁶⁴Ethical Moral values and Indian Education System, XVII Annual International Seminar Proceedings; January, 2016
http://www.internationalseminar.org/XVII_AIS/TS5A_PDF/7.Urmila%20Yadav.pdf

⁶⁵Twelfth Five Year Plan (2012-2017) http://planningcommission.gov.in/plans/planrel/12thplan/pdf/12fyp_vol3.pdf

хувь хэмжээг бууруулах, зарим муж улс дахь хичээлд хамрагдалтын байдлыг хянах системийг бий болгох, үнэт зүйлс (бүх нийтийн соёлын, оюун санааны, ёс суртахууны, эрүүл амьдрах хэв маяг, хүрээлэн буй орчны соёл зэргийг оролцуулаад) ба хувийн зан чанарын (бие даасан, эх оронч, энхтайванч, үндэстний эв нэгдэл, шударга, ертөнцийг үзэх үзлийг бүрэлдүүлэх, орчин үеийн шинжлэх ухаан ба нийгмийн амьдрал-практикийн хөгжлийн түвшинтэй хөл нийлүүлэх, өөрөө өөрийгөө хөгжүүлэх ба боловсруулах, бие даасан, хүсэл эрмэлзэл ба чадвартай байх, бүтээлч бөгөөд хариуцлагатай байх) системийг бий болгох, сургуулийн тоог ялангуяа орон нутагт нэмэгдүүлэх, алслагдсан бус нутгийн багш нарыг орон сууцжуулах, багш нарын өрсөлдөх чадварыг сайжруулах, багш бэлтгэх сургалтын чанарыг өсгөх гэх мэт асуудлуудыг дурдаж болно.⁶⁶

Дээрх хөтөлбөрт тусгагдсанаар орчин үеийн Энэтхэгийн боловсролын системийн нэн тэргүүний зорилтуудын нэг нь суралцагсдын ёс суртахууны боловсрол байх бөгөөд үүний үндэс нь үндэстний оюун санааг хадгалах, үндэстний нэр хүндийн тухай боловсрол, оюун санаа ба ёс суртахуунлаг байдлыг суралцагчдад төлөвшүүлэн бүрэлдүүлэх байдаг бол Энэтхэгийн ёс суртахууны боловсролын зорилго нь соёл, оюун санаа, ёс суртахуун ба бүх нийтийн үнэт зүйлсийг өвлөн уламжилсан, өөрөө өөрийгөө ямагт боловсруулдаг, ёс суртахууны хувьд ямагт өсөж дэвшиж байдаг хувь хүн болохын төлөө бие, сэтгэл ба оюун санаагаа нэгтгэн хөгжүүлэх үндсэн дээр хүнийг бүх сайн сайхан талаар нь хөгжүүлэхэд оршдог байна.

12 дугаар төлөвлөгөөний хөтөлбөрийн хүрээнд сургуулийн бага ангиудад ёс суртахууны боловсролын үндсийг заахдаа Энхтайвны боловсролын хөтөлбөр (Peace programm)-ийг боловсруулан өргөнөөр хэрэгжүүлж эхэлжээ. Энэ нь хүүхдэд амар амгалан, эв нэгдэлтэй байх зан чанарыг төлөвшүүлэх зорилготой хичээл бөгөөд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бусадтай эвсэг, найрсаг байх ухамсыг суулгахад чиглэсэн хөтөлбөр юм.

Мөн Энхтайвны хөтөлбөрийн зэрэгцээгээр бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, сурагчдын төрөл бүрийн клуб ажиллуулдаг байна. Эдгээр клубууд нь Энэтхэг үндэстний үнэт зүйлс, соёлыг өвлөн хадгалах, эх оронч үзлийн боловсрол олгох, эх орноо хайрлах, түүний дэлхийд эзлэх байр суурь, үүрэг роль, ач холбогдлыг ойлгуулах зэрэгт асар их анхаардаг. Ёс суртахуун, ёс зүй, дотоод сэтгэлийн боловсрол олгох эдгээр арга хэлбэрүүдийн гол зорилго нь хувь хүнийг цогцоор нь төлөвшүүлэн хөгжүүлэх явдал юм. Энэхүү зорилтыг биелүүлэх үүднээс дэвшиүүлж буй гол зорилтууд нь:

- Хувь хүний оюун ухаан, соёл ба ёс суртахууны хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэх;
- Сурагчдыг орчин үеийн соёл иргэншлийн орчинд ажиллаж амьдрах чадвартай болгон хөгжүүлэх тухайд иргэний боловсролыг олгох;
- Сайн иргэний боловсролын талаарх үе үеийн туршлагыг ашиглах;

⁶⁶Twelfth Five Year Plan (2012-2017) http://planningcommission.gov.in/plans/planrel/12thplan/pdf/12fyp_vol3.pdf

- Оюун санааны болон соёлын уламжлалын түүчээг баталгаажуулах;
- Нийгмийн ёс суртахуун, соёл, шинжлэх ухааны үнэ цэнийг өвлөж хөгжүүлэх;
- Хүн ардын дунд мэдлэгийг түгээн боловсрол, соёлын түвшнийг нь өсгөх.

Эдгээр зорилго, зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд боловсрол, танин мэдэхүй, хүмүүсийн ёс суртахууны төлөвшлийг дээшлүүлэх үйл ажиллагаанд багш нар өргөн цар хүрээтэй арга (ярилцлага, тоглоом наадам, урлагийн тогтолт, нийгмийн ажил, биеийн тамир ба бүтээлч ажил үйлс) хэлбэрүүд (хичээл, музей аж ахуйн нэгжүүд, үйлдвэрийн газрууд, клубүүдээр аялал экскурс зохион байгуулах) болон хэрэгслийг (ном сурх бичиг, туульс, үзүүлэн, компьютер, интернет) ашигладаг байна.

Сүүлийн жилүүдэд Энэтхэгийн ёс суртахууны боловсролын системийн хөгжлийн үйл явцад дараах шинж чанарууд ажиглагдаж байна гэж Оросын судлаач дүгнэжээ⁶⁷. Үүнд: дотоод сэтгэл, бие хүний хөгжил, өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзэл, оюун санааны болон ёс суртахууны тогтмол өсөлт хөгжил, соёл, ёс суртахууны үнэт зүйлс болон уламжлалаас суралцах, иргэнийг төлөвшүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг бүрэлдүүлэх, экологийн сэтгэлгээний үндсийг бүрдүүлэх зэрэг болно.

Гэвч аливаа бусад боловсролын үйл ажиллагааны адилаар ёс суртахууны боловсролыг ямагт шинэчлэн сайжруулж, шинэ хөгжлийн хөтөлбөртэй боловсруулж, түүндээ улс орныхоо өнө эртний түүхэн уламжлалаар шалгагдсан баялаг онол, практик, өрсөлдөх чадвар зэргийг багтаан оруулж байх ёстой гэдэг асуудал тавигдсаар л байгаа аж.

БУТАН: Дэлхийд Аз жаргалын яамтай ганцхан улс байдаг нь Бутан юм. Бутан Улс хөгжлийн шалгуур үзүүлэлтийг ДНБ-ээр хэмждэггүй бөгөөд харин түүний оронд өөрсдийн боловсруулсан “нийт үндэстний аз жаргал” гэсэн үзүүлэлтийг шалгуур болгодог байна. Бутан Улс хүн амын тооллого явуулахдаа иргэн бүрзэсээ “Та аз жаргалтай байна уу” гэсэн асуултыг асуудаг уламжлалтай. 2015 оны сүүлчээр уг санал асуулгыг явуулахад хүн амын 35 хувь нь “маш их аз жаргалтай”, 47.9 хувь нь “аз жаргалтай” харин 8.8 хувь нь “тийм ч аз жаргалтай биш” гэж хариулжээ.⁶⁸

Нийт үндэсний аз жаргал гэдэг ойлголт нь Бутаны дөрөвдүгээр эзэн хаан Жигмэд Сингэй Ванчугийн боловсруулан дэвшиүүлсэн нийгмийн байгууллын тухай үзэл юм. Ерөнхийдөө энэ өвөрмөц гүн ухаан нь хэрэглээний суурьтай дотоодын нийт бүтээгдэхүүнтэй адилгүй бөгөөд үндэсний аз жаргал нь хүн төрөлхтний материаллаг хэрэгцээ болон оюун санааны сайн сайхны хоорондох тэнцвэрийг хангагч бөгөөд үүнийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн амжилтын чухал нэгэн хэмжүүр индекс гэж үздэг байна.

⁶⁷Moral education in Russia and India: A Comparative Analysis, Medwell journals, 2016 <http://docsdrive.com/pdfs/medwelljournals/sscience/2016/3765-3769.pdf>

⁶⁸Gross National Happiness in Bhutan: A Living Example of an Alternative Approach to Progress <https://repository.upenn.edu/cgi/viewcontent.cgi?article=1003&context=sire>

Иймээс Засгийн газар нь ард түмнээ аз жаргалтай байлгахыг гол зорилгоо болгосон байдаг. Бутан Улсын Засгийн газраас Үндэсний аз жаргалын хөтөлбөрийг⁶⁹ боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хөтөлбөрт дурдсанаар: ХХI зуун бол хэт их технологийн дэвшил, даяаршил ба нөхөгдөх болоод нөхөгдөшгүй баялгийн тогтвортгүй хэрэглээний эрин үе юм. Энэ бүх нийгэм-эдийн засаг, хүрээлэн буй орчин, улс төрийн асуудлуудын дунд хүмүүс боловсролыг амьдралын утга учрыг ухаарах, асуудлуудыг шийдвэрлэх арга замыг олох хэрэгсэл төдийгүй хувь хүний болон ард нийтийн эрэлт хэрэгцээний хоорондох гүүр болж, улмаар бүх нийтээрээ хөгжин дэвжих суурь болно гэж үзэх болжээ. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийн боловсрол нийтийн сайн сайхан, хүн төрөлхтний хөгжил цэцэглэлтээс илүүтэй хувь хүний ололт амжилтыг хэрхэн олох тухай зах зээлийн хүчин зүйлсийг голчлон эрхэмлэж ирсэн билээ. Өнөөдрийн хүүхдүүд бол ирээдүйн иргэд тул өнөө бидний хүүхдэд олгож буй боловсролоос манай дэлхий ямар байх нь шалтгаална. Тиймээс эх дэлхийгээ хадгалан хамгаалахын тулд бид нэгэн дэлхийн үндэстэн болж нэгдэх хэрэгтэй юм. Ингэж гэмээ нь бид сая дэлхий нийтийн асуудлуудын шийдлийг олно. Энэ бүхэнд хүүхдийг ганц өөрийгөө боддог биш харин бусдын хүсэл, нийтийн асуудлыг шийдвэрлэхэд хамтрах чадвартай, баяр баясгалантай хүн болж өсгөхөд илүү анхаарсан, одоогийнхоос огт өөр боловсрол шаардлагатай байна. Энэ нь дан ганц боловсролын байгууллага, багш нарын анхаарах асуудал бус үүнд эцэг, эх болон олон талын оролцоо, хүсэл тэмүүлэл, үйл хэрэг чухал үүрэгтэй болохыг тодорхойлжээ.

Бутаны нийт хүн амын 80.97% нь бурханы шашинтнууд, 17.83% нь хинду, 1.20% христийн шашинтнууд юм. Үүсгэн байгуулагдсан цагаасаа л Бутаны өвөрмөц соёл нь Бурхны шашин соёлын нөлөө бүхий хөгжик ирсэн. Тийм учраас Бутаны соёл нь бурхны ном сургаалын зарчмуудад гүн бат суурилсан байдаг байна.⁷⁰

Үндэсний аз жаргалын индекс нь хүн амын материаллаг эд баялаг болон оюун санааны, эрүүл мэндийн тэнцвэртэй байдлыг хадгалж байдаг.

Хөтөлбөрийн хүрээнд 2009 оноос Бутаны Засгийн газар улсын сургуулийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, ирээдүйн Бутаны иргэдийг амьдралын утга учрыг ухааруулах, аз жаргалтай амьдралын талаар ойлголтой болгох, байгаль орчноо хамгаалах дадал хэвшлийг бий болгох, энэ дэлхийн бүх зүйл хоорондоо харилцан хамааралтай болохыг ойлгуулах зорилт тавьжээ.

Энэ ч үүднээс Бутан Улсын Боловсролын яамнаас “Бутаны боловсролын төлөвлөгөө”⁷¹ хэмээх 2014-2024 онд хэрэгжүүлэх боловсролын хөтөлбөр, бодлогын баримт бичгийг 2014 онд боловсруулан хэвлүүлжээ. Энэхүү бодлогын баримт бичгийг “аливаа улс орон агуу хүчирхэг байхын үндэс бол ард түмний бүтээлч байдал, зан суртахуун мөн бөгөөд энэ нь тэдний хүртэж буй боловсролын чанараас хамаарна” гэдэгт итгэдэг Дүжал Шива эзэн хааны лагшин мэндэлсний 60 насны ойд зориулсан байна.

⁶⁹https://issuu.com/trykpartner/docs/quality_of_school_education_in_bhut

⁷⁰<https://happinesssummit.world/gross-national-happiness-and-positive-education-in-bhutan/>

⁷¹<https://www.globalpartnership.org/content/bhutan-education-blueprint-2014-2024>

Тэрээр хэлэхдээ: “Улс, эх орноо удирдан жолоодоход чухал олон нэн зорилго, зорилтууд бий. Энэ бүхний нэн тэргүүнд миний бие боловсролыг эрхэмлэнэ. Боловсрол бол - нийгмийг тэгшигтгэн тэнцвэржүүлэгч, өөрийгөө нээж таних нөхцөлийг бүрдүүлэгч - өөрөө өөрийнхөө бүх чадвар, боломжийг танин мэдэх хүчийг өгөгч мөн. Сайн боловсрол билэнд өөртөө итгэх итгэлийг, зөв үнэлэлт дүгнэлтийг, сайн буяны сэтгэлийг, улмаар амгалан жаргаланг баттай олохын арга ухааны хайрлах юм. Сайн сургууль хүүхдэд арьс өнгө, удам угсаа, нийгмийн гарлаас нь үл хамааран амжилтанд хүрэх шударга боломж, амьдралын ахиц дэвшлийн баталгааг олгох болно”⁷² гэжээ.

Бутаны боловсролын систем нь нэг жилийн бэлтгэл бүхий долоон жилийн суурь боловсрол (бэлтгэлээс VI анги), дөрвөн жилийн дунд боловсрол (VII-X анги), хоёр жилийн ахлах буюу бүрэн дунд боловсрол (XI-XII анги)-оос бүрдэнэ. Бутанд б настай элсэн ордог бэлтгэл ангиас X анги хүртэлх ерөнхий боловсрол үнэ төлбөргүй. Гэсэн хэдий ч бүрэн дунд сургууль төгссөний дараа дээд сургуульд суралцагсдыг авьяас чадвар, сурлага, улсын хүний нөөцийн эрэлт зэрэгт нийцүүлэн сонгож Засгийн газрын тэтгэлэгт хамруулна. 12 дугаар ангия дүүргэсэн боловч Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаж чадаагүй сурагчид хувиараа төлбөрөө төлж дээд боловсролыг эзэмшинэ.

Төлөвлөгөө нь нийт 5 бүлэгтэй бөгөөд 2014-2024 он хүртэл боловсролын талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга зам, хөтөлбөрийн үндэслэл, зорилго, зорилтууд, Бутаны боловсролын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга замууд болон боловсролын системд нэвтрүүлэх өөрчлөлтүүд зэргийг маш тодорхой боловсруулсан байна. Энэхүү төлөвлөгөөнд оруулсан боловсролын системийн бага, дунд, ахлах ангиудын сургалтын хөтөлбөрийг хараад уламжлалт соёл, ёс суртахууны боловсролын хичээлүүдийг бүр бэлтгэл, бага ангиас нь төгсөх анги хүртэл нь шалгалт авахгүй боловч заавал судлах хичээл болгон оруулдаг байна.⁷³




⁷²Бутаны Эзэн хаан Жигмэд Хэсар Намжилванчуг. 2014 он.

⁷³<https://www.globalpartnership.org/content/bhutan-education-blueprint-2014-2024>

Зураг 1. Бутаны боловсролын тогтолцоо

Зураг 1. Бутаны боловсролын тогтолцоо



СИНГАПУР: Сингапур Улс нь 1965 онд бүх нийтээр бага боловсрол, 1970-аад онд бүх нийтээр бүрэн бус дунд боловсролтой болсон байна.

Сингапур Улсын хувьд ёс зүй, ёс суртахуунтай холбоотой асуудлыг *Character and Citizenship Education (CCE)* буюу Зан суртахуун ба иргэний боловсролын хичээлээр судалдаг байна. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн Зан суртахуун ба иргэний боловсролын хичээлийн зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна.

Зорилтын 1-4 нь хувь хүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн байна. Үүнд:

1. Хувь хүний сайн сайхан үр дүнд хүрэхийн тулд өөрийгөө ойлгуулах, өөрийгөө удирдах чадварыг эзэмшигүүлэх;
2. Ёс суртахууны зарчмуудыг дээдэлсэн, шударга зарчмыг баримтлан хариуцлагатай шийдвэр гаргах;
3. Хүмүүсийн харилцан хүндэтгэл дээр суурилсан эерэг харилцааг бий болгоход нийгмийн ухамсар, харилцааны чадварыг ашиглах;
4. Уян хатан байж, сорилт бэрхшээлүүдийг боломж болгох чадвартай байх.

Зорилтын 5-8 нь 21-р зууны иргэнийг удирдлага болгон нийгмийн гишүүний хувьд соёлтой, идэвхтэй, хариуцлагатай оролцоо зэрэг иргэний харьяаллын шинж чанаруудыг төлөвшүүлэхэд чиглэгдэж байна. Үүнд:

5. Улс орондоо харьяалаадах, улс үндэстнээ байгуулахад оролцох, үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанарын (*national identity*) бахархал;
6. Сингапурын нийгэм-соёлын олон янз байдлыг ойлгон үнэлж, нийгмийн нэгдмэл байдал, эв нэгдлийг хөхиулэн дэмжих, хамгаалах;
7. Бусдын төлөө санаа тавьж, нийгэм, улс үндэстнийхээ хөгжил дэвшилд идэвхтэй хувь нэмэр оруулах;
8. Олон нийт, үндэсний болон дэлхийн асуудлуудад хариуцлагатай, мэдээлэлтэй иргэний хувьд хариулах чадвартай байх.



Хүснэгт 7. Зан суртахуун ба иргэний боловсролын хичээлийн агуулга

Д/д	Иргэний боловсролын хичээлийн зорилго	Зорилго (Боловсролын шат тус бүрт)			Гол унэт зүйл
		Бага	Дунд	Их сургуулиас ёмних	
1	Хувь хүний сайн сайхан үр дунд хүрэхийн тулд өөрийнөө ойлгуулах, өөрийтгэвч удирдах чадварыг зээмшигүүлэх;	Хөдөлмөрөөрөө баархах	Сүрн боловсрох харцуулгагаа ухамсарлах	Төгс төгөлдрийг илэрхийлэхдээ зорилготой байх	Харцууллага
2	Зөв дадал зурсил, урлагийн талаарх мэдлэг	Биеийн тамираар хичээллэх, урлагийн талаарх мэдлэг	Эрүүл амьдралын хэв маягийг эрэлхийлэх, гол зүйн мэдрэмж		
3	Ёс суртахууны зарчмуудыг дээдэлсан, шударга зарчмыг баримтлан харцуулгатай шийдвэр гаргах;	Буруу, зөвийг ялгах чадвартай байх	Ёс суртахуунтай байх	Зөв гасний төлөө тэмцэх ёс суртахууны зорилтой байх	Харцууллага, шударга байдал
4	Хүмүүсийн харилцан хүндэтгэл дээр сууринсан эерэг харилцааг бий болгоход нийгмийн ухамсар, харилцааны чадварыг ашиглах, чадвартай байх;	Бусадтай хамтран ажиллах, хуваалцах, асран халамжлах чадвартай байх	Багаар ажиллаж, бусадад саннаа тавих	Нийтийн харцуулгатай байж, янз бурийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллас чадвартай байх	Хүндтэл
5	Үнэн хатан байж, сорилт барьшээгүүдийг боломж болгох чадвартай байх;	Өөрийн хүч чадал, давуу талыга хөгжүүлэх	Өөрийн ур чадвар, чадалдаа итгэж, өөрчлөгдөж чаддаг байх	Саад барьшээгүй даван туулах чадвартай байх	Үнэн хатан байдал
	ЮМС Узэгдлийг сонирхож	Бутээгч сэргэгээтэй байх	Шинээг, аж ахуйч байх		

6	Сингапурын нийгэм-соёлын опон янз байдлыг ойлтон үнэлж, нийгмийн нэдмэлт байдал, эв нэгдлийг хөхчилгэн дэмжих, хамгаалах;	Бусадтай хамтран ажиллах, хувалцах, асран халамжлах чадвартай байх	Багаар ажиллаж, бусадад санаа тавих	Нийтийн хариуцлагатай байж, янз бурийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллах чадвартай байх	Хариуцлага, эв нэдэл
7	Бусдын төлөө санаа тавьж, нийгэм, улс үндэстний эх хөлжилт дэвшилд идэвхтэй хувь намэр оруулах;	Бусадтай хамтран ажиллах, хувалцах, асран халамжлах чадвартай байх	Өөртөө ингэлтэйгээр өөрийгөө илэрхийлэх, сэтгэж бодох	Олон янзын үзэл бодлыг ойлгох, харилцах чадвартай байх	Шумжилтэйгээр бодож, үнэмшилтэйгээр харилцах чадвартай байх
			Өөрийн хүч чадал, давуу танаа хөгжүүлэх	Өөрийн ур чадвар, чадалдаа итгэх, өөрчлөлтөд дасан зохицох чадвартай байх	Нийтийн хариуцлагатай байж, янз бурийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллах чадвартай байх
				Багаар ажиллаж, бусадад санаа тавих	Хариуцлага, халамж
8	Юмс үзэгдлийг сонирхох	Бутгалч сэргэлтээтийг байх	Буруу, зөвийг ялгах чадвартай байх	Шинэлэг; аж буйчийг байх	Зөв гасний төлөө тэмцэх ёс суртахууны зорилтой байх
			Өөртөө ингэлтэйгээр өөрийгөө илэрхийлэх, сэтгэж бодох	Олон янзын үзэл бодлыг ойлгох, харилцах чадвартай байх	Шумжилтэйгээр бодож, үнэмшилтэйгээр харилцах чадвартай байх
			Улс орноо таньж мэдэх, хамрлах	Сингапурын иргэн байжын бахархал, дэлхий дахин дахь Сингапурын байр сууринг ойлгох	Хүндлэл, хариуцлага

**ХОЁР. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ёС СУРТАХУУНЫ
БОЛОВСРОЛ ОЛГОХООР ХУУЛЬ, ХОЛБОГДОХ БОДЛОГЫН БАРИМТ
БИЧИГТ ТУСГАСАН УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА**

2.1. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

21-р зууны эхээр Оросод төр, нийгэм, эдийн засгийн чухал өөрчлөлтүүд явагдсан нь нийгмийн ухамсырын түвшинд ихээхэн нөлөө үзүүлсэн. Өөрөөр хэлбэл, одоо Оросын нийгэм ёс суртахуун болон хүмүүжлийн хямралд ороод байна. Энэ нь өсвөр үеийн хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролд ноцтой нөлөө үзүүлж байна. Иймээс сүүлийн 10 жилд төр засгаас гэр бүлийн нийгэм, эдийн засгийн асуудал, мөн хүүхэд, запуусын ёс суртахуун, хүмүүжил төлөвшлийн асуудлыг бүх талаар дэмжиж, хууль эрх зүйн хүрээнд зохицуулах талаар ихээхэн анхаарал хандуулсан. Тухайлбал, 2012 онд Ерөнхийлөгчийн зарлигаар “Хүүхдийн төлөө Үндэсний Стратеги 2012-2017” хүчин төгөлдөр болсон.

Засгийн газраас 2015 онд “2025 он хүртэл ОХУ-ын хүмүүжлийн боловсролын хөгжилд баримтлах стратеги”-ийг (Стратегия развития воспитания в Российской Федерации на период до 2025 года) батлан гаргасан⁷⁴.

ОХУ нь хүүхэд, запуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны асуудлыг зохицуулах тусдаа хуульгүй. Харин хүүхэд, гэр бүлийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулах хууль, дүрэм, журам болон хөтөлбөрийн хүрээнд зохицуулдаг.

Энэхүү асуудлыг зохицуулахад “2025 он хүртэл ОХУ-ын хүмүүжлийн боловсролын хөгжилд баримтлах стратеги” чухал үүрэг гүйцэтгэж байна. Стратеги нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, 1998 оны “Оросын Холбооны Улсын хүүхдийн үндсэн эрхийн баталгааг хангах тухай” хууль (“Об основных гарантиях прав ребёнка в Российской Федерации”), 2012 оны “Оросын Холбооны Улсын боловсролын тухай хууль” (“Об образовании в Российской Федерации”) болон бусад холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах зорилготой. Уг стратегид тодорхойлсноор ОХУ-ын тэргүүний зорилтуудын нэг нь 21-р зууны шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадвартай, уламжлалт ёс суртахууны үнэ цэнийг хадгалсан, эх орны бүтээн байгуулалт болон эх орноо хамгаалах үйлсэд хэзээд бэлэн шинэ үеийг төлөвшүүлэх явдал юм. Энэ асуудлыг шийдэх гол түлхүүр нь хүүхдийн хүмүүжил юм. Хүмүүжлийн стратегийн чиг хандлагыг Ерөнхийлөгч Путин: “Эх орон болон эх дэлхийгээ хайлрадаг, бүх үндэстэн болон угсаатанд адил тэгш ханддаг, хөрш зэргэлдээ амьдарч буй хүмүүсийн түүх соёл, ёс заншилд хүндэтгэлтэй ханддаг бүх талаар боловсorсон, хариуцлагатай иргэн хүнийг төлөвшүүлэх юм” хэмээн тодорхойлон хэлжээ.

⁷⁴https://minобрнауки.ru/открытое_министерство/стратегия/

Стратегия развития воспитания в Российской Федерации на период до 2025 года
Распоряжением Правительства РФ от 29.05.2015 г. № 996-р

Стратегийн зорилго нь хүүхдийн хүмүүжлийн талаарх төрийн нэн тэргүүний бодлого, хүмүүжлийн боловсролыг хөгжүүлэх үндсэн чиг хандлага, уг стратегийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг тодорхойлох, түүнчлэн орос иргэнийг илэрхийлэх хувь хүнийг төлөвшүүлэх, нийгэм дэх ёс суртахууны үндэс суурийг бэхжүүлэх, хүүхдийг үр дүнтэй нийгэмшүүлэх, Оросын Холбооны Улс дахь олон үндэстний үнэт зүйл болон ёс заншил, соёлыг судалж таних, хүндэтгэлтэй хандахад оршино.

Стратеги нь дараах зорилтуудыг агуулна. Үүнд:

- өсвөр үеийг хүмүүжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд хамтарч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ба хүүхдийн хүмүүжилд гэр бүл чухал үүрэгтэй болохыг онцгойлон анхаарах;
- хүүхэд хүмүүжүүлэхэд эцэг эхийн хариуцлагад тулгуурласан гэр бүлийн хүмүүжлийг дэмжих, түүнчлэн эцэг эхийн нийгмийн, харилцааны, сурган хүмүүжүүлэх мэдлэгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- боловсролын системийн хүмүүжилтэй холбоотой үйл ажиллагааны ач холбогдлыг нэмэгдүүлэх;
- хүүхдийг үр дүнтэй нийгэмшүүлэхэд боловсрол, соёл, биеийн тамир, шинжлэх ухаан, танин мэдэхүй, аялал жуулчлал болон бусад байгууллагын хамтын ажиллагааг хангах, нийгэм соёлын дэд бүтцийг бүрдүүлэх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирсон дэд бүтцийг бүрдүүлэх, тэгш хүртээмжтэй хангах юм.

Стратеги нь 4 хэсгээс бүрддэг. Үүнд:

- Хүмүүжлийн боловсролд баримтлах төрийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд;
- Хүмүүжлийн боловсролыг хөгжүүлэх үндсэн чиг хандлагууд;
- Стратегийг хэрэгжүүлэх арга механизмын;
- Хүлээгдэж буй үр дүн зэрэг болно.

Хүмүүжлийн боловсролд баримтлах төрийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд

- хүүхдийг эрхэм чанар, үндэсний ёс заншил болон хүн төрөлхтний ололт амжилтад хүндэтгэлтэй хандахад төлөвшүүлэх, мөн хүүхдийн хүмүүжилд гэр бүлийн үүрэг оролцоог онцгойлон дэмжих, эцэг эхийн нэр хүндийг эрхэмлэх, тэдний хүүхдээ сурган хүмүүжүүлэх нэн тэргүүний эрх ашгийг хамгаалах;
- хүүхэд бүрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
- боловсролын систем дэх хүмүүжлийн асуудлыг үндэсний уламжлалт соёл, ёс суртахуун, хүмүүжил төлөвшил, гэр бүлийн үнэт зүйлстэй уялдуулан зохицуулах;
- хүүхдийн бие, сэтгэл зүй, нийгмийн байдал, ёс суртахуун, хүмүүжил, төлөвшлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх, ялангуяа хүнд нөхцөлд буй хүүхдэд онцгой анхаарал хандуулах (үүнд: эцэг эхийн асран хамгаалалд байдаггүй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үндэстэн хоорондын болон зэвсэгт мөргөлдөөний уршигаар, эсхүл экологийн болон техногенийн осол гамшиг, эсхүл байгалийн давагдашгүй хүчин зүйлийн золиос болсон

хүүхэд, дүрвэгсдийн гэр бүлд буй, эсхүл нүүлгэн шилжүүлсэн нөхцөлд буй хүүхэд, ял авч эрх нь хязгаарлагдсан буюу засан хүмүүжүүлэхэд буй хүүхэд, бусад тохиолдол), мөн орчин тойронтой харьцах хандлагыг төлөвшүүлэх;

- хүүхдийн хэл ярианы соёлыг төлөвшүүлэх;

Оросын ирээдүйн иргэн өсвөр үеийг төлөвшүүлэх, хүмүүжлийн орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор хүмүүжлийн боловсролд хамааралтай субъектүүдийн, өөрөөр хэлбэл гэр бүл, нийгэм, улс төр, боловсрол, шинжлэх ухаан, уламжлалт шашны болон төрийн бус байгууллагууд, биеийн тамир болон соёлын байгууллагууд, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого баримтлах зэрэг болно.

ХҮМҮҮЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГ ХАНДЛАГУУД

Үндсэн чиг хандлагыг 2 бүлэгт хувааж үзсэн. Үүнд:

- 1.Хүмүүжлийн чиг үүрэг бүхий нийгмийн институцийг хөгжүүлэх;
- 2.Уламжлалт ёс заншилд үндэслэж, орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэй уялдуулан хүмүүжлийн үйл ажиллагааг шинэчлэх.

1. Хүмүүжлийн чиг үүрэг бүхий нийгмийн институцийг хөгжүүлэх

Энэ хүрээнд дараах 4 зүйлийг тодорхойлсон. Үүнд:

- Гэр бүлийн хүмүүжлийг дэмжих;
- Боловсролын систем дэх хүмүүжлийн асуудлыг сайжруулах;
- Мэдээллийн хэрэгсэл ашиглаж хүмүүжил олгох боломжийг нэмэгдүүлэх;
- Хүмүүжлийн чиг үүрэг бүхий олон нийтийн байгууллага, холбоодыг дэмжих зэрэг болно.

Гэр бүлийн хүмүүжлийг дэмжихэд

- хүүхдийг сурган хүмүүжүүлэхэд гэр бүлийн харилцааг бэхжүүлэх болон эцэг эхийн нэн тэргүүний эрхийг хамгаалах; олон хүүхэдтэй байх, эцэг эх байхын нийгмийн ач холбогдол болон нэр хүндийг дээшлүүлэх;
- хүүхэд хүмүүжүүлэхэд гэр бүлийн харилцааны соёлыг уламжлалт болон ёс суртахууны үнэт зүйл, уламжлалт шашны ёс заншилд тулгуурлаж хөгжүүлэх, хамгаалах, бэхжүүлэх;
- гэр бүлд хүүхэд хүмүүжүүлэх, ялангуяа олон хүүхэдтэй болон хүүхэд үрчлэн өсгөж буй тохиолдолд хамгийн оновчтой сурган хүмүүжүүлэх туршлагыг дэлгэрүүлэх;
- удмын холбоо, төрөл садны холбоог бэхжүүлэх, олон үе дамжин өвлөгдөж ирсэн гэр бүлийн ач холбогдол бүхий уламжлалыг сэргээн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- боловсролын байгууллага болон хүүхэдтэй ажилладаг бусад байгууллагын хүмүүжүүлэх үйл ажиллагаанд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх;

- боловсролын болон нийгмийн байгууллагуудын оролцоотой эцэг эхийн сурган хүмүүжүүлэх соёлыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Амралтын хугацаанд гэр бүлийн амрах болон боловсролын ач холбогдолтой аялал жуулчлалыг дэмжих дэд бүтцийг сайжруулах;
- гэр бүлийн клубүүд, оршин суугаа газар дахь клубүүд, гэр бүл болон эцэг эхийн холбоодыг дэмжих (эдгээр клуб нь гэр бүлийн харилцааг бэхжүүлэх, мөн гэр бүл, ёс суртахууны уламжлалт харилцааг, гэр бүлийн харилцааны соёлыг, гэр бүлийн хүмүүжилд эцгийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх хамгаалах, сэргээх зорилготой);
- гэр бүлийн хүмүүжлийн хүрээнд эрх зүй, эдийн засаг, анагаах ухаан, сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх болон бусад асуудлаар эцэг эхэд мэдлэг боловсрол, зөвлөгөө өгөх нөхцөлийг бүрдүүлэх юм.

Боловсролын систем дэх хүмүүжлийн асуудлыг сайжруулахад

- төрийн боловсролын стандартад тусгасан хүмүүжлийн цогц асуудлыг үр дүнтэй хэрэгжүүлэх, түүнд үндэслэж хүмүүжлийн боловсролын агуултыг шинэчлэх, мөн сурган хүмүүжүүлэх хамгийн оновчтой туршлагад тулгуурлаж хүмүүжлийн арга болон хэлбэрийг нэвтрүүлэх;
- эцэг эх, гэр бүл, ахмад хүнийг хүндэтгэх, мөн ирээдүйд гэр бүл болох талаар хүмүүжил өгөхөд чиглэсэн боловсролын хөтөлбөрийг уламжлалт гэр бүлийн харилцаа болон ёс суртахууны хүмүүжил төлөвшилд тулгуурлан боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- суурь болон нэмэлт сургалтын хөтөлбөрүүдэд тусгасан хүмүүжилтэй холбоотой хэсгийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэх;
- хүүхдийн хэрэгцээ, ашиг сонирхол, чадварыг харгалzan түүний хөгжлийн үе шатыг төлөвшүүлэхэд шаардлагатай хүмүүжлийн систем болон технологийг хөгжүүлэх;
- авьяас чадвартай хүүхдийг тодруулах, дэмжих нөхцөлийг сайжруулах;
- хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх танин мэдэхүй, хөдөлмөрт сургах, нийгмийн хэрэгцээтэй, урлагийн, биеийн тамирын болон тоглоомын хэлбэрийг нэмэлт боловсролын системийн нөөц бололцоог ашиглаж хөгжүүлэх;
- өсвөр үеийн ном зохиол унших сонирхлыг хөгжүүлэх;
- хүүхдийн орос хэлний болон эх хэлний ур чадвар, харилцааны бусад чадваруудыг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэх;
- хүүхдийн амралтыг зохион байгуулах, эрүүл мэндийг хамгаалахад хүмүүжлийн холбогдолтой сэтгэл зүйн болон сурган хүмүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх юм.

Мэдээллийн хэрэгсэл ашиглаж хүмүүжил олгох боломжийг нэмэгдүүлэхэд

- интернэт, кино, телевиз, ном, сонин хэвлэл, ялангуяа радио, телевиз зэрэг мэдээллийн орчин нь хүүхдийн хөгжилд эерэг нөлөөтэй байх нөхцөлийг бүрдүүлэх;

- Оросын уламжлалт соёл, ёс суртахуун, хүмүүжил, төлөвшил, гэр бүлийн үнэт зүйлсийн талаар мэдээллийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлэхийг дэмжих;
- интернэтийн эх сурвалжид нэвтэрснээр хүүхдийн эрүүл мэнд болон хөгжилд буруугаар нөлөөлөх мэдээллээс хүүхдийг хамгаалах юм.

Хүмүүжлийн чиг үүрэг бүхий олон нийтийн байгууллага, холбоодыг дэмжихэд

- Хүүхдийн манлайлах болон бүтээлч чадварыг хөгжүүлэх зорилгоор хүүхдийн байгууллага, олон нийтийн байгууллагуудын ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, нэмэлт боловсролын байгууллагуудтай үр дүнтэй харилцааг сайжруулах;
- боловсролын байгууллагын хүмүүжүүлэх үйл ажиллагаанд эцэг эхийн болон олон нийтийн байгууллага, холбоодын оролцоог дэмжих;
- нийгмийн ач холбогдолтой танин мэдэхүйн, урлаг соёлын, орон нутгийн, буяны байгууллагуудын үйл ажиллагаанд, мөн сайн дурын үйл ажиллагаанд хүүхдийг өргөнөөр оролцуулах;
- хүүхдийн хүмүүжлийн хүрээнд төр хувийн хэвшилийн түншлэлийг өргөжүүлэх юм.

2. Уламжлалт ёс заншилд үндэслэж, орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэй уялдуулан хүмүүжлийн үйл ажиллагааг шинэчлэх

Үүнд дараах 6 зүйлийг тодорхойлсон.

- Иргэний болон эх оронч хүмүүжил;
- Ёс суртахуун, хүмүүжил төлөвшлийг сайжруулах;
- Соёлын өв уламжлалтай харьцах;
- Биеийн хөгжил ба эрүүл мэндийн соёл;
- Хөдөлмөрт сургах болон мэргэжлээ сонгох;
- Экологитой харьцах харилцаа зэрэг болно.

Иргэний болон эх оронч хүмүүжил

- ертөнцийг үзэх үзэл, Орос орны онцлог, гэр бүл, нийгэм, төрд, мөн гэр бүл болон нийгэмд буй ёс суртахуун, хүмүүжлийн, нийгэм соёлын үнэт зүйлсэд, үндэсний түүх соёлын өв уламжлалд хүндэтгэлтэй хандах, түүнийг хамгаалах, хөгжүүлэхэд хүүхдийг төлөвшүүлэн хүмүүжүүлэх;
- Оросын нийгмийн уламжлалт соёл, ёс суртахуун, хүмүүжлийн үнэт зүйлд тулгуурлаж хүүхдийг идэвх санаачилгатай байх, иргэний үүрэг хариуцлагаа ухамсарлах, мэдлэг боловсрол, чадвараа хөгжүүлэх, Үндсэн хуулиар хүлээсэн эрх, үүргээ хариуцлагатай биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- хүүхдийн эрх зүйн болон улс төрийн харилцааны соёлыг хөгжүүлэх, хүүхдийн эрх, ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргахад тэдний идэвхтэй оролцоог хангах;
- хүүхдэд эх оронч үзлийг, цэргийн хүний адил эх оронч үзлийг төлөвшүүлэх;

- цагаач хүүхдийн хууль эрх зүй, нийгэм соёлын харилцааг хөгжүүлэхэд тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- хэт туйлшрал, ксенофоби буюу гадаадын хүмүүсийг ялгаварлан гадуурхах, мөн нийгмийн гарал, шашин шүтлэг, арьс өнгө, үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах, үндэстэн хоорондын, шашин хоорондын зөрчил болон нийгмийн бусад сөрөг хандлагад автуулахгүй, ёс суртахуунтай байх, зөв зохистой хүмүүжил, үзэл бодол, хандлагыг төлөвшүүлэх юм.

Ёс суртахуун, хүмүүжил төлөвшүүлийг сайжруулахад

- хүүхдийг сайхан сэтгэлтэй, үнэнч шударга, зөв боловсон хүмүүжүүлэх, эцэг эх, багш, ахмад хүмүүс, найз нөхөд болон бусад хүмүүст хүндэтгэлтэй хандах, мөн хариуцлагатай байх, сонголтоо зөв хийх, багаар ажиллах чадвартай, эв найрамдалтай, өрөвч энэрэнгүй, нинжин сэтгэлтэй, хүүхэд болон ахмад настанд ээлтэй, тусч, бэрхшээлийг даван туулах чадварт төлөвшүүлэн хүмүүжүүлэх;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүндэтгэлтэй хандах хандлагыг төлөвшүүлэх;
- хүүхдийн ёс суртахуун, хүмүүжлийн хүрээнд төр, нийгэм, уламжлалт шашны болон олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх юм.

Соёлын өөр уламжлалтай харьцах

- хүүхэд бүр соёлын үнэт зүйлтэй харьцах боломжийг бүрдүүлэх;
- хүүхэд гэр орондоо хүүхдийн ном зохиол унших, мөн сонгодог, орчин үеийн үндэсний болон дэлхийн уран зохиолтой танилцах нөхцөлийг сайжруулах;
- Оросын уламжлалт соёл, ёс суртахууны болон гэр бүлийн үнэт зүйлсийг сурталчлан таниулах ач холбогдол бүхий соёл урлагийн арга хэмжээг дэмжих;
- хүүхдийн оюун ухаан болон ёс суртахууны хөгжилд эерэг нөлөөтэй уран сайхны, баримтат, шинжлэх ухаан танин мэдэхүйн, сургалтын, хөдөлгөөнт кино хийхийг дэмжих;
- номын сангийн үйл ажиллагааг дэмжих;
- үндэсний соёл урлагийн бүтээл, ёс заншлыг хамгаалах, дэмжих нөхцөл бүрдүүлэх юм.

Биеийн хөгжил ба эрүүл мэндийн соёл

- өсвөр үеийг өөрийн эрүүл мэндэд хариуцлагатай анхаарах, эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлэх;
- хүүхэд бүр биеийн тамираар хичээллэх нөхцөл бүрдүүлэх, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, чийрэгжүүлэх, үүнд хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд нөхцөлд буй хүүхдийг мөн адил хамруулах, мөн биеийн тамирын хувьд дэд бүтцийг хөгжүүлэх, түүний үр ашигтай хэрэглээг хэвшүүлэх;

- аюулгүй амьдрах ухаанд сургах, муу зуршлаас сэргийлэх;
- хүүхдийн орчинд идэвхтэй, эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлэх, биеийн тамираар хичээллэх, зөв боловсон хооллох, эрүүл хоол хүнс хэрэглэх, нийтийг хамарсан биеийн тамирын үйл ажиллагааг дэлгэрүүлнэ.

Хөдөлмөрт сургах болон мэргэжлээ сонгоход

- хөдөлмөрт, хөдөлмөрлөж буй хүнд, хөдөлмөрлөсний үр дүнд хүрсэн ололт амжилтад хүндэтгэлтэй хандахад сургах;
- өөрт хамааралтай зүйлийг бие даан хийх чадвар эзэмшиүүлэх, гэрийн ажилд туслах, хөдөлмөрлөх хэрэгцээг ойлгуулах, ямарч ажил хөдөлмөрт чин сэтгэлээс хариуцлагатай, бүтээлч хандлагыг төлөвшүүлэх;
- бусадтай хамтарч ажиллахад идэвх санаачилгатай, хариуцлагатай, өөрт буй нөөц боломжкоо дайчлан ажиллах, хийсэн үйлдлийн утга учир, үр дагаврыг зөв үнэлэх чадварыг хөгжүүлэх;
- мэргэжлээ зөв сонгоход нөлөөлөх нийгмийн ач холбогдолтой үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог, мөн түүний мэргэжлээ сонгох сонголтыг дэмжих юм.

Экологитой харьцах харилцаа

- хүүхдийн экологитой соёлтой харьцах, эх нутгаа хайрлах хандлагыг төлөвшүүлэн хөгжүүлэх;
- экологийн талаарх ойлголтыг төлөвшүүлэх, байгаль орчныг хайрлан хамгаалах хүсэл тэмүүллийг хөгжүүлэх;
- байгалийн нөөц ба түүний зүй зохистой хэрэглээг хариуцлагатай ухамсарлах хандлагыг төлөвшүүлэх юм.

СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА МЕХАНИЗМ-ЫГ дараах 6 хүрээнд авч үзсэн.

Эрх зүйн хүрээнд

- холбооны, бус нутгийн, хотын хэмжээний хүүхдийн хүмүүжилтэй холбоотой хууль, эрх зүйг хүмүүжлийн хүрээнд баримтлах тэрийн бодлоготой уялдуулан боловсронгуй болгох, хэрэгжүүлэх;
- хүүхдийг сурган хүмүүжүүлэхэд гэр бүлийн онцгой үүрэг оролцоо болон эцэг эхийн нэн тэргүүний эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг сайжруулах, тэдний боловсролын системд хамааралтай эрх, ашиг сонирхлыг хамгаалах.

Үдирдлага, зохион байгуулалтын хүрээнд

- Стратегийг хэрэгжүүлэх 3 жилийн хугацаатай цогц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;

- хотын болон бүсийн түвшинд хүмүүжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын санаа санаачилтыг нэгтгэх;
- боловсролын системийн үйл ажиллагааны уялдаа холбоог үр дүнтэй зохицуулах;
- ерөнхий боловсрол, нэмэлт боловсролын байгууллагууд болон хүмүүжлийн чиг үүрэг бүхий бусад байгууллагуудын харилцаа холбоог дэмжих;
- гэр бүл, боловсролын байгууллага болон хүмүүжлийн чиг үүрэг бүхий бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- хүмүүжлийн хүрээний хамгийн сайн сурган хүмүүжүүлэх туршлагыг системтэй судалж, нэвтрүүлэх;
- боловсролын системд хүмүүжлийн үр нөлөөг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийн тогтолцоог бий болгох;
- ОХУ-ын болон хотын түвшний субъектүүдэд Стратегийн хэрэгжилтийн үр нөлөөг хянах ажлыг зохион байгуулах юм.

Боловсон хүчний хүрээнд

- багш, сурган хүмүүжүүлэгчийн мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах уур амьсгалыг бүрдүүлэх, үүнд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, дэмжин ажиллах;
- боловсон хүчний чадавх, багш, сурган хүмүүжүүлэгчийн ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжлийн системд мэргэжлийн стандартыг боловсруулж нэвтрүүлэх;
- эцэг эхчүүдийн сурган хүмүүжүүлэх ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- боловсролын системийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг орчин үетэй зохицуулан хөгжүүлэх, орчин үеийн нийгмийн хэрэгцээтэй уялдуулан салбарын боловсон хүчнийг мэргэжил дээшлүүлэх, дахин бэлтгэх юм.

Шинжлэх ухаан-арга зүйн хүрээнд

- хүүхдийг хүмүүжүүлэх болон нийгэмшүүлэх хүрээнд шинжлэх ухааны судалгаа хийх;
- гэр бүл болон гэр бүлийн хүмүүжлийн талаарх судалгааны ажлыг өргөжүүлэх;
- хүүхдийн хүмүүжил төлөвшилд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэтийн үр нөлөө болон байршлын талаар судалгаа хийх;
- Стратегийг хэрэгжүүлэх арга зүйг боловсруулах.

Санхүүжилтийн хүрээнд

- хүмүүжлийн боловсролыг хөгжүүлэхэд шаардлагатай нөөц, санхүүжилтээр хангах;

- холбооны, бүс нутгийн болон орон нутгийн төсвөөс хүмүүжлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, түүнчлэн төр хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалт татан оролцуулах, хөрөнгө оруулалтын эх үүсвэр буюу янз бүрийн сувгаар санхүүжүүлэх;
- хүмүүжүүлэх чиг үүрэг бүхий субъектүүдийн хувьд уян хатан системийг бий болгох, түүний үйл ажиллагааг үр бүтээлтэй зохион байгуулах юм.

Мэдээллийн хүрээнд

- хүмүүжлийн системд хамааралтай субъектүүдийн харилцаа холбоог хангахад орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологи, цахим мэдээллийн эх үүсвэр болон хэрэгслийг ашиглах;
- хүүхдийн эрх ашгийн төлөө боловсролын байгууллагуудын харилцаа холбоог хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хүмүүжилд зайндын сургалтын хэлбэрийг ашиглах;
- Стратегийг хэрэгжүүлэхэд холбооны болон бүс нутгийн хэмжээний хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг оролцуулах юм.

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮНХ

Стратегийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэх юм.

- олон нийтэд хүмүүжлийн ач холбогдлыг ойлгуулах;
- хувь хүний төлөвшил, улс дахь үндэстэн бүрийн үнэт зүйл, нийгмийн тогтвортой байдал болон эв нэгдлийг бэхжүүлэх;
- гэр бүлийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, эцэг эх байхын утга учрыг ухамсарлах, гэр бүлийн уламжлалт үнэ цэнийг сэргээх, өвлөн хадгалах, гэр бүлийн уламжлалт хүмүүжлийг бэхжүүлэх;
- төр, нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, орчин үеийн дэд бүтцийн хөгжлийг ашиглах, эрх зүйн зохицуулалт хийх, үр ашигтай удирдлагаар хангах, хүмүүжлийн үйл ажиллагаанд хамгийн сайн сурган хүмүүжүүлэх туршлагыг хэрэгжүүлэх замаар хүмүүжлийн системийг хөгжүүлэх;
- хүүхэд бүрийн хувьд тэдний амьдардаг орчин нөхцөл, амьжиргааны түвшин, эрүүл мэндийн байдлыг үл харгалzan чанартай хүмүүжил олгох, хүүхдийн хэрэгцээ шаардлагыг хангах, бүтээлч чадварыг хөгжүүлэх;
- амьдардаг орчин нөхцөл, нийгмийн байдал, амьжиргааны түвшинг үл харгалzan гоц авьяастай хүүхдийг дэмжих зорилгоор холбооны, бүсийн, хотын түвшний хөтөлбөрүүдийг боловсруулж үр дүнтэй хэрэгжүүлэх;
- хүмүүжлийн системийн боловсон хүчиний чадавхыг бэхжүүлэх, хөгжүүлэх;
- хүүхдийн орчинд зэрэг зан төлвийг хэвшүүлж, нийгэм дэх сөрөг үзэгдлийн үр дагаврыг бууруулах;
- хүүхэд залуучуудын хамтын үйл ажиллагааг байнга дэмжих, хүүхэд, эцэг эх, гэр бүлийг хамарсан нийгмийн ач холбогдолтой үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжих;
- хүмүүжлийн холбогдолтой шинжлэх ухааны судалгааны ач холбогдлыг нэмэгдүүлэх;

- мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах;
- Стратегийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх үзүүлэлт болон хяналтын тогтолцоог бий болгох юм.

Оросын хүмүүжлийн стратегийн гол онцлогуудын нэг хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдийн хүмүүжил төлөвшил, мэдлэг боловсрол, хөгжлийн асуудлыг тусгасан явдал юм. Түүнчлэн цагаач хүүхдийн хууль эрх зүй, нийгэм соёлын харилцааг хөгжүүлэхэд тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр заасан байна.

Ер нь хүүхэд хүмүүжүүлэх нь зөвхөн эцэг эх, боловсролын байгууллагын үүрэг биш, төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн холбоод гэх мэт нийгэм дэх бүх байгууллага, хүмүүсийн асуудал учраас тэдний үүрэг оролцоо, хамтын ажиллагааг хангах, дэмжих, хөгжүүлэх талаар энэхүү стратегид тодорхой тусгасан.

Стратегийн сул тал нь ёс суртахуун, хүмүүжил төлөвшлийн боловсролыг хүүхдэд хэдэн нааснаас, ямар түвшинд, хэрхэн олгох талаар дурдаагүй байна.

Ер нь улс орны төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтүүд нь нийгмийн ухамсын түвшинд ихээхэн нөлөө үзүүлдэг. Ийнхүү янз бүрийн нөлөөний улмаас тухайн нийгэм ёс суртахуун, хүмүүжлийн хямралд орж болзошгүй. Энэ нь өсвөр үеийн хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролд ноцтой нөлөө үзүүлдэг. Иймээс гэр булийн нийгэм, эдийн засгийн асуудал, мөн хүүхэд, залуусын ёс суртахуун, хүмүүжил төлөвшлийн асуудлыг бүх талаар дэмжиж, цаг үеэл олсон, зүй зохицой, оновчтой шийдвэр гаргаж хэрэгжүүлэх нь чухал юм.

2.2.БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

Казахстан Улсын хувьд хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны боловсролын тухай тусдаа хууль байхгүй, харин хөтөлбөр хэрэгжүүлдэг. Боловсролын тухай хуулийн 11-р зүйлд боловсролын системийн үргийг тодорхойлсон бөгөөд энд хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролын талаар дараах заалтуудыг тусгасан байна.⁷⁵ Үүнд:

- Үндэсний болон хүн төрөлхтний үнэт зүйлд, мөн шинжлэх ухаан, технологийн ололт амжилтад тулгуурлан хувь хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэхэд чиглэсэн чанартай боловсрол олгох нөхцөлийг бүрдүүлэх;
- хувь хүний бүтээлч чанар, оюуны болон биеийн чадварыг хөгжүүлэх, зөв эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, хувь хүнийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх замаар оюуны чадамжийг хөгжүүлэх;
- иргэний болон эх оронч үзэл, Эх орон – Бүгд Найрамдах Казахстан Улсыг хайлрах, төрийн бэлгэ тэмдэг болон төрийн хэлийг эрхэмлэх, үндэсний ёс заншлыг хүндэтгэх, Үндсэн хуульд харшилсан болон нийгмийн эсрэг аливаа үйлдлийг үл тэвчих чанаруудыг төлөвшүүлэх;
- Идэвх санаачилгатай хувь хүнийг төлөвшүүлэх, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын арга хэмжээнд оролцох, хувь хүний эрх ба үргийн талаарх ухамсартай үзэл бодлыг төлөвшүүлэх;

⁷⁵http://adilet.zan.kz/kaz/docs/Z070000319_Bоловсролын_тухай_хууль_11-р_зүйл

- Үндэсний болон дэлхийн соёлын ололттой танилцах, казах үндэсний болон улс дахь бусад үндэстний түүх, зан заншил, ёс журмын талаар судлах, мөн төрийн хэл, орос болон гадаад хэл сурах нөхцөл боломжуудыг бүрдүүлэх юм.

2010 оноос Сара Назарбаевын санаачилгаар хүүхэд, залуучуудад хүмүүжил, төлөвшил, ардын өв уламжлал, ёс суртахууны боловсрол олгох зорилгоор “Өөрийгөө таних” хөтөлбөрийг боловсролын системд нэвтрүүлэн хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөрийг анх 2001 оноост туршилтын шугамаар зарим боловсролын байгууллагад хэрэгжүүлсэн. Эхний ээлжинд цэцэрлэг, сургууль, коллеж, их дээд сургуулийг хамарсан нийт 184 байгууллагад 9 жил туршилтын шугамаар явуулж, сайн боловсруулсны үр дүнд улсын хэмжээнд боловсролын системд нэвтрүүлсэн.

Сара Назарбаев хөтөлбөрийг санаачлах болсон шалтгааныг “Нэг үе бид хүүхдийн хүмүүжлийн талаар ярихад компьютер эзэмшиж сурах, англи хэлээр ярьж сурах зэргийг хүүхэд хүмүүжүүлэх гол зорилго болгодог байв. Үүний үр дүнд зарим талаар сэтгэл эмзэглэмээр байдалд хүрсэн. Хүүхдүүд маань өсч том болоод сайн сайхныг саар муугаас ялгах чадваргүй, ойр дотно хүмүүсийнхээ жаргал зовлонг хуваалцах сэтгэлгүй нэгэн болж төлөвшиж байна. Хүүхэд багасаа эрүүл саруул, аз жартайт амьдралын зэрэгцээ амьдралын мэргэн ухаанд суралцах, бусдад туслахын сайн сайхныг ойлгодог байгаасай. Мөн өөрийгөө хэн болох, юуны төлөө амьдарч буй, юуны төлөө зүтгэж байгааг ойлгоосой гэж хүсдэг. Хүн бүр өөрийгөө нээж харуулах нь чухал юм.

Анх “Бөбек” төвийг байгуулахдаа өнчин хүүхдүүдэд туслах зорилгоор юуны түрүүнд эрүүл мэндийн байгууллагуудтай нягт холбоотой ажилласан. Тэднийг хувцас хунар, эм тариа, хоол хүнсээр хангах зорилготой ажилласан боловч энэ нь асуудлыг шийдэх сайн арга биш болохыг ойлгосон юм. Эцэст нь асуудлыг бий болгож буй шалтгаантай тэмцэхээр шийдсэн. Тиймээс боловсролын салбарт шинжлэх ухааны үндэстэй сурах бичгүүдийг зохиож, боловсролын системд нэвтрүүлэх шинэ хөтөлбөрийг өргөн барьж байна” хэмээн илэрхийлсэн.⁷⁶

Энд бидний гол алдаа хүүхдийн мэдлэг боловсролд түлхүү анхаараад хүмүүжлийн асуудлыг орхигдуулсан ба түүнээс үүсэх ирээдүйн үр дагаврыг онцлон хэлжээ. Хүнд ямар нэг зүйл өгч халамжаар тэтгэх биш, мэдлэг боловсролоор тэтгэж, хүний өөрт буй нөөц бололцоо, чадварыг хөгжүүлэх нь чухал юм.

Хөтөлбөрийн зорилго нь хүний дотоод ертөнцийг нээснээр зөв боловсон хүн болж төлөвшихэд дэмжлэг үзүүлэх, эрхэм дээд чанарт сургах, амьдрах чадвар болон боломжийг хөгжүүлэхэд оршино. Түүнчлэн бодол санаа, уг яриа, үйл хөдлөлөө зөв уялдуулах, ямар ч асуудлыг өөрийн болон бусдын туслын тулд оновчтой шийдэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, хүний эрхийг хүндэтгэх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

⁷⁶<http://bobek.kz>

“Өөрийгөө таних” хөтөлбөрийн гол санаа нь хүүхэд, залуучуудыг ёс суртахуунтай байх эрхэм чанараа хадгалахад сургаас гадна үндэстэн бүрийн, хүн бүрийн хамгийн сайн сайхан, гэгээлэг, ариун чанарыг улам хөгжүүлэхэд оршино.

Хөтөлбөрийг Казахстан Улсын боловсролын системд нэвтрүүлснээр “Өөрийгөө таних” хичээлийн хөтөлбөр бий болж, 2010 оны 9-р сарын 1-нээс улсын хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн. Хичээлийн агуулга нь хүний мөн чанарт тулгуурласан бөгөөд өөрийн эрхэм чанарыг мэдрэх, өөрийгөө хүндэтгэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээг ойлгуулан хүмүүжүүлэхийн зэрэгцээ амьдралд зүг чигээ зөв тодорхойлох, шийдвэр гаргах, хариуцлагаа ухамсарлах чадварыг хөгжүүлэхэд оршино. Цэцэрлэг, сургууль, коллежийн хувьд суралцагчдад зөв боловсон хүмүүжилт олгох нь нэн тэргүүний асуудлын нэг байдаг. Тийм учраас уг хичээл нь сургуулийн мэдлэгийн талбарт гол үүрэг гүйцэтгэж байна.

2010 оноос хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд сургууль, коллеж, сурган хүмүүжүүлэх ухааны их дээд сургуулиудад “Өөрийгөө таних” хичээл орж эхэлсэн.

Хөтөлбөрийг анх туршилтын журмаар хэрэгжүүлж эхлэхдээ Казахстаны бүс болгонд зарим боловсролын байгууллагад нэвтрүүлсэн. Тэдгээр байгууллагад сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад халуун дотно, итгэл дүүрэн, бүтээлч сэтгэлгээгээр хандах, таатай уур амьсгал бүрдүүлэх, эерэг арга барилаар ажиллах зэрэг шаардлагууд тавигдсан.

“Бөбек”⁷⁷ төв нь тэдгээр туршилтын байгууллагын үйл ажиллагааг дэмжин, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан. Өөрөөр хэлбэл, “Өөрийгөө таних” хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, сургалт зохион байгуулах, бүсийн, улсын, олон улсын хэмжээний боловсролын форум зохион байгуулах, эцэг эхчүүдийн сурган хүмүүжүүлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Энэ бүхний үр дүнд сурган хүмүүжүүлэх туршлага хуримтуулах, туршлага судлах, улмаар хамгийн тохиромжтой туршлагыг сонгож цаашид хэрэгжүүлэх ач холбогдолтой. Мөн туршлага солилцох зорилгоор мэргэжил арга зүйн хүрээнд «Самопознание.KZ» сэтгүүл гаргаж, www.ozin-azi-tanu.kz интернэт сайт ажиллуулж байна.

⁷⁷“Бөбек” нь Үндэсний шинжлэх ухаан-практик, боловсрол, эрүүл мэндийн төв бөгөөд 1995 онд Ерөнхийлөг Назарбаевын санаачилгаар байгуулгасан, 1997 оноос Сара Назарбаев тэргүүлж буй, Бүгд Найрамдах Казахстан Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

**Хүүхэд залууст хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролыг
хэдэн наснаас, ямар түвшинд, хэрхэн олгох талаар**

“Өөрийгөө таних” хөтөлбөрийг боловсролын бүх түвшний байгууллагад хэрэгжүүлдэг бөгөөд хүүхдийн насны онцлогт тохируулж “Өөрийгөө таних” хичээлийн хөтөлбөрийг боловсруулсан байна.

Сургуулийн өмнөх боловсролын түвшинд⁷⁸

“Өөрийгөө таних” болон “Бөбек” хөтөлбөрүүдийн хүрээнд 2009 оноос “Өөрийгөө таних” тусгай цэцэрлэгүүд ажиллаж эхэлсэн. Зорилго нь хүүхдийг бүх талаар цогц хөгжүүлэх бөгөөд хүүхдэд зориулсан аливаа үйл ажиллагаанд хүний үнэт зүйлсийн талаарх ойлголтыг ухаж ойлгуулах, хүүхдийн өөрийгөө таних болон өөрийн чадварыг мэдрэх ойлгох чадамжийг идэвхжүүлэн хөгжүүлэхэд оршино. Уг цэцэрлэг нь хүүхдэд мэдлэг боловсрол олгох, хүүхдийг хүмүүжүүлэх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах ба чийрэгжүүлэх зэрэг цогц сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг “Өөрийгөө таних” хөтөлбөртэй уялдуулан явуулах боломжоор бүрэн хангагдсан. Цэцэрлэгийн багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эх, хүүхдүүдэд чиглэсэн бүх үйл ажиллагааг “Өөрийгөө таних” хөтөлбөртэй уялдуулж явуулдаг.

Сургуулийн өмнөх насны хүүхдийг сурган хүмүүжүүлэх хичээлийн хөтөлбөрийн агуулга нь хүүхдийн байнгын өдөр тутам хийдэг гол үйлдэл буюу тоглох үйлдлээр дамжуулан мэдлэг боловсрол олгох, төлөвшүүлэн хүмүүжүүлэхэд чиглэсэн.

Түүнээс гадна хичээлийн хөтөлбөртэй уялдуулсан нэмэлт боловсрол олгох зорилгоор дараах хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны хүүхдэд англи хэлний мэдлэг олгох;
- “Сайхан сэтгэлт дельфин” усан сэлэлт;
- “Бяцхан гоц ухаантан” шатрын сургалт;
- “Az жаргалын жигүүр” театрны студи;
- “Тэмүүлэл” урлагийн студи;
- “Байгаль орчныг чин сэтгэлээсээ хайрла” экологийн клуб;
- “Бяцхан од судлаач” одон орны клуб зэрэг болно.

Цэцэрлэгт улсын тэргүүний шилдэг багш нар ажиллаж, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

“Өөрийгөө таних” цэцэрлэгт хүүхдийг зөв боловсон сурган хүмүүжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагаанд эцэг эхийн үүрэг, оролцоо нэн чухал үүрэгтэй. Эцэг эхтэй хамтран ажиллах зорилгоор “Нээлттэй хаалга” буюу эцэг эхэд зориулсан өдөрлөгийг тогтмол зохион байгуулдаг. Уг арга хэмжээ нь хүүхдүүд хайр халамжтай, сайхан сэтгэлтэй байх, мөн бусадтай харилцан ойлголцоход хэрхэн суралцсан хүмүүжиж буйг эцэг эхчүүдэд харуулах зорилготой.

⁷⁸<http://character.org/uploads>

“Өөрийгөө таних” хөтөлбөрийг сургуулийн өмнөх боловсролд хэрэгжүүлснээр хүүхдүүд хүnlэг зан чанарын тухай ойлголт авч, сайн сайхан үйл хийж суралын зэрэгцээ аливаа зүйлд ухамсартай хандаж суралын зорилтуудыг тодорхойлох, хүnlэг сонголт хийх, мөн хэлсэн үг болон үйлдэлдээ хариуцлагатай байхыг төлөвшүүлэхэд оршино.

Бага, дунд боловсролын түвшинд

Өөрийгөө таних замаар мэдлэг боловсрол олгохын зорилго нь суралцагчийн үнэт зүйл, зөв дадал зуршлыг хөгжүүлэх, өөртөө хандах болон хүрээлэн буй орчинтой, хүн төрөлхтөнтэй харьцах хандлагыг, улмаар хүnlэг зан чанар, нийгэмд ач тустай хандлагыг хэвшүүлэх, өөрийн сонирхлыг нээх, амьдралын зорилгыг тодорхойлох, хүnlэг сонголт хийх, мөн хэлсэн үг болон үйлдэлдээ хариуцлагатай байхыг төлөвшүүлэхэд оршино.

Хичээлийн агуулгыг хүний үнэт зүйлд үндэслэн боловсруулсан бөгөөд дараах агуулгын хүрээнд боловсрол олгох юм. Үнд:

- хайр сэтгэл, эрүүл мэнд, эрх чөлөө, аз жаргал, хөдөлмөр, бие болон сэтгэлийн уялдаа холбоо, амьдралын зорилго, хүний үүрэг хариуцлага, мөн санаа бодол, үг яриа, үйл хөдлөлийн уялдаа холбоог бүрэн гүйцэд ойлгуулах замаар өөрийгөө таних;
- гэр бүл, наиз нөхөд, хүндэтгэл, эрх тэгш байдал, халуун дотно харьцаа, харилцан ярилцах, харилцан ойлголцох, эв найрамдалтай байхын утга учрыг бүрэн гүйцэд ойлгуулах замаар бусдыг таних;
- байгаль орчин, эх орон, дэлхий ертөнц, амьдрал болон бүхэл ертөнцтэй уялдан зохицох, итгэл найдвар зэрэг ойлголтыг бүрэн гүйцэд авснаар хорвоо ертөнцийг таних;
- шударга үнэн, бүтээлч байдал, соёл урлаг, хүн төрөлхтний эв нэгдэл, “хүн төрөлхтөн эх дэлхий хэмээх нэгэн дээвэр дор хамт амьдардаг”-ийг бүрэн гүйцэд ойлгуулах замаар хүн төрөлхтний оюуны бүтээл, мэдлэг туршлагын талаар таньж мэдэх юм.

Бага дунд боловсролын түвшинд боловсруулсан хичээлийн хөтөлбөр нь хүний үнэт зүйлсийн тухай үндсэн ойлголтуудыг хөгжүүлэхэд тасралтгүй байдлыг хангах буюу дэс дараатай мэдлэг олгоход чиглэсэн.

Хичээлийн хөтөлбөр нь “өөрийгөө таних”, “нийгэм дэх хүн”, “хүн ба хүрээлэн буй орчин”, “хүн төрөлхтний оюуны бүтээл, мэдлэг туршлага” гэсэн 4 хэсгээс бүрддэг. Бага, дунд боловсролын сургуулиудад эдгээрийн нэршил өөр байж болох ч агуулгыг хэвээр хадгална.

“Өөрийгөө таних” буюу нэгдүгээр хэсэгт сурагчид “хүний дотоод ертөнц”, “хүnlэг сонголт хийх” зэрэг ойлголтуудыг эзэмшиж нээршил өөрийгөө таних үндсэн ойлголтыг авах, амьдралын зорилго, үүрэг хариуцлагын талаар ухамсарлаж бусдад туслахын утга учрыг ойлгож эхэлнэ.

“Нийгэм дэх хүн” буюу хоёрдугаар хэсгийн зорилго нь сурагчдын зан чанарыг төлөвшүүлэх хүмүүжүүлэх, түүний зэрэгцээ хөдөлмөрч, сахилга бат сайтай,

хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх, үг яриа болон үйл хөдлөл уялдаа холбоотой нэгдмэл байхын утга учрыг ойлгуулахад оршино. Энэ хэсгийн сэдвүүд сурагчдад бодол санаа үйлдлийн харилцан хамаарлыг ойлгуулах, мөн өөрийгөө таних, өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээг таниулахад чиглэсэн.

“Хүн ба хүрээлэн буй орчин” буюу гуравдугаар хэсгийн агуулга нь орчин тойронтой харьцахад ёс зүйн хэм хэмжээтэй байхын утга учрыг ойлгуулах, гэр бүлээ гэх хайр халамж, хамт олон, найз нөхөд, бусад хүмүүст хүндэтгэлтэй хандах, бусдад итгэх болон бусдын итгэлийг даах чадварыг төлөвшүүлэх зорилготой. Мөн сурагчид анги болон гэр орондоо тэгш эрх эдлэх, түүнчлэн халуун дулаан уур амьсгал бүрдүүлж, тэдний нийгмийн идэвхийг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарна.

“Хүн төрөлхтний оюуны бүтээл, мэдлэг туршилага” буюу дөрөөдүгээр хэсэг нь сурагчдад хүрээлэн буй ертөнцийн гоо сайхан, мөн бүх улс үндэстний урлаг соёлын өв уламжлалд шингэсэн үнэнч байдал, тусч чанар, хайр халамж, шударга ёс зэрэг зерэг сайхан үзэл санааг ухамсарлаж ойлгуулахыг зорьсон. Энэ хэсгийн сэдвүүд нь улс орнуудын урлаг соёл, түүх, ёс заншлыг хүндэтгэх, хүн төрөлхтний эв нэгдлийн талаар ойлгуулах зорилготой. Жишээ нь: агуу хүмүүсийн амьдралыг танилцуулснаар сурагчид хүн хүрээлэн буй орчинтойгоо хэрхэн зохицох талаарх ойлголтыг эзэмших юм.

“Өөрийгөө таних” хичээлийн давуу талуудын нэг нь түүнийг заах явцад сургалтын зарим онцлог арга барилыг хэрэглэдэгт оршино. Тухайлбал, хичээл орж эхлэх болон дуусах үед таатай сэтгэгдэл төрүүлэх, онцолж хэлбэл, “Зүрхнээс зүрхэнд” арга барил нь сурагчийн хичээлд оролцох идэвхийг нэмэгдүүлж, хамт олондоо өөрийгөө нээж харуулах болон хамт олноо эерэгээр хүлээж авах боломж бүрдүүлдэг.

Коллеж, их, дээд боловсролын түвшинд

“Өөрийгөө таних” хөтөлбөрийн хүрээнд түүхэнд нэрээ мөнхөлсөн эрдэмтэн мэргэдийн амьдрал, тэдний хэлсэн сургаал үсийн мөн чанарыг таниулах замаар суралцагчийн дотоод ертөнцийг нээхийг зорьдог. Ингэснээр нийгмийн өмнө хариуцлагаа ухамсарладаг, идэвхтэй, бүтээлч, хүнлэг, хөдөлмөрч хойч үеийг төлөвшүүлэх юм.

Жишээлбэл: “Есик” коллежид нийгмийн ухааны чиглэлээр суралцаж буй оюутнуудад ёс суртахуун, хүмүүжлийн боловсрол олгодог хичээлийн хөтөлбөрийг “Өөрийгөө таних” хөтөлбөрийн агуулгатай нийцүүлж боловсруулсан.⁷⁹

⁷⁹<http://www.balakkk.kz>

«Өзин-өзү тану» рухани-адамгершлік білім берудің жаңартылған бағдарламасын техникалық және кәсіптік білім беру мекемелерінде оқыту ерекшеліктері

Хичээлийн хөтөлбөрийн зорилго:

- Оюутнуудын дотоод ертөнцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Зан чанарыг нь төлөвшүүлэх, өөрөөр хэлбэл, хариуцлага, нэр төр, төлөв даруу зэрэг хүнлэг чанаруудыг төлөвшүүлэх;
- Сурч мэдсэн зүйлийг амьдралд хэрэгжүүлж хэвшүүлэх;
- Хүн болон хүрээлэн буй орчинд сайн үйл хийхийг сургаснаар ирээдүйд ажил мэргэжилдээ дуртай, бүтээлч боловсон хүчнийг бэлтгэх, тэдний мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зэрэг болно.

Хичээлийн хөтөлбөрт буй гол онцлог нь хүмүүжлийн асуудлыг мэдлэг боловсрол олгохоос чухалд тавьсан бөгөөд мэдлэг боловсролыг хүмүүжил дотор багтаасан. Өөрөөр хэлбэл, боловсрол олгох нь хүмүүжлийн нэг асуудал юм. Хичээлийн хөтөлбөрийн агуулга нь хүний үнэт зүйлсийг нээх зорилготой. Түүнчлэн хувь хүнийг төлөвшүүлэх бус төгс хүнийг хүмүүжүүлэх бөгөөд суралцагч бүрийн өөрт буй нөөц боломжийг нээх, хүнлэг чанар болон бүтээлч чанарыг төлөвшүүлэх, бодол санаа, уг яриа, үйл хөдлөл нь уялдаа холбоотой, зан төлөв тэгширсэн зөв боловсон хүнийг төлөвшүүлэн хүмүүжүүлэхэд оршино. Мөнхийн үнэт зүйлсийн талаар ойлгуулж, өөрийгөө таних, нийгэмд сайн сайхан ажиллаж амьдрах боломжийг нээх юм.

Суралцагчийн идэвхийг нэмэгдүүлэх, мэдлэг боловсрол болон хүмүүжил төлөвшлийг хүртээмжтэй олгох үүднээс сургалтын онцлог арга барилуудыг хэрэглэж байна. Үүнд:

- Сайхан сэтгэгдэл төрүүлэх: Хичээл орж эхлэх болон дуусахад сэтгэл ханамжтай байх, сэтгэл санаа тайван байх;
- Хичээлийн ишлэл: Зөв зүйтэй санал бодол, шүүмжлэлийн талаар авч үзэх;
- Яриа хэлэлцүүлэг өрнүүлэх: Хүмүүжлийн ач холбогдолтой сэдвээр яриа хийх;
- Бүтээлч ажил, багаар ажиллах: Ач холбогдолтой тоглоом тоглох, жүжигчилсэн тоглолт хийх, зураг зурах, шүлэг зохиох, эссе бичих, дуу зохиох гэх мэт;
- Хөгжимтэй болон хороор дуулах: Багаар ажиллаж сурх, эв нэгдэлтэй байх зэрэг болно.

Хичээлийн хөтөлбөр нь “Далайн гүнээс шүр, сувд түүх”, “Оюуны мэлмийг нээх”, “Сайн сайханд хөтлөх зам”, “Мэргэн ухаант хүн өөрийн ертөнцийг зөв тодорхойлно” гэсэн 4 хэсгээс бүрддэг.

“Далайн гүнээс шүр, сувд түүх” буюу нэгдүгээр хэсэгт ёс суртахуун, хүмүүжил, төлөвшлийн боловсролыг сүүт эрдэмтэн багш нарын мэдлэг туршлагад тулгуурлаж олгох ба суралцагчийн хүн төрөлхтний оюуны өв уламжлалд хүндэтгэлтэй хандах сэтгэлгээг хөгжүүлэх юм. Тухайлбал: Сократ, Платон, Аль-Фараби, Баласагун, Абай, Шакарим зэрэг агуу эрдэмтдийн түүх, амьдралын тоц ухаан, гайхамшигт мэдлэг боловсролыг судалснаар суралцагчийн идэвхийг өдөөх хөшүүрэг болохоос гадна үлгэр жишээ болно.

“Оюуны мэлмийг нээх” буюу хоёрдугаар хэсэг нь “Өөрийгөө таних” хичээлийн гол хэсэг болох хүн төрөлхтний мөнхийн үнэт зүйлийн талаар ойлголт олгоно. Үүнд: шударга үнэн, хайр халамж, зөв үйлдэл, эв найрамдал, тайван байдал, амар амгалан, хорон муу зүйл хийхгүй байх гэх мэт. Эдгээр ойлголтыг эзэмшсэнээр эрхэм дээд чанарыг төлөвшүүлэх юм.

“Сайн сайханд хөтлөх зам” буюу гуравдугаар хэсгийн агуулга нь хувь хүний ёс суртахуун, хүмүүжил төлөвшлийг хөгжүүлэх замаар зөв боловсон байх, амьдралаа ухамсартай төлөвлөхөд нөлөөлөх, дээд “Би” хүнийг мэдэрч ойлгуулахад оршино.

“Мэргэн ухаант хүн өөрийн ертөнцийг зөв тодорхойлно” буюу дөрөвдүгээр хэсэгт хүн төрөлхтний үнэт зүйлсээр үүсч, амьдралын туршлагаар өвлөгднөн ирсэн хүнлэг чанаруудын талаар авч үзнэ. Ёс суртахуун, хүмүүжилт төлөвшлөөр боловсорч, бодол санаа нь тэгшрэх бөгөөд ингэснээр түр үнэт зүйл болон мөнхийн үнэт зүйл, үнэн ба худлыг ялгах чадвартай болно. Мөн өөрөө амар амгаланг олж, бусдад сайн үйл хийх чадварыг олж авах юм.

“Өөрийгөө таних” хөтөлбөрт тусгасан чухал асуудлын нэг нь багш нарын үүрэг оролцоо юм. Ёс зүй, хүмүүжил төлөвшлийн боловсрол олгоход хүний эрхэм чанаруудыг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлж, хэвшүүлснээр үр дүнд хүрдэг. Үүнд багшийн үүрэг оролцоо чухал ач холбогдолтой. Багшийн хандлага зөв байвал сурагчид нь зөв төлөвшиг юм.

Бодол санаа, үйл хөдлөл хоорондоо уялдсан хүнлэг сайхан сэтгэлтэй, төгс хүнийг төлөвшүүлэх нь өнөөдрийн нийгэмд тулгарч буй гол асуудлын нэг юм.

“Өөрийгөө таних” хичээлийн давуу талуудын нэг нь түүнийг заах явцад сургалтын зарим онцлог арга барилыг хэрэглэдэгт оршино. Энэ нь хичээл орж эхлэх болон дуусах үед таатай сэтгэгдэл төрүүлэх, сэтгэл ханамж авах, улмаар сурагчийн хичээлд оролцох идэвхийг нэмэгдүүлж, хамт олондоо өөрийгөө нээж харуулах болон хамт олноо ээрэгээр хүлээж авах боломж бүрдүүлдэг.

Хөтөлбөрт тусгасан зайлшгүй чухал асуудлын нэг нь багш нарын үүрэг оролцоо болон мэдлэг боловсрол, сурган хүмүүжүүлэх арга зүйг хөгжүүлэхэд анхаарсан. Ёс зүй, хүмүүжил төлөвшлийн боловсрол олгоход хүний эрхэм чанаруудыг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлж, хэвшүүлснээр үр дүнд хүрдэг. Үүнд багшийн үүрэг оролцоо чухал ач холбогдолтой. Багшийн хандлага зөв байвал сурагчид нь зөв төлөвшиг юм.

“Өөрийгөө таних” хөтөлбөрийн сүл тал нь хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдийн асуудлыг онцлон тодорхойлоогүй байна.

Хөтөлбөрийн давуу тал нь түүнийг боловсруулахад хамгийн сайн мэдлэг боловсрол, авьяас чадвартай улсын шилдэг тэргүүний эрдэмтэн багш нарын бүрэлдэхүүн ажилласан тул амьдралд илүү ойр, сонирхол татахуйц бөгөөд боловсролын бүх түвшинд хичээл хэлбэрээр хэрэгжүүлдэг тул маш сайн, жигд хүртээмжтэй байна. Зөвхөн “Өөрийгөө таних” хичээлийн хөтөлбөрийг боловсруулаад зогсоогүй сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, сургалт зохион байгуулах, бүсийн, улсын, олон улсын хэмжээний боловсролын форум зохион байгуулах, багш болон эцэг эхчүүдийн сурган хүмүүжүүлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Энэ бүхнээс харахад хүүхдийн мэдлэг боловсролд түлхүү анхаарч, хүмүүжлийн асуудлыг орхигдуулснаар үр хойч маань сайн сайхныг саар муугаас ялгах чадваргүй, ойр дотно хүмүүсийнхээ жаргал зовлонг хуваалцах сэтгэлгүй нэгэн болж төлөвшихөд хүрээд байна. Энэ бол бидний гол алдаа юм.

Хүнд ямар нэг зүйл өгч халамжаар тэтгэх биш, мэдлэг боловсролоор тэтгэж, хүний өөрт буй нөөц бололцоо, чадварыг хөгжүүлэх нь чухал. Улс орны хөгжлийн үндэс суурь нь хүний хөгжил юм.

2.3.АНУ


АНУ-д иргэний болон зан суртахууны боловсрол нь дараах байдлаар үүсэн хөгжик ирсэн байна.

- 1937 он - Нийгмийн судлалын хөтөлбөр. Нью Йорк нь Нийгмийн судлалын хөтөлбөрийг хянан шалгах ажиллагаа явуулж, судалгааны үр дүнд нийгмийн судлалын хөтөлбөрт зан чанарыг хөгжүүлэхэд чиглэсэн хэсгийг оруулах шаардлагатай гэж дүгнэсэн.
- 1960-1970 он - Академик сургалтыг чухалчилсан үе. Сургууль академик амжилтыг нэгдүгээрт тавьж, зан суртахууны боловсрол хоцрогдсон. Зан суртахууны боловсролыг тусгай хөтөлбөрөөр бус багш олгоно гэж үзсэн.
- 1960-1980 онд Христийн сургуулийн хөдөлгөөн. Улсын ерөнхий боловсролын сургалтад академик буюу сурлагын амжилтыг онцлон ач холбогдол өгч, зан суртахууны боловсрол нь уналтад орсон. Христийн буюу шашны сургуулиуд нь зан суртахуун болон шашны сургалтад ач холбогдол өгөн, гүнзгийрүүлсэн сургалт явуулах болсноор элсэгчдийн тоо үлэмж нэмэгдсэн. Дээрхтэй холбоотойгоор улсын сургуулиудад зан суртахууны боловсролыг дахин зааж эхлэх болсон.
- 1968 он - Зан суртахууны боловсролын хөтөлбөр. Сан Антонио хот дахь Зан суртахууны боловсролын хүрээлэн нь “Зан суртахууны боловсролын хөтөлбөр”-ийг боловсруулсан. Тус хөтөлбөр нь АНУ даяар 60000 сургуульд хэрэгжсэн, өргөн хүрээг хамарсан анхны хөтөлбөр юм.
- 1981-1989 он - Ерөнхийлөгч Р.Рейганы үе. Ерөнхийлөгч Р.Рейган нь сургуулиар дамжуулан зан суртахууны боловсролыг хөгжүүлэхийн ач холбогдлыг онцолж, зан суртахууны боловсролын талаарх олон нийтийн мэдлэгийг сайжруулах, улсын сургуулиудад зан суртахууны хөтөлбөр хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж эхэлсэн.
- 1993-2001 он - Ерөнхийлөгч Б.Клинтоны үе. Ерөнхийлөгч Б.Клинтон сургуулийн зан суртахууны боловсролд нэн тэргүүний ач холбогдол өгч, улсын сургуулиудад зан суртахууны боловсролыг олгох, хөгжүүлэхэд олгодог санхүүгийн дэмжлэгийг гурав дахин нэмэгдүүлсэн.
- 2001-2009 он - Ерөнхийлөгч Ж.Бушийн үе. Ерөнхийлөгч Ж.Буш нь мөн адил аар зан суртахууны боловсролыг олгох, хөгжүүлэхэд олгодог санхүүгийн дэмжлэгийг гурав дахин нэмэгдүүлэхийг Конгрессоос хүссэн.
- 2017 он - Зан суртахууны боловсролын бие даасан хөтөлбөр. Өнөөгийн байдлаар Character Counts!, Heartwood Program, Center for the 4th and 5th R's зэрэг бие даасан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэж байна.

АНУ-ын хувьд ерөнхий боловсролын сургуулиудад Character education буюу Зан суртахууны боловсролын хичээлийг заавал судлах хичээлийн тоонд оруулсан болон хөхиүлэн дэмжихээр хуульчилсан 36 (18 ба 18) муж улс байгаа бол 7 муж улс нь хуулиар тогтоогоогүй боловч бусад баримт бичгийн хүрээнд дэмжихээр тогтоосон, 8 муж улс нь дээрхтэй холбоотой ямарваа нэгэн хууль эрх зүйн зохицуулалтгүй байна.

Хүснэгт 8. Зан суртахууны боловсролыг АНУ-д хуульчлан зохицуулсан байдал

Заавал судлахаар хуульчилсан (18)	Хөхиүлэн дэмжихээр хуульчилсан (18)	Бодлогын баримт бичгийн хүрээнд дэмжихээр заасан(7)	Тодорхой зохицуулалтгүй (8)
Alabama	Arizona	Connecticut	District of Columbia
Alaska	Colorado	Hawaii	Idaho
Arkansas	Delaware	Missouri	Massachusetts
California	Iowa	Montana	Nevada
Florida	Kansas	New Jersey	New Hampshire
Georgia	Louisiana	North Dakota	New Mexico
Illinois	Maine	Vermont	Wisconsin
Indiana	Maryland		Wyoming
Kentucky	Michigan		
Nebraska	Minnesota		
New York	Mississippi		
North Carolina	Ohio		
South Carolina	Oklahoma		
South Dakota	Oregon		
Tennessee	Pennsylvania		
Utah	Rhode Island		
Virginia	Texas		
West Virginia	Washington		



Хүснэгт 1. АНУ-ын муж улсуудад character education-той холбоотой зохицуулалттууд

№	Муж улсын нэр	Хувь	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт	
Д/д	Муж улсын нэр	Огноо	Хувь	Зохицуулалтын тойм агуулга	
1	Алабама	1995	1975 Code of Alabama, Section 16-6B-2(h); 1995 Accountability Law, Act 95-313	1975 оны Алабама мужийн хулиар К-12 ⁸⁰ (Цэцэрлэг, ЕБС)-д хамрагдасадаа өдөр бүр 10 минут зан суртахуунь боловсрол олгохор тогтоосон. 1995 оны Хариуцлагын тухай хулиар ЕБС-д зан суртахуунь боловсролын заавал судлахаар тогтоосон 2005 онос спортоор дамжуулан суралцах нь хөтөлбөрийн хэрээнд тус мужийн 4 дүгээр ангийн сурагч бүр зан суртахуун болон биийн тамирин хөхжлийн хөтөлбөрт хамрагдахаар тусгасан.	“Боловсролын асуудал хариуцсан төрийн зөвлөл болон орон нутгийн бүх удирдах зөвлөлөөс ... эр зорилтой, эх оронч, иргэний эрх үүрээг ухамсарласан, шударга өөрийтөө хүндэтгээдэг, нийжин сэтгэлтэй, хумуустэй хамтран ажиллах болон өөрийнээс удирдах чадвар, зөндэг, ерөвч, тэвчих үзэл, бүгээлч байдал, үр чадвар, туштай, цаг баримтандай, цэвэрч нямбай, хүрээлэн бүй орчно хүндэтгээдэг, тасвэр тэвэээртэй, үнэнч зэрэг зан чанаруудыг төлөвлүүлэхдээ чиглэсэн 10 минутаас дошигийн зааварчилгааг зан суртахууны боловсролын цэгтэй хөтөлбөрийн хүрээнд өдөрт бүх аниудад боловсролын хөрөгжүүнэ. (1995 оны Хариуцлагын тухай хууль),
2	Аляска	1998	Alaska Character Education (ACE) Partnership; Alaska Statute Section 14.33.200	(a) 2007 оны 7 дугаар сарын 1-ний дотор сургуулийн дүүрэг бүр аливаа сурчгийг дарамлах, айлган сурдууллах, эсхүл дээрэлхэйжийг хорилгосон бодлогоян баримт бичгийг баталсан байна. Сургуулийн дүүрэг бүр нь тус бодлогоо эзлэх, асран хамгаалаач, сурагч, сайн дүрүн ажилтан, сургуулийн ажилтуудад танилцуулна. (б) Бодлогоян баримт бичгийг тухайн дүүрэг тус бурийн шийдвэр гарах процесийн дагуу боловсролуулж, батлах ба эзлэх, асран хамгаалагч, сургуулийн ажилтан, сайн дүрүн ажилтан, сурагч, захирагч, олон нийтийн төлөвлөгөөний орлогийн хангах боломжор бурдлуулсэн байна. Бодлогоян баримт бичит зан чанарын зөргөгч УНЭТ зүйлс, учnd, соёлын, хувцасийн дагуу боловсролуулж, биеэ авч явах дарамт шахалт үзүүлэх, айлтан сурдуулэх, дээрэлхэйжийг хорилгосон бодлогояг дагаж мөрдэх үүрэг хариуцлагыг тусгасан байна. Түүнчлэн тус бодлогоян баримт бичит сургуулиас хөөх, гэмт хэргийн талаар орон нутгийн хувь сахижуулж, байгууллагад мэдээлэх зэрэг холбогдох шийтгэлийн зохицуулалтыг тусгасан. Сургуулийн ажилтан, сайн дүрвнхан, оюутнууд, сургуулийн захиргаа нь дээрхийг дагаж мөрднө.	

⁸⁰АНУ-ын ерөнхий боловсролын тогтолцоо нь К-12 буюу цэцэрлэгээс 5-р андийг Бага Цэцэрлэгээс 6-8 дугаар анд хүргэл Дунд (Middle) болон 9-12 ангилууд Ахлах (High) гэсэн дараалалттай байдаг. Энэ ерөнхий бүтэц АНУ-н нийт 50 муж, Вашингтон ДС хотод адил дагж мөрдэх болон сургуульд оюутан эзслүэх бүртэх, шалтгаалж эзлэх нь тухайн муж, улмаар тухайн хотын сургуулийн дүүрэг тус бүрт хариуцсан адилгүй байж болдог. Энээрээр хэлбэрэл, сургуулийн орлогтоо, зэрдэл, боловсон хүчиний бодлого, сургуульд хүхэд сургуулийн эрхтэй байна.

<i>Д/д</i>	<i>Муж улсын нэр</i>	<i>Хууль нэр</i>	<i>Огноо</i>	<i>Хууль тоогдоожижүүн тойм агуулга</i>	<i>Хуулийн заалт</i>
3	Арканзас	1997	Act 631 of 1997	1997 оны 631 дугаар хуульд заасны дагуу Арканзас Мужийн дургийн бүх сургуулиудад зан суртахуны боловсролын хичээлийг заавал судлахаар тогтоосон.	Ерөнхий Ассамблей нь зан суртахуны болон иргэний боловсрол, хумүүжил нь гол төлөв эцэх эхийн хариуцлагад хамаарах асуудал болохыг хулээн зөвшөөрч буй хэдий ч угзэр хязгаарладахгүй байна. Цаашлан Ерөнхий Ассамблей нь сургачдыг нийгмийн амьдралд балгажэхд улсын сургуулиудад зан суртахуны болон иргэний боловсролыг бэхжүүлэх шаардлагатай тодорхойлсон. Боловсролын яамны Ерөнхий боловсролын газрын захирал нь улсын болон мужийн хэмжээнд иргэний болон зан суртахуны боловсролын асуудлаар үйл ажиллагаа явуулж буй сект бус (шашины аж Урсгал бус) дэмжилэ, туслацаа талаарх мэдээллийг орон нутгийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн ёмнөх боловсролын байгууллагуудад гаргаж өгнө. Тус газрын захирал нь сект бус төсөл, хөгөлөр, затваруудын талаарх мэдээллийг тус муж дахь бүх сургуулиудад хүргэх Урагтай байна. ... Захирал нь хөр жил түгамэн энэхүү хуулийн хэрэгжилт, үр дүнгийн явцын тайлант гаргаж өгнө.
4	Калифорни	2000	California Education Code Section 233.5(a) [formerly named Section 44806] and Section 44790.3	Калифорни муж нь Боловсролын хульдааа зан суртахуны боловсрол опгын тусгаж, тухайн мужийн баги бүрт зан суртахуны боловсролын гарын авлагайар хангахаар заасан байна. 2007 оны тогтолцоо тус мужид жил бурийн 10 дугаар сарыг "Зан суртахуны боловсролын сар" болгон зарласан.	"Багш бүр сургачдад ёс суртахуун, үнэн, шудара ёс, эх оронч үзэл, Америкийн иргэний эх, Урал, бахархлын талаарх үнэн зөв ойлготыг өтөх, ба эрх төрш байдлаа, хүний нэр төр, үндэс зөв зетэй харилцааг хөгжүүлэх, гэрийн тэжээвэр амьтдыг энэрэх, энэрэнгүй, хүмүүнлэг хандах хандлагыг төлөвшүүлэх, сургачдын залхуурал, будалуулэг уг хэл хэрэглэх, худал хуурмагас хол байхыг зааж сургахыг эрмэлзэнэ. Гүннлэн батын сургачдын өөрсдийн потенциаллаа бурэн дуурэн ашиглах, албанаа аллагчлал бүхий хандлага, үйлдвэрс ангид, үзэн ядах үзэл дээр сууринсан хүчирхийлээс урьдчилсан сэргийлэхэд чиглэсэн орчныг буудуулжийт эрмэлзэнэ..." (Калифорни Боловсролын Кодын 233.5 (а) хэсэг) "Хууль тогтоох байгууллага нь Калифорнийн сургуулиудад (1-12-р ант), сургуулийн ёмнөх боловсрол ёс зүй, иргэний үр дүнтэй боловсролын хөтөлбөрийг хөгжүүлэх, хэрэгжүүлэхийг хөхилгэн дэмжих шаардлагатай тогтоожээ. (44790.3р хэсэг).

Д/д	Муж улсын нэр	Хууль тогтоомжийн нэр	Огноо	Хууль тооцоомжийн тойм агуулга	Хуулийн заалт
5	Флорида	1999	House Bill 365 of 1999 (Florida Statutes Sections 233.061 and 230.2316 amended)	Senate Bill 20E of 2002	<p>1998 онд Флоридагийн Хууль тогтоох байгууллага № бага сургуульд зан суртахууны боловсрол оптохоор тогтоосон. 1999 онд Хууль оруулсан намжил, вөрчөлөтвөр зан суртахууны боловсрол нь шашнаас ангид байж, анхаарал халамж, тэвчээр болон санаачилгатай байдал зэрэг зан чанарыг төлөвлүүлэхад чиглэнэ. Мен 1999 онд Флоридагийн Хуулийн 233.0619-р хэсэгт оруулсан нэмэлт, вөрчөлөтвөр сургууль зарвардахаас үрьчилсан сэргийлтийх, академик хоцродолт хууль эрхэзин болон зан суртахууны боловсрол оптохоор тусгасан байна. 2002 онд багалсан Сенатын Хуулиар 2004-2005 оны хичээлийн жилээс эхэн цэцэрлэгээс сургуулийн 1-12-р анид зан суртахууны төлөвшүүлэх, хөгжлийн хөтөлбөр хөрөнгөүүдээр зассан байна. 1999 онд байгуулагдсан Флорида Мужийн зан суртуулиудад дээмжтэй үзүүлээ.</p> <p>1998 онд иргэний боловсрол, бусдыг болон өөрийнхөө хүндтэй зэрэгт суурилсан нийт 27 зан чанарыг төлөвшүүлэхэд чиглэсэн зан суртахууны боловсролыг Жоржия мужийн бага, дунд, ахлах суртуулиудын сургалтын хөтөлбөрт оруулахаар хуульд тусгассан байна.</p>
6	Жоржия	1997	Title 20, Chapter 2, Article 6 of the Official Code of Georgia amended with 20-2-145		<p>“Мужийн боловсролын удирдах зөвлөл нь 1997-1998 хичээлийн жилд К-12 түвшинд зориулан зан суртахууны боловсролын цогц хөтөлбөрийг боловсруулна. Зан суртахууны боловсролын цогц хөтөлбөр нь сургачад дээр зорил, эх орчон үзэл, иргэншил, үнэнч шударга байдал, бусдыг хувьцаад, нийжин сэгэл, хамтран ажиллах, ёөрчийн хувьцаад, хянах, найрас, энээрэнгүй, тавчих üzэл, хичээнгүй, өгөөмөр, цаг баримтлах, цзвэрч нямбай, сэргээлэн цовоо, сургуулийн дэг журмыг сахих, хүрээлэн буй орчныг хувьцаад, Ертэнцийн эзнийг хүндэтгэх, бутгаалцыг байдал, спортын үр чадвар (sportsmanship), түүштэй зэрэг зан чанарыг хөгжлийн чиглэнэ. Орон нутгийн удирдах зөвлөлүүд нь дээрх хөтөлбөрийг аль чанги болон хугацаанд хэрэгжүүлэх бол Мужийн удирдах зөвлөлүүд нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлж төлөвлөөгөөг дэмжих Уяргатай байна. Энэхүү хуульд үл нийцэх бүх хувь болон хуулийн хэсгүүд нь хүчингүй болно.” (Official Code of Georgia, Annotated 20-2-145a in 2002)</p>

№	Муж улсын нэр	Хуль нэр	Хууль тооюомжийн огноо	Зохицуулалтын тойм агуулга		Хуулийн заалт	
				Улсын зорилтуудын тийрэл	Улсын зорилтуудын тийрэл		
7	Иллиной	1998	Illinois Children's Mental Health Act of 2003 (Public Act 93-0495; Senate Bill 1951 of 2003); House Bill 1336 of 2005 (amended language originally defined in 1998)	2005 онд Иллиной мужийн хуулиар бүх суртахуны зан тогтоосон. 2007 онд АНУ-ын Боловсролын зан суртахуны боловсрол шударга ёс, бусдыг хундэлэх, гэмт хөрийг буурулах хөтөлбөрөөс Иллиной мужийд зан суртахуны боловсролыг хөгжүүлэхэд төвлөшүүлэх стандартыг дээшгүүлэхийг зорино. (House Bill 1336 of 2005). Иллиной мужнь сургаачдын сурх чадвар, гэмт хэрэг, хүчирхийлэл Үйлдэх зэрэгт сэтээцийн эргул мэнд ихээж нөлөөлдгүй онцолж, Иллиной мужийн Боловсролын Удирдах зөвлөл Иллиной мужийн сургаалтын стандартад нийтийн болон сэтгэл хөдөллийн хөгжлийн стандартыг боловсруулж, хэрэгчүүлэхийг урэг болгов.” (Иллиной мужийн хуудайн сэтээцийн эргул мэндийн тухай хууль, 2003)	“Улсын сургуулийн багш бур зан суртахуны боловсролыг заах ба Үндэхэн хариуцлагатай, шударга зан, бусдыг халамжлах, итгэл даах чадвар, иргэншил зэрэйг заах замаар сургачдын шударга зан, нинжиж сэтгэл, шударга ёс, бусдыг хундэлэх, гэмт хөрийг буурулах ёс суртахуны эр зориг болон сайн зан чанарыг 500 000 ам.долларын грантыг 8 ахлах сургууль сурагчдын цаашдын амьдралц нь шаардлагах ур чадвар, туршлага оптох 4 жилийн туршилтын хөтөлбөр хөрөгчүүлэхэд оптосон.	“Улсын сургуулийн багш бур зан суртахуны боловсролыг заах ба Үндэхэн хариуцлагатай, шударга зан, бусдыг халамжлах, итгэл даах чадвар, иргэншил зэрэйг заах замаар сургачдын шударга зан, нинжиж сэтгэл, шударга ёс, бусдыг хундэлэх, гэмт хөрийг буурулах ёс суртахуны эр зориг болон сайн зан чанарыг 500 000 ам.долларын грантыг 8 ахлах сургууль сурагчдын цаашдын амьдралц нь шаардлагах ур чадвар, туршлага оптох 4 жилийн туршилтын хөтөлбөр хөрөгчүүлэхэд оптосон.	“Улсын сургуулийн багш бур зан суртахуны боловсролыг заах ба Үндэхэн хариуцлагатай, шударга зан, бусдыг халамжлах, итгэл даах чадвар, иргэншил зэрэйг заах замаар сургачдын шударга зан, нинжиж сэтгэл, шударга ёс, бусдыг хундэлэх, гэмт хөрийг буурулах ёс суртахуны эр зориг болон сайн зан чанарыг 500 000 ам.долларын грантыг 8 ахлах сургууль сурагчдын цаашдын амьдралц нь шаардлагах ур чадвар, туршлага оптох 4 жилийн туршилтын хөтөлбөр хөрөгчүүлэхэд оптосон.
8	Индиана	1937	Indiana Code 20-10.1-4-4 (Morals Instruction)	1995 онд Индиана мужийн Ерөнхий Ассамблей нь сайн иргэншилийн боловсрол олгоохор хуульчилсан ба Үндэхэн Индиана мужийн иргэнд шаардлагатай 13 зан чанарыг тодорхойлсон байна. Тус хууль нь 1937, 1975 онуудад, батлагдаж байсан хуулийн зохицуулалтад ойлготуудыг дахин баталгаажуулсан. Энэхүү хуулийг хөрөгчүүлэхийн түлд Индиана мужийн Боловсролын яам нь 2000 онд Андерсон их сургуультай хамтран зан чанарын хөгжлийн төвийг байгуулж, тус мужийн сургууль болон нийтийн бүлгүүдэд зан чанарын боловсрол оптоход нь дэмжилэг үзүүлж эхэлсэн байна. Мэн мужнь зан суртахуны боловсрол оптоход орцож буй бүхий п оролцогч талуудад зориулсан “Сайн иргэншилийн төлөөх туншууд” Эцэг эх, сургууль, орон нутаг, гарын авлагат, зэаврыг боловсруулсан байна.	Улсын болон хувийн сургуулийн 1-12-р ангид ерөнхий сурье хийзээлд багшахаа бүр хийзээлээ заахдаа үзүүлж шударга зан, ёс суртахуун, эзлэдэг зан, хууль сажин биелүүлэх, териин тут далбаа, АНУ-ын Үндэсэн хууль болон муж улсaa дээдлэх, гэр орон болон эцэг эхээ хундэлэх, үзүүн шударгаар хөдөлгүүрлэх болон шударга, сайн иргэнхий хөгжүүлэхэд, анхаарна. Мужийн захирагч (The state superintendent) нь дээрхтэй холбоотойгоор 1-12-р ангид, заах ерөнхий сурье хичээлүүдэд оруулах материал, зарчмыг боловсруулж, бэлтгэнэ.” (Indiana Code 20-10.1-4-4, Morals Instruction. Formerly: Act 1975, P.L.240, SEC.1).	Улсын болон хувийн сургуулийн 1-12-р ангид ерөнхий сурье хийзээлд багшахаа бүр хийзээлээ заахдаа үзүүлж шударга зан, ёс суртахуун, эзлэдэг зан, хууль сажин биелүүлэх, териин тут далбаа, АНУ-ын Үндэсэн хууль болон муж улсaa дээдлэх, гэр орон болон эцэг эхээ хундэлэх, үзүүн шударгаар хөдөлгүүрлэх болон шударга, сайн иргэнхий хөгжүүлэхэд, анхаарна. Мужийн захирагч (The state superintendent) нь дээрхтэй холбоотойгоор 1-12-р ангид, заах ерөнхий сурье хичээлүүдэд оруулах материал, зарчмыг боловсруулж, бэлтгэнэ.” (Indiana Code 20-10.1-4-4, Morals Instruction. Formerly: Act 1975, P.L.240, SEC.1).	Улсын болон хувийн сургуулийн 1-12-р ангид ерөнхий сурье хийзээлд багшахаа бүр хийзээлээ заахдаа үзүүлж шударга зан, ёс суртахуун, эзлэдэг зан, хууль сажин биелүүлэх, териин тут далбаа, АНУ-ын Үндэсэн хууль болон муж улсaa дээдлэх, гэр орон болон эцэг эхээ хундэлэх, үзүүн шударгаар хөдөлгүүрлэх болон шударга, сайн иргэнхий хөгжүүлэхэд, анхаарна. Мужийн захирагч (The state superintendent) нь дээрхтэй холбоотойгоор 1-12-р ангид, заах ерөнхий сурье хичээлүүдэд оруулах материал, зарчмыг боловсруулж, бэлтгэнэ.” (Indiana Code 20-10.1-4-4, Morals Instruction. Formerly: Act 1975, P.L.240, SEC.1).

<i>Д/д</i>	<i>Муж улсын нэр</i>	<i>Хульь нэр</i>	<i>Огноо</i>	<i>Хульь тоогоомжийн агуулга</i>	<i>Хуулийн заалт</i>
9	Кентукки	2000	House Bill 157 of 2000	2000 онд Кентуккийн багц хуулийн 162-р хэсгийн багталж, 156, 158-р хэсгэг нэмэгт, өөрчилгээний оруулж сургуулийн сургалтын хөгөлбөрт зан суртахууны боловсролын чигээл оруулахай тогтоосон Кентукки Дээрх хуулийг багалгнаар Кентукки мужийн Боловсролын Удирдаах зөвлөл нь сургуулиудад зан суртахууны боловсролыг опгожийн холбоогийн асуудлар заавар, зөвлөгөө өгч, сургалтын хөгөлбөртөө оруулахад нь дээмийнгээгүй зажилана.	“... зан суртахууны боловсрол гэдэг нь сургачдын бусдыг энээрх сэйтэл, иргэншил, зөлдэг, хундэтэл, харууллага, бие даан ажиллах чадвар зэрэг сургачдад зээмшигүүблэг зохицын чанар, Уэт зүйлийн сургачилсан, тусгасан сургалтын хөгөлбөр, стратеги байж ба эцэг эх, багш, орон нутгийн иргэдийн үнэт зүйлсийг тусгаж, сургалцалын амьдроал сайжруулахад чилгэсэн байна.” (Chapter 162, Section 1 of KRS. New chapter created in House Bill 157 of 2000).
10	Небраска	1996	Nebraska Statutes, Chapter 79, Sections 725, 726, and 727	1927 онд Небраска муж нь зан суртахууны боловсрол дахь сургуулиудын гүйцэтгэх ширгийн тодорхойлон хувь тогтоомжийг анх багталсан. 1996 онд Унэнч шударга, ёс суртахуун, эндэг, дурам сахидал, төрийн туг далбаа, АНУ-ын Ундсан хууль болон Небраска мужийн Ундсан хуулийг дээдээрэх, гэр орон болон эзэг хундлэх, Унэнч шударгаар хөдөлмөрлөх болон шударга, сайн иргэнийг хөгжүүлэхэд чанаруудыг Небраскаийн хуулийн 79-725 д-тус мужийн ирэнд байвал зохицын чанаруудын хэмжэээр тодорхойлсон байна. Мэн хуульд Небраскагийн Боловсролын Комиссар нь тухайн муж дахь бүх K12 сургуулиудад зан суртахуунь боловсрол опгох талбар санал зөвлөмж гарах ба тус хуулийг хэрэгжүүлэгийг агивaa этгээд нь гэмт зөрчил үйлдсэн болно. (Небраска Мужийн зан суртахуунь боловсролын Удирдамжийн дараах хаягаар орж Унэнч УУ http://www.nic.state.ne.us/eribus/E2000/H091-2002.pdf)	Небраска мужийн улсын, хувийн, сум хийдийн дэргэдэх (parochial), эсхүл шашины боловсрол опгох (denominational) сургуульд багшилах батш нь үнэнч, шударга, ёс сургахуун, эндэг, хууль дурам сахиин биенгүүдэг төрийн туг далбаа, АНУ-ын Ундсан хууль болон Небраска мужийн Ундсан хуулийг дээдээрэх, гэр орон болон эзэг хундлэх, Унэнч шударгаар хөдөлмөрлөх болон шударга, сайн иргэнийг хөгжүүлэхэд шаардлагатай бусад зан чанарыг хөгжүүлжээд анхаарвна. (Nebbraska Statutes, Chapter 79, Section 725).

<i>Д/д</i>	<i>Муж улсын нэр</i>	<i>Хууль нэр</i>	<i>Огноо тоо</i>	<i>Зохицуулалтын тойм агуулга</i>	<i>Хуулийн залтт</i>
11	Нью Йорк	2000	Project SAVE (Safe Schools Against Violence in Education Act)	2000 онд Нью Йоркийн Ассамблей нь Боловсрол дахь хүчирхийлийн эсрэг Аюулгүй сургуулын тухай хувь (SAVE) хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн ба хөтөлбөрт сургуулын орчинд биеэ авч явах ёс зүйн дурэм, сургуулын аюулгүй хамтран ажиллаж, сургуулийн орчинд хүндэтэй хариуцлагыг дээдэлсэн орчныг буруулжээд зөлдэг найрсаг байдал, иргэншил, зан сурхахуны боловсролын хөтөлбөрийг боловсруулах ... дээрх нь сурагчдаад үнэнч, тэвчих үзэл, хувийн харилцлага, бусдыг хүндэтэх, хувь дурэм сахин билгүүлэх, зөлдэг нийтэмд хувь нэмэр оруулах, өөрсдийн зан чанарт зөргээр нөвлөлхөд чиглэгдэн байна. (Project SAVE, 2000).	Нью Йоркийн сургуулиуд нь хүнд хэцүү болон хүч хэрэглэж буй тохиолдлуудыг таслан зогсоох, зохицуулах цогц төлөвлөгөөт боловсруулж, орон нутагт гарч болзошлыг хүчирхийлийн эсрээдлийг бууруулах, урьдчилтан сэргийлэхэд орон нутгийн тунчлалтэй хамтран ажиллаж, сургуулийн орчинд хүндэтэй хариуцлагыг дээдэлсэн орчныг буруулжээд зөлдэг найрсаг байдал, иргэншил, зан сурхахуны боловсролын хөтөлбөрийг боловсруулах ... дээрх нь сурагчдаад үнэнч, тэвчих үзэл, хувийн харилцлага, бусдыг хүндэтэх, хувь дурэм сахин билгүүлэх, зөлдэг нийтэмд хувь нэмэр оруулах, өөрсдийн зан чанарт зөргээр нөвлөлхөд чиглэгдэн байна. (Project SAVE, 2000).
12	Хойд Каролина	2001	Student Citizen Act of 2001 (House Bill 195 of 2001)	Сургатыг иргэний тухай хуулийг 2001 (SL. 2001-363) онд Хойд Каролина мукийн хувь тоотох байгууллага баталсан ба орон нутгийн боловсролын удирдах зөвлөг бүр зан чанарын сургатын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхээр тогтоосон байна.	Сургатыг хичээлийн хөтөлбөрт оруулан дараах зан чанарыг хөгжүүлжээд чиглэсэн байна. Үндэл: эр зориг (бусад нь хийгүй байсан ч зөв зүйлийг хий эр зоригтой байх, бусдыг дагах бус өөрийн ухамраа дагах, хүнд хэчлүү боловуур дунгтай эзлийг хийхийг эрмэлзэх); эрүүл сэргээгээ/good judgement (зөв, зохистой зорилго соноож, чухал зүйлсийн эрэмбэ дарааг зөв тогтоох, үйлдлийнхээ үр дагаврын талаар бодож тунгаах, мэргэн ухааныг үндэслэн гаргах); шударга зан (бүх зүйлд үнэнч, илтэл даах чадвартай, шударга байх дотоод хүч чадалтай байх, шударга, нэр хүндтэй байх); нинжин сэргээл (бусдыг бодж, зөлдэг, тусч, бусыг ойлгох, бусдыг энэрч, нийүүлэх, нахэрлэх, өгөөмөр сэргээл, өөртэй нь хэрхэн харьцахыг хүсэж буй байдлаар бусадтай харьцах); туштай байх (хүнд хэцүүг үл харгалзан тавьсан зорилтдоо туштай байх, алдаа, дугтагал гаргасан тохиолдлыг тасвар тавчээртэй байж, үргэлжлүүж, дахин оропдох) ...” (The Student Citizen Act of 2001).

UH.MN
СУДАЛГААНЫ САН

Д/д	Муж улсын нэр	Хууль нэр	Огноо тооогоомжийн	Хууль зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт
13	Өмнөд Каролина	2000	South Carolina Code, Section 59-17-135 (Amended from 1976 Code)	1996 онд мужийн Боловсролын яам нь зан чанарын урт хугацааны хөтөлбөр боловсрууллах, дэд бүтцийг бий болгоход 4 жилийн хугацаатай буцалтугийг тэтгэлэг авсан ба 2000 онд Өмнөд Каролина мужийн Ерөнхий Ассамблей Нь Гэр бүлт-хүндэлэлийн тухай хуулийг баталж, Боловсролын яаманд зан сурхахуны хөтөлбөрт зориулан 265,000 амдоллар оптосон байна. Хуульд засанс дагуу сургууль бур зан чанарын боловсролын хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөр болон түүний хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэж байхаар тусгасан. Өмнөд Каролинагийн Боловсрол болон эдийн засийн хөгжлийн тухай хуулиар Өмнөд Каролинагийн хуулийн 59-17-135-д нэмэлт, өөрчлөлт оруулсан зан сурхахуны болгосронд тусгавал зохиц 24 зан чанарын тогтоосон байна.	Муж улсын сургуулийн итгээмжэтийн зөвлөл бүр нь зан сурхахуны боловсролын асуудлаар бодлого боловсруулж, тус бодлогын чадсан дээр хэрэгжүүлж буй зан сурхахуны боловсролын хөтөлбөр нь дараах зан чанаруудыг тусгасан байна. Үндсэн дээр хэрэгжүүлж чадвар, цэвэрч бусдыг хүндлэх, үнэч, өөрийн төидэгээд чадвар, цэвэрч нямыдай, эзлдэг бусадтай хамтран ажиллах, иргэншил, эх оронч узэл, эр зорил, шударга, нинжин сэйтэл, өөрийгөө хүндлэх, энэрах, хичээнгүй, ажил хөдөлмөрийн ёс зүй, хичээл сургалтын зөв дадал зурашил, өгөөмөр, цаг баримталаа; урам зорилтой, тэвчээрэй, спортын үр чадвар (sportsmanship) ба сайн үйл хэрэг зэрэг байна. Сургуулийн үйлдээрд зөвлөхүүд нь зан сурхахуны боловсролын бодлого, хөтөлбөр боловсруулахдаа нийгмийн булгуулдийн бүхийл төлөөлүүдийг оролцуулна. (South Carolina Code, Section 59-17-135)
14	Өмнөд Дакота	1997	South Dakota Legislative Statute, 13-33-6.1	2001 онд Өмнөд Дакотагийн Боловсролын яам нь зан сурхахуны боловсролын хөтөлбөр боловсруулахад холбооны грант хулээн авсан ба нийт 10 сургуулийн сонгон авч, түүшилтийн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн байна. Тэтгэлэг олгосон гол зорилго нь Өмнөд Дакотагийн хууль дүрэмд зассан чанаруудыг агуулсан сайн зан чанарын сургалтыг бий	Уйлдээрд байгууллага нь нэгээс дошигий, эсхүл дөрвөөс дээш хичээлийн Уйлрайд өөрөөр тогтоосноос бусад тохиолдож мукийн улсын болон хувийн бух бага, дунд сургуулиудад зан чанарын сургалт явуулах ба сурагчдад иргэншил, эх оронч узэл, үнэнч байдал, хувийн сахилга бат, өөрийгөө хүндлэх, бэлгийн харьцаанд орохгүй байх, Өмнөд Дакота музид, үндээстэн ястнуудын оруулсан хувь нэмрийт хүндлэх, ахмад болон удирдлагыг хүндлэх зэрэгийн чухлыг ойлгуулахад чиглэгдэнэ. South Dakota Legislative Statute, 13-33-6.1

Д/д	Муж улсын нэр	Хууль нэр	Огноо тоо/тоомжийн	Хууль зохицоолын тойм агуулга	Хуулийн заалт
15	Тенесси	1985	Tennessee Code Annotated (TCA), Sections 49-6-1007 and 49-2-118;	1985 онд Тенессиийн Ассамблей TCA 49-6-1007-г баталсан ба хуульд заасны дагуу улсын бух сургуулиуд 1999 онд дээрх хууль намэлт, өвчрүүлт оруулж сургуулиуд нь хэрэгжүүлж буй зал чанарын хөтөлбөрийн талаарх мэдээллийг Боловсролын яам болон Ерөнхий Ассамблейд мэдээлж байхаар зассан. 1999 онд TCA 49-2-118-ийн баталсан ба угзэр 1-6-р ангид зан чанарын сургалтын агуулгад маргаан, зорилдлыг тусгахаар зохицуулж шийдвэрэлж асуудлыг тусгахаар зохицуулсан байна. 2004 онд House Bill 3456 (Public Chapter Number 919)-г баталсан ба зан чанарын боловсрол оплож буй арга зүй, сайн түршлагыг түгээхээр тогтгосон. 2008 онд House Bill 2790-г баталсан ба угзээр улсын бүх K12 сургуулиудад зан чанарын сургалтын агуулгад маргаан, зорилт хүч хэрэглэхгүй зорилт хуульчилсан.	Улсын бүх сургуулиудад сургач бүрт эзрэг хандлагыг төлөвшүүлэх, зэрэг Унэт зүйлийг удирдлага болгон иргэн болж төлөвшино. (T.C.A. 49-6-1007).
16	Юта	2004	Utah Code Annotated, Sections 53A-13-101.4 and 53A-13-109; HCR 7 of 2003; House Bill 339 of 2006	2002 онд Юта мужийн хууль тогтоох дагуу тус мэдээний улсын сургуулиудад АНУ-ын түх болон улс төрийн (терийн онол) хичээлийг үр дүнтэй явуулж буй эсэхийг тогтол хянавт тавих юм. 2003 онд дээрх хөтөлбөрийг иргэний харилцага, бусдын хундилээд чиглэсэн зан чанар, иргэний боловсролор ортуулсан байна. 2004 онд Ютийн Ерөнхий чуулганаар Utah Code, Section 53A-13-109-ийн баталсан байна. 2005 онд Юта мужийн хуаваны хичээлийн хөтөлбөрийн хүрээнд иргэний болон зан сургуулиуны боловсролыг Нэмж тусгасан байна.	"Нэгдсэн хичээлийн хөтөлбөрөөр сургачад шударга, ёс суртуяа, хүчэг, Уураг, наар тэр, хувь дурэм сахин билгүүлэх, Тусгаар тогтолын тухай бичиг болон Үндсэн хууль, Юта Муж улс болон түүний хөгжлийн түүхийг ойлгох хүндэтэх, эцэг эх, гэр орон, гар булээ хүндлэх, шудараар хөдөлмөрлөх хэрэццээ, үнэ цээж болон сайн, шудара хүн, иргэн болон төлөвшихэд шаардлагатай бусад ур чадвар, зорилт, зан чанаруудыг хөгжүүлэх, Үндсэн хулиар баталгаажсан, өмнөх чөлөөг цэвэрчээсээ хамгаалах уламжилж ирсэн эрх чөлөөг цашид хадгаж, замаарахаар тусгасан Иргэн болон зан суртуяа, боловсролыг энэ хэсэгт зассан ухадахуун, хүрээнд үр дүнтэй олгоход орон нутгийн сургуулийн удирдах зөвлөл, байна.

Д/д	Муж улсын нэр	Огноо	Хульь тоогтоомжийн нэр	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт		
17	Виржиния	1999	Code of Virginia, Sections 22.1-208.01, 22.1-201 and 22.1-202; House Bill 1498 of 2003 (Chapter 777)	2006 онд House Bill 339 нь иргээдийн болон зан суртахуны боловсролын талаар зорилгоо бүхий эвзэл, сургалтуудыг дэмжих зорилготой Югтайн Иргэний болон зан чанарын боловсролын хороог байгуулсан ба 2006-2007 оны хийээлийн жилд 50 000 ам.доллар оптосон байна.	Удирдлагатуд нь шаардлагатай сургалт, удирдамж, дэмжилгээд зөртээр хангаж болно. (Utah Code Annotated, Section 53A-13-109).	"Зан суртахуны боловсролын зорилго нь сурагчдын сурхын сайджууллах, сурягаа болон сахилга батын асуудлыг дээшүүлэхэд шаардлагатай зан чанар, ёс суртахуны хэм хэмжээг ухамсаршуулах, зан суртахуны боловсрол оплож, хамгийн төлөвлүүлэхэд оршино. Хөтөлбөр тус бурийг сурагч, эцэг эх, нийгмийн бүлгүүдийн оролцотойгоор боловсруулна. Заяж сургалт зохиж зан чанарын тоонд итгэл дахь чацвар, үзүүч шудараа байдал, мөрдөж явах "Алтан дурам"-ий дагас мөрдөх, хийдэгэлтийн хандах, хүлцэн тэвнич, зөндөг байх, хөдөлмөрч байх, хариуцлагатай хандах, эдийн засийн хувьд бусдаас хараат бус, өөрийгөө удирдах чадвартай, муу үйлдлийн үр дагаврыг ойлгодо, ялангуяа гадуурхажийн байх, бусдыг хамжих, энээрэн, нийгүүлсэх, бусдыг бодлог өгөөмөр зан, эх оронч узэл, АНУ-ын далбааг дээдлэх, Таннарагтаа үнэнч байх, нийтийн сайн сийхны төлөө санна тавих, хууль дээдлэх зэрэг орно."	(Code of Virginia, Section 22.1-208.01).

<i>Д/д</i>	<i>Муж улсын нэр</i>	<i>Хууль нэр</i>	<i>Огноо тоо</i>	<i>Хууль тоо тоим агуулга</i>	<i>Хуулийн заалт</i>
18	Баруун Виржиния	2001	1995 State School Act, House Bill 2208 of 2001 (amended West Virginia Code, Section 18-2-13); West Virginia Code, Section 18-2-9	1995 онд батлагдсан Улсын сургуулийн тухай хуулиар Мужийн боловсролын департамент нь долоо хоног бүр орох зан суртахуны зөрчилбес сэргийлэх боловсрол зөрчилбес урьчилсан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулна. 2001 онд Баруун Виржиниагийн хууль тогтоо байгууллага нь House Bill 2208 (attended West Virginia Code, Section 18-2-13)-г баталсан ба сургуулийн соёл, үйл ажиллагаа болон хичээлийн хөтөлбөр зэрэгт зан суртахуны боловсролын цогц хөтөлбөрийг оруулахаар Мужийн зөвлөлдүрүүлэх болгосон байна. Гучинчлан Баруун Виржиниагийн Кодексийн 18-2-9-р хэсэгт засансаар бүх сургачид иргэний АНУ-ын Үндсэн хуулийн, Үндэсний болон муж улсын төрийн тогтолцооны талаарх хичээлийг заавал судлахаар засан байна.	"Мужийн зөвлөл нь цэцэрэгзэс 12-р анги хүртэлх сургалт бүхий бүх сургуулиуд одоо мөрдөж буй хичээлийн хөтөлбөртөө зан суртахуны боловсролын агуултыг боловсруулж, туслахаар заасан. Суртуулиуд нь үнэнч шударга, иргэншил, бусадад санаа тавьдай, сурлаян амжилт, гарийн даалгавраа хийх, хичээлээ таслахгүй байх, маграан үүсгэхгүй байх, зайлсхийх, хүч хөрөглэхгүй байх, суртуулийн зөврөгжсөн борчтой орчин бурдулэхэд хувь нэмэр оруулах, хичээлд идэвхтэй орцою, үе тэнглихэндээ архи, тамхи, мансууруулах бодисыг хөрөглүүлэхгүй байх талаас нь нөлөө үзүүлэх, дээрх бодисын хөрөглэхгүй бийг дагаварын талаар мэдлэгтэй болгох, эрүүлийн болон бусдыг хүндтэх, өврөө ингэлтэй байдлыг нэмэгдүүлэх, мүү углээр дууриал, бооцоот толлоом зэргийн хор уршиг, өөрийн үйлдлийн дагаварын талаар мэддэг байх, шудараар хөдөлмөрлөх зэрэг зан чанаруудыг төлөвшүүлэхээр тусган замъдралд шаардлагатай ур чадвар, "харшууллагатай сургач", эсхүл бусад хөтөлбөрийн хүрээнд судална." (West Virginia Code, Section 18-2-13),

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Программа нравственно-духовного образования «Самопознание» в Республике Казахстан, <http://bobek.kzhi/minashaitan/nirajim/bissmillahi/rahmani/rahim>
- Білім туралы, Қазақстан Республикасының 2007 жылғы 27 шілдедегі № 319 Заны. http://adilet.zan.kz/kaz/docs/Z070000319_
- «ӨЗІН-ӨЗІ ТАНУ» рухани-адамгершілік білім берудің жаңартылған бағдарламасын техникалық және кәсіптік білім беру мекемелерінде оқыту ерекшеліктері (Гуманитарлық бағыттағы мамандықтар бойынша), Жошибаева Гульнара Сагатовна <http://www.balakkk.kz/>
- Рухани-адамгершілік білім беру бағдарламасының КР жалпы білім беру жүйесіне ендірілуін күрылымдық-функционалды талдау, <https://articlekz.com/kk/article/17616>
- http://www.character.org/uploads/PDFs/Misc_FAQs.pdf
- http://pure-oai.bham.ac.uk/ws/files/33442828/Character_Asia_1_.pdf
- https://www2.gwu.edu/~ccps/pop_moral.html
- <http://education.oxfordre.com/view/10.1093/acrefore/9780190264093.001.0001/acrefore-9780190264093-e-119>
- <https://www.tandfonline.com/doi/full/10.1080/03057240.2017.1285222>
- <https://labs.la.utexas.edu/adrg/files/2013/12/Lapsley-Yeager-MCE-Handbook-Chapter.pdf>
- <https://files.eric.ed.gov/fulltext/EJ1134548.pdf> 2011
- <https://files.eric.ed.gov/fulltext/EJ1095995.pdf>
- <http://character.org/more-resources/character-education-legislation/>
- <http://www.character.org/wp-content/uploads/What-States-Are-Doing.pdf>
- <http://www.ncpublicschools.org/docs/charterededucation/handbook/elements.pdf>
- <https://www.cde.ca.gov/ls/yd/ce/chartered.asp>
- <http://www.ncpublicschools.org/docs/charterededucation/handbook/content.pdf>
- <https://www.preceden.com/timelines/331129-history-of-character-education>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3

БҮЛЭГ

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ХҮНИЙ ЭРХИЙН ИНСТИТУЦИЙН ЗАГВАРУУД, ОМБУДСМЭНИЙ
ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР, ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

(Харьцуулсан судалгаа)

Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нэг. Дэлхийн улс орнуудын хүний эрхийн институцийн загвар

- 1.1. Хүний эрхийн комиссууд
- 1.2. Хүний эрхийн омбудсмэн институц
- 1.3. Холимог байгууллагууд
- 1.4. Зөвлөх чиг үүрэг бүхий хороод
- 1.5. Хүний эрхийн хүрээлэн болон төвүүд
- 1.6. Хүний эрхийн тодорхой асуудлаар дагнасан байгууллагууд

Хоёр. Омбудсмэний тогтолцоо, үйл ажиллагааны хэлбэр, эрх зүйн байдал

- 2.1. Омбудсмэний тухай ойлголт, түүхэн хөгжлийн тойм
- 2.2. Омбудсмэний тогтолцоо, эрх зүйн байдал
- 2.3. Омбудсмэний үйл ажиллагаа, хамрах хүрээ, бүрэн эрх
- 2.4. Омбудсмэний үйл ажиллагааны зохион байгуулалт, шийдвэр

АШИГЛАСАН МАТЕРИАЛ



УДИРТГАЛ

Судалгаанд дэлхийн улс орнуудын хүний эрхийг хамгаалах институцийн ерөнхий загвар болон омбудсмэний загвар, тэдгээрийн үүсэл, хөгжил, үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, бүтэц, чиг үүрэг, эрх зүйн байдлын талаар олон улсын байгууллагын судалгаа, холбогдох хууль эрх зүйн орчны хүрээнд судаллаа.

Судалгааны захиалгын дагуу энд хүний эрхийн омбудсмэний тухай дэлгэрүүлэн авч үзсэн болно.

СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ

Олон улсад хүний эрхийн байгууллага байгуулах, хүний эрхийг хамгаалах, энэ талаар хамтран ажиллах, дэмжих явдал улам бүр өсөн нэмэгдэж байна.

Дэлхийн улс орнуудад газарзүйн бүс, эрх зүйн тогтолцооны уламжлалаас хамааран хүний эрхийн байгууллагын янз бүрийн загвар, бүтэц үүсэн хөгжсөөр байна. Судалгаанаас үзэхэд Үндэсний хүний эрхийн комиссын загвар нь нийт улс орнуудын талаас дээш хувийг эзэлдэг бол омбудсмэн нь Зүүн Европ, Төв болон Өмнөд Америк, хамтын нийгэмлэгийн орнуудад түгээмэл хөгжсөн бөгөөд нийт улсуудын гуравны нэг хувийг эзэлдэг байна.

Омбудсмэний загвар нь хүний эрхийн комиссоос өмнө оршиж байсан урт хугацааны уламжлалтай. Хууль зүйн нэр томъёоны тайлбарт тодорхойлсноор⁸¹ “омбудсмэн” нь аливаа захиргааны байгууллагаас хүний эрхийг сахин хангаж байгаад хяналт, шалгалт хийхээр тусгайлан сонгогдсон албан тушаалтан ба байгууллагыг хэлдэг байна.

Энэ нь зарим улсад өөрөөр нэрлэгдэх бөгөөд ерөнхийлөгч, парламент, эсхүл засгийн газраас сонгогдох болон томилогддог.

Омбудсмэн тухайн асуудалд зуучлалын буюу албан ёсны мөрдөн шалгах ажиллагаанаас илүүтэйгээр асуудлыг богино хугацаанд шийдвэрлэхэд чиглэдэг онцлогтой. Ихэнх улс оронд омбудсмэн нь парламентын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, парламентад жил бүр ажлаа тайлагнадаг. Ингэснээр иргэдийн санал гомдол гардаг, иргэдийг бухимдуулж буй “зөрчилтэй газар” нийгмийн харилцаа хаана байгааг мэдээллэх хийгээд тэнд төрийн аппаратыг өөрчлөн сайжруулах шаардлагатайг мэдээлдэг ач холбогдолтой юм.

Түүнчлэн омбудсмэнний институцийг үйл ажиллагаагаа явуулж буй байдлаас нь хамааруулан:

1. Асуудлын мөрөөр арга хэмжээ авдаг;
2. Асуудлыг урьдчилан харж арга хэмжээ авдаг гэж хуваах нь бий.

⁸¹Эрх зүйн эх толь бичиг. С.Нарангэрэл. 2007 он. 352 дахь тал.

Омбудсмэн төрийн байгууллагуудын талаар гаргасан иргэний өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх үндсэн чиг үүрэгтэй. Иргэд төрийн байгууллагуудын хууль бус болон шударга бус байдлын талаар Омбудсмэнд гомдол гаргаснаар мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлдэг.

Омбудсмэндийн тогтолцоо улс орон бүрт харилцан адилгүй олон хэв шинж, хувилбартай байдаг байна. Энэхүү олон хувилбарт хэв шинжит байдал ба онцлог нь түүнийг сонгох процедурт нэгэн адил тусгалаа олсон байдаг. Тухайлбал: түүнийг томилдог хамгийн түгээмэл “сонгодог” хэлбэр нь парламентаар томилдог хэлбэр юм.

Омбудсмэндийн бүрэн эрхийн хугацаа нь гол төлөв парламентын нэгэн бүрэн эрхийн хугацаатай дүйцэх буюу 4-6 жил байна.


Ихэнх оронд Парламентын комисс болон тодорхой депутатуудын санал хүсэлт омбудсмэндийн хянан шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх үндэслэл болж өгдөг байна. Мөн ихэнхдээ Омбудсмэнүүд өөрсдийн санаачилгаар хянан шалгах үйл ажиллагаагаа эхлүүлдэг байна.

Омбудсмэндийн бүрэн эрх нь мэдээж түүний чиг үүргийн зорилтоос шалтгаална. Нийтлэг шаардлага нь гэвэл тухайн гомдолтой холбогдол бүхий аливаа шаардлагатай баримт бичгийг шаардаж гаргуулан авах, төрийн бусад хяналтын байгууллагад зарим тодорхой ажиллагаа зохион байгуулж хийхийг шаардах, шаардлагатай тохиолдолд омбудсмэндийн албанаас санхүүжүүлэн шаардлагатай мэргэжилтэнг хянан шалгах үйл ажиллагаандaa татан оролцуулах эрхтэй байдаг байна.

Мөн түүнчлэн омбудсмэн нь шалгасан санал гомдлынхоо дагуу тухайн асуудлаар холбогдох хууль тогтоомж, шийдвэрт оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар Парламент болон Засгийн газарт хандсан зөвлөмж гаргаж болдог байна. Үүний зэрэгцээ зарим оронд Омбудсмэн Үндсэн хуулийн шүүхэд шууд хандаж болдог жишиг ч бий.

Омбудсмэндийн парламентын болон олон нийтийн өндөр статус нь парламентын гишүүний халдашгүй байдалтай адил байх бөгөөд энэ мэт зарим төрлийн баталгаа болон түүний үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хуулиар баталгаажуулж өгсөн байдаг.

Дэлгэрэнгүйг судалгаанаас үзнэ үү.



СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нэг. ҮНДЭСНИЙ ХҮНИЙ ЭРХИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАГВАРУУД⁸²

Венийн Тунхаглал⁸³ болон үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу улс орнууд олон улсын хүний эрхийн жишигт нийцсэн хамгийн оновчтой тогтолцоог сонгох эрхтэй. Хэдийгээр Парисын зарчмуудаар⁸⁴ үндэсний хүний эрхийн байгууллагын чиг үүрэг, хариуцлагын жишигийг тогтоосон ч түүний бүтэц, загварыг тодорхойлж өгөөгүй байна. Дэлхийн улс орнуудад газарзүйн бүс, эрх зүйн тогтолцооны уламжлалаас хамааран хүний эрхийн байгууллагын янз бүрийн загвар, бүтэц үүсэн хөгжсөөр байна.

НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын албанаас 2010 онд гаргасан “Улс орнуудын хүний эрхийн байгууллагуудын тухай” судалгааны тайлан⁸⁵-гаас үзэхэд Үндэсний хүний эрхийн комиссын загвар нь нийт улс орнуудын талаас дээш хувийг эзэлдэг бол омбудсмэн нь Зүүн Европ, Төв болон Өмнөд Америк, хамтын нийгэмлэгийн орнуудад түгээмэл хөгжсөн бөгөөд нийт улсуудын гуравны нэг хувийг эзэлдэг байна. Хүний эрхийн байгууллага байгуулах, хүний эрхийг хамгаалах, энэ талаар хамтран ажиллах, дэмжих явдал улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь бодит зүйл юм. Тухайлбал: зарим орнууд нэгээр тогтохгүй хүний эрхийн асуудал хариуцсан байгууллагудтай болж байгааг дурдах хэрэгтэй. Зарим нь Үндсэн хуулийн хүрээнд өөр өөр бүс нутагт өөр өөр комисс ажиллахаар, зарим нь хүүхдийн, эмэгтэйчүүдийн зэрэг тухайлсан хүрээнд ажиллах байгууллага ч байдаг.

Хэдийгээр олон байгууллага олон хүрээнд ажиллаж байгаа боловч эрх хэмжээ, чиг үүргийн хувьд оновчтой, үндэсний ганц байгууллагын ажиллаж буй түвшинтэй ойролцоо байх тохиолдол ч байдаг. Иймд өргөн хүрээний бүрэн эрх, чиг үүрэгтэй хүний эрхийн комиссын загварыг шинээр үндэсний хүний эрхийн байгууллага байгуулах гэж буй болон хэд хэдэн үндэсний байгууллагатай улс оронд санал болгох нь илүү үр дүнтэйг тус тайлан⁸⁶ тэмдэглэсэн байна.

1.1. Хүний эрхийн комиссууд

Хүний эрхийн комиссын загвар нь дараах онцлог шинжтэй.

- Хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн бүрэн эрх бүхий тэрийн байгууллага;
- Шийдвэр гаргах түвшний бүрэн болон бүрэн бусаар ажилладаг олон тооны гишүүдээс бүрддэг;

⁸²National Human right institutions 2010-

https://www.ohchr.org/Documents/Publications/PTS-4Rev1-NHRI_en.pdf

⁸³ХҮНИЙ ЭРХИЙН ДЭЛХИЙН БАГА ХУРАЛ БА ВЕНИЙ ТУНХАГЛАЛ 1993 он.

<http://mn-nhrc.org/hrd/ViennaDeclarationProgrammeActionBrochure.pdf>

⁸⁴<https://nhri.ohchr.org/EN/AboutUs/Pages/ParisPrinciples.aspx>

⁸⁵National Human right institutions 2010-

https://www.ohchr.org/Documents/Publications/PTS-4Rev1- NHRI_en.pdf

⁸⁶Мөн тэнд

- Мөрдөн шалгах ажиллагаа гол чиг үүрэг нь болж байдаг;
- Хувь хүнээс гаргасан гомдлыг хүлээн авах боломжтой;
- Мөрдөн шалгах ажиллагаа явуулсны дунд зөвлөмж гаргах бүрэн эрхийг эдэлдэг.

Хүний эрхийн комисс нь ерөнхийдөө хэд хэдэн гишүүдтэй байх ба энэ нь Парисын зарчмын үндсэн хэм хэмжээ болох олон ургальч үзэл, олон тооны гишүүдийн санал бодол гэсэн зарчмыг хангаж өгдөг байна. Гишүүдийн хувьд байнгын болон түр хугацаанд ажиллах боломжтой.

Хүний эрхийн асуудлаар болон хувь хүний гомдлын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь асуудалд үр дүнтэйгээр хандах чухал ач холбогдолтой боловч тухайн асуудлаар шалгалт явуулах, гомдол гаргагчид хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлдэг зэргээс шалтгаалан комиссын үйл ажиллагааны зардал харьцангуй өндөр байдаг.

Зарим комиссууд зөвхөн тэгш эрхийн болон хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалтын эсрэг чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал: АНУ, Австрали, Канад, Шинэ Зеланд, Их Британи гэх мэт. Гэхдээ ихэнх тохиолдолд хүний эрхийн комиссууд өргөн хүрээнд хүний бүх л эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

1.2. Хүний эрхийн омбудсмэн институц

Омбудсмэний загварын хувьд хүний эрхийн комиссоос өмнө оршиж байсан урт хугацааны уламжлалтай. Омбудсмэн тухайн асуудалд зуучлалын буюу албан ёсны мөрдөн шалгах ажиллагаанаас илүүтэйгээр асуудлыг богино хугацаанд шийдвэрлэхэд чиглэдэг онцлогтой.

Үндэсний хүний эрхийн омбудсмэн институц (Испани хэлт улс орнуудад “defensor del pueblo”, эсхүл Зүүн Европ болон Төв Европын зарим газраар “улсын хамгаалагчид” гэж нэрлэгдэнэ) нь ерөнхийдөө “сонгодог” омбудсмэн албадынхтай төстэйгөөр нэг тэргүүнтэйгээр зохион байгуулагддаг. Хэдийгээр эдгээр институцууд нь тухайлан хүний эрхийг сурталчлан хамгаалдаг боловч төрийн удирдлага дахь сайн засаглалд үндсэндээ төдий л анхаардаггүй юм. Энэ бол Омбудсмэний өөрийнх нь нэр төр, шударга зан, манлайлал, тэрчлэн нийгэмд энэхүү албан тушаал оршин байх эрх мэдэлд маш ихээр тулгуурлаж байдаг загвар юм. “Омбудсмэн-төст” Үндэсний хүний эрхийн институцууд нь дараах ерөнхий онцлогтой байна:

- Хүний эрхийг хамгаалан, сурталчлах эрх бүхий төрийн институт;
- Ихэвчлэн шийдвэр гаргагч нэг тэргүүний (зарим нь орлогч нартай байх нь бий) удирдлагатай байна;
- Үндсэндээ хүний эрхийн асуудлыг авч үзэх эрх бүхий байдаг ч эмэгтэйчүүдийн эрх гэх зэрэг зөвхөн нэгэн эрхийг тусгайлан авч үзэж төрөлжих нь бас бий;

- Хүний эрхийн асуудлаар мөрдөн байцааж судлах ба ихэвчлэн хувь хүний санал гомдлыг хүлээн авна;
- Ерөнхийдөө санал зөвлөмж гаргахаар хязгаарлагдсан байдаг.

Сүүлийн үед зарим ийм төрлийн байгууллагууд нь санал зөвлөмжийг нь үл ойшоосон, эсхүл үгүйсгэсэн тохиолдолд шүүхэд, эсхүл тусгай шүүн таслах байгууллагад хандах эрхтэй болсон байна.

Омбудсмэнний институц нь санал зөвлөмж гаргах эрх мэдэлтэй, ихэнх нь санал гомдлыг шийдвэрлэх талаар илүү уян хатан бөгөөд хурдан байх ч талтай. Омбудсмэнний институц нь нэг тэргүүнтэй байдаг нь олонхын шаардлагыг биелүүлэхэд бэрхшээлтэй болгодог. Учир нь олонх, эсхүл давамгайлж буй бүлгийн нэг гишүүн нийгмийн бусад бүлгийн дунд байгууллагын нэр хүндийг унагах боломжтой гэж үздэг. Тиймээс зөвлөгч нарын хурал, эсхүл зөвлөл зэргийг байгуулах зэргээр энэ нөхцөл байдлаас зайлсхийх арга замууд бий.

1.3. Холимог байгууллагууд

“Холимог-(Hybrid)” үндэсний хүний эрхийн байгууллагууд нь олон эрх бүхий мандаттай улсын нэг байгууллагууд юм. Тэдгээр нь хүний эрхийн асуудлыг авч үзэх боловч удирдлагын асуудал, авлигат, эсхүл хүрээлэн буй орчны асуудлуудыг хөндөн үзэж болдог байна. Испани болон зарим Латин Америкийн орнуудын хууль, эрх зүйн хүрээнд хүний эрхийн асуудал болон уламжлалт омбудсмэнний үүрэг, үйл ажиллагааг хослуулан нэгтгэсэн нэгэн байгууллагыг үүсгэн байгуулдаг практик бий. Тэдгээрт “омбудсмэн төст” Үндэсний хүний эрхийн байгууллагуудын зарим онцлог шинжүүд бий. Тухайлбал: тэдгээр нь нэг тэргүүнтэй, зөвхөн санал зөвлөмж гаргах эрхтэй гэх мэт.

Холимог үндэсний хүний эрхийн байгууллагуудын давуу тал нь:

- ✓ хосолсон буюу нэгдмэл мандаттай байдаг. Тэр нь асуудлуудын тухайд “нэг цонхны” үйлчилгээ үзүүлнэ.
- ✓ хэд хэдэн асуудлыг хамарсан санал гомдлуудыг хамтын ажиллагаа илүү сайтайгаар судалж шийдвэрлэх хамтын ажиллагааны хөшүүрэгтэй байдаг.

Харин тэдний сул тал нь:

- ✓ олон янзын эрхийн мандатын хэрэгжилтийг үр дүнтэй хангахад хүндрэлтэй байдаг байна. Холимог буюу нэгдмэл эрхийн мандат нь хүний эрхийн үнэ цэнийг бууруулж болзошгүй талтай.

1.4. Зөвлөх чиг үүрэг бүхий хороод

Зөвлөх чиг үүрэг бүхий хороод нь нийгмийн бүхий л хэсгийн төлөөллийг багтаасан өргөн хүрээний гишүүнчлэлтэй байдаг. Эдгээр хороод нь хүний эрхийг хамгаалах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг хэдий ч тэр бүр хувь хүмүүсийн гаргасан өргөдөл, гомдлын мөрөөр мөрдлөг, шалгалт хийгээд байдаггүй.

Зөвлөх хороод нь хүний эрхийн гол чухал асуудлуудаар Засгийн газарт санал, зөвлөгөө өгч, хүний эрхийг зөрчсөн ноцтой асуудлуудын талаар мэдээлдэг. Эдгээр хороод нь хүний бүхий л эрхийн талаар өргөн дэлгэрэнгүй судалгаа явуулж, тухайн улс орондоо хэрэгжүүлэх тал дээр зөвлөгөө өгч ажилладаг байна. Зарим хороод нь үзүүлж буй үйлчилгээгээ үнэлдэг бол зарим нь үйл ажиллагаагаа өргөжүүлж гадаадын улс орнууд дахь ижил төрлийн чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах сонирхолтой байдаг байна. Зөвлөх хороод нь дараах онцлогуудтай. Тухайлбал:

- Олон тооны гишүүд нь нийгмийн бүхий л хэсгийг төлөөлдөг;
- Хүний эрхийг зөрчсөн асуудал бүрийг шийдвэрлээд байхгүй ч хүний эрхийн бүхий л асуудлаар өргөн хүрээний зөвлөгөө, мэдээлэл өгдөг;
- Хүний эрхийн талаар судалгаа явуулж, Засгийн газарт зөвлөгөө өтөхөд анхаарч ажилладаг байна.

Нийгмийн бүхий л хэсгийг багтаасан олон тооны гишүүнчлэлтэй тул гаргасан санал, зөвлөмж нь олон нийтийн дэмжлэгийг хүлээж, Засгийн газар болон ард иргэдийн аль алины итгэлийг даасан байгууллага байж чаддаг байна. Олон гишүүдтэй байх нь зардал өндөр байх хэдий ч хөнгөн хуумгай шийдвэр гаргахаас сэргийлдэг давуу талтай.

Хүний эрхийн асуудлаар зөвлөгөө өгөх, өргөн хүрээнд судалгаа явуулах тал дээр анхаарч ажилладаг нь тухайн асуудлаар нарийвчилсан дүгнэлтэд хүрч, илүү үр дүнд хүргэдэг. Эдгээр хороод нь иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхээсээ илүү онолын талын судалгаан дээр анхаарлаа хандуулж ажилладаг нь хүний эрхийг шууд хамгаалах ажлаас хөндийрүүлж байна гэсэн шүүмжлэл байдаг байна. Хувь хүний асуудлыг судалж, шийдвэрлэх чиг үүрэггүй ийм төрлийн хүний эрхийн хороодын үйл ажиллагааг үр дүн багатай гэж үзэх нь ч бий. Гэвч эдгээр хороод нь хүний эрхийн аливаа асуудлыг тодорхой цаг хугацаанд нөөц бололцоогоо дайчлан, өргөн хүрээнд системтэйгээр судалдаг нь нэг хүний асуудлыг бус нэлэнхүйд нь нийгэмд тулгараад буй асуудлыг шийдвэрлэхэд үр дүнгээ өгдөг байна. Ийм төрлийн хүний эрхийн төлөө байгууллагууд ихэвчлэн Европ, Франц хэлээр ярьдаг Африкийн улсуудад байдаг.

1.5. Хүний эрхийн хүрээлэн болон төвүүд

Хүний эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хүрээлэн болон төвүүд нь хүний эрхийн зөвлөх хороодтой адилаар нийгмийн бүхий л хэсгийн төлөөллийг багтаасан олон тооны гишүүдтэй байдаг. Зөвлөх хороодтой мөн адил иргэдийн өргөдөл гомдлыг судалж, шийдвэрлэх эрх мэдэл байхгүй. Зөвлөх хороодоос ялгаатай нь олон тооны гишүүд нь шийдвэр гаргахад бүгд оролцохгүй бөгөөд шийдвэрийг зөвхөн мэргэжлийн хүмүүст даатгадаг байна. Хүний эрхийн төвүүд нь хүний эрхийн аливаа асуудалтай холбоотой бодлогын хувилбарыг боловсруулж ажилладаг байна. Төвүүд нь мөн хүний эрхийн асуудлаар судалгаа явуулахад түлхүү анхаардаг.

1.6. Хүний эрхийн тодорхой асуудлаар дагнасан байгууллагууд

Хүний эрхийн тодорхой асуудлаар үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд түгээмэл байдаг. (*тухайлбал: жендерийн асуудал, хүүхэд болон угуул иргэдийн эрхийн тухай асуудал*)

Хүний эрхийг хамгаалах, хангах зорилго бүхий эдгээр байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, эрх мэдэл нь ойролцоо тул хамтарч ажиллавал илүү үр дүнд хүрэх юм. Олон улсын зохицуулах хороо болон тус хорооны Магадлан итгэмжлэх дэд хороо нь бүсийн хэмжээнд хүний эрхийн тодорхой асуудлаар үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг бүртгэн, хамтын ажиллагааг сайжруулах бодлого боловсруулж, санамж бичиг байгуулан, хувь хүнээс гаргасан өргөдөл гомдол, хүний эрхтэй холбоотой бусад асуудлуудаар эдгээр хүний эрхийн байгууллагууд хоорондоо чөлөөтэй мэдээлэл солилцох, хэрэгжилтийн талаар туршлага солилцох боломжоор хангадаг байна. Зарим улс орнуудад Хүний эрхийн байгууллага болон Омбудсмэний алба зэрэгцэн оршиж байгаа бөгөөд эдгээр байгууллагууд нь хамтын ажиллагаагаа сайжруулж, хүний эрх нь зөрчигдсөн, гомдол гаргасан этгээдийн асуудал шийдэгдэхгүй өнгөрөхөөс сэргийлэх нь зүйтэй.

2009 оны зургадугаар сард зохион байгуулагдсан Олон улсын омбудсмэний IX хуралдаан дээр НҮБ-ын Хүний эрхийн Дээд комисsar хэлэхдээ:

“Хүний эрхийг хамгаалах тодорхой эрх үүрэг хүлээгээгүй ч хүний эрхийг сахин хамгаалах үйлсэд Засгийн газрын хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих Омбудсмэний алба нь чухал үүрэгтэй болохыг тэмдэглэж байна.

Хүний эрхийг зөрчиж буй олон асуудлууд үнэн хэрэгтээ засаг, захиргааны хариуцлагагүй үйл ажиллагаа, хууль бус үйлдэл, захиргааны зөрчлөөс үүдэлтэй байдаг. Захиргааны хариуцлагын тухай хуулийн хэрэгжилтэд омбудсмэний тавих хяналт нь төрийн захиргааны албан хаагчидтай харьцахад иргээдийн эрхийг хамгаалах гол түлхүүр болдог билээ.” гэжээ. Хүний эрхийн асуудлаар үйл ажиллагаа явуулах бүрэн эрхтэй байгууллагууд нь газар нутгийн хувьд зйтай оршидог ч харилцаа холбоогоо сайжруулж, үндэсний хэмжээнд дуу хоолойгоо нэгтгэх боломжтой юм.

Хүний эрхийн үндэсний хороод нь тухайн улс олон улсын өмнө хүний эрхийн талаар хүлээсэн “боловсруулж бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх” үүргээ гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавьдаг. Засгийн газар нь хүний эрхийг хангах гол үүрэг хүлээсэн хэдий ч иргэний нийгмийн төлөөллүүдтэй харилцах, санал бодлоо солилцох тал дээр дутагдалтай байдаг. Үнэн хэрэгтээ хүний эрхийн тухай асуудал дээр тус байгууллагууд эсрэг байр суурь баримтлах нь бий. Засгийн газрын харьяа Хүний эрхийн үндэсний хороод нь иргэний нийгмийг Засгийн газартай холбох онцгой үүрэг хүлээдэг. Хүний эрхийн үндэсний хороод нь хүний үндсэн эрхээ эдлэх боломжоор хангах үүрэг хүлээдэг байна.

Хоёр. ОМБУДСМЭНИЙ ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР, ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

2.1. Омбудсмэний тухай ойлголт, түүхэн хөгжлийн тойм

Омбудсмэн гэдэг нь “ард түмний төлөөлөгч” гэсэн утгатай Швед үг юм. Эрх зүйн тайлбар толь болон бусад эх сурвалжид бичсэнээр, “янз бүрийн захиргааны байгууллагаас хүний эрхийг сахин хангаж байгаад хяналт шалгалт хийхээр тусгайлан сонгогдсон /томилогдсон/ албан тушаалтан, гадаадын зарим улсад хувь хүн ба нэгдэл”, мөн “нийтийн эрх ашгийг хохиросон үйл ажиллагаанд иргэдээс гаргасан гомдол, хүсэлтэд хариу өгөх, шинжлэн судлахаар төрөөс томилогдсон албан тушаалтан”⁸⁷, “төрийн байгууллага болон албан тушаалтны хүнд суртал, шударга бус үйл ажиллагааны талаар иргэдээс гаргасан гомдлыг магадлан шалгадаг хараат бус, олон нийтийн албан тушаалтан”⁸⁸ гэжээ.

Улс бүхэнд нэрлэх нэр томъёоны хувьд өөр байдаг ч явуулж буй үйл ажиллагааны хувьд бүгд төрийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэр, үйл ажиллагаа хүний эрхийг зөрчсөнтэй холбоотой бүхий л гомдлыг хариуцдаг байна.

Скандинавын улсуудад “Омбудсмэн”, Испани, Колумбид “ард түмний хамгаалагч”, Их Британид “парламентын Бүрэн эрхт элч”, Энэтхэгт “ардын элч” буюу локпал, Францад “зуучлагч”, Румынд “ард түмний өмгөөлөгч”, Нигерид “Олон нийтийн санал гомдлын хороо”, Австри зэрэг зарим оронд хяналтын талаарх үндсэн зарчмыг хадгалсан хамтын удирдлагын тогтолцоо ч болж өөрчлөгдөн хөгжсөн байдаг.

Нидерландын нэрт судлаач Дональд Роват (1965, 1985)-ын тодорхойлсноор дэлхий дээр омбудсмэний хоёр загвар байдаг ажээ.

- **Нэгдүгээр загвар** нь Швед (1809 онд анх үүссэн)-Финландын (1919 онд анх байгуулагдсан) буюу “сонгодог омбудсмэн”-ий загвар гэж нэрлэгдэнэ. Сонгодог загварын омбудсмэн нь зөвхөн төрийн төв, хот, орон нутгийн засаг захиргаа төдийгүй шүүхийн процедур, захиргааны асуудлуудыг хамарсан маш өргөн эрх үүрэгтэй. Тэрээр төрийн албан хаагчийг буруутай үйлдлийнх нь төлөө шийтгэх, шүүхэд шилжүүлж таслан шийтгэх шаардлагатай эсэхийг шийдэх эрхтэй байдаг ажээ. Хэдийгээр сонгодог загварын омбудсмэн энэ эрхээ жилд цөөн удаа эдэлдэг ч энэ нь тус албаны сүр хүч, ард түмний дундах нэр хүндэд их нөлөөтэй байдаг байна.
- **Хоёр дахь загвар** нь Дани улсын загвар (1953 онд үүссэн) хэмээн нэрлэгдэх ба шүүх эрх мэдэлгүй, зөвхөн төрийн захиргааны асуудлууд дээр төвлөрч ажилладаг. Өөрөөр хэлбэл, төрийн удирдлагын үйл явц дахь дутагдал доголдолд голлон анхаарна. Дани улсын энэхүү загвар дэлхийд хамгийн өргөн тархжээ.

⁸⁷Ж.Амарсанаяа англи-орос-герман-монгол олон улсын эрх зүйн толь

⁸⁸The New Encyclopaedia Britannica, 15-th edition, 1992, Volume8, page 946

Хүний эрхийг хамгаалах институт болох омбудсмэний институт нь анх 1809 онд Засаг захиргааны тухай Актын б дугаар зүйлийг үндэслэн байгуулагдсан. Энэхүү Актаар хууль, бусад шийдвэрийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих нэг юмуу хэд хэдэн омбудсмэнийг сонгох үүрэг Шведийн парламент Риксдагт оногдсон болно.

Хожим омбудсмэний институц өргөжин тэлж, эхэндээ хойт Европын орнуудад, тухайлбал: 1919 онд Финландад, 1954 онд Данид, 1960-1980-аад онд дэлхий нийтэд түгээмэл дэлгэрсэн хяналтын тогтолцоу болж хөгжсөн байна. Гэхдээ Данийн омбудсмэний тогтолцоо Шведийнхээс арай өөр бөгөөд дэлхий нийтэд түгэн тархсан омбудсмэний тогтолцооны суурь загвар болжээ. 1962 онд Шинэ Зеландад, 1967 онд Их Британи болон Канадын зарим мужид, 1969 онд Хавайн арлуудад, 1971 онд АНУ-ын мужуудад, Австралийн хойт, өмнөд мужид, 1973 онд Францад, 1976 онд Португалид, 1981 онд Испанид, 1982 онд Голландад, 1988 онд Польшид, 1989 Унгар тус тус байгуулагджээ. Харин сүүлийн жилүүдэд Филиппин, Тайланд, БНСУ зэрэг олон орнууд Омбудсмэнтэй болсон байна.

2.2. Омбудсмэний тогтолцоо, эрх зүйн байдал

Ихэнх улс оронд омбудсмэн нь парламентын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, парламентад жил бүр тайлагнадаг. Ингэснээр иргэдийн санал гомдол гардаг, иргэдийг бухимдуулж буй “зэрчилтэй газар” нийгмийн харилцаа хаана байгааг мэдээлэх хийгээд тэнд төрийн аппаратыг өөрчлөн сайжруулах шаардлагатайг мэдээлдээг ач холбогдолтой юм.

Бүтцийн хувьд маш уян хатан, амар хялбар өөрчлөгдөж байдаг. Өөрөөр хэлбэл, омбудсмэний тогтолцоо нь эрх зүйн ямар ч тогтолцоонд зохицдог өвөрмөц онцлогтой.

Улс орнуудад омбудсмэний тогтолцоо, түүний чиг үүрэг харилцан адилгүй байвч ерөнхийдөө агуулга нь адил гэж хэлж болно. Иргэдийн санал гомдлыг барагдуулах талаарх омбудсмэний нийтлэг чиг үүргийн талаар гэвэл:

1. Хяналтын үйл ажиллагаа;
2. Төр, иргэний хоорондын зөрчлийг шийдвэрлэхэд тус дэм болох үйл ажиллагаа (function of conflict-resolution);
3. Өөрчлөн байгуулах, шинэчлэх үйл ажиллагаа гэсэн үндсэн гурван чиглэлтэй байdag.

Тодруулбал, омбудсмэн хяналтын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага шиг биш, харин иргэдийн эрх зөрчигдэж байгаа талаар гаргасан гомдлын мөрөөр хяналт хийх болон зарим тохиолдолд омбудсмэний өөрийнх нь санаачилгаар хянан шалгах үйл ажиллагаа явуулдаг байна.

Үйл ажиллагааны хоёр дахь чиг үүргийн тухайд гэвэл тус дэм, нөлөө үзүүлэх гэдэг нь илүү оновчтой томьёолол байж болох талтай. Учир нь омбудсмэнний гаргасан шийдвэр нь тухайн зөрчлийг зайлшгүй шийдвэрлэх императив хүчинтэй баримт бичиг болдоггүй бөгөөд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд уг зөрчлийг хэрхэн арилгах талаар зөвлөмж болдог. Тиймээс энэ нь үнэн чанартаа шүүхийн шийдвэр шиг заавал биелүүлэх хүчинтэй биш, харин зөрчлийг арилгахад тус нөлөө үзүүлэх чиг үүрэгтэй гэж үзэж болох юм.

Гурав дахь чиг үүргийн тухайд тодруулахад омбудсмэнний үйл ажиллагааны өөрчлөх, шинэчлэх чиг үүрэг нь түүний арга ажиллагаатай салшгүй холбоотой гарч ирдэг өвөрмөц онцлог юм. Яагаад гэвэл омбудсмэнний нөлөө нь түүний эрх мэдэлд бус, харин парламент, олон нийтийн санаа бодол болон өөрийнх нь нэр хүндэд тулгуурладаг юм. Тиймээс түүний энэ чиг үүрэг маш чухал нөлөөтэй байдаг ажээ.

Омбудсмэнний үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийттэй нягт холбоотой явагддаг. Иймд омбудсмэнний үйл ажиллагаа нь иргэд, төрийн байгууллагуудын харилцааг илүү ойр дөт болгох, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, эрх баригчдын иргэдтэй харилцах харилцааг өөрчлөн сайжруулах үр нөлөөтэй хүчин зүйл болдог юм.

Омбудсмэнний тогтолцоо улс орон бүрт харилцан адилгүй олон хэв шинж, хувилбартай байдаг.

Омбудсмэнний тогтолцооны олон хувилбарт хэв шинжит байдал ба онцлог нь түүнийг сонгох процедурт нэгэн адил тусгалаа олдог байна. Түүнийг томилдог хамгийн түгээмэл “сонгодог” хэлбэр нь гэвэл парламентаар томилдог хэлбэр юм. Олон оронд албан тушаалтны жагсаалтад омбудсмэнийг Парламентын Омбудсмэн (Финланд), Фолькетингетс Омбудсмэн (Дани), Парламентын Бүрэн эрхт элч (Их Британи) зэргээр оруулсан байдаг. Омбудсмэний бүрэн эрхийн хугацаа нь гол төлөв парламентын нэгэн бүрэн эрхийн хугацаатай дүйцэх буюу 4-6 жил байдаг. Финланداد эхэндээ нэг жилийн хугацаатай сонгогддог байснаа 1933 оноос гурван жилээр, 1957 оноос 5 жилийн хугацаатай болжээ. Харин Испанид 5 жилийн хугацаагаар сонгодог бол Хорватад 8 жилийн хугацаагаар сонгодог байна.

Омбудсмэнний бүрэн эрхийн хугацааны талаарх харьцуулалт

Хугацаа	2 жил	3 жил	4 жил	5-6 жил	10 жил	Хязгаар байхгүй
Улс	Австрали	Финланд, Шинэ Зеланд, АНУ-ын зарим муж	Швед, Норвег, Дани, АНУ-ын зарим муж	Канадын болон АНУ-ын зарим муж, Израиль, Испани, ОХУ	Канадын Нью Брансуик муж	Их Британи, Хойд Ирланд

Зарим улс оронд омбудсмэнний томилдог процедур нь арай өөр, омбудсмэнний тогтолцоо нь гүйцэтгэх засаглалдаа илүү ойтсон шинжтэй байдаг. Жишээ

ны: Шинэ Зеландад омбудсмэнийг парламентын санал болгосноор генерал-губернатор томилдог ажээ. Европын орнуудаас гүйцэтгэх засаглалдаа илүү ойр байдаг нь Францын хэлбэр юм. Францад Сайд нарын Зөвлөлийн шийдвэрээр Медиаторыг (посредник буюу холбогч, зуучлагч) 6 жилийн хугацаагаар томилдог байна. Харин Суданаас бусад Африкийн ихэнх оронд омбудсмэнийг Засгийн газар, эсхүл Ерөнхийлөгч томилдог. Намибид мөн Ерөнхийлөгч томилдог байна.

Омбудсмэнийг томилох

Томилох байгууллага	Парламент	Ерөнхий сайдын санал болгосноор Парламент	Парламентын санал болгосноор Ерөнхийлөгч, Амбан захирагч, Хатан хаан	Амбан захирагч	Засгийн газар, Сайд нарын Зөвлөл
Улс	Швед, Финланд, Норвег, Дани, АНУ-ын зарим муж, Португали, Испани, ХБНГУ-ын Рейнальд-Пфальц, Австри, ОХУ, Хорват, Турк	Канадын Квебек муж	Их Британи, Хойд Ирланд, Шинэ Зеланд, Канадын зарим муж, Израиль	АНУ-ын зарим муж	Франц

Харин Туркийн “Хүний эрхийн хянан шалгах хороо”-г Үндэсний Их Хурлын /ҮИХ/ байнгын хорооны хэлбэрээр байгуулахаар дотоод дэгийн хуулиндаа тусгасан байдаг бөгөөд үйл ажиллагааных нь зарчмыг бие даасан хуулиар тусгайлан зохицуулдаг. Тус хорооны гишүүдийн тоог Туркийн ҮИХ-ын даргын дэргэдэх Зөвлөх хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаар тогтооно. Хорооны бүрэлдэхүүнийг улс төрийн намын бүлгүүд болон бие даагч нарыг бүх гишүүний тоонд харьцуулан гарах хувиар тооцон тохирохоор төлөөлнө.⁸⁹

Ихэнх орны Омбудсмэний тухай хуулиудад түүнийг томилоход тусгай шаардлага тавьдаггүй. Харин омбудсмэнээр ажиллахад нэлээдгүй хязгаарлалтыг хуульчилсан байдаг. Тухайлбал: зарим оронд омбудсмэн нь парламентын гишүүн байж болохгүй, улс төрийн, арилжааны чиглэлийн үйл ажиллагаа болон ямарваа нэг өөр ажил алба эрхлэхгүй байх гэх зэрэг хязгаарлалтай байдаг.

Омбудсмэний парламентын болон олон нийтийн өндөр статус нь парламентын гишүүний халдашгүй байдалтай адил зарим төрлийн баталгааг хуулиар зохицуулсан байдаг. Тухайлбал: Хорват Улсын Үндсэн хуулийн 93-р зүйлд: Омбудсперсон болон Хорват Улсын Парламентаас хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахаар сонгогдсон бусад төлөөлөгчид нь Хорват Улсын парламентын гишүүний адил халдашгүй эрх эдэлнэ гэж заасан байдаг. Түүнчлэн Омбудсмэний тухай хууль тогтоомжуудад түүний үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг баталгаажуулж өгсөн байдаг. Ялангуяа санхүүгийн болон улс төрийн талаар хараат бус байх зарчмыг онцлон авч үздэг

⁸⁹https://www.ombudsman.gov.tr/contents/files/Law%20no_%206328-revised-03-08-2018.pdf

байна. Тухайлбал: омбудсмэнд хэн ч тодорхой санал гомдлын мөрөөр шалгах, барагдуулахад ямарваа нэг зөвлөмж өгөх эрх байхгүй гэдгийг хуульчилж өгсөн байх жишээтэй. Тиймээс омбудсмэнүүд зөвхөн парламентад ажлаа хариуцаж тайлагнадаг байна. Засгийн газраас томилогддог омбудсмэнүүд Засгийн газартаа тайлагнана.

Харин хуульд омбудсмэннийг хугацаанаас нь өмнө албан тушаалаас нь чөлөөлөх, өөрийн хүснэгтээр огцуулах, цаашид үйл ажиллагаагаа эрхлэх боломжгүй гэж үзэх, гэмт хэрэг үйлдэх зэрэг зохицуулалтыг нэлээд сайн оруулж өгдөг байна.

2.3. Омбудсмэнний үйл ажиллагаа, хамрах хүрээ, бүрэн эрх

Омбудсмэнний үйл ажиллагааны хамрах хүрээ нь улс орнуудад харилцан адилгүй байдаг. Швед, Финланд зэрэг оронд анх омбудсмэнний тогтолцоо үүсч хөгжихдөө үйл ажиллагааны хүрээ нь зөвхөн гүйцэтгэх засаглалын засаг захиргааны байгууллагаар хязгаарлагдахгүй шүүх, хорих газар, цэргийн байгууллагыг хүртэл хамарч байсан. Тэгвэл өнөө үед ихэнх оронд омбудсмэн нь зөвхөн Засаг захиргааны төв болон төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны хүрээг хамардаг. Дани, Финланд, Канадын зэрэг зарим оронд омбудсмэнний хяналтын үйл ажиллагааны хүрээнд Засгийн газрын гишүүд, прокурорын байгууллага хамрагддаг. Их Британи, Франц, Шинэ Зеланд зэрэг оронд орон нутгийн засаг захиргааны удирдлагын үйл ажиллагааг хамарна. Их Британи, Испани зэрэг оронд улсын ерөнхий омбудсмэнний ажил бус нутгийн болон орон нутгийн омбудсмэнүүдийн үйл ажиллагаатай уялдаа холбоотой байдаг.

Омбудсмэнний тогтолцоо хөгжсөн улс орнуудад омбудсмэнний төрөлжсөн байгууллага байгуулгадан ажилладаг байна. Тухайлбал: Норвег, ХБНГУ, Финланд, Португали, Австрали Турк⁹⁰ зэрэг оронд парламентад хүний эрхийг төлөөлөх омбудсмэн, нийтийн эрх ашгийг хамгаалах омбудсмэн, эрүүл мэндийн омбудсмэн, батлан хамгаалахын омбудсмэн, орон нутгийн засаг захиргааны байгууллагын омбудсмэн, Израильд цэргийн талаар ирүүлсэн өргөдөл гомдол хариуцсан офицер, Канадын Үндэсний батлан хамгаалах департмент болон зэвсэгт хүчиний омбудсмэн, Шведэд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр гэх зэргээр төрөлжиж байна.

Ихэнх тохиолдолд омбудсмэнний хянан шалгах ажлын үндэслэл нь омбудсмэнний хамрах хүрээний байгууллага, албан тушаалтны гаргасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн шийдвэр, үйл ажиллагааны талаарх хувь хүний гомдол болдог. Эдгээр зөрчил нь харилцааны болоод үйл ажиллагааны нэлээд өргөн хүрээний үйлдлийг хамардаг байна. Жишээ нь: иргэдтэй бүдүүлэг харьцах, шударга бус, ялгавартай хандах, тэр бүү хэл Их Британид удирдлагын “муу” арга ажиллагаа ч иргэдийн гомдлын үндэс болдог байна.

⁹⁰<https://eujournal.org/index.php/esj/article/viewFile/6043/5820>

Мөн зарим улс оронд иргэдийн гомдлоос гадна омбудсмэн өөрийн санаачилгаар холбогдох хууль бусад актад тусгагдсаны дагуу үйл ажиллагаа явуулах эрхтэй байдаг. Жишээ нь: Туркийн Хүний эрхийн хяналтын хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор яам, агентлаг болон бусад төсвөөс санхүүждэг байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд, их сургуулиуд, бусад нийтийн удирдлагын байгууллагууд болон хувийн секторын байгууллагуудаас мэдээлэл хүсэх, тэдгээрт хяналт шалгалт хийх, холбогдох этгээдийг дуудан мэдээлэл авах бүрэн эрхтэй байхаас гадна шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалтын үеэр илэрсэн зөрчлийг үнэн зөв магадлах үүднээс тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнээс мэдээлэл авч болдог.

Омбудсмэн нь иргэдээс гаргасан гомдлын дагуу хяналтын үйл ажиллагаа явуулдаг ч зарим оронд гурав дахь этгээд болон хувийн байгууллагын гомдлыг ч хүлээн авч болдог байна.

Ихэнх улсад аливаа иргэн омбудсмэнд шууд хандах эрхтэй. Хүний эрх зөрчсөн догондол дутагдал ба эрх мэдлээ урвуулан ашиглах, алдаа зөрчилтэй, шударга бус шийдвэр гаргах, Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох, төрийн удирдлага ба түүний албан хаагчдыг олон нийтийн өмнө хариуцлага хүлээлгэдэг болгох үүрэгтэй байдаг. Уг зөрчил байдал илэрвэл омбудсмэн нь энэ тухай зохих байгууллага буюу албан тушаалтанд тэдгээрийг мэдэгдэж, түүнийг арилгахыг заана. Тэрээр татгалзсан тохиолдолд шүүн таслах ажиллагааны байгууллага буюу парламентад хандаж болно. Гэхдээ омбудсмэнээс Засгийн газар заавал биелүүлэх шийдвэрийг гаргах эрхгүй байдаг, харин өөрчлөлт оруулах талаар зөвлөмж өгдөг. Төрийн байгууллагуудыг харьялсан омбудсмэн эдгээр байгууллагуудад хамаарах өргөн эрхтэй байдаг. Зарим оронд шүүх, цагдаа, цэрэг зэргийг хамаардаг байхад зарим газар эдгээр нь омбудсмэнний харьялалд хамаардаггүй.

Улс орнуудад омбудсмэнний байгууллага гүйцэтгэх үүргээсээ хамааран бүрэн эрх нь янз бүр байх боловч дараах бүрэн эрхийн хувьд нийтлэг байна:

1. Төрийн байгууллагын удирдлагын хуульд нийцээгүй буюу шударга бус үйл ажиллагаа хийсэн эсэхийг шалгах;
 2. Шалгалтын явцад захиргаа зохисгүй үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол энэ байдлыг арилгах зөвлөмж өгөх;
 3. Онцгой тохиолдолд хууль тогтоох байгууллагад хандах эрхтэй.
- Омбудсмэн нь жилийн ажлын тайлангаа олон нийтэд мэдээлэх ба хууль тогтоох байгууллагад тайлагнадаг.⁹¹

Ихэнх оронд Парламентын комисс болон тодорхой депутатуудын санал хүсэлт омбудсмэнний хянан шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх үндэслэл болж өгдөг байна. Мөн ихэнхдээ омбудсмэнүүд өөрсдийн санаачилгаар хянан шалгах үйл ажиллагаагаа эхлүүлдэг.

⁹¹se2.dcaf.ch/.../Files/.../ipu_hb_mongolian.pdf

Болгарт анх 1998 онд Омбудсмэнийг байгуулах тухай хууль батлан гаргасан боловч 2005 онд анхны Омбудсмэнийг улсын болон мужийн гэсэн үйл ажиллагааны статустай байхаар сонгосон. Болгарт омбудсмэний талаар Үндсэн хуульдаа тусгаж өгсөн байх ба хуулийн 5 дугаар бүлэгт тус улсын парламентын хүний эрхийн омбудсмэн, үндэстний болон үндэстний цөөнхийн эрхийн парламентын омбудсмэний үйл ажиллагааны талаар зааж өгсөн.⁹²

Улс орнуудын хууль тогтоомжид гомдол гаргахад тавигдах шаардлагын талаар зарим зүйлийг оруулсан байдаг. Үүнд: нэргүй гомдлыг хүлээж авахгүй байх, гомдлыг бичгээр гаргах, (АНУ, Канадын зарим мужид утсаар гомдол гаргаж болдог), гомдолд татвар ногдуулахгүй байх гэх мэт.

Нөгөө талаар омбудсмэнд хандаж гаргасан гомдол нь тухайн асуудлаар урьд өмнө нь шүүхээр авч хэлэлцсэн, эсхүл шүүхээр хэлэлцэхээр хүлээгдэж байгаа асуудал, гомдол байж болохгүй. Ер нь эрхийг хамгаалах бусад аргатай давхардахгүй байхыг хуульчилсан байдаг. Ихэнхдээ хуулиар тухайн асуудлыг хянан авч үзэх цаг хугацааны талаар заалт оруулсан байдаг. Тухайлбал: эрх нь зөрчигдсөнөөс хойш 1-2 жилийн хугацаанд гомдлыг авч үзсэн байхаар заадаг. Омбудсмэнд гаргасан гомдол бүрийг авч үзээд байдаггүй. Гомдлыг авч үзэх, эсэхийг омбудсмэн өөрөө шийддэг. Түүний энэ шийдвэр эцсийн байх бөгөөд энэ талаар ямар нэг санал гомдлыг хүлээн авахгүй.

Их Британид гомдлыг хүлээн авах өвөрмөц дэгийг тогтоосон нь аливаа гомдол гаргагч этгээд түүнийгээ заавал парламентын гишүүнээр дамжуулан тавих ёстой ажээ. Энэ нь нэг талаас ирж буй гомдлын тоо хэмжээг бууруулан парламентын шүүлтүүрээр орох хүндрэлтэй боловч нөгөө талаар омбудсмэний анхаарлыг хүний эрхийг зөрчиж буй нэлээд түгээмэл, тархмал болон анхаарал татсан асуудалд хандуулах ач холбогдолтой гэж үздэг.

Омбудсмэний бүрэн эрх нь мэдээж түүний чиг үүргийн зорилтоос шалтгаална. Нийтлэг шаардлага нь гэвэл тухайн гомдолтой холбогдол бүхий аливаа шаардлагатай баримт бичгийг шаардан гаргуулж авах, төрийн бусад хяналтын байгууллагад зарим тодорхой ажиллагаа зохион байгуулж хийхийг шаардах, шаардлагатай тохиолдолд омбудсмэний албанаас санхүүжүүлэн шаардлагатай мэргэжилтэнг хянан шалгах үйл ажиллагаандaa татан оролцуулах эрхтэй байдаг байна.

Хянан шалгах явцдаа төрийн тодорхой албан тушаалтны үйл ажиллагаа нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй байдал илэрвэл хэргийг шүүхэд шилжүүлнэ. Харин тухайн хэрэгтэй холбогдох баримт бичгийг омбудсмэний цуглуулсан мэдээлэл, материал зөвхөн түүний мэдлийн байх бөгөөд шүүх тэдгээрийг хэргийн баримт болгон ашиглах боломжгүй юм.

⁹²<http://net.jogtar.hu/jr/gen/getdoc.cgi?docid=94900020.tv&dbnum=62>

2.4.Омбудсмэний үйл ажиллагааны зохион байгуулалт, шийдвэр

Ихэнх улс оронд омбудсмэн үйл ажиллагаагаа ганцаарчилсан байдлаар явуулдаггүй. Гол төлөв батлагдсан төсөвтөө багтаан алба, товчоо байгуулан ямар орон тоотой ажиллахаа тодорхойлон гаргаж, түүнийгээ өөрөө удирдан ажилладаг байна. Алба нь ихэвчлэн хэд хэдэн төрөлжсэн хэлтэс, байцаагчид болон шаардлагатай техник ажилтнуудаас бүрддэг. Гэхдээ тухайн орны хүн ам, хөгжил, уламжлал, гаргаж буй санал гомдлын тоо зэргээс шалтгаалж омбудсмэний албаны ажилтнуудын тоо харилцан адилгүй байдаг.

Зарим орны хуульд омбудсмэний албанд гаргасан санал гомдлыг ямар журмаар шийдвэрлэдэг дэгийн талаар товч оруулсан байдаг. Жишээ нь: Канадын Бритиш Колумб мужийн Омбудсмэний тухай Актын 14, 15 дугаар зүйлд зааснаар гаргасан санал гомдлыг шалган тогтоо явцад болон эцсийн байдлаар шийдвэр гаргахаас өмнө талуудын хооронд харилцан эвлэрэх үе шат байхаар заасан байдаг байна.

Омбудсмэн гаргасан санал гомдлын мөрөөр шалгаад ямарваа нэг заавал биелүүлэх эрхийн хүчинтэй шийдвэр гаргадаггүй өвөрмөц онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага болон холбогдох албан тушаалтны буруутай үйл ажиллагааны уршгаар иргэний эрх зөрчигдсөн болох нь тогтоогдсон тохиолдолд омбудсмэн нь захиргааны буруутай шийдвэрийг өөрчлөх, эсхүл уг буруутай шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг төлүүлэхийг шаардсан зөвлөмж гаргах эрхтэй байдаг. Нөгөө талаар бас захиргааны байгууллагаас гаргаж байгаа шийдвэрийг илүү энэрэнгүй, боловсронгуй болгох талаар арай өргөн хүрээтэй зөвлөмж ч гаргаж болдог байна.

Туркийн хувьд Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцтай Туркийн Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг нийцүүлэх зорилгоор шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тогтоож, эл зорилгоор хуулийн нэмэлт, өөрчлөлтийг санал болгох зэрэг бусад улсын адил нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна шаардлага гарвал гадаад орны хүний эрхийн зөрчлийг өөрийн санаачилгаар болон тухайн орны эрх бүхий байгууллагын хүсэлтээр хянан шалгадаг. Гарсан үр дүнг тухайн улсын парламентад шууд, эсхүл эрх бүхий байгууллагад хүргэдэг бөгөөд жил бүрийн тайландаа үйл ажиллагааны үр дүн, дотоодод болон гадаадад Хүний эрхийн хүндэтгэл, хэрэгжилтийн байдлын агуулгыг тусган бэлтгэдэг байна.

Мөн омбудсмэн нь шалгасан санал гомдлынхоо дагуу тухайн асуудлаар холбогдох хууль тогтоомж, шийдвэрт оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар Парламент болон Засгийн газарт хандсан зөвлөмж гаргаж болдог байна. Үүний зэрэгцээ зарим оронд омбудсмэн Үндсэн хуулийн шүүхэд шууд хандаж болдог жишиг ч бий. Харин омбудсмэний үйл ажиллагааны талаарх тайланг жил бүр парламентад бичгээр гаргаж тайлагнах асуудлыг заавал гүйцэтгэх ажлын нэг болгож хуульчилдаг байна.

Омбудсмэний үндсэн шинж нь олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх явдал бөгөөд манай улсад Хүний эрхийн үндэсний комиссыг адилтган үздэг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Эрх зүйн эх толь бичиг. С.Нарангэрэл. 2007 он. 352 дахь тал
- Ж.Амарсанаа англи-орос-герман-монгол олон улсын эрх зүйн толь
- СТ-09/217 “Мандатын эрх, УИХ-ын гишүүний бүрэн эрх, Байцаан шинжих түр хороо, түүний бүрэн эрх, Хүний эрхийн омбудсмэн, Авлигатай тэмцэх омбудсмэн, Төсвийн аудит”-ын тухай” харьцуулсан судалгаа
- СТ-18/221 “Парламентын хүний эрхийн хороод, тэдгээрийн үйл ажиллагааны талаарх гадаад орнуудын туршлага” харьцуулсан судалгаа
- National Human right institutions 2010- https://www.ohchr.org/Documents/Publications/PTS-4Rev1-NHRI_en.pdf
- The New Encyclopaedia Britannica, 15-th edition, 1992, Volume8, page 946
- <https://mn.wikipedia.org/wiki/Омбудсмен>
- https://www.ombudsman.gov.tr/contents/files/Law%20no_%206328-revised-03-08-2018.pdf
- <https://eujournal.org/index.php/esj/article/viewFile/6043/5820>
- se2.dcaf.ch/.../Files/.../ipu_hb_mongolian.pdf
- <http://net.jogtar.hu/jr/gen/getdoc.cgi?docid=94900020.tv&dbnum=62>



**ХУУЛЬ, ХҮЧНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИД БОЛОН
ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНУУДАД ХОЛБОГОДХ
ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГЫН
ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА: МОНГОЛ УЛС БОЛОН
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

Ц.Норовдондог (Ph.D), Г.Билгээ, Д.Жигваагүнсэл
О.Нарантуяа, Р.Нургүл, Р.Оргилмаа
Р.Өнөрсайхан, Ц.Элбээзаяа

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

НЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

- 1.1 Бүгд Найрамдах Армен улс: Мөрдөн шалгах тусгай албаны тухай
Бүгд Найрамдах Армен Улсын хууль (албан бус орчуулга)
- 1.2 Оросын Холбооны Улс
- 1.3 Монтенегро Улс
- 1.4 Бүгд Найрамдах Солонгос Улс
- 1.5 Америкийн Нэгдсэн Улс
- 1.6 Украин Улс

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ТУРШЛАГА

- 2.1 Монгол Улсын мөрдөн байцаах албаны үүсэл, хөгжил түүний
өөрчлөлт, шинэчлэл

АШИГЛАСАН МАТЕРИАЛ



СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ

Судалгааны захиалгын дагуу хууль, хүчний байгууллагын албан хаагчидтай холбоотой гэмт хэргийн шинжтэй мэдээллийг шалгах хараат бус, бие даасан байгууллага, тэдгээрийн чиг үүрэг, эрх хэмжээ, харьяаллын талаарх бусад орнуудын туршлагыг харьцуулан судлав. Судалгаанд БНАУ, ОХУ, БНСУ, АНУ, Украин, Монтенегро зэрэг улсуудыг хамруулснаас гадна Монгол Улсын туршлагыг тоймлон оруулав.

Монгол Улсын тухайд: Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх Мөрдөн байцаах алба нь УИХ-ын 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 47 дугаар тогтоолоор байгуулагдан ажиллаж байгаад 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан мөн өдрийн УИХ-ын 22 дугаар тогтоолоор татан буугдаж, харьяалал нь Авлигатай тэмцэх газарт шилжжээ.

Одоо **Авлигатай тэмцэх газарт хэрэг бүртгэх, мөрдөн байцаах чиг үүрэг бүхий Мөрдөн шалгах хэлтэс** ажилладаг бөгөөд тус хэлтэс нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.

Мөн түүнчлэн Цагдаагийн Ерөнхий газрын харьяанд Мөрдөн байцаах алба ажиллаж байна. Уг албаны **Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс нь** Улсын ерөнхий прокурорын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн A/67 дугаар тушаалаар Улсын ерөнхий прокурорын газраас шалгах харьяалал тогтоосон шүүгч, прокурор, Авилгатай тэмцэх газрын алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.⁹³

Бусад орнуудын тухайд: Энэхүү судалгаанд Армен, Орос, Монтенегро, Өмнөд Солонгос, Америк, Украин зэрэг улсуудын хувьд ижил чиг үүрэг бүхий мөрдөх албадын туршлагыг судалсан бөгөөд тэдгээрийн харьяалал, чиг үүрэг, эрх хэмжээ, эрх зүйн орчин болон бусад холбогдох туршлагын талаарх мэдээллийг оруулсан болно. Судалгаанд хамруулан орнуудаас Бүгд Найрамдах Армен Улсын Мөрдөн шалгах тусгай албаны үйл ажиллагааг бие даасан хуулиар тусгайлан зохицуулсан байх тул захиалагчид цэгтэй мэдээлэл өгөх үүднээс уг хуулийг бүрэн эхээр нь орчуулан хүргүүлж байна. (Албан бус орчуулга хавсаргав).

Дээрх орнуудыг засаглалын хувьд авч үзвэл ихэнх нь буюу Армен, Өмнөд Солонгос, Орос, Америк зэрэг улсууд ерөнхийлөгчийн засаглалтай, Монтенегро улс парламентын засаглалтай, Украин улс холимог засаглалтай байна.

⁹³<http://police.gov.mn/a/3456>

Мөрдөх албаны тухайд авч үзвэл дээрх улс орнуудад ижил чиг үүрэгтэй албад байх боловч харьялал, нэршил нь улс орон бүрт өөр өөр байна. Тухайлбал:

- Армен Улсад Мөрдөн шалгах тусгай алба нь **Засгийн газрын харьяанд**;
- ОХУ-д Мөрдөн байцаах хороо нь **ОХУ-ын Ерөнхийлөгчийн удирдлага дор**;
- Монтенегрод Улсын тусгай прокурорын алба нь **Прокурорын газрын дэргэд**;
- АНУ-д Мөрдөн шалгах алба нь **Хууль зүйн яамны харьяанд**;
- Украинд Улсын мөрдөн байцаах газар нь **Засгийн газрын дэргэд** ажилладаг байна.

Дээрх орнуудын Мөрдөх албадын эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл ихэнх нь тусгайлсан хуулиар үйл ажиллагаагаа зохицуулж байна. Тухайлбал:

- Армен Улсын Мөрдөн шалгах тусгай албаны үйл ажиллагааг **Мөрдөн шалгах тусгай албаны тухай хууль** (Закон о специальной следственной службе) болон Үндсэн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх процессийн тухай хууль, Иргэний хууль, Мөрдөн байцаах тусгай албаны ажлын албаны журам, олон улсын гэрээ хэлэлцээр, холбогдох бусад хууль тогтоомжуудаар;
- ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны үйл ажиллагааг **Мөрдөн байцаах хорооны тухай хууль** (Закон О Следственном комитете РФ) болон Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Эрүүгийн хууль, “ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, “ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны үйл ажиллагааны тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг зэрэг хууль тогтоомжуудаар;
- Монтенегро улсын хувьд Улсын тусгай прокурорын албаны үйл ажиллагааг **Монтенегро Улсын тусгай прокурорын албаны тухай хууль** (law on special public prosecutor's office of Montenegro) болон Улсын прокурорын үйлчилгээний тухай хуулиар;
- Украины Улсын мөрдөн байцаах газрын үйл ажиллагааг **Улсын мөрдөн байцаах газрын тухай хууль** (The Law of Ukraine “On the State Bureau of Investigation”), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудаар тус тус зохицуулна.
- АНУ-ын хувьд Хууль зүйн яамнаас баталсан Холбооны улсын эрх зүйн актуудын код (Code of Federal regulations)-ын 28 дугаар хэсгийн VI бүлгийн 600 (28 CFR Part 600)-д **Тусгай төлөөлөгчид холбогдох асуудлуудыг тус тус зохицуулсан байна.**

Судалгааны үр дүнг нэгтгэн, бусад улс орнуудын мөрдөх албадын туршлагыг тоймлон авч үзвэл:

АРМЕН УЛС:

Армен Улсын Мөрдөн шалгах тусгай алба нь 2007 онд батлагдсан **Мөрдөн шалгах тусгай албаны тухай хуулиар** (Закон о специальной следственной службе) байгуулагдсан бөгөөд хараат бус байдлаар бүрэн эрхээ хэрэгжүүлдэг

бие даасан статустай байгууллага байна. Энэ хуулиар Мөрдөн шалгах тусгай алба байгуулах болон үйл ажиллагаа явуулах нөхцөл, журам, мөн албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой харилцаа, албан тушаалын ангилал, зэрэглэл, эрх, үүрэг хариуцлага, эрх зүйн, болон нийгмийн баталгаа, албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой бусад харилцааг зохицуулна.

Бүтцийн хувьд Мөрдөн шалгах тусгай алба нь дараах хэлтсүүдээс бүрдэнэ.⁹⁴ Үүнд:

- Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг, албан тушаалтны гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (*Department of Investigation of Corruption, Organized and Official Crimes*);
- Эрүүдэн шүүх болон хүний эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (*Department of Investigation of Tortures and Crimes against Person*);
- Нийтлэг шинжтэй гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (*Department of Investigation of Crimes of General Character*) зэрэг болно.

Мөрдөн шалгах тусгай алба нь Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх процесийн тухай хуульд заасны дагуу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын удирдах албан тушаалтан болон төрийн тусгай албаны ажилтан албан тушаалаа урвуулан ашиглах, эсхүл биеэр үйлдсэн гэмт хэрэг, мөн сонгуулийн үйл явцтай холбоотой эрүүгийн гэмт хэргийг урьдчилан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулна.⁹⁵

Дээрх хуульд зааснаар хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын удирдах ажилтанд дараах албан тушаалтныг хамруулна.⁹⁶ Үүнд:

- Улсын Ерөнхийлөгч;
- Ерөнхий сайд,
- Шадар сайд;
- Парламентын гишүүд;
- Үндсэн хуулийн цэцийн тэргүүн болон гишүүд;
- Шүүхийн тэргүүн болон шүүгчид;
- Улсын Ерөнхийлөгчийн ажлын албаны дарга;
- Үндэсний Хурлын (парламент) ажлын албаны дарга;
- Засгийн газрын ажлын албаны дарга;
- Засгийн газрын сайдууд, дэд сайдууд;
- Засгийн газрын харьяа агентлагууд болон төрийн захирагааны төв байгууллагын дарга, орлогчид;
- Мужийн захирагч, тэдгээрийн орлогчид;
- Ереван хотын захирагч, түүний орлогчид;
- Армен Улсын Төрийн Хянан Шалгах Палатын зөвлөлийн дарга, гишүүд;
- Армен Улсын Төв банкны дарга, зөвлөлийн гишүүд;

⁹⁴<http://www.ccc.am/en/1428926241>

⁹⁵Мөрдөн байцаах тусгай албаны тухай хууль, 1 дүгээр бүлэг, 2.1 дүгээр зүйл <http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus>

⁹⁶Мөрдөн байцаах тусгай албаны тухай хууль, 1 дүгээр бүлэг, 4.2 дугаар зүйл <http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus>

- Армен Улсын зохицуулах хороодын дарга, гишүүд;
- Армен Улсын Сонгуулийн хорооны дарга, гишүүд;
- Армен Улсын Үндэсний Статистикийн хорооны дарга, орлогч дарга зэрэг болно.

Төрийн тусгай албаны ажилтанд дараах албан хаагчид орно.⁹⁷ Үүнд:

- Прокурор;
- Батлан хамгаалах салбар дахь төрөөс бүрэн эрх олгосон байгууллагад ажилладаг мөрдөгчид (следователи государственного уполномоченного органа в области обороны);
- Цагдаагийн албан хаагч (цэргийн цагдаа орохгүй);
- Үндэсний аюулгүй байдлын албан хаагч (хилийн цэрэг, зэвсэгт хүчин орохгүй);
- Татварын байгууллагын албан хаагч;
- Гаалийн байгууллагын албан хаагч;
- Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх байгууллагын албан хаагч;
- Эрүүгийн хэргийн гүйцэтгэх алба;
- Авран хамгаалах албаны албан хаагч зэрэг болно.

Энэхүү тусгай алба нь Бүгд Найрамдах Армен Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан хүний болон иргэний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийг дээдлэн хүндэтгэх, хүнлэг энэрэнгүй, ил тод байх зарчмыг баримтлан ажилладаг.

Мөрдөн шалгах тусгай албаны даргыг Армен Улсын Ерөнхий прокурорын санал болгосноор Ерөнхийлөгч томилох бөгөөд хуульд заасан үндэслэлийн дагуу албан тушаалаас чөлөөлнө. Мөрдөн шалгах тусгай албаны дарга үйл ажиллагааны талаарх мэдээллийг Армен Улсын Үндэсний Их Хурал (парламент) болон Ерөнхийлөгчид жил бүр бичгээр тайлагнана.

Мөрдөн шалгах тусгай албанаас явуулж буй урьдчилан мөрдөн шалгах ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд Армен Улсын Ерөнхий прокурор болон түүнээс эрх олгосон тусгай прокурорууд хяналт тавина.

ОХУ:

ОХУ-д мөрдөн байцаах ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий ОХУ-ын Мөрдөн байцаах хороо (Следственный комитет РФ) ажилладаг.

2010 онд **ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны тухай хууль**⁹⁸ батлагдаж 2011 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Мөрдөн байцаах хорооны **удирдлагыг**

⁹⁷Мөрдөн байцаах тусгай албаны тухай хууль, 1 дүгээр бүлэг, 4.3 дугаар зүйл <http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus>

⁹⁸ФЗ О Следственном комитете РФ от 28.12.2010 г. № 403-ФЗ.

ОХУ-ын Мөрдөн байцаах хорооны тухай хуулиар түүний үйл ажиллагааны зорилго, зарчим, бүтэц, зохион байгуулалт, түүний удирдлагын томилох, чөлөөлөх, албан хаагчдад тавигдах шаардлага, хязгаарлалт, хориг, тэдэнд олгох тусгай цол, цолны нэмэгдэл болон мөнгөн урамшууллын хэмжээ, шагнал урамшуулалт, төрийн хамгаалалтад байх баталгаа, нийгмийн хангамж, заавал хамрагдах даатгалын төрөл, хүзээлгэх хариуцлага, албан үүргээс нь чөлөөлөх болон үйл ажиллагаанд нь тавих прокурорын хяналт зэрэг харилцааг зохицуулна.

ОХУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 151.2-т зааснаар дараах 4 чиглэлээр эрүүгийн хэргийг мөрдөн байцаах ажиллагаа явуулна. Үүнд:

1. Үндсэн хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний эсрэг, хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг, нийтийн аюулгүй байдлын эсрэг, төрийн эрх мэдэл, төрийн алба, орон нутгийн байгууллагын ашиг сонирхлын эсрэг, захиргааны хариуцлагын эсрэг, шударга ёсны эсрэг, цэргийн албаны эсрэг гэх мэт эрүүгийн гэмт хэргүүд;
2. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 447 дугаар зүйлд заасан төрийн өндөр албан тушаалтнууд, тэдгээрийн албан тушаалтын болон мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой эрүүгийн гэмт хэргүүд;
3. ОХУ-ЫН хууль, хүчний байгууллагын албан тушаалтнууд, тэдгээрийн албан тушаалтын болон мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой эрүүгийн гэмт хэргүүд;
4. Насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн болон насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой хүнд, онц хүнд гэмт хэргүүд орно.

Мөрдөн байцаах хорооны тухай хуулийн 13.2, 14.2, 15.6, МБХ-ны дүрмийн 16-д тус тус заасны дагуу ОХУ-ЫН Ерөнхийлөгч нь МБХ-ны даргын санал болгосноор МБХ-ны дарга, түүний 1-р орлогч, бусад орлогчдыг; ерөнхий болон ОХУ-ЫН субъектүүдийн мөрдөн байцаах газрын дарга, тэдгээрийн 1-р орлогчид, бусад орлогчдыг; бусад удирдах албан тушаалтнуудыг томилж, чөлөөлнө.

Хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу МБХ-ны дарга жил бүр ОХУ-ЫН Ерөнхийлөгчид ажлаа тайлagnана. Мөн хуулийн 44 дүгээр зүйлд МБХ-ны мөрдөн байцаах үйл ажиллагаанд ОХУ-ЫН Ерөнхий прокурор болон бусад прокурорууд хяналт тавихаар заасан байна.

МОНТЕНЕГРО УЛС:

Монтенегро Улсын Прокурорын газрын дэргэд мөрдөн байцаах чиг үүрэг бүхий **Улсын тусгай прокурорын алба** ажилладаг. Тус албаны үйл ажиллагааг 2015 оны 02 дугаар сарын 26-нд батлагдсан “**Монтенегро Улсын тусгай прокурорын албаны тухай хууль**⁹⁹ (*law on special public prosecutor's office of Montenegro*)”-аар зохицуулсан байна.

Энэхүү хууль нь Улсын тусгай прокурорын албаны бүтэц зохион байгуулалт, шүүх эрх мэдэл, Улсын тусгай прокурорын албаны дарга болон тусгай прокуроруудыг сонгох шаардлага ба процедур, бусад төрийн болон захиргааны албадуудтай хэрхэн харилцах хэм хэмжээ, албаны үйл ажиллагаанд холбогдох бусад харилцааг зохицуулна.

Улсын тусгай прокурорын алба нь дараах тасаг, албадаас бүрдэнэ.

- Санхүүгийн мөрдөн байцаах тасаг
- Дүн шинжилгээ, судалгааны тасаг
- Олон улсын хамтын ажиллагааны тасаг

⁹⁹[https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2015\)012-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2015)012-e)

Хуулийн 3-р зүйлд зааснаар Улсын Тусгай прокурорын алба нь дараах гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэнэ. Үүнд:

1. хуулиар заасан хугацаа харгалзахгүйгээр аливаа зохион байгуулалттай гэмт хэрэг;
2. өндөр түвшний (их хэмжээний) авлига:

а) хэрвээ төрийн албан тушаалтан¹⁰⁰ дараах гэмт хэргүүдийг үйлдсэн бол:

- албан тушаалаа урвуулан хэрэглэсэн;
- албан үүргээ гүйцэтгэх үедээ хуран мэхэлсэн;
- албан тушаалын нөлөөгөө худалдаалсан;
- албан тушаалын нөлөөгөө худалдаалах сэдэл төрүүлсэн;
- авлига өгсөн;
- авлига авсан.

б) хэрвээ дараах гэмт хэргийг үйлдээд 40.000 еврогоос давсан орлого олсон бол:

- үйл ажиллагаанд албан тушаалаа урвуулан ашигласан;
- эдийн засагт эрх мэдлээ урвуулан ашигласан.

3. мөнгө угаасан;

4. терроризм;

5. цэргийн гэмт хэрэг зэрэг болно.

Улсын тусгай прокурорын албаны үйл ажиллагааг Улсын прокурорын үйлчилгээний тухай хуулийн дагуу боловсруулсан Удирдлагын төлөвлөгөөнд үндэслэн Улсын дээд прокурорын алба хянана.

ӨМНӨД СОЛОНГОС УЛС:

Тус улс нь Авлигатай тэмцэх бие даасан байгууллагатай боловч Улсын Дээд прокурорын газрын бүтцэд авлигын эсрэг болон зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий тусгай хэлтэс ажилладаг. Тус хэлтэс нь Ерөнхий прокурорт шууд харьялагдах бөгөөд босоо удирдлагын тогтолцоотой байна. Прокурорын мөрдөн байцаах ажиллагааг прокурорын цагдаа болон тусгай мөрдөн байцаах алба (*Special Investigation Agency*) явуулна.

Тусгай мөрдөн байцаах алба нь дүүргийн прокурорын газраас шилжүүлсэн хэрэг болон хууль тогтоомжоор өөрт харьяалуулсан гэмт хэргүүдэд тусгай мөрдөн шалгах, мөрдөн байцаах ажиллагаа явуулна. Үүнд:

- Авлигын 5 том гэмт хэрэг;
- Батлан хамгаалах үйл ажиллагаан дахь авлигын гэмт хэрэг;
- Үндэсний баялгийг гадагш гаргахтай холбоотой авлигын гэмт;
- Орон нутаг дахь авлига, хүний нөөцийн томилгоотой холбоотой авлига;
- Санхүүгийн болон үнэт цаастай холбоотой гэмт хэрэг зэрэг болно.

¹⁰⁰Энэхүү хуульд төрийн албан тушаалтан гэдгийг төрийн эрх мэдэлтэн, төрийн захиргааны эрх мэдэлтэн, нутгийн өөрөө удирдах эрх мэдэлтэн, нутгийн захиргааны эрх мэдэлтэн (цаашид албаны эрх мэдэлтэн гэнэ), бие даасан эрх мэдэлтэн, зохицуулах эрх мэдэлтэн, олон нийтийн байгууллага, олон нийтийн аж ахуйн нэгж, эсхүл аливаа бизнесийн байгууллага, эсхүл хуулийн этгээд зэрэг олон нийтийн эрх мэдлийг хэргэжүүлэгч, эсхүл нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагаа эрхэлдэг төрийн мэдлийн үйл ажиллагааг эрхлэгчид, сонгогдсон, нэр дэвшсэн, эсхүл томилогдсон хүнийг, эсхүл сонгогдсон, нэр дэвшсэн, томилогдсон албаны эрх мэдэлтэй хүнийг ойлгоно.

Солонгос Улсын хувьд Прокурорын байгууллага нь Хууль зүйн яам, Цагдаагийн байгууллага нь Дотоод хэргийн яаманд харьялагддаг. Хууль хүчний байгууллагын ажилтнууд, төрийн өндөр албан тушаалтантай холбоотой гэмт хэргийг тусгайлан мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байгууллагын талаарх мэдээлэл судалгааны явцад олдоогүй болно.

АНУ:

Америкт хууль сахиулах байгууллагын албан хаагчидтай холбоотой гэмт хэргийг Хууль зүйн яам (*Department of Justice*)¹⁰¹ мөрдөн шалгана.

Уг алба нь цагдаагийн албан хаагчид, засан хүмүүжүүлэх газрын ажилтнууд, шүүгч, прокурор болон холбооны улсын, мужийн, орон нутгийн хууль сахиулах байгууллагын албан хаагчдад холбогдох хүч хэрэглэсэн, эрх мэдэл, албан тушаалаа хэтрүүлэн ашигласан, хилсээр баривчилсан, шүүгдэж буй этгээдэд бие махбодын болон сэтгэл санааны хохирол учруулсан, санаатайгаар эмнэлгийн тусламж үзүүлэхээс зайлсхийсэн, бэлгийн дарамт үзүүлсэн, гэмт хэргийг таслан зогсоохоос зайлсхийсэн зэрэг гэмт хэргүүдийг мөрдөн шалгадаг. Түүнчлэн гэмт хэргийг илрүүлэх явцад саад хийсэн, хохирогч болон гэрчийг мэдүүлэг өгөхөд саад учруулсан, мэдүүлгийг хуурамчаар үйлдсэн, хэргийг нуун дарагдуулсан, баримт нотолгоог хуурамчаар үйлдсэн зэрэг хэргүүдийг мөрдөж ял оноодог.¹⁰²

Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд болон төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой гэмт хэргийн мэдээллийг Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурорын томилсон Тусгай төлөөлөгч (*Special Counsel*) шалгаж, мөрдлөг явуулдаг байна. АНУ-д Ерөнхий атторней буюу Ерөнхий прокурор нь нэгэн зэрэг Хууль зүйн асуудал хариуцсан сайдын алба хашдаг онцлогтой.¹⁰³

Холбооны улсын эрх зүйн актуудын код (*Code of Federal regulations*)-д заасны дагуу **Тусгай төлөөлөгч** нь өөрт олгосон эрхийн хүрээнд АНУ-ын аль ч прокурорын адил мөрдлөг явуулах, ял оноох эрхтэй. Мөн тухайн хэргийн мөрдөлт аль шатанд явж байгаа зэрэг хэрэгт холбоотой мэдээллийг Ерөнхий прокурор болон Хууль зүйн яамны ажилтнуудад мэдээлэх эсэхээ өөрөө шийдэх бүрэн эрхтэй байна.

Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу мөрдлөгийн явцад бий болсон гэнэтийн үйл явдлын талаар Ерөнхий прокурорт мэдээлэх шаардлагатай. Мөрдөн шалгах үйл явц дууссаны дараа гэмт этгээдэд ногдуулсан ял, эсхүл гэм буруугүйг нотолсон нотолгоог Ерөнхий прокурорт танилцуулна. Тусгай төлөөлөгчийн мөрдсөн болон ял ногдуулсан аливаа хэргийг Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу Ерөнхий прокурор олон нийтэд мэдээлэх эсэхийг шийдвэрлэнэ.

¹⁰¹<https://www.justice.gov/crt/law-enforcement-misconduct>

¹⁰²<https://www.law.cornell.edu/uscode/text/18/242>

¹⁰³Б. Цэрэнбалтав, Б. Амарбаясгалан “Прокурорын хяналт”, 2009, УБ

УКРАИН:

Украин Улсын Парламентаас 2015 оны 11 сарын 12-ны өдөр Улсын мөрдөн байцаах газрын тухай хууль¹⁰⁴-ийг баталж, 2016 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байна.

Улсын мөрдөн байцаах газар нь 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Улсын мөрдөн байцаах албаны тогтолцоо нь төв аппарат, нутаг дэвсгэрийн нэгж дэх салбар, тусгай нэгж, боловсрол, судалгааны байгууллагаас бүрдэнэ. Тус газар нь Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан албан тушаал ерөнхийлөгч, парламентын гишүүд, засгийн газрын гишүүд, үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, сонгуулийн төв хорооны гишүүд, засгийн газрын гишүүд, төв банкны ерөнхийлөгч, шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтуудын үйлдсэн гэмт хэрэг, мөн авлигатай тэмцэх газрын албан хаагчдын үйлдсэн Эрүүгийн хуулийн худал мэдүүлэг өгөх, худал мэдүүлэг өгүүлэхээр албадах, мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулах, гэмт хэргийг үл мэдээлэх зэрэг гэмт хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагааг явуулна.

Улсын мөрдөн байцаах газар нь Засгийн газрын дэргэдэх төв байгууллага бөгөөд тус байгууллагаас явуулах мөрдөн шалгах ажиллагаанд Прокурорын байгууллага хяналт тавьж ажилладаг.

УМБГ-ын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Украин улсын Ерөнхийлөгч 5 жилийн хугацаагаар томилох ба улируулан томилохыг хориглоно.

Улсын мөрдөн байцаах албаны үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтцийг мөрдөн байцаах албаны дарга нь Засгийн газартай зөвшилцэж батлахаар заасан байна.



¹⁰⁴The Law of Ukraine “On the State Bureau of Investigation”, <https://zakon3.rada.gov.ua/laws/show/794-19>

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

НЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.1. БҮГД НАЙРАМДАХ АРМЕН УЛС

Армен Улсад Засгийн газрын харьяа¹⁰⁵ Мөрдөн шалгах тусгай алба ажилладаг бөгөөд уг албаны үйл ажиллагааг 2007 онд батлагдсан Мөрдөн шалгах тусгай албаны тухай хуулиар (Закон о специальной следственной службе) зохицуулдаг. Армен Улс нь Ерөнхийлөгчийн засаглалтай боловч Монгол улстай төрийн байгууламжийн хувьд ижил нэгдмэл улсын статустай, хуучин социалист орон юм. Тус улсын Мөрдөн шалгах тусгай албаны тухай хууль нь харьцангуй нарийвчилсан зохицуулалттай, загвар болохуйц хууль байх тул бүрэн эхээр нь орчуулж хавсаргав.

Албан бус орчуулга

МӨРДӨН ШАЛГАХ ТУСГАЙ АЛБАНЫ ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ АРМЕН УЛСЫН ХУУЛЬ¹⁰⁶

Батлагдсан огноо: 28.11.2007

Нэгдүгээр бүлэг. Ерөнхий зүйл

Хоёрдугаар бүлэг. Мөрдөн шалгах тусгай албаны тогтолцоо, албан хаагчдыг томилох, чөлөөлөх, зэрэг цол олгох нөхцөл ба журам

Гуравдугаар бүлэг. Мөрдөн шалгах тусгай албаны алба хаагчдын эрх зүйн баталгаа, эрх, үүрэг болон албан үүргийн хэрэгжилтэнд хяналт тавих, аттестатчилах, давтан сургах

Дөрөвдүгээр бүлэг. Мөрдөн шалгах тусгай албанд ажиллагсдын материаллаг хангамж, нийгмийн болон бусад баталгаа

Тавдугаар бүлэг. Мөрдөн шалгах тусгай албаны ажлын аппарат, санхүүжилт

Зургадугаар бүлэг. Шилжилтийн нөхцөлүүд

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1-р зүйл. Хуулийн зохицуулалтын хамрах хүрээ

Энэ хуулиар Мөрдөн шалгах тусгай алба байгуулах болон үйл ажиллагаа явуулах нөхцөл, журам, мөн албанд алба хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхтэй

¹⁰⁵Мөрдөн байцаах тусгай албаны ажлын албаны журам, 3 дугаар бүлэг 13 дугаар зүйл
<http://www.ccc.am/ru/1428578692>

¹⁰⁶Закон Республики Армения "О Специальной Следственной Службе"
<http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus>

холбоотой харилцаа, албан тушаалын ангилал, зэрэглэл, эрх, үүрэг хариуцлага, эрх зүйн болон нийгмийн баталгаа, албан үүрэгтэй нь холбоотой бусад харилцааг зохицуулна.

2-р зүйл. Мөрдөн шалгах тусгай алба

1. Мөрдөн шалгах тусгай алба нь Армен Улсын Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх процессиин тухай хуульд заасны дагуу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын байгууллагуудын удирдах албан тушаалтнууд болон төрийн тусгай албаны ажилтнуудын хамжаа оролцоотойгоор үйлдэгдсэн эрүүгийн гэмт хэргүүд, эдгээр албан тушаалтнуудын биечлэн үйлдэгдсэн эрүүгийн гэмт хэргүүд, мөн түүнчлэн бүх шатны сонгуулийн процесст үйлдэгдсэн эрүүгийн гэмт хэргүүдийг урьдчилан мөрдөн шалгана. Армен Улсын Ерөнхий прокурор дээрх албан тушаалтнуудад хамааралтай хэргийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд шаардлагатай гэж үзвэл хэргийг ердийн журмаар мөрдөн шалгаж байсан байцаагч мөрдөн байцаах байгууллагаас хэргийг татан авч Мөрдөн байцаах тусгай албанд шалгуулахаар шилжүүлж болно.
2. Мөрдөн шалгах тусгай алба нь төрийн онцгой үүрэгтэй албанад тооцогдох тул тус албанад ажиллагдын эрх зүйн байдлыг энэхүү хуулиар тогтооно. Мөрдөн шалгах тусгай албанад ажиллагсад нь төрийн тусгай албан хаагчийн статустай байна.
3. Мөрдөн шалгах тусгай алба нь Армен Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх процессиин тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн хүнлэг, энэрэнгүй, ил тод, хүний эрх, эрх чөлөө, нэр хүндийг дээдэлж, хуулийн зарчимд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.
4. Мөрдөн шалгах тусгай албанаас явуулж буй урьдчилан мөрдөн шалгах ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд Армен Улсын Ерөнхий прокурор болон түүнээс эрх олгосон тусгай прокурорууд хяналт тавина.
5. Мөрдөн шалгах тусгай албыг Албаны дарга удирдана.
6. Мөрдөн шалгах тусгай алба нь үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг ил тод болгох ба тусгай албаны дарга нь Армен Улсын Үндэсний Их Хурал болон Ерөнхийлөгчид үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг жил бүр бичгээр тайлагнана.
7. Мөрдөн шалгах тусгай албаны төв оффис Ереванд байрлана.

3-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны талаарх хууль тогтоомж

1. Мөрдөн шалгах тусгай албаны тухай хууль тогтоомж нь энэ хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх процессиин тухай хууль, Армен Улсын холбогдох бусад хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрүүдээс бүрдэнэ.
2. Хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Мөрдөн шалгах тусгай албаны дарга дотоод үйл ажиллагааны журам тогтоосон эрх зүйн акт болон бие даасан шийдвэр гаргана.

3. Хэрэв энэ хуульд заасан асуудлыг Армен Улсын нэгдэн орсон гэрээ хэлэлцээрт өөрөөр заасан бол олон улсын гэрээ хэлэлцээрийн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

4-р зүйл. Хуульд заасан нэр томьёо, үндсэн ойлголтууд

Энэ хуульд дараах нэр томьёо, ойлголтуудыг ашиглана.

1. Мөрдөн шалгах тусгай албаны ажилтан - гэж тус албаны дарга, түүний орлогч, онц ноцтой гэмт хэргийг мөрдөн шалгах ахлах мөрдөн байцаагчид болон онц ноцтой гэмт хэргийн мөрдөгчдийг хэлнэ.
2. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын байгууллагуудын удирдах албан тушаалтнууд - гэж Армен Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Шадар сайд, Үндэсний Их Хурлын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн гишүүд, Шүүх байгууллагын дарга нар болон шүүгчид, Армен Улсын Ерөнхийлөгчийн ажлын албаны дарга, Армен Улсын Үндэсний Их Хурлын ажлын албаны дарга, Армен Улсын Засгийн газрын ажлын албаны дарга, Засгийн газрын сайдууд болон дэд сайдууд, Засгийн газрын харьяа агентлагууд болон төрийн захирагааны төв байгууллагын дарга, орлогчид, Мужийн захирагч, тэдгээрийн орлогчид, Ереван хотын захирагч, түүний орлогчид, Армен Улсын Төрийн Хянан Шалгах Палатын зөвлөлийн дарга, гишүүд, Арменийн Төв банкны дарга, зөвлөлийн гишүүд, Армен Улсын зохицуулах хороодын дарга ба гишүүд, Армен Улсын Сонгуулийн хорооны дарга, гишүүд, Армен Улсын Үндэсний Статистикийн хорооны дарга, орлогч дарга нарыг хэлнэ.
3. Төрийн тусгай албанд үүрэг гүйцэтгэгч - гэж батлан хамгаалах салбар дахь төрөөс бүрэн эрх олгосон байгууллагад ажилладаг мөрдөгчид, прокурорууд, цагдаагийн алба (зэвсэгт хүчний цагдаад хамаарахгүй), үндэсний аюулгүй байдлын алба (хилийн цэрэг, зэвсэгт хүчний салбар ангиуд хамаарахгүй), татвар, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, эрүүгийн хэргийн гүйцэтгэх алба, авран хамгаалах алба зэрэг тусгай албадын эрх бүхий албан тушаалтнуудыг хэлнэ.
4. Сонгуулийн процесстой холбоотой гэмт хэрэг - гэж Армен Улсын Эрүүгийн хуулийн 143, 150, 1541, 1542-р зүйлд заасан гэмт хэргүүдийг хэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

МӨРДӨН ШАЛГАХ ТУСГАЙ АЛБАНЫ СИСТЕМ, УГ АЛБАНД АЖИЛЛАГСАДЫГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ, ЗЭРЭГ ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ БА НӨХЦӨЛ

5-р зүйл. Мөрдөн шалгах тусгай албаны албан тушаалын систем

¹²⁰<https://www.tuzilastvocg.me/index.php/en/special-state-prosecutor-s-office>

¹²¹[https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2015\)012-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2015)012-e)

¹²²Монтенегро улсын нийслэл

Хуулийн 3-р зүйлд зааснаар Улсын Тусгай прокурорын алба нь дараах гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэнэ. Үүнд:

1. хуулиар заасан хугацаа харгалзахгүйгээр аливаа зохион байгуулалттай гэмт хэрэг;
2. өндөр түвшний (их хэмжээний) авлигат:
 - a) хэрвээ төрийн албан тушаалтан¹²³ дараах гэмт хэргүүдийг үйлдсэн бол:
 - албан тушаалаа урвуулан хэрэглэсэн;
 - албан үүргээ гүйцэтгэх үедээ хууран мэхэлсэн;
 - албан тушаалын нөлөөгөө худалдаалсан;
 - албан тушаалын нөлөөгөө худалдаалах сэдэл төрүүлсэн;
 - авлигат өгсөн;
 - авлигат авсан.
 - b) хэрвээ дараах гэмт хэргийг үйлдээд 40.000 евро-оос давсан орлого олсон бол:
 - үйл ажиллагаанд албан тушаалаа урвуулан ашигласан;
 - эдийн засагт эрх мэдлээ урвуулан ашигласан.
3. мөнгө угаасан;
4. терроризм ба;
5. цэргийн гэмт хэрэг.

Дээр заасан эрүүгийн хэргийн гэм буруутныг хянан шийдвэрлэх ажлыг Улсын прокурорын албаны тэргүүний хувиар Ерөнхий тусгай прокурор, улсын прокурорын хувиар тусгай прокурорууд гүйцэтгэх ба, тэдний орон тоог Прокурорын зөвлөл Улсын прокурорын үйлчилгээний хуулийг үндэслэн тогтооно.

Ерөнхий тусгай прокурор нь өөрийн болон Тусгай прокурорын албаны ажлыг Улсын дээд прокурорт, харин тусгай прокурорууд нь ажлаа Ерөнхий тусгай прокурорт тус тус тайлагнана.

Улсын тусгай прокурорын албаны үйл ажиллагааг Улсын прокурорын үйлчилгээний тухай хуулийн дагуу боловсруулсан Удирдлагын төлөвлөгөөнд үндэслэн Улсын дээд прокурорын алба хянана.

Тусгай прокурорын албаны үйл ажиллагааны санг Улсын прокурорын үйлчилгээнд төсөвлөсөн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон хуваарилна.

Хуулийн 2-р бүлэгт Улсын тусгай прокурорын албаны бүтэц, зохион байгуулалтыг зохицуулсан байна. Тухайлбал:

¹²³Энэхүү хуулинд төрийн албан тушаалтан гэдгийг төрийн эрх мэдэлтэн, төрийн захиргааны эрх мэдэлтэн, нутгийн өөрөө удирдах эрх мэдэлтэн, нутгийн захиргааны эрх мэдэлтэн (цаашид албаны эрх мэдэлтэн гэнэ), бие даасан эрх мэдэлтэн, зохицуулах эрх мэдэлтэн, олон нийтийн байгууллага, олон нийтийн аж ахуйн нэгж, эсхүл аливаа бизнесийн байгууллага, эсхүл хуулийн этгээд зэрэг олон нийтийн эрх мэдлийг хэргжүүлэгч, эсхүл нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагаа эрхэлдэг төрийн мэдлийн үйл ажиллагааг эрхлэгчид, сонгогдсон, нэр дэвшсэн, эсхүл томилогдсон хүнийг, эсхүл сонгогдсон, нэр дэвшсэн, томилогдсон албаны эрх мэдэлтэй хүнийг ойлгоно.

Улсын тусгай прокурорын алба нь тасаг, албадаас бүрдэнэ. Тасгууд (divisions) нь эрүүгийн хэргийг хянах, санхүүгийн мөрдөн байцаах, дүн шинжилгээ ба судалгаа, олон улсын хамтын ажиллагааны зэрэг ажил үүргийг гүйцэтгэх зорилгоор зохион байгуулагддаг бол албадууд (Services) нь олон нийттэй харилцах, мэргэжлийн, захиргааны болон техникийн үйл ажиллагааг хангах үүднээс зохион байгуулагдана.

Тасгууд: Эрүүгийн гэмт хэрэгтнийг хянан шийдвэрлэх тасаг нь урьдчилсан байцаалт, мөрдөн байцаалт, тэрчлэн төрийн бусад албадуудтай хамтын ажиллагаатай бүхий л ажил үүргийг гүйцэтгэнэ.

Санхүүгийн мөрдөн байцаах тасаг нь гэмт хэргийн үйлдлийн явцад олсон орлого, гэмт хэрэг үйлдсэнээр олсон үл хөдлөх хөрөнгө зэргийг шалган тогтоох зорилгоор мэдээлэл цуглуулах, мөн үл хөдлөх хөрөнгийг хураан битүүмжлэх арга хэмжээг авна.

Дүн шинжилгээ, судалгааны тасаг нь төрийн бусад албадтай мэдээлэл солилцох, тэдгээрт буй мэдээллийн санг хэрэглэх, судлах, хэргийн статистик тайлан ба хяналт зэргийг ашиглах нөхцөлүүдийг бүрэлдүүлэн, баяжуулах үүргийг гүйцэтгэнэ.

Олон улсын хамтын ажиллагааны тасаг нь бусад улс болон олон улсын байгууллагуудын нэр хүндтэй эрх мэдэлтнүүдтэй хамтран ажиллах, Улсын тусгай прокурорын албаны эрх мэдлийн хүрээнд хамаарах гэмт хэргийг хянан шийдвэрлэх зорилго бүхий олон улсын гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр байгуулагдаж буй хамтарсан мөрдөн байцаах багийн гишүүдийг томилох зэрэг ажил үүргийг гүйцэтгэнэ.

Улсын тусгай прокурорын алба нь Ерөнхий тусгай прокурор болон тусгай прокурор, зохих тооны зөвлөгч, бусад төрийн албан хаагчдын орон тоотой байна.

Ерөнхий тусгай прокурор нь таван жилийн хугацаатай сонгогдоно. Тусгай прокурор нь хэрвээ улсын прокуророор, эсхүл шүүгчээр наанадаж дөрвөн жил ажилласан бол тэтгэврийн насанд хүртлээ сонгогдоно. Харин улсын прокуророор, эсхүл шүүгчээр наанадаж дөрвөн жил ажиллаагүй бол тусгай прокуророор дөрвөн жилийн хугацаатай сонгогдоно.

Хуулийн 4-р бүлэгт Улсын тусгай прокурорын албаны цагдаагийн газартай хэрхэн харилцан ажиллах талаар зохицуулсан. Тухайлбал: хуулийн 3 дугаар зүйлд заасан гэмт хэрэгтэй холбогдох цагдаагийн ажил үүргийг Улсын тусгай прокурорын цагдаагийн тусгай нэгжийн цагдаагийн албан хаагчид гүйцэтгэнэ. (цаашид Цагдаагийн тасаг гэнэ) Цагдаагийн тасгийн дарга нь VII түвшний боловсрол мэргэжилтэй, их сургуулийн зэрэгтэй байх шаардлага бүхий цагдаагийн мэргэжлээр наанадаж 8 жил ажилласан ажлын туршлагатай хүн байна. Цагдаагийн тасгийн даргыг цагдаагийн хэрэг хариуцсан захиргааны

эрх мэдэлтэн (цаашид Цагдаагийн захиргаа гэнэ) Ерөнхий тусгай прокурортой зөвшилцөн томилно. Цагдаагийн тасгийн ажилтан нь VII түвшний боловсрол мэргэжилтэй, их сургуулийн зэрэгтэй байх шаардлага бүхий цагдаагийн мэргэжлээр наанадаж 4 жил ажилласан ажлын туршлагатай хүн байна.

Цагдаагийн ажилтны үүрэг хариуцлагын тухайд цагдаагийн тасгийн дарга болон ажилтан нь Ерөнхий тусгай прокурор, эсхүл холбогдох тусгай прокурорын өгсөн тушаалыг гүйцэтгэнэ. Ерөнхий тусгай прокурорын зөвшөөрөлгүйгээр цагдаагийн тасгийн дарга болон ажилтан цагдаагийн захиргаанд ямар нэгэн өөр албан тушаал хашихаар, эсхүл ажил үүрэг гүйцэтгэхээр шилжин томилогдохгүй.

Хуулийн 5-р бүлэгт Улсын тусгай прокурорын албаны мөрдөн байцаагчдын үйл ажиллагаа, эрх үүргийн талаар хуульчилсан байна. Тухайлбал:

Улсын тусгай прокурорын албаны эрх мэдлийн хүрээний гэмт хэргийг мөрдөн байцаах зорилгоор Ерөнхий тусгай прокурор нь татвар, гааль, мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх ба мөрдөн байцаах ажил хэргийн хамааралтай захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдад зарим тодорхой ажил хэргийг шилжүүлэн өгч болно (цаашид мөрдөн байцаагчид гэнэ).

Дээр заасан албан байгууллагуудын дарга нар Ерөнхий тусгай прокурорын хүсэлтээр хяналт шалгалтын ажил үүргийг гүйцэтгэх ажлын туршлага, чадвартай болон Улсын тусгай прокурорын албаны эрх мэдлийн хүрээний гэмт хэргийг мөрдөн байцаах ажилд шаардагдах бусад мэдлэгтэй төрийн албан хаагчдын нэрсийн жагсаалтыг гаргаж өгнө.

Ерөнхий тусгай прокурорын санал болгосноор Улсын дээд прокурор жил тутмын мөрдөн байцаагч нарын нэрсийн жагсаалтыг хүлээн авч, улмаар энэхүү дээр заасан байгууллагын удирдлагууд болон Ерөнхий тусгай прокурорт хүргүүлнэ. Мөрдөн байцаагч нь тусгай прокурорын тушаалыг биелүүлэх ажлыг түүний зааварчилгаа, өөрийн ажил мэргэжлийн дүрэм журам, Эрүүгийн хэргийн хуулийн дагуу гүйцэтгэнэ. Мөрдөн байцаагч нь хуульд заасан үүрэг даалгаврыг тусгай прокурорын заасан хугацаанд гүйцэтгэх ба энэхүү ажлыг гүйцэтгэж буй тухайд өөрийн шууд харьялах даргад мэдүүлэн илтгэхгүй байж болно. Хэрвээ мөрдөн байцаагч ямарваа хүндэтгэх шалтгаангүйгээр тусгай прокурорын тушаал ба зааварчилгааны дагуу ажиллаж чадаагүй, эсхүл эсрэгээр ажилласан тохиолдолд тусгай прокурор энэ тухайд түүний шууд харьялах удирдлагад мэдэгдэнэ.

Тусгай прокурорын тушаалыг гүйцэтгэж чадаагүй ба энэхүү зүйлийн гуравдугаар доголд заасан утгаар тусгай прокурорын тушаал, заавраас зөрчсөн үйлдэл нь мөрдөн байцаагчийн албан үүргээ ноцтой зөрчсөн хэрэг болно.

Энэхүү зүйлийн гуравдугаар доголд заасан тохиолдлуудад мөрдөн байцаагчийн шууд харьяалах албаны удирдлагаас түүнд сахилгын хариуцлага ногдуулна.

Мөрдөн байцаагч нь Авлигалаас урьдчилан сэргийлэх хуулийн дагуу өөрийн үл хөдлөх хөрөнгө ба орлогын тухай, мөн өөрийн гэр бүл ба хууль ёсны хамтрагч, хүүхдүүдийн үл хөдлөх хөрөнгө ба орлогын талаар мэдүүлнэ.

Хуульд тусгайлан зааснаар тухайлсан нарийн төвөгтэй хэргүүдэд Ерөнхий тусгай прокурор нь тусгай прокурор, цагдаагийн тасгийн ажилтан, зохих бусад байгууллагын төрийн албан хаагчдаас бүрдсэн мөрдөн байцаах тусгай багийг байгуулж болно. Мөрдөн байцаах багийн ахлагч нь тусгай прокурор байх ба тухайн мөрдөн байцаах багийн бусад гишүүд түүний тушаалыг гүйцэтгэж, түүний удирдлагад ажиллана.

1.4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

БНСУ нь Ерөнхийлөгчийн засаглалтай бөгөөд төрийн байгууллагуудын удирдлагыг ихэвчлэн Ерөнхийлөгч нь томилдог онцлогтой. Улсын дээд прокурорын газар нь Ерөнхий прокурорын газартай ижил статустай байх ба Улсын дээд прокурорыг Хууль зүйн сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилдог.

Улсын дээд прокурорын үндсэн чиг үүрэг нь:¹²⁴

- Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаа явуулах, хяналт тавих;
- Гэм буруутай этгээдэд ял ногдуулах;
- Эрүүгийн хариуцлага, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих;
- Авлига, хээл хахуулийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах.

БНСУ нь Авлигатай тэмцэх бие даасан байгууллагатай боловч Улсын Дээд прокурорын газрын бүтцэд авлигын эсрэг болон зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий тусгай хэлтэс ажилладаг. Тус хэлтэс нь Ерөнхий прокурор болон түүнд шууд харьяалагдах босоо удирдлагын тогтолцоотой ажилладаг. Прокурорын мөрдөн байцаах ажиллагааг **прокурорын цагдаа болон Тусгай мөрдөн байцаах алба (Special Investigation Agency)** явуулна.

Тусгай мөрдөн байцаах алба нь дүүргийн прокурорын газраас шилжүүлсэн хэрэг болон хууль тогтоомжоор өөрт харьяалуулсан гэмт хэргүүдэд тусгай мөрдөн шалгах, мөрдөн байцаах ажиллагаа явуулна. Үүнд:

1. Авлигын 5 том гэмт хэрэг - Улсын эдийн засаг, аюулгүй байдал, өрсөлдөх чадвар, ил тод байдалд хохирол учруулахуйц (авлига, зуучлах, зуучилсны төлөө төлбөр авах, хувьдаа ашиглах, завших, итгэл эвдэх) гэмт хэргийг таслан зогсоох, мөрдөн шалгах, ял шийтгэл ногдуулах;

¹²⁴https://www.iaac.mn/old/pdf/turshlaga/Korea_2015.pdf -БНСУ авилгатай тэмцэх үйл ажиллагаа, 2015 он, 8 дахь тал

2. Батлан хамгаалах үйл ажиллагаан дахь авлигын гэмт хэрэг - Үндэсний аюулгүй байдал болон батлан хамгаалах үйл ажиллагаан дахь авлигын гэмт хэрэг;

3. Үндэсний баялгийг гадагш гаргахтай холбоотой авлигын гэмт хэрэг - Улсын томоохон технологийг эзэмшиж, ашиглаж буй байгууллага, компанийн сүүлийн үеийн технологийг гадагш гаргахтай холбоотой гэмт хэргийг шуурхай илрүүлэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах;

4. Орон нутаг дахь авлига, хүний нөөцийн томилгоотой холбоотой авлига Орон нутгийн болон төрийн байгууллагын удирдлага нь хүний нөөцийн томилго болон шинээр ажилд авахдаа авлига авахтай холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах;

5. Санхүүгийн болон үнэт цаастай холбоотой гэмт хэрэг - олон тооны хохирогчтой санхүүгийн гэмт хэрэг, их хэмжээний хувьцааны үнийг хуурамчаар өсгөх бууруулах замаар үйлдсэн зохион байгуулалттай гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.

Прокурорын байгууллага нь үйл ажиллагаандaa Прокурорын тухай хууль болон Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийг дагаж мөрдөнө. Прокурорын байгууллагын тухай хуульд зааснаар шинээр хэлтэс, алба байгуулах, түүний эрх хэмжээг тогтоохтой холбоотой асуудлыг Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

Солонгос Улсын хувьд прокурорын байгууллага нь Хууль зүйн яам, цагдаагийн байгууллага нь Дотоод хэргийн яамандаа харьялагддаг. Хууль, хүчний байгууллагын ажилтнууд, төрийн өндөр албан тушаалтантай холбоотой гэмт хэргийг тусгайлан мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байгууллагын талаарх мэдээлэл судалгааны явцад олдоогүй болно.

1.5. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-д хууль сахиулах байгууллагын албан хаагчидтай холбоотой гэмт хэргийг Хууль зүйн яам (*Department of Justice*)¹²⁵ мөрдөн шалгана. Угалбань цагдаагийн албан хаагчид, засан хүмүүжүүлэх газрын ажилтнууд, шүүгч, прокурор болон холбооны улсын, мужийн, орон нутгийн хууль сахиулах байгууллагын албан хаагчдад холбогдох хүч хэрэглэсэн, эрх мэдэл, албан тушаалаа хэтрүүлэн ашигласан, хилсээр баривчилсан, шүүгдэж буй этгээдэд бие махбодын болон сэтгэл санааны хохирол учруулсан, санаатайгаар эмнэлгийн тусламж үзүүлэхээс зайлсхийсэн, бэлгийн дарамт үзүүлсэн, гэмт хэргийг таслан зогсоохоос зайлсхийсэн зэрэг гэмт хэргүүдийг мөрдөн шалгадаг байна. Түүнчлэн гэмт хэргийг илрүүлэх явцад саад хийсэн, хохирогч болон гэрчийг мэдүүлэг өгөхөд саад учруулсан, мэдүүлгийг хуурамчаар үйлдсэн, хэргийг нуун дарагдуулсан, баримт нотолгоог хуурамчаар үйлдсэн зэрэг хэргүүдийг мөрдөн шалгаж ял оноодог байна.¹²⁶

¹²⁵<https://www.justice.gov/crt/law-enforcement-misconduct>

¹²⁶<https://www.law.cornell.edu/uscode/text/18/242>

Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд болон төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой гэмт хэргийн мэдээллийг Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурор (цаашид Ерөнхий прокурор)-ын томилсон Тусгай төлөөлөгч (*Special Counsel*) шалгаж, мөрдлөг явуулдаг байна. (АНУ-д Ерөнхий атторней буюу Ерөнхий прокурор нь нэгэн зэрэг Хууль зүйн асуудал хариуцсан сайдын алба хашдаг)¹²⁷

АНУ-ын Хууль зүйн яамнаас 1999 онд баталсан Холбооны улсын эрх зүйн актуудын код (*Code of Federal regulations*)-ын 28 дугаар хэсгийн VI бүлгийн 600 (28 CFR Part 600)-д¹²⁸ **Тусгай төлөөлөгчид холбогдох** дараах асуудлуудыг зохицуулжээ. Үүнд:

- 600.1 Тусгай төлөөлөгчийг томилох үндэслэл
- 600.2 Ерөнхий прокуророос авах арга хэмжээний хувилбарууд
- 600.3 Тусгай төлөөлөгчид тавигдах шаардлага
- 600.4 Тусгай төлөөлөгчийн эрх мэдлийн хүрээ
- 600.5 Тусгай төлөөлөгчид туслах ажилтан, албан хаагчид
- 600.6 Тусгай төлөөлөгчийн бүрэн эрх
- 600.7 Тусгай төлөөлөгчийн үүрэг, хариуцлага
- 600.8 Тусгай төлөөлөгчийн мэдэгдэл болон мөрдлөгийн тайлан
- 600.9 Ерөнхий прокурорын мэдэгдэл болон тайлан

600.1 Тусгай төлөөлөгчийг томилох үндэслэл

Ерөнхий прокурор, эсхүл ерөнхий прокурор татгалзсанаар үүрэг гүйцэтгэгч томилогдсон тохиолдолд тодорхой хүн, эсхүл хэрэг дээр мөрдлөг явуулах шаардлагатай гэж үзвэл Ерөнхий прокурорын үүрэг гүйцэтгэгч дараах тохиолдолд Тусгай төлөөлөгчийг томилох эрхтэй:

- (а) Ерөнхий прокурорын ажлын алба болон Хууль зүйн яамны шүүн таслах хэлтсийн ажилтнууд тухайн хүн, эсхүл тухайн асуудлыг мөрдөх, яллах ажиллагааг явуулахад ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдлууд үүсч болзошгүй тохиолдолд;
- (б) Иргэд, олон нийтийн зүгээс тухайн хэргийг мөрдөн шалгахдаа тусгай төлөөлөгч томилохыг шаардсан тохиолдолд.

600.2 Тусгай төлөөлөгчид тавигдах шаардлага

- (а) Тусгай төлөөлөгчөөр томилогдох этгээд нь хуульч мэргэжилтэй, аливаа нөлөөнд автахгүй, аль нэг талыг баримтлан шийдвэр гаргахгүй байх боломжтой, мэргэжлийн туршлага дээрээ тулгуурлан мөрдлөгийг шуурхай, нарийвчилсан байдлаар явуулах чадвартай байх ба АНУ-ын Эрүүгийн хууль болон Хууль зүйн яамны бодлогыг мөрдөн шалгах болон яллах үйл ажиллагаандаа баримталж шийдвэр гаргана. АНУ-ын Засгийн газарт ажилладаг этгээдийг тусгай төлөөлөгчөөр томилохыг хориглоно.

¹²⁷Б.Цэрэнбалтав, Б. Амарбаясгалан “Прокурорын хяналт”, 2009, УБ

¹²⁸<https://www.law.cornell.edu/cfr/text/28/part-600>

(б) Тусгай төлөөлөгчөөр томилох этгээдийн талаар дэлгэрэнгүй судалгаа хийж, ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчил бий эсэхийг нарийвчлан шалгасны үндсэн дээр “итгэмжлэгдсэн ажилтан”-аар томилно.

600.4 Тусгай төлөөлөгчийн эрх мэдлийн хүрээ

Олгогдсон эрх: Ерөнхий прокурорын олгосон эрхийн хүрээнд тусгай төлөөлөгч нь үүргээ гүйцэтгэнэ. Тусгай төлөөлөгч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ тодорхой баримт нотолгоо бүхий мэдээллээр хангагдах ёстай. Тусгай төлөөлөгч нь худал мэдүүлэг өгөх, үнэн мөнийг гүйвуулах, баримт нотолгоог устгах, гэрчийг айлган сүрдүүлэх зэрэг гэмт хэргүүдийг мөрдөх, ял оноох эрхтэй.

Нэмэлт эрх: Хэргийг мөрдөх явцад тус хэргийг илрүүлэхтэй холбоотой нэмэлт ажиллагаа шаардагдсан, эсхүл шинээр мөрдлөг хийх шаардлагатай болсон тохиолдолд Ерөнхий прокурортой зөвлөлдөн шийдвэрлэнэ. Ерөнхий прокурор тусгай төлөөлөгчийн эрхийг нэмэгдүүлэх, эсхүл өөр байгууллага болон ажилтанд үүрэг өгөх зэргээр асуудлыг шийдвэрлэж болно.

Иргэний болон захиргааны эрх: Мөрдөх явцад буруутан этгээдэд захиргааны болон иргэний (эрүүгийн бус) шийтгэл ногдуулах боломжтой гэж үзвэл Ерөнхий прокурортой зөвлөлдөж шийдвэрлэнэ.

600.5 Тусгай төлөөлөгчид туслах ажилтан, албан хаагчид

Тусгай төлөөлөгч нь шаардлагатай тохиолдолд Хууль зүйн яамны ажилтнуудаас тусламж дэмжлэг авч болно. Тус яамнаас хэргийг мөрдөхөд тохиромжтой албан хаагчдын мэдээллийг тусгай төлөөлөгчид гарган өгснөөр тохирох ажилтнуудыг сонгон, тэдгээрийг удирдан, үүрэг даалгавар өгч ажиллуулна. Шаардлагатай бол тус ажилтнуудыг яамнаас гадуур ажиллуулах боломжтой.

600.6 Тусгай төлөөлөгчийн бүрэн эрх

Тусгай төлөөлөгч нь өөрт олгосон эрхийн хүрээнд АНУ-ын аль ч прокурорын адил мөрдлөг явуулах, ял оноох эрхтэй. Тусгай төлөөлөгч нь тухайн хэргийн мөрдөлт аль шатанд явж байгаа зэрэг хэрэгт холбоотой мэдээллийг Ерөнхий прокурор болон Хууль зүйн яамны ажилтнуудад мэдээлэх эсэхээ өөрөө шийднэ.

600.7 Тусгай төлөөлөгчийн үүрэг хариуцлага

(а) Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны дүрэм, журам, бодлогыг баримталж ажиллана. Хэрэв тусгай төлөөлөгч өөрийн гаргасан шийдвэртээ итгэлтэй байгаа боловч тэр нь Хууль зүйн яамны дүрэм, журамд нийцэхгүй тохиолдолд нэн даруй Ерөнхий прокурортой зөвлөлдөх шаардлагатай.

(б) Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны хэн нэгэн албан тушаалтны өдөр тутмын хараа хяналтан дор ажиллахгүй. Гэвч Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийн хийсэн аливаа мөрдлөг болон буруутан этгээдэд ногдуулсан ялын талаар тайлбар авч болно. Хэрэв тусгай төлөөлөгчийн авсан арга хэмжээ нь Хууль зүйн яамнаас авч хэрэгжүүлдэг үйл ажиллагаатай нийцэхгүй болон шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд цаашид үргэлжлүүлэхийг хориглоно. Тус шалгалтыг явуулж, шийдвэр гаргахдаа тусгай төлөөлөгчийн цаашдын байр суурь, төлөвлөгөөг сайтар анхаарч авч үзнэ. Хэрэв Ерөнхий прокурор тусгай төлөөлөгчийн хэрэгжүүлж буй болон цаашид төлөвлөж буй үйл ажиллагаа нь шаардлагагүй болон тохиромжгүй гэж үзвэл 600.9(а)(3)-т зааснаар Конгресст мэдэгдэнэ.

(в) Тусгай төлөөлөгч болон ажлын албаны гишүүд нь Хууль зүйн яамны ажилтан, албан хаагчдын нэг адил ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн буруутай үйлдэл хийсэн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулна. Ерөнхий прокурорын зөвшөөрлөөр Хууль зүйн яамны тодорхой хэлтэс, алба нь тухайн асуудлыг судалж, арга хэмжээ авна.

(г) Зөвхөн Ерөнхий прокурор л тусгай төлөөлөгчид шийтгэл ногдуулах болон үүрэгт ажлаас нь чөлөөлөх эрхтэй. Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийг албан тушаалаа ашиглан гэмт хэрэг үйлдсэн, ажил үүргээ гүйцэтгээгүй, ашиг сонирхлын зөрчилтэй, Хууль зүйн яамны дүрэм, журмыг зөрчсөн зэрэг тохиолдуудад үүрэгт ажлаас нь чөлөөлнө. Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийг ямар шалтгааны улмаас ажлаас чөлөөлж буй тухайгаа өөрт нь бичгээр мэдэгдэнэ.

600.8 Тусгай төлөөлөгчийн ажлын тайлан

(а) Төсөв

- (1) Хууль зүйн яамнаас тусгай төлөөлөгчийг үүрэгт ажлаа гүйцэтгэх бүхий л нөөц бололцоогоор хангана. Томилогдоноосоо хойш 60 хоногийн дотор тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны Зохион байгуулалтын хэлтэстэй хамтран төсвийн санал боловсруулж, Ерөнхий прокурорт хянуулахаар өгнө. Тухайн санал дээр үндэслэн Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийн үйл ажиллагааны төсвийг боловсруулна. Төсөвт мэргэшил, дадлага бүхий албан хаагчийг авч ажиллуулах зардлыг багтаасан байна.
- (2) Санхүүгийн жил эхлэхээс 90 хоногийн өмнө тусгай төлөөлөгч нь Ерөнхий прокурорт хэргийн мөрдлөгийн үйл явцыг мэдээлж, дараа жилийн төсвийн саналаа танилцуулна. Ерөнхий прокурор нь мөрдөх үйл ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзвэл ирэх жилийн төсөвт тусгана.

(б) Онц чухал үйл явдлуудын талаар мэдээлэх

Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу мөрдлөгийн явцад бий болсон гэнэтийн үйл явдлын талаар Ерөнхий прокурорт мэдээлэх шаардлагатай.

(в) Гэмт хэргийг хаах

Тусгай төлөөлөгч нь мөрдөн шалгах үйл явц дууссаны дараа гэмт этгээдэд ногдуулсан ял, эсхүл гэм буруугүйг нотолсон нотолгоог Ерөнхий прокурорт танилцуулна.

600.9 Ерөнхий прокурорын тайлан

(а) Ерөнхий прокурор нь доорх нөхцөлүүдэд Конгрессын хоёр танхимын Хууль зүйн хорооны дарга наарт мэдэгдэл хийнэ. Үүнд:

- (1) Тусгай төлөөлөгчийг томилоход;
- (2) Тусгай төлөөлөгчийг чөлөөлөхөд;
- (3) Тусгай төлөөлөгчийн авсан арга хэмжээ нь Хууль зүйн яамны дүрэм, журмыг зөрчсөн, тухайн арга хэмжээг авах шаардлагагүй байсан, эсхүл тохиromжгүй арга хэмжээ авсан гэж үзэн мөрдлөгийг үргэлжлүүлэхийг хориглосон тохиолдолд.

(б) Тусгай төлөөлөгчийн мөрдсөн болон ял ногдуулсан аливаа хэргийг Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу Ерөнхий прокурор олон нийтэд мэдээлэх эсэхийг шийдвэрлэнэ.

1.6. УКРАИН УЛС

Украин улсын 2012 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль¹²⁹ (ЭХХШТХ)-д зааснаар:

- Дотоод хэргийн асуудал эрхэлсэн байгууллага;
- Тагнуулын байгууллага;
- Татварын хууль тогтоомжийн дагуу хяналт, шалгалт явуулах эрх бүхий төрийн байгууллага;
- Авлигатай тэмцэх газар,
- Улсын мөрдөн байцаах газар нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүргийг гүйцэтгэдэг байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын мөрдөгчид нь дараах бүрэн эрхтэй байхаар хуульчилжээ. Үүнд:

- ЭХХШТХ-д заасан үндэслэлээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах;
- ЭХХШТХ-д заасан мөрдөн байцаалтын эрэн сурвалжлах ажиллагаа явуулах;

¹²⁹Criminal procedure code of Ukraine, <https://rm.coe.int/16802f6016>

- Эрэн сурвалжлах болон нууц мөрдөн шалгах ажиллагаа гүйцэтгэхийг холбогдох байгууллагад даалгах;
- Хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу аудитын болон холбогдох шалгалт явуулах шийдвэр гаргах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай холбогдох зөвшөөрлийг шүүх, прокуророос авах, танилцуулах;
- Прокурортой зөвшшилцөн сэжигтнээр тооцох;
- Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд үндэслэн яллах дүгнэлт үйлдэх, эмнэлгийн болон боловсролын албадлагын арга хэмжээ хэрэглэх талаар прокурорт санал гаргах, зөвшөөрөл авах;
- Мөрдөн шалгах ажиллагааг зогсоох зэрэг хуульд заасан үндэслэлээр мөрдөн шалгах ажиллагааны шийдвэрүүд гаргах;
- ЭХХШТХ-иар олгосон бусад бүрэн эрх.

Тус хуулийн 216 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагуудын хэргийн харьяаллыг тогтоож өгсөн байна. Үүнд:

- Тагнуулын байгууллага нь төрийн эрх мэдлийг хууль бусаар авах зэрэг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 1 дүгээр бүлэгт заасан үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд, хууль бусаар хил давуулах болон төрийн нууц, хилийн халдашгүй байдал, цэрэг татлага, дайчилгаатай холбогдох гэмт хэргүүд, энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүдэд;
- Татварын холбогдох байгууллага нь татвар, албан журмын даатгалаас зайлсхийх, зориудаар дампууруулах, төлбөрийн чадваргүй болгох, хууль бус үйлдвэрлэл, худалдааны гэмт хэргүүдэд болон дээрх гэмт хэргүүдийг мөрдөн шалгах эрх бүхий этгээдээс үйлдсэн тохиолдолд тус гэмт хэргүүдэд;
- Улсын мөрдөн байцаах газар(УМБГ) нь Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан албан тушаал ерөнхийлөгч, парламентын гишүүд, засгийн газрын гишүүд, үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, сонгуулийн төв хорооны гишүүд, засгийн газрын гишүүд, төв банкны ерөнхийлөгч, шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтуудын үйлдсэн гэмт хэрэг, мөн авлигатай тэмцэх газрын албан хаагчдын үйлдсэн Эрүүгийн хуулийн худал мэдүүлэг өгөх, худал мэдүүлэг өгүүлэхээр албадах, мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулах, гэмт хэргийг үл мэдээлэх гэмт хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагааг явуулна.
- Дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын мөрдөгч нар нь дээр дурдсанаас бусад гэмт хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагааг явуулна.
- УМБГ-аас мөрдөн шалгах ажиллагаа явуулах хуулийн зохицуулалтыг 2014 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хуульд нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн бөгөөд мөн тус өдөр Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэн баталж¹³⁰, уг хуулиар Үндсэн хуулиар

¹³⁰law on the Public Prosecutor's Office, The Law of Ukraine, [https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=C-DL-REF\(2013\)041-e](https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=C-DL-REF(2013)041-e)

тогтоосон чиг үүрэгт харшлах тул прокурорын байгууллага нь Үндсэн хуулиар тогтоосон чиг үүрэгт хамаarahгүй чиг үүргийг гүйцэтгэхгүй гэж тухайллан зааж, хуучин прокурорын байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсныг зогсоон, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дотор Улсын мөрдөн байцаах газрыг байгуулж, тус байгууллагыг чиг үүргээ гүйцэтгэж эхлэх хүртэл прокурорын байгууллага мөрдөн шалгах ажиллагааг явуулж байхаар тогтоосон байна.

Украины парламентаас 2015 оны 11 сарын 12-ны өдөр Улсын мөрдөн байцаах газрын тухай хууль¹³¹-ийг баталж, 2016 оны 3 дугаар сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байна.

Улсын мөрдөн байцаах газар нь Засгийн газрын дэргэдэх төв байгууллага гэсэн эрх зүйн байдалтайгаар ажилладаг ба тус байгууллагаас явуулах мөрдөн шалгах ажиллагаанд Прокурорын байгууллага хяналт тавьж ажилладаг байна. УМБГ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах гэж томьёолоод харьялан шалгах субъектийг ЭХХШТХ-д зааснаар тодорхойлсон байна.

УМБГ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлд Мөрдөн байцаах албаны бүрэн эрхийг дараах байдлаар заасан байна. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх;
- Мөрдөн байцаах албаны эрх мэдэлд хамаарах гэмт хэргийг таслан зогсоох;
- Тодорхой төрлийн гэмт хэргийн мөрдөн байцаах арга зүйг боловсруулж батлуулах;
- Хуульд заасны дагуу гэмт хэргийн үр дүнд олж авсан эд хөрөнгийг хураан авах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах;
- Холбогдох чиглэлээр мэргэжилтнүүдийг сургах, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах;
- Гадаад улсын эрх бүхий байгууллагаас хүлээн авсан хууль зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх;
- Украин Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу цагдаа болон бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллах;
- Энэ хуульд заасан журмын дагуу өөрийн үйл ажиллагааны талаар тайлан гаргаж, ажлын үр дүнг олон нийтэд мэдээлэх;
- Хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Улсын мөрдөн байцаах албаны тогтолцоо нь төв аппарат, нутаг дэвсгэрийн нэгж дэх салбар, тусгай нэгж, боловсрол, судалгааны байгууллагаас бүрдэнэ. Улсын мөрдөн байцаах албаны үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтцийг мөрдөн байцаах албаны дарга нь Засгийн газартай зөвшилцэж батлахаар заасан байна.

¹³¹The Law of Ukraine “On the State Bureau of Investigation”, <https://zakon3.rada.gov.ua/laws/show/794-19>

УМБГ-ын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Украян Улсын Ерөнхийлөгч 5 жилийн хугацаагаар томилох ба улируулан томилохыг хориглоно. Улсын мөрдөн байцаах газрын дарга, түүний орлогч нарт тавигдах шаардлагад:

- 1) 35-аас доoshгүй настай;
- 2) хууль зүйн өндөр боловсролтой;
- 3) хамгийн багадаа арван жил хуулийн байгууллагад ажилласан байх;
- 4) удирдах албан тушаалд 5-аас доoshгүй жил ажилласан туршлагатай байх;
- 5) улс төрийн намын гишүүнчлэлгүй байх;
- 6) өндөр ёс суртахуунтай, нэр хүндтэй;
- 7) эрүүл мэндийн хувьд албан үүргээ биелүүлэх бүрэн чадвартай байх.

2016 оны 3 дугаар сард Засгийн газраас Ерөнхийлөгч, Парламент, Засгийн газрыг төлөөлсөн гурав гурван гишүүн буюу нийт 9 гишүүн бүхий УМБГ-ын албан хаагчдыг сонгон шалгаруулах хороог байгуулсан бөгөөд улмаар 2017 онд УМБГ-ын даргыг томилсон. УМБГ-ын дарга нь тус хорооноос нэр дэвшүүлсэн дэд дарга болон бусад мөрдөгч нарыг томилно.

Улсын мөрдөн байцаах албаны төв оффис, нутаг дэвсгэрийн нэгжийн тоонд хамаарах нийт ажилтны тоо дээд тал нь 1500 хүн байхаар хуульд заасан байна. УМБГ нь 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар нийт 295 мөрдөгч ажиллаж байгаагаас төв оффист 102 мөрдөгч, орон нутаг дахь салбарт 193 мөрдөгч ажиллаж байна.



ХОЁР. МОНГОЛ УЛС

2.1 Монгол Улсын мөрдөн байцаах албаны үүсэл, хөгжил түүний өөрчлөлт, шинэчлэл

Дотоод явдлын яамны сайдын 1946 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 504 тоот тушаалаар Цагдан сэргийлэх газрын гүйцэтгэх 1 дүгээр хэлтсийн харьяанд "... ард иргэдийн өргөдөл гомдлыг шалган барагдуулах, мөрдөн байцаалт явуулж байх үүрэгтэй тусгай группийг байгуулснаар Мөрдөн байцаах албаны үндэс суурь тавигджээ".¹³²

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1962 оны 144 дүгээр зарлиг, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн мөн оны 313 дугаар тогтоолоор Цагдан сэргийлэх ерөнхий газрын системд ажиллаж байсан Мөрдөн байцаах аппаратыг татан буулгаж, 1962 оны 07 дугаар сарын 01-нээс Прокурорын байгууллагад мөрдөн байцаах албыг төвлөрүүлэн, Улаанбаатар хотын прокурорын газарт Мөрдөн байцаах газар, аймгийн прокурорын газарт Мөрдөн байцаах группийг ажиллуулахаар шийдвэрлэжээ.¹³³

Мөрдөн байцаах ажлын удирдлага зохион байгуулалт оновчтой биш, хэргийн илрүүлэлт хангалтгүй шалтгаанаар МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 1964 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 218 дугаар тогтоолоор мөрдөн байцаах ажлыг Цагдан сэргийлэх байгууллагад шилжүүлж, НАХЯ-ны сайдын 1964 оны 511 дугаар тушаалаар Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын харьяа Мөрдөн байцаах газрыг байгуулсан.

Прокурорын байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын үндсэн хуульд нийцүүлэн зохицуулах зорилгоор Улсын Бага Хурлын 1992 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 36 дугаар тогтоолоор Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг орон тоо, төсөв, эд хөрөнгийн хамт Цагдаагийн ерөнхий газарт шилжүүлж байжээ.¹³⁴

Энэ үеэс Мөрдөн байцаах албаны үйл ажиллагаа төвлөрч, материаллаг бааз бэхжиж, дээд боловсролтой, хуульч, эрх зүйч мэргэжилтэй боловсон хүчинээр бүрэн хангагдаж, төвдөө төрөлжсөн 8 хэлтэс, аймаг, дүүргийн 31 тасагтай болсон байна.¹³⁵

Эрх зүйн тогтолцооны шинэчлэл, нийгмийн харилцааны өөрчлөлттэй холбоотойгоор "Прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 47 дугаар тогтоол батлагдсантай холбоотойгоор Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 179 дүгээр тогтоолын дагуу Мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагчдыг орон тоо, төсөв, эд хөрөнгийн хамт

¹³²mbg.police.gov.mn/news/content/id/718/type/119/menuid/86 /Мөрдөн байцаах албаны товч түүх/

¹³³lolita.blogmn.net/77730/ulsyn-murdun-baicaah-gazar.html /Улсын Мөрдөн байцаах газар/

¹³⁴dardas.mn/news/view/7830 / Авшилгатай тэмцэх газарт Мөрдөн байцаах албыг нэгтгэснээс хойш,/

¹³⁵Монгол Улсын Их Хурал "Прокурорын байгууллагын тухай" хуулийн хувийн хэрэг. /Д-5; ХН-794/

цагдаагийн байгууллагаас Улсын ерөнхий прокурорын мэдэлд шилжүүлэн, Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Мөрдөн байцаах алба байгууллагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ.¹³⁶

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай мөн өдрийн хуулиар Прокурорын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйл / Улсын прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба, 45 дугаар зүйл мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагч/-ийг тус тус хүчингүй болсноор Прокурорын байгууллагын дэргэдэх мөрдөн байцаах алба татан буудаж, тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн албан тушаал, авлигын гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байсан харьялал нь Авлигатай тэмцэх газарт шилжжээ.¹³⁷



¹³⁶Монгол Улсын Их Хурал “Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн хувийн хэрэг /Д-8; ХН-839/

¹³⁷<https://www.iaac.mn/page/54?menu=146&lang=en>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

АРМЕНИЯ УЛС:

- Закон Республики Армения "О Специальной Следственной Службе" <http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus>
- Устав государственного управленческого учреждения "Аппарат Специальной Следственной Службы Республики Армения" <http://www.ccc.am/ru/1428578692/55>
- Специальная следственная служба Республики Армения <http://www.ccc.am/ru/>

ОХУ:

- "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ
- Положение о Следственном департаменте МВД РФ. Утвержден приказом МВД России от 1 июля 2011 г. N 780 "Об утверждении положения о Следственном департаменте Министерства внутренних дел РФ". Эх сурвалж: ДХЯ-ны цахим хуудас: <https://sledcom.ru> - 2019.04.04.
- Конституция РФ (12.12.1993). Эх сурвалж: <http://www.constitution.ru>
- Закон О Следственном комитете РФ от 28.12.2010 N 403-ФЗ. Эх сурвалж: https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija
- Уголовно-процессуальный кодекс РФ от 18.12.2001 г. № 174-ФЗ. Эх сурвалж: <http://ivo.garant.ru>
- Уголовный кодекс РФ от 13.06.1996 N 63-ФЗ. Эх сурвалж: <http://www.consultant.ru>
- Указ Президента РФ № 1182 от 27.09.2010 "Вопросы Следственного комитета РФ".
- Эх сурвалж: https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija - 2019.04.04.
- Указ Президента РФ № 14.01.2011 "Вопросы деятельности Следственного комитета РФ".
- Эх сурвалж: https://sledcom.ru/documents/Pravovaja_informacija - 2019.04.04.
- МБХ-ны түүх. Эх сурвалж: МБХ-ны цахим хуудас: <https://sledcom.ru> - 2019.04.04.
- МБХ-ны түүх. Эх сурвалж: МБХ-ны цахим хуудас: <https://sledcom.ru> - 2019.04.04.
- ФЗ О Следственном комитете РФ от 28.12.2010 г. № 403-ФЗ.
- Указ Президента РФ от 14.01.2011 № 38 "Вопросы деятельности СК РФ".

МОНТЕНЕГРО УЛС:

- law on special public prosecutor's office of Montenegro [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2015\)012-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2015)012-e)
- <https://www.tuzilastvocg.me/index.php/en/special-state-prosecutor-s-office>

ӨМНӨД СОЛОНГОС УЛС:

- https://www.unafei.or.jp/publications/pdf/RS_No53/No53_13VE_Soo.pdf
- <http://www.spo.go.kr/site/eng/main.do>
- <http://www.law.go.kr/법령/검찰청법/-Прокурорын байгууллагын хууль /солонгос хэлээр/>

АНУ:

- <https://fas.org/sgp/crs/misc/R44857.pdf>
- <https://www.law.cornell.edu/cfr/text/28/part-600>
- <https://www.justice.gov/crt/law-enforcement-misconduct>
- <https://www.justice.gov/crt/addressing-police-misconduct-laws-enforced-department-justice>
- <https://www.law.cornell.edu/uscode/text/18/242>
- <https://www.law.cornell.edu/uscode/text/34/12601>
- <https://www.justice.gov/opa/press-release/file/967231/download>

УКРАИН УЛС:

- [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2014\)047-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2014)047-e)
- <https://www.unian.info/politics/2252799-ukraines-state-bureau-of-investigation-completely-replaces-pgo.html>
- <https://www.kyivpost.com/ukraine-politics/state-bureau-of-investigation-to-officially-commence-work-on-nov-27.html>
- <https://antac.org.ua/en/analytics/who-will-lead-the-state-bureau-of-investigations/>
- Criminal procedure code of Ukraine, <https://rm.coe.int/16802f6016>
- <https://zakon.rada.gov.ua/laws/show/en/794-19>
- law on the Public Prosecutor's Office, The Law of Ukraine, [https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-REF\(2013\)041-e](https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-REF(2013)041-e)
- The Law of Ukraine "On the State Bureau of Investigation", <https://zakon3.rada.gov.ua/laws/show/794-19>

МОНГОЛ УЛС:

- mbg.police.gov.mn/news/content/id/718/type/119/menuid/86 /Мөрдөн байцаах албаны товч түүх/
- lolita.blogmn.net/77730/ulsyn-murdun-baicaah-gazar.html /Улсын Мөрдөн байцаах газар/
- lolita.blogmn.net/77730/ulsyn-murdun-baicaah-gazar.html /Улсын Мөрдөн байцаах газар/
- www.legalinstitute.mn/

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН БОЛОН ТЭДГЭЭРИЙН АЖЛЫН АЛБАДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

(Харьцуулсан судалгаа)

Д.Халиун, Р.Оргилмаа

АГУУЛГА

НЭГ. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Афганистан (2011-2016)
- Замби (2015-2019)
- Тринидад Ба Тобаго (2013-2018)
- Кирибати (2017-2022)
- Өмнөд Африк (2014-2019)
- Руанда (2011-2015)
- Съерра Леон (2016-2019)
- Уганда (2014-2018)
- Пакистан (2014-2018)
- Бутан (2014-2018)
- Киргиз (2016-2021)
- Соломоны Арлууд (2017-2021)

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Австрали
- Их Британи
- Молдова
- Шинэ Зеланд

АШИГЛАСАН МАТЕРИАЛ



НЭГ. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү судалгаанд гадаадын улс орнуудын Парламентын стратеги төлөвлөгөө, зорилго, зорилтуудыг харьцуулсан болно. Мэдээллийн хайлт хийж судлахад 13 улс (Афганистан, Бутан, Замби, Зимбабве, Кирибати, Киргиз, Соломоны Арлууд, Съерра Леон, Тринидад ба Тобаго, Өмнөд Африк, Пакистан, Руанда, Уганда)¹³⁸ Парламентын стратеги төлөвлөгөөгөө олон нийтэд нийтэлсэн байна. Үүнээс гадна гадаадын зарим орны хувьд Парламентын аппарат буюу ажлын албаны стратеги төлөвлөгөө¹³⁹ (Австрали, Бангладеш, Канад, Их Британи, Молдова, Шинэ Зеланд зэрэг), эсхүл муж улсын түвшний хууль тогтоох байгууллагын стратеги төлөвлөгөө (тухайлбал: Австрали, Канадын муж улсууд, Шотланд гм.), эсхүл тодорхой чиглэлээр, тухайлбал: Парламентын МХХТ-ийн Стратеги төлөвлөгөө зэргийн хүрээнд батлан хэрэгжүүлж байна.

Судалгаанд хамрагдсан 13 улсын Парламентын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацааны хувьд 3-5 жил байх ба үүний талаас дээш хувь нь 4 жил байх бол 1/3 нь 5 жилээр төлөвлөсөн байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Парламентын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа

Парламентын Стратеги төлөвлөгөөний хугацаа		
3 жил	1 улс	Съерра Леон
4 жил	7 улс	Бутан, Пакистан, Руанда, Соломоны Арлууд, Уганда, Киргиз, Замби
5 жил	5 улс	Афганистан, Кирибати, Өмнөд Африк, Тринидад ба Тобаго, Зимбабве

Судалгаанд хамрагдсан 13 улсаас 7 улсын Стратеги төлөвлөгөөний хугацаа дууссан боловч, шинэчлэн нийтлэгдээгүй байгаа бол 6 улсын Стратеги төлөвлөгөө хүчин төгөлдөр хэрэгжиж байна.



¹³⁸Судалгаанд хамрагдсан ихэнх орнуудын Парламентын стратеги төлөвлөгөөг гол төлөв олон улсын байгууллагууд (Олон улсын парламентын холбоо, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Хамтын нөхөрлөлийн орнуудын холбоо, Parliamentarians for Global Action-PGA, The Association of European Parliamentarians with Africa -AWEPA)-ын төсөл, хөтөлбөрийн хүрээнд боловсруулан, хэрэгжүүлж байна.

¹³⁹Гадаадын зарим улс орнуудын Парламентын аппарат буюу ажлын албаны стратеги төлөвлөгөөг Хавсралт 3-аас дэлгэрүүлж үзнэ үү.

Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудын тоо хэмжээний хувьд судалгаанд хамрагдсан улс орнууд 4-6 үндсэн зорилт дэвшүүлсэн бол 5 улс нийт 6 стратеги зорилт, харин 4 улс 4-5 стратеги зорилт тус тус дэвшүүлсэн байна. Парламентын стратеги төлөвлөгөөнд парламентын чиг үүрэгтэй холбоотой асуудлыг улс орнууд хэрхэн эрэмбэлснийг Хүснэгт 2-оос үзнэ үү.

Парламентуудын стратегийн тэргүүлэх чиглэлийг хэрхэн тодорхойлсныг авч үзвэл парламентын гол чиг үүргүүд болох хууль тогтоох, хянан шалгах, төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлуудаас гадна Парламентын Аппарат буюу ажлын албатай холбоотой асуудлыг дийлэнх парламентууд стратеги төлөвлөгөөндөө тусгасан байна. Үүнээс парламентын хяналтын, төлөөллийн чиг үүрэгтэй холбоотой асуудлыг судалгаанд хамрагдсан бүх парламент бие даасан зорилт болгон тусгасан бол хууль тогтоох чиг үүрэгтэй холбоотой асуудлыг 12, Парламентын ажлын албатай холбоотой асуудлыг 11 улс тусгасан байна. Парламентын гадаад харилцаатай холбоотой асуудлыг нийт 4 улс бие даасан зорилт болгон дэвшүүлсэн байгаа бол зарим орнуудад парламентын хөгжлийн түвшин, улс орны нөхцөл байдал зэргээс хамааран Парламентын бие даасан, хараат бус байдал (*Parliamentary autonomy*), сонгуульт албан тушаалтны чадавх (MP's capacity), Парламентын дэд бүтэц, Цахим парламент (*e-Parliament*), Парламентын сургалт, судалгааны нэгж, Үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх механизм (*National development goals*), жендерийн эрх тэгш байдал (*gender mainstreaming*) зэрэг асуудлыг бие даасан стратеги зорилт болгон дэвшүүлсэн байна. (Хүснэгт 3) Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

Хүснэгт 2. Парламентын Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн зорилтууд, тэдгээрийг эрэмбэлсэн байдал

Улс	Хууль тогтоох үйл ажиллагаа	Хяналтын үйл ажиллагаа	Үйл ажиллагааны ил тод байдал, төлөөллийн чиг үүрэг	Гадаад харилцаа	Парламентын ажлын алба	Бусад	Нийт зорилтын тоо
Афганистан	1	2	4	-	5	3,6	6
Бутан	2	3	4	-	1	-	4
Кирибати	2	3	4	-	5	1	5
Пакистан	1	2	3	-	4	5,6	6
Руанда	1	2	4	5	6	3	6
Съерра Леон	2	3	4	-	1	-	4
Соломоны арлүүд	2	3	4	-	-	1	4
Өмнөд Африк	5	1	3	4	6	2	6
Тринидад ба Тобаго	2	3	4	-	-	1	4
Уганда	-	3	2	5	1	4,6	6
Киргиз	2	3	1	5	4	-	5
Замби	1	2	4	-	+ ¹⁴⁰	3,5	5
Зимбабве	1	2	3	-	4	5	5
Нийт	12	13	13	4	11		

¹⁴⁰Замби Улсын Парламентын стратеги төлөвлөгөө нь Парламентын үйл ажиллагаатай холбоотой болон Парламентын ажлын албатай холбоотой гэсэн хоёр хэсгээс бүрдэж байна.

Хүснэгт 3. Парламентын Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан (бусад) зорилтууд

Бусад	Парламентын хараат бус, бие даасан байдал, гишүүдийн чадавх	Барилга байгууламж, дэд бүтэц	Цахим парламент	Сургалт, судалгаа	ҮХ-р тогтоосон сурь зарчим, Үндэсний хөгжлийн зорилтууд	Төсөв	Жэнэр	ЗГ-тай харилцах харилцаа
Афганистан	v	v						
Кирибати	v							
Пакистан			v	v				
Руанда					v			
Соломоны Арплуд	v							
Өмнөд Африк								v
Тринидад ба Тобаго	v							
Уганда		v			v			
Замби	v					v		
Зимбабве							v	

Улс орнуудын Стратеги төлөвлөгөөнд түүнийг боловсруулах болсон үндэслэл, шалтгаан, нөхцөл байдлын судалгаа (Киргиз), хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө/Implementation roadmap (Бутан, Сьерра Леон, Руанда, Киргиз), хүрэх үр дүн/milestones, хүлээгдэж буй үр дүн/expected results (Пакистан, Руанда), шалгуур үзүүлэлт (Өмнөд Африк, Уганда), төсөв (Өмнөд Африк, Киргиз), хяналт шинжилгээ (Руанда) зэргийг тусгасан байна.

Улс	Хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө	Хүрэх үр дүн/ milestones	Шалгуур үзүүлэлт/ Indicators	Төсөв	Хяналт шинжилгээ /Monitoring and evaluation	Бусад
Афганистан	-	-	-	-	President of the House and the Administrative Board	Annual evaluation Final evaluation (2016)
Руанда	Timeframe	Expected results	Performance indicators	Budget	Steering Committee Internal Committee in each Chamber	Annual evaluation Mid-term evaluation (2013) Final evaluation (2015)

Тринидад ба Тобаго	-	-	-	-	Project Implementation, Monitoring and Evaluation Unit	Two-monthly written updates. An annual written report. Mid-term review of the Strategic Plan, conducted by an external, independent consultant as selected and recruited by the Office of Parliament
Уганда	-	Means of verification	Performance indicators +	-	Independent consultants commissioned by Parliamentary Commission.	Annual evaluation Mid-term evaluation (2016) Final evaluation

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ПАРЛАМЕНТЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДСЭН ЗОРИЛТУУДЫГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАСАН ЗОРИЛТУУДТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Стратеги зорилт 1. Ардчилсан нийгмийн хөгжлийн чиг хандлага, зарчмын дагуу хувь тогтоох үйл ажиллагааны зохион байгуулалтыг зохион байгуулалтыг бүх талаар хөгжүүлэх, чанар. Үр дүнг дээшшуулэх.	Стратеги зорилт 2. Улсын хянан хангийн чиг хандлага, зарчмын дагуу хувь тогтоох үйл ажиллагааныхаа тохижуулалтыг уламзхийн болгоож, түүний үр дээшшуулэх.	Стратеги зорилт 3. Улсын Их Хурлын арчилсан тулгуулан арга зохиб, ажиллагааныхаа тохижуулалтыг уламзхийн болгоож, түүний үр дээшшуулэх.	Стратеги зорилт 4. Улсын Их Хурлын гадаад, уламзхийн парламент хөгжүүлэх, хамтын ажиллагааны үр дүнг дээшшуулэх.	Стратеги зорилт 5. Парламентын ажлын мэргэжлийн алба болох парламент газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, Уйншилгээний хөнгөөн арга чанарыг сайжруулах.	Бусад
2. Киррибати ¹⁴¹	Зорилт 2 – Парламент баталсангаас замаар эрхэд сурилсан, оролцоон дээр тулгуурласан, тогтвортой хөгжлийг хангахад төрийн санийн эх үсвэрлийг хамгийн дээд хэмжээнд бамтгана байна	Зорилт 3 – Парламент нь Засийн газарт Үр дунгийн хангахад тавих замаар эрхэд сурилсан, оролцоон дээр тулгуурласан, тогтвортой хөгжлийг хангахад төрийн санийн эх үсвэрлийг хамгийн дээд хэмжээнд бамтгана байна	Зорилт 4 – Парламент ирээдийн парламентын ардчилалд итгэх итгээний бажгуулэхд олон даяар иргэд, олон нийтийн харилцах харилцааг идэвхтэй хөгжүүлж, илүү нээлттэй ил тод, оролцоого хангасан бамгууллага байна	Зорилт 5 – Слиker, Парламентын тишүүд болон бусад тол Уйншилгээний бамгаалжсан болон ардчилсан унэт зүйлсийг сурталчилж, хариуцлагатай удирдагч нар хэмээн хүлээн зөвшөөрдсөн баих	Зорилт 1 – Парламентын Слиker болон тишүүд итгээний бамгаалжсан болон ардчилсан унэт зүйлсийг сурталчилж, хариуцлагатай удирдагч нар хэмээн хүлээн зөвшөөрдсөн баих
3. Киргиз Улс ¹⁴²	3.2. Хувь тогтоох үйл ажиллагаа	3.3. Хяналтын үйл ажиллагаа	3.1. Төлөөлийн үйл ажиллагаа	3.5. Олон улсын үйл ажиллагаа	3.4. Дун шинжилгээний үйл ажиллагаа
4. Соломоны Аргууд ¹⁴³	2. Парламентын хувь тогтоох үйл ажиллагааг боловсрончийн болгох	3. Парламентын Засийн газарт Үр дунгийн хангахад тавих чадвавхыг сайжруулах	4. Парламентын боловсроол, олон нийтийн харилцах болон гишүүдийн	1. Парламентын Улсад Уйншилгээний бамгаалжсан, Парламентын	

¹⁴¹ Kiribati Parliament Corporate Strategic Plan (2017-2022) https://agora-parl.org/sites/default/files/kiribati_parliament.corporate.strategic_plan_final_max_2010.pdf

¹⁴² СТРАТЕГИЯ развития Жогорку Кенеша Каиральской Республики до 2021 года <http://cpd.minjust.gov.kg/act/view/ru-ru/82056>

¹⁴³ National Parliament of Solomon Islands Strategic Plan 2017-2021 <http://www.parliament.gov.sb/files/Parliament%20Strategic%20Plan%2017To21.pdf>

	замаар хууль тогтоомжийн чанарыг сайжруулах	төвлөөллийн чиг Ургийг сайжруулах		ажилтнуулын чадавхыг бэхжүүлэх.		
5. Съерра Леон ¹⁴⁴	Зорилт 2: Хууль тогтоо чадавхыг бэхжүүлэх	Зорилт 3: Хяналтын чадавхыг бэхжүүлэх	Зорилт 4: Парламентыг нээлттэй болгох	Зорилт 1: Институцийн чадавхыг бэхжүүлэх		
6. Замбий ¹⁴⁵	Стратегиин зорилт 1: Үндэсний Ассамблейн хууль тогтоо чиг Ургээ үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх.	Стратегиин зорилт 2: Хувь тогтоох байгуулалтын Гүйцэтгэх эрх мэдээд үр дүнтэй хяналт тавих чадавхыг бэхжүүлэх.	Стратегиин зорилт 4: Үндэсний Ассамблейн төвлөөллийн чиг Ургийг бэхжүүлэх.	Парламентын Захиргааны (Administration) стратегийн зорилтууд Стратегиин зорилт 1: Үндэсний Ассамблейд чиг Ургээ үр дүнтэй биенгуулэхдэд үзүүлэх дэмжлэгийг бэхжүүлэх. Стратегиин зорилт 2: Захиргааны Уйличигээ сайжруулах. Стратегиин зорилт 3: Парламентын тишигдээд ажилтнууд албан Ургээ илүү үр дүнтэй гүйцэтгэхэд чиглүүлэн дэд бүтцийг хөгжүүлэх.		
7. Эмнэл Африк ¹⁴⁶	1.7.5 Үндсэн хуулиар хулээсэн хууль тогтоох Ургээ хэргүүлэхэд нь Парламентын чадавхыг нэмэгдүүлэх	1.7.1 2014-2019 оны дунд хугацааны стратегиийн төвлөөлөвийн зорилтуудыг хэрэгжүүлэх	1.7.3 Олон нийтийн орцоноо заварыг хэрэгжүүлэх замаар ардчиллыг хөгжүүлэхд 2019 он гэхэд Парламентын	1.7.4 Парламентын олон улсын хамтын ажиллагааг сайжруулах	1.7.6 Парламентын гишүүдэд үндсэн хуулиар хүлээсэн Ургээ үр дүнтэй биенгуулэхд нь үр өгөжтэй, чадварлаг	1.7.2. Нэгдмэл ашиг сонирхлын асуудлаар тэр, засгийн бусад саibартай хамтран ажиллаж, засгийн

¹⁴⁴ Strategic Plan of the Parliament of Sierra Leone 2016-2019. With the support of United Nations Development Programme (UNDP). https://agora-parl.org/sites/default/files/parliament_strategic_plan_final-sierra_leone.pdf

¹⁴⁵ Парламент болон Тамын газрын Странын төслийн, <http://www.parliament.gov.zm/sites/default/files/documents/pages/Final%20National%20Assembly%20Strategic%20Plan%281%29.pdf>,

¹⁴⁶ STRATEGIC PLAN FOR THE 5th DEMOCRATIC PARLIAMENT 2014-2019. <https://www.parliament.gov.za/storage/app/media/StratPlan/5strat%20plan%202013may%202015.pdf>,

				Уйцилгээ Узүүлэх газар хоорондын харилцааг бэхжүүлэх	
8.	Пакистан ¹⁴⁷	Зорилт 1. Хуль тогоомжийн холбоотой бүх асуултыг Пакистаны ард түмэнд үр нэлвөтгий үр ашигтай байхаар бэхжүүлэх;	Зорилт 2. Хянантай бүх цаг Уеийн турш, бүхий л түвшинд, ялангуяа Парламентын Хороодын түвшинд, ил тод байдал давамгайлж, цаг хугацаа, нөвчийн зохицтой ашиглалтад харуулсанга хүлээгжэх боловжтой байхаар баталгаажуулах;	Зорилт 3. Ассамблейн Төлөөллийн чиг Ургийг сайжруулах замаар Ассамблейн шударга Байдлыг сахижж. ИМУУ мэдээлэлтэй, сонирооч, төлөөлж буй Тойргүүдийнхаяа ХИНДЛЭЛ хүлээсэн болгох;	Зорилт 4. Тажхимын бүхий л чиг Урээ, Үйл ажиллагааг Үр ашигтай болгох;
9.	Уганда ¹⁴⁸			Стратеги зорилт 3 Байгууллагын хянантай-	Стратеги зорилт 5 Стратеги зорилт 1 Угандаагийн гадаад. Парламентын бүрэн
				Стратеги зорилт 4 Парламентын	

¹⁴⁷ Strategic Plan 2014-2018 of the National Assembly of Pakistan http://www.na.gov.pk/uploads/1439219002_845.pdf
¹⁴⁸ Uganda - Five-year strategic plan for the Parliament (2014-2018) <https://agora-parl.org/sites/default/files/uganda - five-year strategic plan for the parliament 2014-2018.pdf>

		Шинжилгээ, чиглэгэнд үр дүнтэй тогтолцоог бий болгох замаар Парламентын хариуцалтын тогтолцоог бэхжүүлэх	ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх - хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдээлд хянант тавих	Бодлогын хүрээнд Парламентын гадаад харилцаа, олон улсын оролцог сайжруулах	Эрхээс хэрэгжүүлэх чадвагыг нь бэжжүүлэх	шудараа, тогтвортой хөгжлийн үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд оролцог Стратеги зорилт 6 Үр ашиг, бүтээмжийг сайжруулжад Парламент (танхим, хорооны өрөө, машины зогсоол, оффис гэх мэт)ын барилга байгууламжийг өргөтгэх
2. Засгийн газартай хамтран холбогдох салбарын хөгжлийг богино болон урт хугацааны тэргүүлэх чиглэлийг харгалзан хууль тогтоох ажиллагааг тодорхой төлөвлөх. Холбогдох салбарт хууль батлах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тооцоолох (таамаглах) практикийг Парламентын үйл ажиллагаанд нэвтрүүлэх. Хүлээгдэж буй үйл явдлыг урьдчилан таамаглах, хууль шаардлагатай эсэхэд бодитой дүгнэлт гаргахыг Засгийн газарт үүрэг өгөх;
3. Хууль эрх зүйн болон төрөлжсөн мэргэжлийн дүн шинжилгээ, хууль зүйн техниктэй холбоотой мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. Одоо дагаж мөрдэж байгаа хууль тогтоомжийг тогтмол хянах (хууль тогтоомжийг эргэн хянаж үнэлэх/ретроспективная оценка законодательства) тогтолцоог бий болгож, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалыг хэрэглэх байдлаар батлагдаж буй хууль тогтоомжийн чанарыг сайжруулах;
4. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг гагцхүү мэргэшсэн мэргэжилтнүүдээр гүйцэтгүүлж, тэдгээрийн мэргэшүүлэн хөгжүүлэх боломжийг олгосон шаардагдах хууль эрх зүйн зохицуулалт, бүтэц зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлэх;
5. Хэлэлцэж буй хуулийн төсөлд олон нийтээс санал авах, санаа бодлыг тусгах ажлыг сайжруулах. Олон нийттэй зөвлөлдөх нэгдсэн арга барилыг боловсруулах. Хуулийн төслийг боловсруулахаас

өмнө олон нийтийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах, түүнчлэн аливаа хууль тогтоомжийн хэрэгцээг шаардлагыг тодорхойлоход олон нийтийн оролцоог хангах.

3.3. Хяналтын үйл ажиллагаа

1. Парламентын хяналтын зорилго, объект, хэлбэрийг тодорхой зааж өгсөн дүрэм, журам боловсруулах. Бүгд найрамдах улсын төсвийн гүйцэтгэлийн биелэлт үр дүнтэй байдлыг шалгах шалгуурыг боловсруулж хэрэгжүүлэх. Тооцооны танхим (Счетная палата)-ын Парламентад хүргүүлдэг тайланд Парламентаас баталсан улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүд болон төсвийн зарцуулалтын нийцэл/ул нийцлийн талаар тусгуулах шаардлага тавих;
2. Гишүүний асуулга, парламентын хэлэлцүүлгийн дэг, “Засгийн газрын цаг/засгийн газрын өдөр” (Ерөнхий сайдын мэдээллийн цаг), парламентын мөрдөн шалгах (парламентского расследования) зэрэг процедурын стандарт, парламентын хяналтын төлөвлөлтийн төлөвлөгөө боловсруулж, үйл ажиллагааны нарийвчилсан арга зүйн журам боловсруулж, нэвтрүүлэх;
3. Хяналтын төлөвлөлтийн механизмыг нэвтрүүлж, Парламентын хяналтад хороодоор тэргүүлэх үргийг гүйцэтгүүлэх. Парламентын хяналтад бүлгүүдийн эрх үүргийн/бүрэн эрхийн хязгаарыг тогтоох. Парламентад ажлаа хариуцан тайлагнадаг төрийн байгууллагууд (тайлагнах давтамж, асуудлын хамрах хүрээ, үнэлгээний шалгуур гэх мэт)-ын жил бүрийн тайлан гаргах шалгуур, хэлбэрийг нарийвчлан тогтоох;
4. Парламентын аппарат нь парламентын хяналттай холбоотой ажлын тасралтгүй, тууштай, үр дүнтэй байдлыг хангах бөгөөд давхардал, давтан хяналтыг арилгана. Үүний тулд Аппарат дараах үүргийг хэрэгжүүлнэ:
 - тодорхой асуудлаар хариуцлагатай шийдвэр гаргах, байр суурь илэрхийлэхэд шаардлагатай мэдээллийг авах, цуглуулах;
 - хүлээн авсан мэдээллийн урьдчилсан боловсруулалт хийх;
 - хүлээн авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үнэлэх;
 - тодорхой асуудлаар байр суурь болгох;
 - хууль эрх зүйн тогтолцоог тогтмол хянах;
 - батлагдсан хуулийг хэрэгжүүлэх талаарх мэдээллийг бэлтгэх;
 - Парламентын хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх талаарх гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны урьдчилсан үнэлгээ.

3.4. Дүн шинжилгээний үйл ажиллагаа

1. Парламентын хороодын эрхэлсэн салбарын хүрээнд төрийн бодлогыг боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх. Хороод нь салбарын хөгжлийн асуудлуудыг тэргүүлэх чиглэлийг тодорхойлох шалгуурыг бий болгох хэрэгтэй. Холбогдох хороод (Профильные комитеты) нь хангальтай нөөц (хууль эрх зүйн, институцийн, хүний нөөцийн, мэдээлэл г.м.)-р хангагдсан байна;
2. Аппаратын ажилтнуудын аналитик, судалгааны ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах. Парламентын аппаратын ажилтнуудад зориулж улс орны хөгжлийн гол асуудлуудын талаар арга зүйн семинарыг тогтмол зохион байгуулах практикийг нэвтрүүлэх;
3. Парламентын аппаратын дүн шинжилгээний үйл ажиллагаанд оролцдог ажилтнуудад материаллаг болон материаллаг бус урамшуулалт олгох тогтолцоог нэвтрүүлж, улирлын ажлын үр дүнг үнэлэхэд тус ажлыг зайлшгүй тусгах. Парламентын аппаратын аналитик, дүн шинжилгээний ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах;
4. Одоогийн Судалгааны Төвийг Парламентын Хөгжлийн Төв болгон зохион байгуулж, түүний түр хугацааны хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр шинжээчдийг ажиллуулах эрх мэдлийг өргөтгэх;
5. Парламентын дотоод сүлжээнд дүн шинжилгээний ажлууд (VIP-net)-ыг нийтлэх. Удирдлага нь ажилтнуудад урамшуулалт олгоходоо дээрх нийтэлсэн ажлуудыг харгалзан үзэх ба давхардсан эсэхэд хяналт тавина. Шинжээчдийн хэвтээ харилцааны дотоод форумыг бий болгох.

3.5. Олон улсын үйл ажиллагаа

1. Киргиз Улсын гадаад бодлогын зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай. Хууль тогтоох байгууллагын хүрээнд энэ нь орчин үеийн улс төрийн сэтгэлгээг бий болгох, нийцүүлэх, Парламентын хяналтыг тогтолцоог бий болгоход чиглэгдэнэ;
2. Олон улсын байгууллагын үйл ажиллагаанд парламентын гишүүдийн олон талт оролцоог хангах: дэлхийн хэмжээнд (ЮНЕСКО, Олон улсын парламентын холбоо) болон бүсийн хэмжээнд (PACE, IPA CIS, OSCE PA);
3. Парламентын болон гадаад бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцдог засгийн газрын байгууллагуудтай хамтран ажиллах харилцааны зохицуулалтын механизмыг бий болгох.

1.12.СОЛОМОНЫ АРЛУУД (2017-2021)

1. Парламентын улсад үйлчлэх чадавхыг хөгжүүлэх; Парламентын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх

- 1.1. Парламентын бие даасан, хараат бус байдал;
- 1.2. Парламентын орчны өөрчлөлтийн талаарх Үндэсний парламентын албаны үйлчилгээг сайжруулах;
- 1.3. Хүний нөөцийг бэхжүүлэх;
- 1.4. Парламентын дэд бүтцийг хөгжүүлэх;
- 1.5. Цахим парламент байгуулах;
- 1.6. Парламентын үйл ажиллагааны үр дүнтэй тайлагнал;
- 1.7. Парламентын гишүүдийн чадавх, мэргэжлийн үр чадварыг хөгжүүлэх;
- 1.8. Бус нутгийн болон олон улсын харилцаа холбоог хөгжүүлэх, дэмжих;
- 1.9. Парламентын Санхүүгийн удирдлагын менежментийг бэхжүүлэх (*Strengthen the Parliament Office Finance Management*);
- 1.10. Ёс зүйн дүрэм;
- 1.11. Парламентын үйл явдлын хуанли;
- 1.12. Парламентын жендэрийн бодлого.

2. Парламентын хууль тогтоох үйл ажиллагааг боловсронгуй болгох замаар хууль тогтоомжийн чанарыг сайжруулах

- 2.1. Хууль тогтоох үйл явцын хуваарь;
- 2.2. Парламентын хууль тогтоомжийн төслийг боловсруулах чадавхыг бэхжүүлэх;
- 2.3. Спикерийн зөвлөл байгуулах хувилбаруудыг судлах;
- 2.4. Хууль тогтоох процесийг зөвлөлдөх;
- 2.5. Хуулийн төслийн үр нөлөөг судлах;
- 2.6. Хууль тогтоох үйл явцад оролцох гишүүдийн чадавхыг нэмэгдүүлэх;
- 2.7. Дэгийг шинэчлэн боловсруулах;
- 2.8. Жендэрийн асуудлыг хууль тогтоомж, бодлогод тусгах.

3. Парламентын Засгийн газарт үр дүнтэй хяналттавих чадавхыг сайжруулах

- 3.1. Парламентын хороодыг бэхжүүлэх;
- 3.2. Үр дүнтэй төсвийн хяналт;
- 3.3. Номын сан, судалгааны үйлчилгээг сайжруулах замаар Парламентын хяналтын чадавхыг нэмэгдүүлэх;
- 3.4. Бие даасан хяналтын байгууллагатай харилцах;
- 3.5. Хяналт, төлөөллийн чиг үүрэгтэй холбоотойгоор жендэрийн асуудлыг бодлого, хууль тогтоомжид тусгах.

4. Парламентын боловсрол, олон нийттэй харилцах болон гишүүдийн төлөөллийн чиг үүргийг сайжруулах

- 4.1. Олон нийтийн харилцаа, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;
- 4.2. Парламентын ажилд залуучуудыг оролцуулах;
- 4.3. Парламент болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хоорондын харилцааны ач холбогдлыг таньж мэдэх;

- 4.4. Парламентад хэрэглэгчдэд ээлтэй хэвлэл мэдээллийг боловсруулах, шинэчлэх;
- 4.5. Парламентын төлөөллийн чиг үүргийг нэмэгдүүлэх хувилбаруудыг судлах;
- 4.6. Жендерийн асуудлыг хууль, бодлогод тусгах;
- 4.7. Орон нутгийн хууль тогтоох байгууллагуудтай холбоо тогтоох.

ХОЁР ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү судалгаанд Австрали, ИБУИНХУ, Молдова, Шинэ Зеланд Улсын парламентын ажлын албадын стратеги зорилтыг авч үзлээ.

1. Парламентын үндсэн 3 чиг үүрэг болох хууль тогтоох, хянан шалгах, төлөөлөх чиг үүрэг болон парламентын тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллах үүргийн хүрээнд дээрх 4 улсын парламентын ажлын албадын стратеги төлөвлөгөөг харьцуулан, нийтлэг болон онцлог зорилтуудыг түүвэрлэв.
2. Парламентын ажлын албадын стратеги төлөвлөгөө

1. Парламентын үндсэн 3 чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нийтлэг болон онцлог стратеги зорилтууд

Хууль тогтоох болон хянан шалгах чиг үүргийн хүрээнд

Нийтлэг

1. Парламентын гишүүдийг цаг үеийн асуудлаар, нэгдсэн болон байнгын, түр хороодын хуралдаанд шаардлагатай үнэн зөв, мэдээ мэдээлэл, санал зөвлөмжөөр хангаж ажиллах;
2. Хуулийн төсөл болон парламентаар хэлэлцэх аливаа асуудал судалгаа шинжилгээ, баримт нотолгоон дээр үндэслэсэн байх;
3. Хууль батлагдахаас өмнө болон батлагдсаны дараа нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг судлах, үнэлгээ хийх;
4. Парламентын гишүүдэд шаардлагатай мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын албаны ажилтан, албан хаагчдыг мэргэшүүлэх, дадлагажуулах, хөгжүүлэх, тэдний чадавхыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах;
5. Парламентын хяналт шалгалтын чадавхыг бэхжүүлэх, хяналт шалгалтын үйл явцыг тодорхой болгох;
6. Парламентын үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээ мэдээллийг парламентын үндсэн веб хуудсан дээр байршуулж байх;
7. Парламентын үндсэн интернэт сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, сүлжээний хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлгөөнт интернэт сүлжээний технологийг үйлчилгээндээ ашиглах;

8. Парламентын гишүүд, тэдгээрийн туслах ажилтнууд, ажлын албаны ажилтнуудыг өндөр хурд бүхий, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах, хэрхэн ашиглах сургалт зохион байгуулж байх;
9. Мэдээлэл түгээлт, солилцоог хялбарчлах, цахимжуулах;

Онцлог

1. Хууль зүйн техникийн гарын авлагыг боловсруулах;
2. Ажлын албаны ажилтнуудад шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал бодлоо илэрхийлэх, хувь нэмрээ оруулах боломжоор нь хангаж ажиллах;
3. Парламентаас гадна эрдэмтэн, судлаачидтай хамтарч ажиллах;
4. Парламентын гишүүдийн болон парламентын ажлын албаны төсөв, түүний зарцуулалтыг цаг хугацаанд нь тайлагнах, төсвөө хэрхэн зөв хянаж, зарцуулахад зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, төсөв, санхүүгийн тайлангаа интернэт сүлжээгээр хүлээн авах, хянах боломжийг олгох;

Төлөөлөх чиг үүргийн хүрээнд

Нийтлэг

1. Парламентын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан, тэдний сонирхож буй асуудлаар мэдээлэл өгч, ард иргэдийн санал бодлыг сонсож, хууль тогтоох үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллах;
2. Парламентын цахим хуудас болон нийгмийн сүлжээгээр үйл ажиллагаагаа мэдээлж байх;
3. Парламентын цахим хуудас, парламентын үйл ажиллагааг сурталчлах парламентын дэргэдэх болон орон нутагт байрлах төвүүдээр дамжуулан иргэдийн санал бодлыг сонсох, үйл ажиллагаандаа тусгах байдлаар хамтарч ажиллах;
4. Иргэдийн парламенттай харилцах харилцааг нэмэгдүүлэх зорилгоор парламентын ордоо зочилж, нэгдсэн болон хороодын хуралдааны үйл явцтай танилцах боломжоор хангах;

Онцлог

1. Парламентын үйл ажиллагааг сурталчилсан, таниулсан нээлттэй өдөрлөг зохион байгуулах, иргэд олон нийтийг парламентын удирдлагуудтай уулзах боломжоор хангах;
2. Залуучууд, өсвөр үеийнхэн, бага орлоготой иргэд нь парламентын үйл ажиллагаа, ач холбогдлын талаар мэдээлэл хомс байдагтай холбоотой тэдэнд мэдээллийг ойлгомжтой, хялбар байдлаар хүргэхийг зорих;
3. Парламентын боловсролыг түгээх аргыг өргөжүүлж, сургуулийн насны хүүхдүүдийг парламенттай, түүний үйл ажиллагаатай нь сургалтын хөтөлбөрөөр дамжуулан танилцуулах;
4. Ард иргэдэд парламентын талаарх мэдээ мэдээллийг дүрс бичлэгээр, хэвлэмэл байдлаар, инфографикаар гэх мэтчилэн олон төрлөөр түгээх;

**Парламентын тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллах
чиг үүргийн хүрээнд**

Нийтлэг

1. Ажлын алба нь ажил үүргээ чанартай хийж гүйцэтгэх үүднээс ажлын ачаалал болон нөөц бололцоогоо хянаж, уялдуулж байх;
2. Дотооддоо холбоо харилцаа, мэдээлэл солилцоогоо сайжруулж, нөөц бололцоогоо ашиглан, ажлаа жигд хуваарилан чанартай гүйцэтгэх;
3. Ажилтнуудад мэдээ мэдээлэл хайх, хадгалах систем нь хэрэглэхэд хялбар, боловсруулсан мэдээллээ байрлуулах, эргээд ашиглах боломжтой, үр дүнтэй байхад анхаарч ажиллах;
4. Ажлын алба нь ажилтнуудаа мэргэшүүлэх, дадлагажуулах, хөгжүүлэх болон эрсдэлийг тодорхойлох, даван гарах байгууллагын чадавхыг бий болгож ажиллах;
5. Парламентын ордны барилга байгууламжийн аюулгүй байдлыг ханган, засвар үйлчилгээг тогтмол хийх;

Онцлог

1. Ил тод, нээлттэй өрсөлдөөнт шалгалтаар ажилтнуудыг шалгаруулж авах;
2. Парламентын гишүүд болон ажлын албаны ажилтнуудад зориулсан гарын авлагыг хэвлүүлж, тогтмол шинэчилж байх;
3. Парламент дээр дадлага хийх дадлагын журмыг боловсруулж ажиллах.

ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**2.1. АВСТРАЛИ**

Хууль тогтоох Ассамблейн ажлын албаны стратеги төлөвлөгөө¹⁶²:

- Ардчилсан институц болох Ассамблейд дэмжлэг үзүүлж ажиллах Ажлын алба нь Ассамблей, түүний хороодод хууль тогтоох, хяналт тавих, ард иргэдийг төлөөлэх үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллах;
- Ассамблейн гишүүдэд дэмжлэг, туслалцаа үзүүлж, зөвлөгөө өгөх Ассамблейн гишүүдэд Ассамблейн болон хороодын, түүнчлэн сонгогдсон тойргийнхoo ажилд идэвхтэй оролцоход нь чанартай, цаг үетэйгээ нийцсэн зөвлөх болон туслах үйлчилгээ үзүүлэх;
- Байгууллагын дотоод чадавхыг бэхжүүлэх
Оновчтой, зөв шийдвэр гаргаж, дотооддоо холбоо харилцаа, мэдээлэл солилцоогоо сайжруулж, нөөц бололцоогоо ашиглан, ажлаа жигд хуваарилан хууль дүрмийн дагуу үйл ажиллагаагаа чанартай гүйцэтгэх (түргэн хугацаанд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлж, зөвлөгөө мэдээллээр хангах)

¹⁶²https://www.parliament.act.gov.au/__data/assets/pdf_file/0006/1195737/Strategic-Plan-Office-of-the-Legislative-Assembly-2018-202.pdf

Зорилт 1-ийн хүрээнд:

- Ассамблей нь хуралдааны дэгээ өөрчлөн, шинэчлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд ажлын алба нь зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;
- Хуралдааны дэгд өөрчлөлт оруулах тохиолдолд ажлын алба нь парламентын үйл ажиллагаа үр дүнтэй, хэвийн явагдахад онцгойлон анхаарч энэ талаар санал зөвлөмж өгөх;
- Гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой Ассамблейн ордны багтаамжийг харгалзан гишүүд, тэдгээрийн ажилтнууд, ажлын албаны ажилтнуудад өрөө тасалгааг хүртээмжтэй, зөв хуваарилах;
- Цахим орчны хэрэглээ, цахим сүлжээ, ялангуяа нийгмийн сүлжээ, хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн хэрэглээ өссөнтэй холбоотойгоор иргэд парламентын үйл ажиллагааг сонирхох, үйл явцад нь анхаарал хандуулах байдал нэмэгдэж байгаа тул тэдний санал бодлыг сонсох, үйл ажиллагаандаа тусгах байдлаар хамтарч ажиллах;
- Иргэд, олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаагаа тухайн үеийн чиг хандлагаас илүүтэйгээр Ассамблейн ардчилсан үзэл баримтлал, үйл явцтай уялдуулах;
- Ассамблей болон гишүүдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах;
- Ажлын алба нь байнгын хувьсан өөрчлөгдөх буй орчин нөхцөлд аюулгүй байдлаа (биет/бодит аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал, хувь хүний аюулгүй байдал болон кибер аюулгүй байдал) ханган, болзошгүй аюул нүүрлэхээс сэргийлэх бодлого болон аюул нүүрлэсэн тохиолдолд хэрэгжүүлэх оновчтой, тохирсон арга хэмжээг боловсруулж ажиллах;
- Ажлын алба нь Ассамблейн ордон дахь хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй, хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлж ажиллах.

Зорилт 2-ын хүрээнд:

- Ажлын алба нь Ассамблейтай холбоотой мэдээ мэдээллийн найдвартай эх сурвалж байх;
- Үнэн зөв, судалгаан дээр үндэслэсэн мэдээ мэдээлэл, санал зөвлөмжийг цаг хугацаанд нь гаргаж өгөх;
- Шинээр гарч буй техник технологитой танилцан, ажил, үйлчилгээндээ нэвтрүүлж ажиллах;
- Өндөр хурд бүхий найдвартай интернэт сүлжээ, программ хангамжийн үйлчилгээ, хөдөлгөөнт тоног төхөөрөмж болон өндөр хурд бүхий хөдөлгөөнт интернэт сүлжээний технологийг үйлчилгээндээ ашиглах;
- Гишүүдэд үзүүлж буй үйлчилгээгээ гар ажиллагаатай, цаасан хэвлэл ашигладаг механик арга барилаас хэрэглэхэд хялбар, түргэн шуурхай цахим систем рүү шилжүүлэх.

Зорилт 3-ын хүрээнд:

- Ассамблейн гишүүд нэмэгдсэний хэрээр ажлын албаны ачаалал, үйлчилгээний чанар, төрөл тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;
- Ажлын алба нь ажил үүргээ чанартай хийж гүйцэтгэх үүднээс ажлын ачаалал болон нөөц бололцоогоо хянаж, уялдуулж байх;

- Ажлын алба нь үр ашиггүй зардлыг багасгаж, байгаа нөөц бололцоогоо үр ашигтай зарцуулах санхүүгийн оновчтой шийдвэр гаргаж байх;
- Ажилтнуудад шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал бодлоо илэрхийлэх, хувь нэмрээ оруулах боломжоор нь хангаж ажиллах;
- Ажилтнуудыг байгууллагын дотоод бүтэц, хэлтэс, албад нэг бурийн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар бүрэн ойлголт өгч, хоорондоо мэдээ мэдээллээ солилцон, харилцан уялдаа холбоотой ажиллах боломжоор хангах;
- Ажилтнуудад мэдээ мэдээлэл хайх, хадгалах систем нь хэрэглэхэд хялбар, боловсруулсан мэдээллээ байрлуулах, эргээд ашиглах боломжтой, үр дүнтэй байхад анхаарч ажиллах;
- Ажлын алба нь байнга өөрчлөгдөх буй эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн аудит, тайлан тооцооны стандарт, цалин хэлс, татвар, мэдээллийн эрх чөлөө, нээлттэй байх зарчим зэрэг үзүүлж буй үйлчилгээндээ гарч буй өөрчлөлт, шинэчлэлтийг мэдэрч, түүнтэй уялдаж ажиллах;
- Ажлын алба нь хууль дүрмээ баримталж, ажилтнуудаа мэргэшүүлэх, дадлагажуулах, хөгжүүлэх болон эрсдэлийг тодорхойлох, даван гарах байгууллагын чадавхыг бий болгож ажиллах.

2.2.ИБУИНВУ

Нийтийн танхимиын ажлын албаны 2016-2021 оны стратеги төлөвлөгөө¹⁶³:

1. Нийтийн танхимиын үйл ажиллагаа, хяналт, хэлэлцүүлэг үр дүнтэй явагдахад дэмжлэг үзүүлэх:
Парламентын гишүүдэд тэдний хэрэгцээ шаардлага дээр үндэслэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, судалгаа мэдээллээр ханган, техник тоног төхөөрөмж болон бусад төрлийн үйлчилгээгээр хангаж үйлчилнэ.
2. Ард иргэдийг хууль тогтоох үйл ажиллагаанд оролцуулах, тэдний идэвхийг нэмэгдүүлэх:
Нийтийн танхимиын үйл ажиллагааг ард иргэдэд нээлттэй болгож, ардчилал, ирээдүйн сайн сайхны төлөө ард иргэдийн идэвхтэй оролцоо хууль тогтоох үйл ажиллагаанд хичнээн чухлыг ойлгуулах. Залуучууд болон өсвөр үеийнхэн, нийгмийн халамж, анхаарал илүү шаардлагатай иргэдийг онцлон үзэж, Нийтийн танхимиын үйл ажиллагаатай танилцуулах боломжийг бүрдүүлж ажиллана. ИБУИНХУ-д болон олон улсад парламентын нэр хүндийг өргөж ажиллана.
3. Парламентын аюулгүй байдал, тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллах:

¹⁶³<https://www.parliament.uk/documents/Strategy-for-the-House-of-Commons-Service-2016-2021-long-version.pdf>

Нийтийн танхимын өмнө тулгараад буй саад бэрхшээлийг даван туулж, хуримтлуулсан туршлага дээр үндэслэн шинэчлэл хийх. Лордын танхимтай хамтран ард иргэдэд нээлттэй байх үндсэн зарчмаа алдагдуулалгүй, парламентад нүүрлэж болзошгүй аливаа эрсдэлээс сэргийлэн ажиллана. Байнгын өөрчлөгдж буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ажиллана.

Зорилт 1-ийн хүрээнд:

- Тусгайлан байгуулагдсан түр хороодын үйл ажиллагааг үр дүнтэй байлгахад анхаарч, шаардлагатай мэдээ мэдээллээр ханганд, зөвлөгөө өгч ажиллах;
- Цаг үеийн асуудлаар, Нийтийн танхимын нэгдсэн болон байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэх асуудлаар мэдээ мэдээлэл бэлтгэн гишүүдэд танилцуулах;
- Нийтийн танхимын гишүүд болон тэдгээрийн туслах ажилтнуудыг өндөр чанар, хурд бүхий найдвартай техник технологиор хангаж, түүнийг ашиглах сургалт зохион байгуулж байх;
- Нийтийн танхимын гишүүдийн туслах, ажлын албаны ажилтнууд болон орон нутгийн тойротг гишүүдээ төлөөлөн ажиллаж буй ажилтнуудыг дэмжин, хамтарч ажиллах.

Зорилт 2-ын хүрээнд:

- Нийтийн танхимын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан, тэдний сонирхож буй асуудлаар мэдээлэл өгч, ард иргэдийн санал бодлыг сонсож, хууль тогтоох үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллах;
- Ард иргэдэд мэдээ, мэдээллийг дүрс бичлэгээр, хэвлэмэл байдлаар, инфографикаар гэх мэтчилэн олон төрлөөр түгзэх;
- Нийтийн танхимын цахим хуудас, цаашлаад нийгмийн сүлжээ, хамтран ажилладаг болон харьяа байгууллагуудын цахим хуудсаар үйл ажиллагаагаа мэдээлэн ажиллах;
- Залуучууд, ёсвер үеийнхэн, бага орлоготой иргэд нь парламентын үйл ажиллагаа, ач холбогдлын талаар мэдээлэл хомс байдагтай холбоотой тэдэнд мэдээллийг ойлгомжтой, хялбар байдлаар хүргэхийг зорино. Парламентын боловсролыг түгээх аргыг өргөжүүлж, сургуулийн насны хүүхдүүдийг парламенттай, түүний үйл ажиллагаатай нь сургалтын хөтөлбөрөөр дамжуулан танилцуулах;
- Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шинэ арга замыг эрэлхийлж ажиллах;
- Олон улсын хэмжээнд парламентат ардчилсан ёсыг дэмжин, нөөц бололцоондоо тулгуурлан бусад орнуудын хөгжиж буй парламентын үйл ажиллагаанд шууд болон холбогдох бусад байгууллагаар дамжуулан дэмжлэг үзүүлж ажиллах.

Зорилт 3-ын хүрээнд:

- Лордын танхимтай хамтран 2020 он гэхэд Вэстминстерийн ордныг шинэчлэх, сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэх;
- Парламентын ард иргэдэд нээлттэй болон аюулгүй байх боломжийг ханган, кибер болон биет халдлагаас сэргийлэх шинэ хамгаалалтыг нэвтрүүлэх;
- Уламжлалаа хадгалж, үйл ажиллагаагаа тогтмол сайжруулан, урт хугацааны зорилтоо хэрэгжүүлж тогтвортой ажиллахыг эрмэлзэнэ;
- Санхүүгийн үйл явц өмнөө тавьсан зорилттой дүйж буй эсэхийг нягталж, үр дүнтэй шийдвэр гаргах үүднээс санхүүгийн зөвлөгөө, мэдээллээр ханган, урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлаа хадгалж ажиллах.

2.3.МОЛДОВА

Парламентын ажлын албаны 2011-2013 онд хэрэгжүүлэх Хөгжлийн тэргүүлэх 5 зорилт нь¹⁶⁴:

1. Хүний нөөцийн чадавхыг сайжруулах;
2. Орчин үеийн, ил тод, нээлттэй мэдээллийн бодлого боловсруулах;
3. Парламентын дэд бүтцийг бий болгох, сайжруулах;
4. Парламентын судалгаа, шинжилгээний чадавхыг бэхжүүлэх;
5. Хууль тогтоох үйл явцыг чанаржуулах юм.

Зорилт 1-ийн хүрээнд:

Парламентын ажлын албаны зорилтыг хэрэгжүүлэхэд чадварлаг хүний нөөцтэй байх нь чухал юм.

1. Парламентын хэлтэс, албадын чиг үүргийг тодорхойлсон парламентын ажлын албаны дүрмийг боловсруулах, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах;
2. Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалтууд зохион байгуулах;
3. Ил тод, нээлттэй өрсөлдөөнт шалгалтаар ажилтнуудыг шалгаруулж авах;
4. Ажилтнуудыг мэргэшүүлэх стратегийн төслийг боловсруулах;
5. Парламентын гишүүд болон ажлын албаны ажилтнуудад зориулсан гарын авлагыг хэвлүүлж, тогтмол шинэчилж байх;
6. Ажилтнуудын ажлын үр дүнг ил тод, бодитойгоор үнэлж, шатлан дэвших зарчмыг боловсруулан мөрдэж ажиллах;
7. Парламент дээр дадлага хийх дадлагын журмыг боловсруулж ажиллах.

¹⁶⁴<https://agora-parl.org/sites/default/files/Strategic%20Development%20Plan%20for%20the%20Secretariat%20of%20the%20Parliament%20of%20Moldova%20%282011-2013%29.pdf>

Зорилт 2-ын хүрээнд:

Парламент, түүний ажлын албаны үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх шаардлагатай.

1. Парламентын харилцаа, холбооны зорилтыг тодорхойлох;
2. Иргэдэд зориулсан Мэдээ мэдээлэл, албан бичгийн төвийг нээн ажиллуулах;
3. Парламентын үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээ, баримтыг парламентын үндсэн веб хуудсанд байршуулж байх;
4. Парламентын үйл ажиллагааг сурталчилсан, таниулсан нээлттэй өдөрлөг зохион байгуулах, иргэд олон нийтийг парламентын удирдлагуудтай уулзах боломжоор хангах;
5. Мэдээ мэдээлэл, албан бичгийг цахимаар шилжүүлэх цахим парламент мэдээллийн системийг бий болгож ажиллуулах;
6. Ил тод, нээлттэй, санхүүгийн болон хангамж үйлчилгээний бодлогыг боловсруулж ажиллах.

Зорилт 3-ын хүрээнд:

Хуулийн төсөл, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг засгийн газар болон парламентын хооронд, түүнчлэн парламент дотроо түргэн шуурхай, цахим хэлбэрээр хайж олох, илгээх, хүлээн авах боломжоор хангах.

1. Техник, тоног төхөөрөмжид үнэлгээ хийх;
2. Парламентын ажлын албаны харьяа (үйлчилгээ хариуцсан) байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийх;
3. Парламентын хуралдаан дээр гишүүдийг цахимаар бүртгэх болон цахим санал хураалтын системийг нэвтрүүлэх;
4. Парламентын хуралдааны шууд орчуулгын болон дуу хураагуурын орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж ашиглах;
5. Архивын материалыг тоон системд хөрвүүлэх.

Зорилт 4-ийн хүрээнд:

Парламентын хууль тогтоох үйл ажиллагааг шаардлагатай судалгаа, мэдээ мэдээллээр хянагх болон парламентаас баталсан хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, судалгаа шинжилгээ, хяналт шалгалтыг бодитой, үр нөлөөтэй явуулахад шаардлагатай мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэх.

1. Ажлын албаны ажилтнуудад шаардлагатай мэдээ мэдээллийн эх сурвалжуудыг ашиглах боломжоор хангах;
2. Номын санг цахим системд шилжүүлэх;
3. Парламентаас гадна эрдэмтэн, судлаачидтай хамтарч ажиллах;
4. Парламентын хяналт шалгалтын чадавхыг бэхжүүлэх, ажилтнуудыг мэргэшүүлэх, хяналт шалгалтын үйл явцыг тодорхой болгох.

Зорилт 5-ын хүрээнд:

Хуулийн төсөл боловсруулах арга барил, үйл явцыг сайжруулах

1. Батлагдсан хууль болон хуулийн төслүүд нь Европын Холбооны хууль дүрэмтэй нийцэж буй эсэхийг нягтлах нэгж байгуулж ажиллах;
2. Хууль батлагдахаас өмнө болон батлагдсаны дараа нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг судлах, үнэлгээ хийх;
3. Хууль зүйн техникийн гарын авлагыг боловсруулах;
4. Хуулийн төслийн шаардлага хангасан, эсхүл хангаагүйг тодорхойлох үе шатыг парламентад хуулийн төсөл өргөн барих үйл явц дээр нэмж оруулах.

2.4.ШИНЭ ЗЕЛАНД УЛС

Төлөөлөгчдийн танхимын ажлын албаны 2016-2020 оны стратеги төлөвлөгөө¹⁶⁵:

Стратеги зорилт 1: Төлөөлөгчдийн танхим болон гишүүдэд чанартай үйлчилгээ үзүүлэх

1. Гишүүд болон парламентын бусад агентлагууд байгаа газраасаа мэдээллийг түргэн шуурхай авах, харилцан солилцох зэргээр ажил үүргээ үр дүнтэй, саадгүй хэрэгжүүлэх.

Үүнд мэдээллийн систем, технологи нь чухал үүрэгтэй бөгөөд парламентын үндсэн интернэт сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, парламентын гадна байрлах харьяа байгууллагуудыг нэгтгэн, сүлжээний хамрах хүрээг өргөжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх.

2. Гишүүд болон парламентын бусад агентлагуудыг чанартай үйлчилгээгээр хангах.

- **Хүний нөөц болон соёлын үйлчилгээ:**

Хүний нөөц болон соёлын баг хамт олон нь парламентын гишүүдэд шаардлагатай мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий Парламентын ажлын албаны хийгээд орон нутгийн иргэдийн хуралд ажиллаж буй ажилтан, албан хаагчдыг сургаж дадлагажуулах, тэдний чадавхыг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

- **Санхүүгийн үйлчилгээ:**

Санхүүгийн баг хамт олон нь парламентын гишүүдийн болон Парламентын ажлын албаны, түүнчлэн парламентын зөвлөх албаны төсөв, түүний зарцуулалтыг цаг хугацаанд нь тайлагнах, тэдгээрийн төсвээ зөв хянаж, зарцуулахад зөвлөгөө, туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Төсөв, санхүүгийн тайлангаа интернэт сүлжээгээр хүлээн авах, хянах боломжийг олгохоор ажиллаж байна.

- **Улс орны нөхцөл байдалтай танилцуулах аяллын үйлчилгээ:**

Парламентын гишүүд, Парламентын ажлын албаны ажилтнууд, холбогдох яамдын ажилтнуудыг улс орны нөхцөл байдал, хүмүүсийн аж амьдралтай танилцуулах дотоодын аяллыг тус баг хамт олон зохион байгуулан ажиллаж байна.

¹⁶⁵<https://www.parliament.nz/media/2753/parliamentary-service-strategic-intentions-2016-2020.pdf>

- Судалгаа, мэдээллийн үйлчилгээ:

Номын сангаас үзүүлдэг тус үйлчилгээ нь парламентын гишүүдийн хувьд албан ўргээ гүйцэтгэхэд нэн чухал, шаардлагатай мэдээллийн эх үүсвэр болдог. Парламентын гишүүд болон парламентын ажлын албаны ажилтнуудад цаг үеийн нэн шаардлагатай мэдээ мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр түргэн шуурхай гарган өгч байна.

Стратеги зорилт 2: Хүртээмжтэй парламент

3. Ард иргэд парламентын үйл явцтай танилцаж, үйл ажиллагаанд нь оролцох.

- Парламентын боловсрол:

Оюутан сурагчдын сургалтын хөтөлбөрт Шинэ Зеланд улсын ардчилал, парламентын үйл ажиллагааны талаар мэдээллийг оруулж, оюутан сурагчид болон ард иргэдийг парламентын түүх, үйл явцтай танилцуулдаг. Өөрийн биеэр ирэх боломжгүй тохиолдолд тухайн иргэн парламентын цахим хуудаснаас мэдээлэл авах боломжтой болсон.

- Иргэдийг хулээн авч уулзах үйлчилгээ:

Иргэд болон парламентын гишүүдийн урьсан зочид долоо хоногийн 7 өдөр тойргийн гишүүдтэйгээ уулзан, Парламентын танхимаар зочлон, санал бодлоо илэрхийлэх боломжтой.

4. Парламент нь иргэд олон нийтэд нээлттэй үйлчлэх боломжийг нэмэгдүүлэх.

Иргэдийн парламенттай харилцах харилцааг нэмэгдүүлэх зорилгоор парламентын ордоор зочилж, парламентын болон хороодын хуралдааны үйл явцтай танилцаах боломжкоор ханган ажиллаж байна. Мөн парламентын ТВ-ийг ажиллуулж, үйл явцыг нэвтрүүлж байна.

Парламентын ордон нь түүхийн дурсгалт газрын нэг болохын хувьд улс орны нэн чухал ажил үйлчилгээг хэвийн явуулах үүднээс парламентын ордны барилга байгууламжийн аюулгүй байдлыг ханган, засвар үйлчилгээг тогтмол хийн ажиллаж байна. Парламентын ордон төдийгүй орон нутаг дахь харьяа байгууллагуудын аюулгүй ажиллагааны стандартыг ханган, гишүүд болон тойргийн сонгогчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжкоор хангадаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Kiribati Parliament Corporate Strategic Plan (2017-2022) https://agora-parl.org/sites/default/files/kiribati_parliament_corporate_strategic_plan_final_may_2010.pdf
- СТРАТЕГИЯ развития Жогорку Кенеша Кыргызской Республики до 2021 года <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/82056>
- National Parliament of Solomon Islands Strategic Plan 2017-2021 <http://www.parliament.gov.sb/files/Parliament%20Strategy/npsi17To21.pdf>
- Strategic Plan of the Parliament of Sierra Leone 2016-2019. With the support of United Nations Development Programme (UNDP) https://agora-parl.org/sites/default/files/parliament_strategic_plan_final-sierra_leone.pdf
- Парламент болон Тамгын газрын Стратеги төлөвлөгөө, <http://www.parliament.gov.zm/sites/default/files/documents/pages/Final%20National%20Assembly%20of%20Zambia%20Strategic%20Plan%2821%29.pdf>
- STRATEGIC PLAN FOR THE 5th DEMOCRATIC PARLIAMENT 2014-2019 <https://www.parliament.gov.za/storage/app/media/StratPlan/5/strat%20plan%2013may2015.pdf>
- Strategic Plan 2014-2018 of the National Assembly of Pakistan http://www.na.gov.pk/uploads/1439219002_845.pdf
- Uganda - Five-year strategic plan for the Parliament (2014-2018) https://agora-parl.org/sites/default/files/uganda_-_five-year_strategic_plan_for_the_parliament_2014-2018.pdf
- Strategic development Plan 2014-2018. With the support of United Nations Development Programme (UNDP) <http://www.nab.gov.bt/assets/uploads/docs/download/2015/strategicplan.pdf>
- STRATEGIC PLAN OF THE PARLIAMENT OF THE REPUBLIC OF TRINIDAD AND TOBAGO, 2013-2018 <http://www.ttparliament.org/documents/2218.pdf>
- Wolesi Jirga Strategic Plan 2011-2016 (Төсөл) https://agora-parl.org/sites/default/files/afghanistan_-_wolesi_jirga_strategic_plan_2011-2016.pdf
- Rwanda - Strategic Plan of the Parliament (2011-2015) <https://agora-parl.org/resources/library/rwanda-strategic-plan-parliament-2011-2015>
- https://www.parliament.act.gov.au/__data/assets/pdf_file/0006/1195737/Strategic-Plan-Office-of-the-Legislative-Assembly-2018-202.pdf
- <https://www.parliament.uk/documents/Strategy-for-the-House-of-Commons-Service-2016-2021-long-version.pdf>
- <https://agora-parl.org/sites/default/files/Strategic%20Development%20Plan%20for%20the%20Secretariat%20of%20the%20Parliament%20of%20Moldova%20%282011-2013%29.pdf>
- <https://www.parliament.nz/media/2753/parliamentary-service-strategic-intentions-2016-2020.pdf>

**УИХ-ЫН ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ САНАЛ ХУРААЛТЫГ
ЦАХИМ ТООЛУУРААР ЯВУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТ БА ГИШҮҮДИЙН ИРЦ**

(Харьцуулсан судалгаа)

*Г.Билгээ, И.Жаргалзаяабямба***АГУУЛГА****СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ****СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

1. УИХ-ын дэгийн тухай хууль тогтоомжийн тойм
2. Санал хураалтыг цахим тоолуураар явуулах зохицуулалтын тойм
3. Цахим санал хураалт ба УИХ-ын гишүүдийн ирц
 - 3.1. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хууль (1997)
 - 3.2. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан (2010)
 - 3.3. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан (2018)

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ


Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдан ажилласан 30 гаруй жилийн түүхэндээ дэгтэй холбоотой Монгол Улсын 3 хууль, Улсын Их Хурлын болон Улсын Бага хурлын 3 тогтоолыг баталж байжээ.

УИХ-ын санал хураах журамд цахим тоолуур ашиглах тухай эрх зүйн анхны зохицуулалтыг 1997 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд тусгасан байна. Үүний дараа хуралдааны дэгийг УИХ-ын 2001 оны 61, 2006 оны 14 дүгээр тогтоолоор шинэчлэн батлахдаа санал хураалтыг цахим тоолуураар явуулахыг хэвээр үлдээжээ. Гэвч одоо мөрдэж буй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг анх 2007 онд батлахдаа дээрх зохицуулалтыг оруулаагүй байсныг 2010 онд нэмж оруулсан; мөн 2018 онд хурууны хээгээр хуралдааны ирцэд бүртгүүлэх, асуулт асуух, уг хэлэх, санал өгөхөөр шинээр оруулсан байна.

Судалгааны ажлыг гүйцэтгэх явцдаа УИХ-ын архивт байгаа дээрх хууль тогтоомжуудын хувийн хэргийг судалж үзэхэд санал хураалтыг цахим тоолуураар явуулах үндэслэл шаардлагыг дурдаагүй байна.

Судалгааны явцад санал хураалтыг цахим тоолуураар явуулснаар УИХ-ын гишүүдийн чуулганы хуралдааны ирцэд хэрхэн нөлөөлснийг зарим үзүүлэлтээр харьцуулан авч үзлээ: УИХ-ын гишүүдийн хуралдааныг тасалсан өдөр (цаг) нь чуулганы нэгдсэн худалдаан хуралдсан өдөр (цаг)-т эзлэх хувийг тооцон үзвэл дараах үр дүн гарч байна. Үүнд:

- 1997 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд гишүүдийн тасалсан цагийн нийлбэрийг 1996 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад **нэг хувиар буурсан**;
- 2010 оны хаврын ээлжит чуулганыг 2009 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад **гишүүдийн хуралдаан тасалсан үзүүлэлт нь 7 хувиар өссөн**;
- 2019 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд гишүүдийн бүртгэлд ороогүй буюу тасалсан өдрийн нийлбэр нь 2018 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад **нэг хувиар өссөн байна**.



СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1.УИХ-ЫН ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТОЙМ¹⁶⁶

Монгол Улсын байнгын ажиллагаатай парламент байгуулагдсан цагаасаа хойш хуралдааны дэгээ 6 удаа шинэчлэн баталсан бөгөөд аливаа асуудлыг хамтран хэлэлцэж олонхоороо шийдвэрлэхдээ баримтлах журмаа илүү тодорхой болгоо ажиллаж байсан.

Монгол Улсын парламентын хуралдааны анхны дэгийг БНМАУ-ын Бага Хурлаас 1990 оны 01 дүгээр тогтоолоор “БНМАУ-ын Бага Хурлын анхдугаар чуулганы дэг”¹⁶⁷ нэртэйгээр баталж байжээ.

Үүний дараа 1992 онд Улсын Бага Хурлаас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг баталсан байна. Энэ хуулийн 6-9 дүгээр бүлгүүдэд¹⁶⁸ УИХ-ын чуулганы хуралдааны дэгтэй холбоотой зохицуулалтыг тусгаж нэлээд өргөн агуулгатай болгосон: нэг талаас УИХ, түүний гишүүдийн эрх зүйн байдлыг тодорхой болгож, нөгөө талаас УИХ-ын чуулганы хуралдааны дэгийг бүхэлд нь зохицуулсан агуулгатай болгосон. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан УИХ-ын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тодорхой болгож нарийвчлан зохицуулсан байна.

УИХ-ын 2 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан парламент (1996-2000) өмнөх парламентад үйлчилж байсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг хүчингүй болгож, Монгол Улсын Их Хурлын тухай хуулиас гадна Монгол Улсын Их Хурлын чуулган хуралдааны дэгийн тухай хуулийг шинээр баталжээ. Энэ үеэс Монголын парламентад 1997 оноос хойш Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан журмыг хоёр хуулиар зохицуулж эхэлсэн байна.

УИХ-ын 3 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан парламент (2000-2004) дэгийн асуудлыг УИХ-ын тогтоолоор зохицуулахаар шийдвэрлэж, “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” УИХ-ын 2001 оны 61 дугаар тогтоолыг батлан гаргажээ.

Дэгийн зохицуулалтыг шинэчлэх болсон гол шалтгаан нь 2000 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотой. Хуулийн төслийн танилцуулгад “УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах дэг (журам)-ээ хуулиар тогтоож байсан. Энэ асуудлыг ажлын хэсэг аяч үзэж өмнө нь мөрдөж байсан хууль, тогтоол, гадаад орнуудын туршилага зэргийг судлан үзсэний үндсэн дээр эрх зүйн талаасаа ямар хэлбэрийн эрхийн актаар зохицуулах

¹⁶⁶Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс. Л.Өлзийсайхан. УБ., 2010 он. 54-59 дэх тал.

¹⁶⁷БНМАУ-ын Бага Хурлын 1990 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн “Дэг батлах тухай” 1 дүгээр тогтоол. Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (1990-2017 он). Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018. 208-214 дэх тал.

¹⁶⁸Монгол Улсын Их Хурлын тухай хууль:

Зургадугаар бүлэг - Улсын Их Хурлын чуулганы хуралдаан;
Долдугаар бүлэг - Тодорхой асуудал хэлэлцэж шийдвэрлэх;
Ниймдугаар бүлэг - Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл хянан хэлэлцэх, батлах;
Есдүгээр бүлэг - Улсын Их Хурал шийдвэр гаргах, түүнийг нийтлэх журам.

нь илүү тохиromжтойг анхаарсан. Улсын Бага Хурал энэ асуудлаа хуулиар биш тогтоолоор баталж мөрдөж байсан. Мөн гадаадын ихэнх орнууд энэ асуудлаа тодорхой дүрэм, журмаар тогтоон мөрдүүлж байна” гэж дурдсан байна.¹⁶⁹

Хүснэгт 1. УИХ-ын дэгийн тухай хууль тогтоомжийн жагсаалт¹⁷⁰

	Баримт бичгийн нэр	Баталсан огноо (дугаар)	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо (дугаар)	Хүчингүй болсон огноо (дугаар)
1.	Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын анхдугаар чуулганы дэг	“Дэг батлах тухай” БНМАУ-ын Бага хурлын тогтоол, 1990.09.13, №01	БНМАУ-ын Бага хурлын тогтоол, 1990.11.12, №29	
2.	Монгол Улсын Их Хурлын тухай	Монгол Улсын хууль, 1992.07.06		1997.02.06-ны хуулиар
3.	Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг	Монгол Улсын хууль, 1997.02.06	1997.05.22, 1997.06.13, 1997.07.04, 1998.01.08, 1999.01.22-ны хуулиудаар	2001.06.21-ний хуулиар
4.	Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай”, УИХ-ын тогтоол, 2001.06.21, №61	2001.11.08-ны №82, 2004.05.13-ны №29 УИХ-ын тогтоолуудаар	УИХ-ын тогтоол, 2006.01.27, №14
5.	Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай”, УИХ-ын тогтоол, 2006.01.27, №14		УИХ-ын тогтоол, 2007.10.11, №67
6.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай	Монгол Улсын хууль, 2007.10.11	2008.12.04, 2009.06.11, 2009.07.03, 2010.12.30 , 2011.01.20, 2011.12.23, 2012.08.17, 2012.12.21, 2012.12.21, 2014.10.16, 2015.01.29, 2015.05.29, 2015.07.08, 2016.01.19, 2016.04.14, 2016.12.01, 2017.01.12, 2017.05.12, 2017.11.10, 2017.11.23, 2018.06.29, 2019.01.18-ны хуулиудаар	

¹⁶⁹УИХ-ын Тамгын газрын архив. Данс 5, ХН 288.

¹⁷⁰Эх сурвалж:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 1990-2017 он (Эх сурвалж, харьцуулсан судалгаа). Ерөнхий редактор Ц.Цолモン. УБ., 2018.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://www.legalinfo.mn/additional/?lawid=356>

УИХ-ын 4 дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан парламент (2004-2008) дэгийн зохицуулалтыг 2 удаа шинэчилжээ. 2006 онд “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” УИХ-ын 14 дүгээр тогтоолыг, 2007 онд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг тус тус баталжээ. 2007 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг өнөөг хүртэл буюу байнгын ажиллагаатай парламентын түүхэнд хамгийн удаан даган мөрдөж байна.

2.САНАЛ ХУРААЛТЫГ ЦАХИМ ТООЛУУРААР ЯВУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТОЙМ

УИХ-ын санал хураах журамд цахим тоолуур ашиглах тухай эрх зүйн анхны зохицуулалтыг 1997 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд тусгасан байна. Үүний дараа УИХ-ын тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг”-ийг 2 удаа шинэчлэн батлагдахад санал хураалтыг цахим тоолуураар явуулах зохицуулалтыг хэвээр үлдээжээ.

Одоо мөрдөж байгаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг анх 2007 онд батлахдаа санал хураалтын цахим тоолуурын талаар зохицуулалт оруулаагүй байсныг 2010 оны Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчилж, “Санал хураалт явуулах ерөнхий журам” гэсэн 9¹ дүгээр зүйлийг нэмж оруулан санал хураалтыг цахим тоолуураар явуулахаар тусгажээ.

*Хүснэгт 2. Дэгийн тухай хууль тогтоомжуудад тусгасан санал
хураалтыг цахим тоолуураар явуулах зохицуулалт¹⁷¹*

Монгол Улсын хууль Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг 1997.02.06	УИХ-ын тогтоол Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг 2001.06.21, №01	УИХ-ын тогтоол Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг 2006.01.27, №14	Монгол Улсын хууль Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай 2007.10.11
41 дүгээр зүйл. Санал хураалт, түүнийг явуулах журам 4.Үндсэн хууль, энэ хууль болон, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд санал хураалт явуулахдаа хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар уг асуудлыг шийдвэрлэнэ.	Хорин тав. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд санал хураалт явуулах журам 25.2.Үндсэн хууль, бусад хууль болон энэ дэд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд санал хураалт явуулахдаа хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар уг асуудлыг шийдвэрлэнэ.	Хорь. Нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах 20.3.4.ил санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл <u>цахим тоолуураар</u> явуулах.	9 ¹ дүгээр зүйл. Санал хураалт явуулах ерөнхий журам 9 ¹ .2.Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл <u>цахим тоолуураар</u> , нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл <u>цахим тоолуураар</u> явуулна. Хуралдааны ирцэд бүртгүүлэх, асуулт асуух, уг хэлэх, <u>цахим тоолуураар</u> санал өгөхөд биеийн давхцахгүй өгөгдөл / гарын хурууны хээз-/ өөр идэвхждэг систем бүхий <u>цахим тоолуурыг</u> ашиглана.

¹⁷¹Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 1990-2017 он. Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018. 313, 337-338 дахь тал.

<p>Энэ хууль болон бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тоолуураар, харин нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тоолуур ашиглан явуулна.</p>	<p>Үндсэн хууль, бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тоолуураар, харин нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тоолуур ашиглан явуулна.</p>	<p>9¹.3. Санал хураах хуудас ашиглан нууц санал хураалт явуулж бол Улсын Их Хурлын гишүүдээс бурдсэн тооллогын комисс байгуулан санал хураалт явуулж, дүнг танилцуулна.</p> <p>9¹.4. Цахим тоолуураар нууц санал хураалт явуулах бол зөвхөн санал хураалтын дүн гарах бөгөөд санал ёгсөн гишүүдийн нэрс цахим тоолуурын системд хадгалагдахгүй.</p> <p>9¹.5. Санал хураалт явуулах үед гишүүн санал ёгхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусдад шилжүүлэх, бусад гишүүний өмнөөс санал ёгехийг хориглоно.</p>
--	--	---

Дээрх хууль тогтоомжийн төслийн архивын хувийн хэргийг үзэхэд санал хураалтыг цахим тоолуураар явуулах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг дурдаагүй байна.¹⁷²

1997 оноос хойш Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 21 удаа нэмэлт, өөрчлөлт орж байжээ. 2018 онд энэ хуулийн 9¹ дүгээр зүйлийн 9¹.2 дахь хэсэгт гарын хурууны хээгээр хуралдааны ирцэд бүртгүүлэх, асуулт асуух, уг хэлэх, санал өгөхийг цахим болгон өөрчилсныг 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс мөрдөх эхлээд байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2018.06.29)-ийн танилцуулгад: “УИХ-ын гишүүний хариуцлагыг нэмэгдүүлэх замаар УИХ-ын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд хуралдааны ирцэд бүртгүүлэх, асуулт асуух, уг хэлэх, цахим тоолуураар санал өгөхөд биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-өөр идэвхждэг систем бүхий цахим тоолуурыг ашиглах, гишүүн чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд оролцсон ирцийн мэдээг сар бүр гаргаж, олон нийтэд мэдээлэх, гишүүн нэгдсэн хуралдаанд хүндэтгэн үзэх

¹⁷²Тайлбар:

1997 оны 02 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн архивын хувийн хэрэгтэй танилцахад энэ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга байхгүй байв. (УИХ-ын Тамгын газрын архив, Данс 4, ХН 207)

УИХ-ын “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” 2001 оны 61 дүгээр тогтоопын архивын хувийн хэрэгтэй танилцахад энэ тогтоопын төслийн үзэл баримтлал байгаагүй, харин танилцуулгад санал хураалтыг цахим тоолуураар явуулах үндэслэл шаардлагыг дурдаагүй байв. (УИХ-ын Тамгын газрын архив, Данс 5, ХН 288)

УИХ-ын “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” 2006 оны 14 дүгээр тогтоопын архивын хувийн хэрэгтэй танилцахад энэ тогтоопын төслийн үзэл баримтлал, танилцуулгад санал хураалтыг цахим тоолуураар явуулах үндэслэл шаардлагыг дурдаагүй байв. (УИХ-ын Тамгын газрын архив, Данс 6, ХН 739)

2010 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн архивын хувийн хэрэгтэй танилцахад энэ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга байхгүй байв. (УИХ-ын Тамгын газрын архив, Данс 7, ХН 812)

шалтгаангүйгээр оролцоогүй бол тасалсан өдрийн цалинг олгохгүй байх, гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй асуудлаар уг хэлбэл хуралдаан даргалагч нэг удаа сануулах, сануулгыг зөрчвөл тухайн уг хэлэх хугацааг дуусгавар болгох зохицуулалтуудыг шинээр тусгасан. Хууль батлагдсанаар УИХ-ын гишүүний хариуцлага нэмэгдэх хууль зүйн ээрэг үр дүн гарч, цаашлаад хууль тогтоомжийн чанар сайжрах, тогтвортой байхад сайнаар нөлөөлөх ач холбогдолтой”¹⁷³ гэсэн байна.

3. ЦАХИМ САНАЛ ХУРААЛТ БА УИХ-ЫН ГИШҮҮДИЙН ИРЦ

Судалгааны энэ хэсэгт санал хураалтыг цахим тоолуураар явуулах тухай эрх зүйн зохицуулалт нь УИХ-ын гишүүдийн ирцэд хэрхэн нөлөөлснийг тодорхой хугацааны үечлэлээр авч үзсэн болно. Ингэхдээ гишүүдийн тасалсан өдрийн тоо (цаг)-г нэгдсэн худалдааны тоо (цаг)-той харьцуулж гаргасан болно. Статистик үзүүлэлтийг цахим санал хураалт анх зохицуулсан **1997 оны хууль**, нэмж оруулсан **2010 оны хууль** болон гарын хурууны хээгээр идэвхждэг систем бүхий цахим тоолуурыг ашиглахаар **шинээр тусгасан 2018 оны хууль** хэрэгжиж эхэлсэн тухайн ээлжит чуулганы ирцийн мэдээг түүний өмнөх ээлжит чуулганы ирцийн мэдээтэй харьцуулж гаргалаа.

Хүснэгт 3. Эрх зүйн орчин ба харьцуулалт хийсэн хугацаа

	<i>Баримт бичгийн нэр (баталсан огноо)</i>	<i>Тайлбар</i>	<i>Харьцуулалтад хамрагдах хугацаа</i>
1.	Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль (1997.02.06)	Санал хураалтыг цахим тоолуураар явуулахаар (анх удаа зохицуулсан)	<ul style="list-style-type: none"> • 1996 оны намрын ээлжит чуулган • 1997 оны хаврын ээлжит чуулган
2.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2007)-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2010.12.30)	Санал хураалтыг цахим тоолуураар явуулахаар (нэмж оруулсан)	<ul style="list-style-type: none"> • 2009 оны намрын ээлжит чуулган • 2010 оны хаврын ээлжит чуулган
3.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2007)-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2018.06.29)	Хуралдааны ирцэд бүртгүүлэх, асуулт асуух, уг хэлэх, цахим тоолуураар санал өгөхөд биеийн давхцахгүй өгөгдэл (гарын хурууны хээ)-өөр идэвхждэг систем бүхий цахим тоолуурыг ашиглахаар (шинээр тусгасан)	<ul style="list-style-type: none"> • 2018 оны намрын ээлжит чуулган • 2019 оны хаврын ээлжит чуулган (2019.04.05-26)

3.1. УИХ-ЫН ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬ (1997)

УИХ-ын 2 дахь удаагийн сонгуулийн 1996 оны намрын ээлжит чуулган 1996 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр нээгдэж, 1997 оны 02 дугаар сарын 06-ны өдрийг дуустал ажлын 107 хоног үргэлжилж, энэ хугацаанд нэгдсэн хуралдаан 36 өдөр, 200 цаг үргэлжлэн хуралдجээ.¹⁷⁴

¹⁷³Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга. УБ., 2018. 101 дэх тал.

¹⁷⁴УИХ-ын 1996 оны намрын чуулганы дүнгийн тухай танилцуулга. УИХ-ын Тамгын газрын архив, Данс 4, ХН 336.

УИХ-ын 1997 оны хаврын ээлжит чуулган 1997 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 07 дугаар сарын 09-ний өдрийг дуустал ажлын 82 хоног үргэлжилсэн бөгөөд энэ хугацаанд нэгдсэн хуралдаан 24 өдөр, 144 цаг үргэлжлэн хуралдсан байна.¹⁷⁵

Энэхүү хоёр чуулганы танилцуулгад УИХ-ын гишүүдийн ирцийн зөвхөн “өвчтэй, чөлөөтэй, тасалсан, хоцорсон” цаг, минутыг оруулжээ. Санал хураалтыг цахим тоолуураар явуулсан 1997 оны хаврын ээлжит чуулганы гишүүдийн тасалсан цагийн нийлбэрийг өмнөх 1996 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад нэг хувиар буурсан байна.

*Хүснэгт 4. УИХ-ын гишүүдийн ирцийн тойм¹⁷⁶
(УИХ-ын 1996 оны намар, 1997 оны хаврын ээлжит чуулган)*

Үзүүлэлтүүд	1996 оны намрын ээлжит чуулган (1996.09.30-1997.02.06)		1997 оны хаврын ээлжит чуулган (1997.04.05-07.09)		Зөрүү
	Нийлбэр цаг	Эзлэх хувь	Нийлбэр цаг	Эзлэх хувь	
Хуралдсан байдал	200:00	100%	144:00	100%	
Гишүүдийн хуралдааныг					
- тасалсан цаг	537:50	4%	332:15	3%	1% ↓

3.2. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан (2010)

УИХ-ын 2010 оны намрын ээлжит чуулганы хуралдаан 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдрийг дуустал ажлын 92 өдөр үргэлжилж нэгдсэн хуралдаан 37 удаа, 155 цаг 46 минут үргэлжлэн хуралдсан байна.¹⁷⁷

УИХ-ын 2011 оны хаврын ээлжит чуулган 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 07 дугаар сарын 09-ний өдрийг дуустал ажлын 69 өдөр үргэлжилсэн ба нэгдсэн хуралдаан 42 удаа, 116 цаг 11 минут үргэлжлэн хуралджээ.¹⁷⁸

Ээлжит хоёр чуулганы танилцуулгад “хуралдсан дүн”, УИХ-ын гишүүдийн “хуралдаанд оролцсон болон оролцоогүй дүн, гадаад болон орон нутагт ажилласан, чөлөөтэй, өвчтэй, тасалсан, хоцорсон дүн”-г цаг, минут, өдрөөр гаргасан байна.

¹⁷⁵УИХ-ын 1997 оны хаврын чуулганы дүнгийн тухай танилцуулга. УИХ-ын Тамгын газрын архив, Данс 4, ХН 399.

¹⁷⁶Эх сурвалж:

-УИХ-ын 1996 оны намрын чуулганы дүнгийн тухай танилцуулга. УИХ-ын Тамгын газрын архив, Данс 4, ХН 336.

-УИХ-ын 1997 оны хаврын чуулганы дүнгийн тухай танилцуулга. УИХ-ын Тамгын газрын архив. Данс 4, ХН 399.

¹⁷⁷Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он. 14, 169 дэх талууд.

¹⁷⁸Улсын Их Хурлын 2011 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он. 13, 120 дахь тал.

2010 оны хаврын ээлжит чуулганы гишүүдийн хуралдаан тасалсан үзүүлэлт нь өмнөх 2009 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад 7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 5. УИХ-ын гишүүдийн ирцийн тойм¹⁷⁹
(УИХ-ын 2009 оны намар, 2010 оны хаврын ээлжит чуулган)*

Үзүүлэлтүүд	2009 оны намрын ээлжит чуулган (2010.10.01-2011.02.10)		2010 оны хаврын ээлжит чуулган (2011.04.05-07.09)		Зөрүү
	Нийлбэр өдрийн тоо	Эзлэх хувь	Нийлбэр өдрийн тоо	Эзлэх хувь	
Хуралдсан байдал	37	100%	27	100%	
Гишүүдийн хуралдаанд					
- оролцсон байдал	1936	70%	1364	66%	4%↓
- оролцоогүй	814	30%	688	34%	4%↑
Үүнээс:					
- тасалсан	207	7%	291	14%	7%↑

3.3. УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан (2018)

УИХ-ын 2018 оны намрын ээлжит чуулган 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийг дуустал ажлын 88 өдөр үргэлжилсэн. Чуулганы хугацаанд нэгдсэн хуралдаан 31 удаа, 121 цаг 06 минут үргэлжлэн хуралдсан байна.¹⁸⁰

УИХ-ын 2019 оны хаврын ээлжит чуулганы хувьд нэгдсэн мэдээ гараагүй тул УИХ-ын цахим хуудаст байршуулсан нэгдсэн хуралдааны тэмдэглэлийг эх сурвалжаа болгож авсан. Судалгаанд 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 26-ны өдрийг¹⁸¹ хүртэлх ажлын 16 өдрийн мэдээг хамруулсан болно. Энэ хугацаанд нэгдсэн хуралдаан 6 удаа 25 цаг 38 минут үргэлжлэн хуралджээ.¹⁸²

Харьцуулалтад хамрагдаж байгаа хоёр чуулганы танилцуулгыг үзэхэд УИХ-ын гишүүдийн ирцийн мэдээнд “тасалсан” гэснийг “бүртгэлд ороогүй” гэж өөрчилсөн байна. УИХ-ын 2019 оны хаврын ээлжит чуулганы хуралдаанд гишүүдийн бүртгэлд ороогүй (эсхүл тасалсан) өдрийн нийлбэр нь өмнөх 2018 оны намрын ээлжит чуулгантай харьцуулахад 1 хувиар өссөн байна.

¹⁷⁹Эх сурвалж:

- Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он. 120-125 дахь тал.
- Улсын Их Хурлын 2011 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он. 169-174 дахь тал.

¹⁸⁰Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2019 он. 13 дахь тал.

¹⁸¹2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар.

¹⁸²Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 05, 11, 12, 18, 19, 26-ны өдруудийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл. Эх сурвалж: www.parliament.mn

Хүснэгт 6. УИХ-ын гишүүдийн ирцийн тойм¹⁸³
(УИХ-ын 2018 оны намар, 2019 оны хаврын ээлжит чуулган)

Үзүүлэлтүүд	2018 оны намрын ээлжит чуулган (2018.10.01-2019.02.02)		2019 оны хаврын ээлжит чуулган (2019.04.05-26)		Зөрүү
	Нийлбэр өдрийн тоо	Эзлэх хувь	Нийлбэр өдрийн тоо	Эзлэх хувь	
Хуралдсан байдал	31	100%	6	100%	
Бүртгэлд ороогүй (тасалсан) тоо	183	8%	42	9%	1% ↑

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁸³Эх сурвалж:

- Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2019 он. 139-140 дэх тал.
- Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 05, 11, 12, 18, 19, 26-ны өдрүүдийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл. Эх сурвалж: www.parliament.mn

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Ном, товхимол

- Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын Тамгын газар (1990-2015 он). Ерөнхий редактор Б.Бодбаатар. УБ., 2015.
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 1990-2017 он (Эх сурвалж, харьцуулсан судалгаа). Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018.
- Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс. Л.Өлзийсайхан. УБ., 2010 он.
- Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга. УБ., 2018.
- Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он.
- Улсын Их Хурлын 2011 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2011 он.
- Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаарх нэгдсэн танилцуулга. УБ., 2019 он.
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://www.legalinfo.mn/additional/?lawid=356>

Хуралдааны тэмдэглэл

- Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 05, 11, 12, 18, 19, 26-ны өдрүүдийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл. Эх сурвалж: www.parliament.mn

УИХ-ын Тамгын газрын архивын нэгж

- Данс 4, ХН 207.
- Данс 4, ХН 336.
- Данс 4, ХН 399.
- Данс 5, ХН 288.
- Данс 6, ХН 739.
- Данс 7, ХН 812.



**ПАРЛАМЕНТЫН ХУРАЛДААНЫ ИРЦ БОЛОН САНАЛ ХУРААЛТЫГ
БИОМЕТРИЙН МЭДЭЭЛЭЛ АШИГЛАН БҮРТГЭХ ГАДААДЫН ЗАРИМ
ОРНЫ ТУРШЛАГА, ТЕХНИК ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

(Мэдээлэл, лавлагаа)

Д.Халиун

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Нэг. Парламентын хуралдааны ирц, санал хураалтад биометрийн мэдээлэл (хурууны хээ) ашиглаж буй улс орнуудын туршлага

Хоёр. Техник, зохион байгуулалт

АШИГЛАСАН МАТЕРИАЛ



СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ

Олон улсын парламентын холбооны 2018 онд гаргасан тайлангаас үзвэл дэлхийн улс орнуудын 112 парламентын танхимын (үүнд хоёр танхимтай улс орнуудын дээд болон доод танхimuуд орсон) 67% нь парламентын хуралдааны санал хураалтыг цахим систем ашиглан явуулдаг байна. Үүнээс хамгийн түгээмэл ашиглагдаж байгаа төхөөрөмжүүд нь гишүүний карт, эсхүл жетон (46%) болон гишүүн бүрийн суудалд сурилуулсан товчлуур (51%) байна.

Зарим парламент хуралдааны санал хураалтад хоёр дахь шатны баталгаажуулалтыг ашигладаг ба судалгаанд хамрагдсан орнуудаас 13% нь биометрийн мэдээлэлгээ (хурууны хээ)-ийг ашигладаг бол 10% нь нууц үг (pin code, password зэрэг) ашиглаж байна.¹⁸⁴

***Хуралдааны ирц болон санал хураалтад биометрийн мэдээлэл
ашигладаг улс орнууд***

	Үе шат	Улсын тоо	Улсын нэр
Хуралдааны ирцийг хурууны хээгээр бүртгүүлдэг систем	Туршилтын шатанд	1	Зимбабве
	Нэвтрүүлсэн	4	Кени, Өмнөд Африк, Турк, Уганда
Санал хураалтыг хурууны хээгээр бүртгэдэг систем	Туршилтын шатанд	3	Украин, Ирак, Канад
	Нэвтрүүлсэн	13	Албани, Аргентин (дээд, доод танхим), Болгар, Бразил (дээд доод танхим), Итали, Кени (дээд, доод танхим), Колумби, Малайз, Өмнөд Африк, Турк, Чили, Шри Ланка, ЭльСальвадор



¹⁸⁴World e-Parliament Report 2018, IPU <https://www.ipu.org/resources/publications/reports/2018-11/world-e-parliament-report-2018>

Нэг. Парламентын хуралдааны ирц, санал хураалтад биометрийн мэдээлэл (хурууны хээ) ашиглаж буй улс орнуудын туршлага

Санал хураалт:

Мэдээллийн хайлт хийж судлахад өдгөө парламентын санал хураалтад хурууны хээгээр санал өгөх системийг **Албани, Аргентин, Болгар, Бразил, Итали, Кени, Колумби, Малайз, Турк, Өмнөд Африк, Чили, Шри Ланка, Эль Сальвадор** зэрэг 13 улс нэвтрүүлсэн бол Украян, Канад, Ирак зэрэг орнууд Олон улсын парламентын холбоо (ОПХ)-оос явуулсан санал асуулгад нэвтрүүлэхээр төлөвлөсөн гэж хариулсан байна. (Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү.)

Болгарын Парламент нь өөр гишүүний картаар санал өгөх асуудлыг халах зорилгоор 2010 онд хурууны хээгээр санал өгөх системийг нэвтрүүлсэн боловч биометрийн мэдээлэл цуглуулах, гишүүний карттай холбох зэрэг асуудлаас болж хойшлогдон 2013 оны 6-р сараас эхлэн бүрэн хэрэгжиж эхэлсэн байна. Болгарын Парламентын дэгийн 63-р зүйлд санал хураалттай холбоотой асуудлыг дараах байдлаар зохицуулсан байна.¹⁸⁵

“63.3. Санал хураалтыг цахим тоолуур ашиглан явуулах /63.2.5/ тохиолдолд саналыг депутат тус бүрийн биометрийн мэдээллийг ашиглан, эсхүл депутат тус бүрийн биометрийн мэдээллийг ашиглан идэвхждэг системийг ашиглан хураана.” гэж заажээ

Италийн Төлөөлөгчийн танхим нь нэг гишүүн олон хүний өмнөөс санал өгч буйг таслан зогсоох зорилгоор хурууны хээгээр санал өгөх системийг 2010 онд нэвтрүүлсэн байна. Италийн Төлөөлөгчийн танхимын дэгийн 10-р бүлэгт Санал хураалттай холбоотой асуудлыг тусгасан бөгөөд 49.4-5-р заалтад¹⁸⁶ заасны дагуу ил болон нууц санал хураалтыг цахим тоолуурын системийг ашиглан явуулж болно гэж заасан байна.

Ирц:

Улс орнуудын парламентын гишүүдийн ирцийг хурууны хээгээр бүртгэхтэй холбоотой мэдээллийн хайлт хийж үзэхэд **Кени, Өмнөд Африк, Турк, Уганда** зэрэг улс орнууд нь хурууны хээгээр бүртгэх системийг нэвтрүүлээд байгаа бол Зимбабве Улсын Парламентын Дэгийн хороо нь гишүүдийн ирцийг хурууны хээгээр бүртгэх систем нэвтрүүлэхээр хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

¹⁸⁵<http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>

¹⁸⁶http://en.camera.it/application/xmanager/projects/camera_eng/file/RULES_OF_PROCEDURE_CHAMBER_OF_DEPUTIES.pdf

Хоёр. Техник, зохион байгуулалт

KONTRAX JSC¹⁸⁷ нь 1992 онд Унгарын Будапешт хотноо төвтэй, Зүүн Европын 6 улсын олон улсын холдинг хэлбэртэй байгуулагдсан. 2000 оноос Контракс нь Болгарын компани болон өөрчлөгдсөн. Тус компани нь 2010 онд Болгарын Үндэсний Ассамблейн хуралдааны санал хураалтыг хурууны хээгээр бүртгэх системээр тоноглох, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Зураг 1. Болгарын Үндэсний Ассамблейн санал хураалтын систем



Зураг 2. Болгарын Үндэсний Ассамблейн санал хураалтын төхөөрөмж





Эх сурвалж: <https://www.mzv.sk/documents/10182/13850/Kontrax.pdf/5e54dab8-097c-4a50-a341-e0f3ee4edd26>

¹⁸⁷<http://www.kontrax.bg/en/>, http://computerworld.bg/inenglish/articles/34695_it_green_technologies_healthrelated_hightech_products_and_services_are_key_areas_for_bulgaria

Eurel Informatica SpA-г 1986 онд Ром хотноо үүсгэн байгуулсан. Тус компани нь төрийн захиргааны байгууллагуудад зориулсан тоног төхөөрөмж үйлдвэрлэж, нийлүүлдэг бөгөөд Италийн Сенат, Төлөөлөгчдийн Танхим, Европын Парламентыг тус тус цахим тоолуурын төхөөрөмжүүдээр хангасан. Eurel Informatica компани нь хурууны хээгээр санал өгөх тоног төхөөрөмжийг Италийн Төлөөлөгчдийн танхим, Албанийн парламентад амжилттай нэвтрүүлсэн. Тус компани болон бүтээгдэхүүний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаар орж үзнэ үү. <http://english.eurel.it/home>

Зураг 3. Италийн Төлөөлөгчдийн танхимиын санал хураалтын систем, тоног төхөөрөмж





Эх сурвалж: Eurel Informatica, <http://english.eurel.it/20?platform=9>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <http://www.ipu.org/pdf/publications/eparl16-en.pdf>
- http://www.nomos-leattualitaneldiritto.it/wp-content/uploads/2015/10/RoPs_Albanian-Assembly_English.pdf
- <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>
- http://en.camera.it/application/xmanager/projects/camera_eng/file/RULES_OF_PROCEDURE_CHAMBER_OF_DEPUTIES.pdf
- <https://www.parliament.lk/en/how-parliament-works/standing-orders>
- <http://www.independent.co.uk/news/uk/politics/electronic-voting-in-for-mps-in-parliament-could-improve-accuracy-of-how-votes-are-recorded-a6875766.html>
- http://www.legco.gov.hk/general/english/library/stay_informed_parliamentary_news/electronic_recording_of_divisions.pdf
- <http://www.lop.parl.gc.ca/content/lop/researchpublications/prb0028-e.htm#CBiometrics>
- <http://www.haaretz.com/news/mks-reject-fingerprint-proposal-for-knesset-voting-1.92126>
- http://www.parliament.go.ug/images/stories/constitution/rules_2012.pdf
- <http://www.kontrax.bg/en/>
- http://computerworld.bg/inenglish/articles/34695_it_green_technologies_healthrelated_hightech_products_and_services_are_key_areas_for_bulgaria
- <https://www.mzv.sk/documents/10182/13850/Kontrax.pdf/5e54dab8-097c-4a50-a341-e0f3ee4edd26>



Хавсралт**Парламентын чуулганы хуралдааны ирц, санал хураалтыг хурууны хээгээр бүртгэдэг улс орнууд**

	Улсын нэр	Нэвтрүүлсэн огноо	Хуралдааны ирцийг хурууны хээгээр бүртгүүлдэг	Санал хураалтыг хурууны хээгээр бүртгэдэг
1	Албани ¹⁸⁸	2016*		Нэвтрүүлсэн: Хурууны хээгээр санал ёгех систем нэвтрүүлсэн. Италитай ижил систем ашигладаг.
2	Аргентин	2016*		Нэвтрүүлсэн: Биометрийн үзүүлэлт ашиглан санал ёгех систем нэвтрүүлсэн (2016 ОУПХ тайлан)*
3	Болгар	2013		Нэвтрүүлсэн: Хурууны хээгээр санал ёгех системийг 2010 онд нэвтрүүлж, 2013 онд ашиглалтад оруулсан.
4	Бразил	2016*		Нэвтрүүлсэн: Биометрийн үзүүлэлт ашиглан санал ёгех систем нэвтрүүлсэн (2016 ОУПХ тайлан)
5	Зимбабве ¹⁸⁹	2018	Туршилтын шатанд: Нэвтрүүлэхээр төлөвлөсөн (biometric clocking) Дэгийн байнгын хороогоор гишүүдийн ирцийн биометрийн бүртгэлийн систем нэвтрүүлэхээр хэлэлцэн шийдвэрлэсэн.	
6	Ирак ¹⁹⁰	2016		Туршилтын шатанд: Биометрийн үзүүлэлт ашиглан санал ёгех систем нэвтрүүлэхээр төлөвлөсөн (2016 ОУПХ тайлан)
7	Итали ¹⁹¹	2010		Нэвтрүүлсэн: Хурууны хээгээр санал ёгех системийг 2010 онд нэвтрүүлсэн.
8	Канад	2018**		Туршилтын шатанд: Нийтийн танхим ирэх 2 жилийн хугацаанд хурууны хээгээр санал ёгех систем нэвтрүүлэхээр төлөвлөсөн. (2018 ОУПХ тайлан)

¹⁸⁸<http://english.eurel.it/8?news=11>¹⁸⁹On a few occasions, we had to adjourn debates in the National Assembly and we now concluded with the Committee on Standing Rules and Orders - the policy body which manages Parliament - that we are going to introduce biometric registers so that when a Member of Parliament ... is clocked in and clocked out as well. That way, we will be able to trace which Member of Parliament has the habit of sneaking in and out. Further, we have agreed with the Committee on Standing Rules and Orders that we have an attendance and contribution audit.”<https://www.zimbabwesituation.com/news/biometric-register-for-ninth-parliament/><http://businessdaily.co.zw/index-id-national-zk-45545.html>¹⁹⁰we depend the electronic voting while some time spend the hand voting according to the decision of parliament before vote and the near future we will depend biometric for vote, Dataset used for the preparation of the World e-Parliament Report 2016¹⁹¹<http://english.eurel.it/8?news=11>

9	Кени ¹⁹²	2014	Нэвтрүүлсэн:*(biometric register) Гишүүд ирцээ хурууны хээгээр бүртгүүлнэ. (Цахим бүртгэлийн системийг шинэчлэх ажил явагдаж байгаа. 2018 оны 8-р сарын байдлаар)	Нэвтрүүлсэн: Биометрийн үзүүлэлт ашиглан санал өгөх систем нэвтрүүлсэн (2016 ОУПХ тайлан) (Цахим бүртгэлийн системийг шинэчлэх ажил явагдаж байгаа. 2018 оны 8-р сарын байдлаар)
10	Колумби	2016*		Нэвтрүүлсэн: Биометрийн үзүүлэлт ашиглан санал өгөх систем нэвтрүүлсэн (2016 ОУПХ тайлан)
11	Малайз ¹⁹³	2018*		Нэвтрүүлсэн: Парламентын ордонг өргөтгөх төслийн хүрээнд биометрийн үзүүлэлт ашиглан санал өгөх систем нэвтрүүлсэн (2018 ОУПХ тайлан)
12	Өмнөд Африк ¹⁹⁴	2015/2018**	Нэвтрүүлсэн: (electronic attendance monitoring system) RFID карт болон хурууны хээгээр нэгдсэн хуралдаан болон байнгын хороодын хуралдааны ирцийг бүртгэнэ. Гишүүдийг танхимд нэвтрэх, гарахад RFID карт автоматаар унших бол ирцийг гишүүдийн эрхийг хурууны хээгээр бүртгэнэ.	Нэвтрүүлсэн: Биометрийн үзүүлэлт ашиглан санал өгөх систем нэвтрүүлсэн (2018 ОУПХ тайлан)
13	Түрг ¹⁹⁵	2016*	Нэвтрүүлсэн: Хурууны хээгээр бүртгэдэг	Нэвтрүүлсэн: Биометрийн үзүүлэлтээс гадна нууц үг бүхий карт ашигладаг.

¹⁹²MPs will from Tuesday record their attendance of Parliament using fingerprints under a new biometric register installed during the recess in a bid to curb fraud in payment of allowances. The legislators were required to register with the House Information Communications Technology Department Monday to enable use of the system immediately the House resumes for its second session Tuesday afternoon. The debating chamber is equipped with modern technology, including public address system, electronic voting system, computer monitors and electronic buzzers.

<https://www.businessdailyafrica.com/news/Parliament-takes-MPs-fingerprints/539546-2200888-91p1kvz/index.html>

<https://www.bbc.com/news/world-africa-26137631>

*National Assembly Speaker Justin Muturi on Wednesday announced that the digital biometric system adopted in the eighth Parliament was undergoing an overhaul (21 August 2018)

<https://www.kenyans.co.ke/news/222687-national-parliament-speaker-justin-muturi-introduces-changes-12th-parliament>

¹⁹³e-Voting is provided in the existing Digital Conferencing System (DCS) but it is not being used due to transparency issue. Under the upgrading project of Parliament Building (Phase 2) which is currently ongoing, DCS will be replaced with Integrated Digital Conferencing System (IDCS) whereby this e-Voting will be replaced by new technology via Biometric Recognition. Dataset used for the preparation of the World e-Parliament Report 2016

¹⁹⁴In South Africa, Parliament put up electronic attendance monitoring system, which would provide accurate and instant record of MPs' attendance of committee meetings and plenary sittings. The system consists of two technologies: radio frequency identification (RFID) and biometric (fingerprint) to monitor the attendance of members at sittings of plenary and committee meetings. Unlike the fingerprint, RFID goes an extra mile to automatically detect MPs when they enter and exit a chamber or a committee room.

Biometrics like the ones Uganda is about to start using, are limited to fingerprint recognition and requires MPs to register their attendance using their thumbprint.

<https://www.gov.za/speeches/electronic-recording-members'-attendance-national-parliament-sittings-starts-april-27-mar>

¹⁹⁵Parmak İzi Tanımlaması TBMM Genel Kurul Salonunda, yoklama-oylama ve söz talebi işlemleri, parmak izini tanıyan elektronik cihazla ya- pilabildiğinden, milletvekillerinin parmak izi, Karşılama ve Danışma Börosunda, Bilgi İşlem Mədrəsəbine bağlı, Genel Kurul İş letme Birimi teknik görevlilerince alınacak ve kendilerine yasama duyma boyunca kullanabilecekleri bir şifre (PIN Kodu) ile birlikte 'TBMM Genel Kurul Salonu Elektronik Oylama, Yoklama ve Konferans Sistemi Kartı' verilecektir.

https://www.tbmm.gov.tr/yayinlar/Milletvekili_Rehberi.pdf

14	Уганда ¹⁹⁶	2017	Нэвтрүүлсэн: (biometric clocking) Нэгдсэн хуралдааны 4 хаалга дээр 8 хуруу унших төхөөрөмж байрлуулсан. Гишүүн танхимд нэвтрэх, гарахдаа хурууны хээгээ бүртгүүлнэ. Гишүүний ирцээ бүртгүүлсэн цаг, хуралдааны танхимд байсан хугацаа нь танхим дахь дэлгээн дээр гарна. (Одоогоор хууль, дүрэмд холбогдох зохицуулалт тусгагдаагүй)	
15	Украин ¹⁹⁷	2017		Туршилтын шатанд: Нэгдсэн хуралдааны танхимыг автоматжуулах тендер зарласан, техникийн шаардлагад зааснаар гишүүний санал хураалтад мэдрэгчтэй дэлгэц болон товчлууртай төхөөрөмж, карт уншигчтай байна. Тоног төхөөрөмжийг нууц уг, ID карт, эсхүүл хурууны хээгээр идэвхжүүлнэ.
16	Чили	2016*		Нэвтрүүлсэн: Биометрийн үзүүлэлт ашиглан санал ёгөх систем нэвтрүүлсэн. (2016 ОУПХ тайлан)
17	Шри Ланка ¹⁹⁸	2017**		Нэвтрүүлсэн: Биометрийн үзүүлэлт ашиглан санал ёгөх системийг 2017.07.25-нд нэвтрүүлсэн. (2018 ОУПХ тайлан)

¹⁹⁶<https://allafrica.com/stories/201703220534.html>

¹⁹⁷По результатам технического переоснащения зала заседаний Рады должна быть создана интегрированная автоматизированная система «Электронный зал пленарных заседаний». Система должна обеспечивать легкий и оперативный доступ депутатов во время работы в зале пленарных заседаний к информационно-документальным ресурсам законотворческого процесса. На рабочем месте депутата должен быть цветной сенсорный экран (тач-скрин) с возможностью голосования по нему и дополнительный модуль с кнопками для голосования на случай выхода из строя тач-скрина, персональный компьютер, сканер считывания биометрических данных, кардридер, микрофон, громкоговоритель и устройство для пользования синхронным переводом. Доступ к рабочему месту должен быть при помощи логина и пароля, ID-карты или сканера отпечатка пальца. Также система будет обеспечивать контроль пребывания на рабочем месте с помощью системы видеонаблюдения.

РИА Новости Украина: <https://rian.com.ua/politics/20170807/1026543888.html>

¹⁹⁸"The delegate panels had to have all the features that were required and they also had to be easy to use. Each member's desk is provided with a contribution panel which consists of speaker, volume and channel selector for listening to interpreted languages with headphones. Biometric readers for authentication and voting panel for voting are also present. The microphone panel is provided with a gooseneck microphone and a request to talk button."

<http://www.inavateapac.com/case-studies/article/case-study-sri-lankan-parliament-complex-sri-lanka>

<http://english.gossiplankanews.com/2016/11/ministers-and-members-of-parliament-to.html>

<https://www.srilankaneowlive.com/component/k2/item/19333-parliament>

* ОУПХ-ноос 2016 онд гаргасан тайланд орсон анхдагч мэдээлэл.

** ОУПХ-ноос 2018 онд гаргасан тайланд орсон анхдагч мэдээлэл, албан ёсоор нийтэд нээлттэй болоогүй. УИХ-ын Тамгын газрын Гадаад харицааны хэлтсээр дамжуулан ОУПХ-ноос холбогдох мэдээллийг авсан.

БҮГД НАЙРАМДАХ ИРЛАНД УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

(Мэдээлэл, лавлагаа)

Д.Халиун

Бүгд Найрамдах Ирланд Улс нь 1937 оны 7 сарын 1-нд баталсан Үндсэн хуулиа тус оны 12 сарын 29-ны өдрөөс эхлэн бүх нийтээрээ дагаж мөрдөж ирсэн.

Хууль тогтоох дээд байгууллага нь Ерөнхийлөгч, Төлөөлөгчдийн болон Сенатын танхимаас бүрдэх Вестминстериин загвар¹⁹⁹ бүхий Парламент юм. Төлөөлөгчдийн танхимиын 166 гишүүн (ирэх сонгуулиар 158 болгон бууруулах гэж буй)-ийг бүх нийтийн сонгуулиар сонгодог. Харин Засгийн газрын тэргүүний нэр дэвшигүүлсэн 11, Үндэсний болон Дублины Их сургуулиас сонгогдсон 6 төлөөлөгч, тусгай 5 салбараас нэр дэвшигүүлсэн 43 (улсын болон орон нутгийн) нийт 60 гишүүнтэй Сенатын танхим 7 жилийн хугацаатай бүрэн эрхээ хэрэгжүүлдэг.²⁰⁰

2017 онд Парламентын төсвийн алба байгуулагдсанаар Ирландад “Бие даасан төсвийн институц (Independent Fiscal Institution)” буюу төсвийн хяналт, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бие даасан, хараат бус 2 байгууллагатай болсон.²⁰¹ Эдгээр нь:

- Ирландын Төсвийн зөвлөх зөвлөл - **Irish Fiscal Advisory Council** (2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулагдсан)
- Парламентын төсвийн алба - **Parliamentary Budget Office**²⁰² (2017 оны 8 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан)



Irish Fiscal
Advisory Council

БҮГД НАЙРАМДАХ ИРЛАНД УЛСЫН ТӨСВИЙН ЗӨВЛӨХ ЗӨВЛӨЛ (Irish Fiscal Advisory Council (IFAC))

Байгуулагдсан: 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр.
(2011 оноос байнгын бус үйл ажиллагаа явуулж байсан)

Байгуулсан эрх зүйн акт: 2012 онд батлагдсан Төсвийн хариуцлагын тухай хууль - Fiscal Responsibility Act 2012 (FRA).²⁰³

Төсөв: EUR 800 000 (Төсвийн хариуцлагын тухай хуулиар тогтоосон).
Орон тоо: Зөвлөлийн гишүүн, дарга - 5 (part-time буюу орон тооны бус) болон байнгын ажиллагаатай ажлын алба (full-time secretariat) - 7 албан хаагч.

Зөвлөлийн гишүүдийг Сангийн сайд 4 жилийн хугацаагаар томилно.

Зөвлөлийн дарга:

- 2016-оноос эдийн засагч Симус Коффи (Seamus Coffey) (University College Cork).
- 2011-2016 он Профессор Джон МакХэйл (National University of Ireland Galway).

¹⁹⁹Парламентын дээд танхим нь төсөвтэй холбоотой асуудлаар харьцангуй хязгарагдмал эрх үүрэгтэй байна.

²⁰⁰<https://www.oecd.org/gov/budgeting/Review-of-budget-oversight-by-parliament-Ireland.pdf>

Source: Oireachtas Library and Research Service (2011), www.oireachtas.ie/parliament, www.president.ie, <http://per.gov.ie/public-expenditure>

²⁰¹Дээрх 2 байгууллага нь нэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэдий ч хоорондоо ялгаатай чиг үүрэг, зорилго, статустай байна. Парламентын төсвийн алба нь Парламентын болон түүний хороодод дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байх ба дээрх 2 байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийг давхцуулжгүй байхад онцгой анхаарч, байгууллагын удирдлагууд цаашид хамтран ажиллах тал дээр тогтол уулзалт зохион байгуулдаг. Зарим улсад, тухайлбал, Австрий ПТА-ны дарга нь Австрийн Төсвийн зөвлөлийн хуралд санал өгөх эрхгүйгээр оролцдог.

²⁰²Ireland's Parliamentary Budget Office (PBO) was established (on 15th August 2017) within the Houses of the Oireachtas as part of the process of D6il reform. A commitment in relation to its establishment was also made in the Programme for a Partnership Government. The PBO is one of the specialist units which have been established in recent years within the Houses of the Oireachtas Service. These include the Office of the Parliamentary Legal Advisor and the Library & Research Service (L&RS).

²⁰³https://data.oireachtas.ie/ie/oireachtas/parliamentaryBudgetOffice/2017/2017-11-24_the-role-and-functions-of-ireland-s-parliamentary-budget-office_en.pdf

ЕХ/ОУВС-аас Ирландад үзүүлэх санхүүгийн дэмжлэг болон 2011 оны Засгийн газрын Хөтөлбөр зэргийн хүрээнд явагдсан төсвийн шинэтгэлийн хүрээнд 2012 онд батлагдсан Төсвийн хариуцлагын тухай хуулиар Төсвийн зөвлөх зөвлөлийг байгуулсан.

Ирландын Төсвийн зөвлөх зөвлөл нь төсвийн төсөөлөл, төсвийн бодлогын чиглэлээр бие даасан, хараат бусаар шинжилгээ хийх зорилго бүхий бие даасан байгууллага юм.

2013 оны 7-р сарын ЕХ-ны тогтоолыг²⁰⁴ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Төсвийн Зөвлөх зөвлөлийн чиг үүрэгт улсын төсвүүд болон Тогтвортой байдлын хөтөлбөрүүдийн суурь болох Сангийн яамнаас бэлтгэдэг макро эдийн засгийн төсөөллийг үнэлэх, баталгаажуулах чиг үүргийг нэмж тусгасан. Энэхүү нэмэлт чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтыг Төсвийн зөвлөх зөвлөл болон Сангийн яам хооронд байгуулсан санамж бичгээр (2018 оны 1-р сарын 30-ны өдөр) зохицуулсан.

Төсвийн зөвлөх зөвлөлийн чиг үүрэг

- Төсөөв болон Тогтвортой байдлын хөтөлбөрийн үндэс, суурь болох Сангийн яамнаас бэлтгэсэн макро эдийн засгийн төсөөллийг зохистой гэж үзсэний үндсэн дээр баталгаажуулах.
- Сангийн яамнаас гаргасан албан төсөөлөлд дүн шинжилгээ хийх. Сангийн яамнаас Тогтвортой байдлын хөтөлбөрийн шинэчилсэн хувилбар - хавар, төсвийн төсөл – намар тус тус гаргадаг байна.
- Засгийн газрын төсвийн санхүүжилт нь ЕХ-ны Тогтвортой байдал ба Өсөлтийн гэрээтэй холбоотой эдийн засаг, төсвийн удирдлагын зохистой удирдлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэх.
- Төсвийн хариуцлагын тухай хуулиар тогтоосон шаардлага, төсвийн дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих. “Төсвийн дүрэм”-д зааснаар төсөөв алдагдалгүй, эсхүл тэнцвэртэй байх буюу алдагдалгүй, тэнцвэртэй байхад чиглэсэн байх юм.
- Төсвийн дүрэм зөрчигдсэн нь Засгийн газраас үл хамаарах онцгой нөхцөл байдал үүссэн, эдийн засгийн уналт зэргээс төсөөвт нөлөөлсөн эсэхийг тогтоох үүрэгтэй байна.
- Төсвийн зөвлөх зөвлөлийг дээрх чиг үүргээ бие даан, хараат бусаар гүйцэтгэхд хуулиар баталгаажуулна.
- Төсвийн зөвлөх зөвлөлийн зөвлөл нь жилд хоёр удаа “Төсвийн үнэлгээний тайлан”, жилд нэг удаа Төсвийн урьдчилсан мэдэгдэл гарган Сангийн сайдад хүргүүлж, 10 хоногийн дотор олон нийтэд нийтэлнэ. Засгийн газар нь Төсвийн зөвлөх зөвлөлийн төсвийн холбогдох дүрэм журамд нийцэж буй эсэхэд хийсэн үнэлгээний тайланг хүлээн аваагүй бол Сангийн сайд Парламент (доод танхим)-д хүлээн аваагүй шалтгааныг тусган мэдүүлнэ.

²⁰⁴REGULATION (EU) No 473/2013 OF THE EUROPEAN PARLIAMENT AND OF THE COUNCIL of 21 May 2013 on common provisions for monitoring and assessing draft budgetary plans and ensuring the correction of excessive deficit of the Member States in the euro area
<https://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:L:2013:140:0011:0023:EN:PDF>

Төсвийн зөвлөх зөвлөл нь макро эдийн засаг, төсвийн бодлогод чиглэдгийн хувьд Засгийн газраас Парламентад өргөн барьсан төсвийн жил бүрийн зарлагын задаргаа, шинээр оруулж ирж буй төсвийн бодлогын асуудлаар оруулж ирж буй шинэ санал тус бүрийг хянан, шинжилгээ хийдэггүй.

Ирландын Төсвийн Зөвлөх зөвлөлийн чиг үүрэгт (Австрали, Канад, Нидерланд зэргийн ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагын чиг үүрэгт байдагтай адил) бодлогын төслүүдийн нарийвчилсан зардлыг гаргах, үүнд улс төрийн янз бүрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрүүд, эсхүл шинэ Засгийн газар, эвслийн аливаа санаачилга бодлого нь төсвийн тэнцэлд хэрхэн тусгагдаж, эдийн засагт үзүүлэх үр нөлөө нь ямар байхыг тооцох зэрэг чиг үүргийг хүлээдэггүй. Зөвлөл нь шинжилгээний тайлан, ажлын баримт бичтийг өөрийн санаачилгаар олон нийтэд зориулан нийтэлдэг байна.

Хууль тогтоох байгууллагатай хэрхэн хариуцлагдаг тухай

ИТЗ3 нь үйл ажиллагаагаа Засгийн газар болон Парламентаас хараат бусаар явуулах боловч Сангийн сайд зөвлөлийн гишүүдийг томилно. Мөн тэрээр холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлээр Парламентын доод танхимын зөвшөөрснөөр зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, огцуулна. ИТЗ3 нь ажилтан авах, байр түрээслэх зэрэгт Сайдын зөвшөөрлийг (Төрийн зардал, шинэтгэлийн сайд (Minister for Public Expenditure and Reform)-тай зөвшилцөн) урьдчилан авсан байна.

Төсвийн хариуцлагын тухай хуульд заасны дагуу ИТЗ3 нь үйл ажиллагааны тайлангаа жил бүр Сайдад хүргүүлэх ба Сайд хуулбарыг “боломжтой болмогц” Парламентад хүргүүлнэ (13-р зүйл). Ерөнхий хянан шалгагчийн алба болон Ерөнхий аудитор нь парламентад хүргүүлсэн ИТЗ3-ийн санхүүгийн тайланд аудит хийнэ (10-р зүйл). Парламентын доод танхим нь ИТЗ3-ийн даргаас холбогдох нотлох баримт шаардаж болох ба 2 танхимын хороод нь ИТЗ3-ийн үйл ажиллагааг тайлагнахыг ИТЗ3-ийн даргаас хүсэж болно (11-р зүйл).

ИТЗ3 нь үйл ажиллагаагаа явуулахад Сангийн яамны ашиглаж буй загварчлал, аргыг мэдэж байх шаардлагатай байдгаас гадна ИТЗ3 нь Сангийн яам, Төв Статистикийн газар, Үндэсний төрийн сангийн агентлаг зэрэг байгууллагаас гаргаж буй мэдээллээс ихээхэн хамааралтай байдаг. Иймд ИТЗ3 нь зарим байгууллагатай статистикийн болон бусад мэдээллийн зохистой урсгал бий болгох тал дээр санамж бичиг байгуулах нь зүйтэй гэсэн санал гаргасан. ИТЗ3 нь Эдийн засаг, нийгмийн судалгааны хүрээлэнтэй нягт хамтран ажилладаг.

Үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө

Төсвийн зөвлөх зөвлөл нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлын төлөвлөгөөгөө өөрөө боловсруулан баталдаг. Зөвлөл нь гол төлөв сард нэг удаа цуглдаг, ихэнх ажлаа утсаар, эсхүл и-мэйлээр гүйцэтгэдэг. Гол ажлууд нь Сангийн яамнаас гаргасан албан төсөөлөлд дүн шинжилгээ хийх.

Сангийн яамнаас Тогтвортой байдлын хөтөлбөрийн шинэчилсэн хувилбар - хавар, төсвийн төсөл - намар тус тус гаргадаг байна. ИТЗ3 нь мэргэжлийн шинжээч, экспертуудийг гэрээгээр авч ажиллуулж болдог.

Төсөв

2011-2012 онд ИТЗ3 нь Засгийн газрын буцалтгүй тусламжаар санхүүжиж, 2012 онд EUR 650 000 төсөвтэй байсан бол 2013 онд ИТЗ3-ийн төсвийн дээд хэмжээг Төсвийн хариуцлагын тухай хуулиар EUR 800 000 байхаар тогтоосон ба жил бүр инфляцын хэмжээтэй уялдуулан индескюүлж тооцно. ИТЗ3-ийн төсөв ("non-voted" expenditure)-ийг хуулиар тогтоосон байх ба Засгийн газраас санал оруулж, Парламент батлах шаардлагагүй байдаг нь томоохон хамгаалалт болдог байна. Холбогдох тайлангуудад дээрх санхүүжилтийн хэмжээ нь үйл ажиллагаа явуулахад хангалттай, хүрэлцэхүйц гэж дурдсан байна.

Үдирдлага, бүтэц

ИТЗ3-ийн 5 гишүүнийг Сангийн сайд томилж, мөн тэрээр гишүүд дундаас даргыг сонгоно. Зөвлөлийн гишүүн улс төрийн алба хашихыг хориглоно. Гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба нэг удаа улируулан ажиллуулж болно. Энэ нь парламентын бүрэн эрхийн 5 жилийн хугацаатай зөрүүлж тогтоосон хугацаа юм.

Зөвлөлийн гишүүнийг хугацаанаас нь өмнө Сангийн сайд гагцхүү Парламентын доод танхимын тогтоолд Төсвийн хариуцлагын тухай хуульд заасан дараах үндэслэлийг дурдсаны үндсэн дээр чөлөөлж болно. Үүнд:

- а) гишүүн нь эрүүл мэндийн шалтгаанаар чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх чадваргүй болсон;
- б) гишүүн нь зүй бус үйлдэл үйлдсэн (*misbehaviuor*);
- в) тухайн гишүүн нь сонирхлын зэрчилтэй гэж сайд үзсэн; эсхүл
- г) гишүүнийг отцуулах нь ИТЗ3-ийн үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад зайлшгүй шаардлагатай гэж үзсэн зэрэг байна.

Мөн гишүүнийг дараах үндэслэлээр отцууулж болно:

- а) дамжуурлаа зарласан;
- б) зээлдүүлэгчтэй (үүрэг гүйцэтгүүлэгчтэй) харилцан тохиролцсон хэлэлцээр, тохиролцоо хийсэн;
- в) гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн;
- г) запилан буюу шударга бус үйл ажиллагаатай холбоотойгоор зөрчил үйлдсэн; эсхүл
- е) 1990 оны Компанийн тухай хуулийн 150-р зүйлийг зөрчсөн (4-р зүйл [4]).²⁰⁵

²⁰⁵has a declaration under Section 150 of the Companies Act 1990 made against him or her or is subject or is deemed to be subject to a disqualification order by virtue of Part VII of that Act. (Article 4[4]).

Дээрхээс гадна гишүүн нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдж болно.

2011 онд байгуулагдсан зөвлөлийн бүтэц нь эдийн засаг, төрийн санхүүгийн чиглэлээр мэргэшсэн, Эдийн засаг, нийгмийн судалгааны хүрээлэн, ОУВС, ЭЗХХАБ зэрэг нэр хүндтэй олон улсын байгууллагад ажиллаж байсан туршлагатай хүмүүсээс бүрдсэн.

Зөвлөлийн гишүүн нь Ирландын иргэн байх шаардлагагүй байх ба 2011 оны анхны бүтцэд Ирландын иргэн бус 1 гишүүн ажиллаж байсан ба 5 гишүүний 3 нь гадаадад байрлаж байсан. Дээрхийг зөвлөлийн үйл ажиллагааг илүү бодитой, үр дүнтэй болгоно гэж үзсэн байна.

ИТ33-ийн гишүүд нь орон тооны бус хэдий ч, ажлын ачаалал өндөр зэргийг харгалзан орон тооны албан хаагчтай адил цалинжуулах зарчмыг баримталдаг. ИТ33-ийн даргын жилийн цалин EUR 20 520 байх бол гишүүний цалин EUR 11 970 байна.

Анх ИТ33-ийн ажлын алба нь 3 ажилтантай байсан бол өдгөө 7 болон нэмэгдсэн. Ажлын албаны ажилтнуудыг сэлгэн ажиллуулах журмаар ажиллуулдаг. (Тухайлбал, Төв Банк, Үндэсний төрийн сангийн агентлаг, Төрийн зардал, шинэтгэлийн яам болон Эдийн засаг, нийгмийн судалгааны хүрээлэн зэргээс) Хэдийгээр төсөв санхүүгийн хувьд ИТ33 нь ажлын албаны ажилтныг ажиллуулахад хүндрэл гаргадаггүй бол дээр дурдсанчлан Сангийн сайдаас урьдчилан зөвшөөрөл авдаг нь (ажилтан тус бүрд бус, орон тооны хувьд) зохион байгуулалтын хувьд төдийлөн хараат бус байж чадахгүй байна.

ПАРЛАМЕНТЫН ТӨСВИЙН АЛБА²⁰⁶ (Parliamentary Budget Office (PBO))

Байгуулагдсан: 2017 оны 8 дугаар сарын 15-ны өдөр.


Төсөв: EUR 960 000 (2018 онд төлөвлөсөн).

Орон тоо: 15-төлөвлөсөн.



²⁰⁶ПТА нь сүүлийн жилүүдэд явагдсан Парламентын шинэтгэлийн хүрээнд байгуулагдсан нэгжийн нэг бөгөөд үүнээс гадна Парламентын хуулийн зөвлөхийн алба, Номын сан, судалгааны алба зэрэг тус тус байгуулагдсан байна.

ИРЛАНДЫН ПАРЛАМЕНТЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



**ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦАД ИРГЭДИЙН
ОРОЛЦОOG ХАНГАХ ЦАХИМ СИСТЕМИЙН ТАЛААРХ
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ, Р.Өнөрсайхан
О.Нарантуяа, Р.Нургул

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хууль боловсруулах процесийн шинж чанар нь энэхүү процесийг удирдан зохион байгуулах, хууль хэвлэн нийтлэхэд зориулсан онцгой бөгөөд нарийн технологийг бүтээх хэрэгцээ шаардлагыг бий болгож буй талаар Австралийн эрдэмтэн, доктор Тимоти Арнольд-Мур өөрийн эрдэм шинжилгээний бүтээлдээ өгүүлсэн байна.

Энэ төрлийн мэдээллийн технологийг Англи, Австрали, Канад, Япон, Солонгос гэх мэт томоохон улс орнуудад хэрэглэдэг бөгөөд Австралийн Тасмани мужийн Засгийн газраас хууль тогтоомжийн мэдээллийн үйлчилгээг олон нийтэд хүргэх үйлчилгээг сайжруулах, хууль тогтоомж боловсруулах, удирдан зохион байгуулах системийг бий болгох зорилгоор төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүний үр дүнд Тимоти Арнольд-Мур-ийн мэдээллийн технологид суурилсан EnAct программыг боловсруулж нэвтрүүлсэн.

Энэхүү программыг хэрэгжүүлж эхлэхээс өмнө Тасманийн хууль тогтоомжийн удирдлага зохион байгуулалт хямралын түвшинд хүрээд байсан бөгөөд ийнхүү хууль тогтоомжийн нэгтгэл алдагдаж зохих тэмдэглэгээг хийж чадахгүй байгаагаа тус улсын Засгийн газар хүлээн зөвшөөрч, эдгээр асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор хууль тогтоомжийг боловсруулах, удирдан зохион байгуулах, олон нийтэд хүртээмжтэй болгох төслийг эхлүүлсэн нь амжилттай хэрэгжсэн

Судалгааны ажил нь:

- Хууль боловсруулах, хэвлэн нийтлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх программ хангамжийн зорилго;
- Хуулийн төсөл боловсруулалтад ашиглагдах мэдээлэл, технологийн системийн бүрэлдэхүүн гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

Энэхүү программ хангамж нь хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг, хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх албаны ажилд дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд программыг хэрэглэх болсноор зөвхөн хууль тогтоомжийг нэгтгэхээс гадна хууль тогтоомж боловсруулахад нэгдсэн нэг форматтай болгосноороо ач холбогдолтой болсон.

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

Энэхүү лавлагаа, мэдээллийг Австралийн Тасмани мужийн хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, цахим мэдээллийн санд оруулах, хэвлэн нийтлэх хүртэлх бүх үе шатыг нэг программ хангамжаар шийдсэн туршлагын талаар судалсан болно.

Хууль боловсруулах процесийн шинж чанар нь энэхүү процесийг удирдан зохион байгуулах, хууль хэвлэн нийтлэхэд зориулсан онцгой бөгөөд нарийн технологийг бүтээх хэрэгцээ шаардлагыг бий болгож байна. Хууль боловсруулан батлах, хэвлэн нийтлэх хүртэл хийгддэг ажилбарууд, санхүүгийн болон биет бус ашиг, мөн эрх зүйн баримт бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг нь тусгайлсан программ хангамжид тодорхой хөрөнгө оруулалт шаардлагатай байгааг Австралийн эрдэмтэн, доктор Тимоти Арнольд-Мур²⁰⁷ өөрийн эрдэм шинжилгээний бүтээлдээ өгүүлсэн байна.

Австралийн Мельбурн дэх Хaanы технологийн их сургуулийн Доктор Тимоти Арнольд-Мур (Timothy Arnold-Moore) “Хууль эрх зүйн мэдээллийн систем” (“Information systems for legislation”) сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Энэхүү судалгааны ажилдаа 20 гаруй жилийг зарцуулсан бөгөөд энэ хугацаанд Австралийн Тасмани (EnAct), Шинэ Өмнөд Уэльс (LEGIS), Квинсленд (QuILLS) мужууд, Сингапур (LEAP), Канад (LIMS) зэргийн Засгийн газруудад хууль тогтоомж боловсруулах, нийтлэхэд нь дэмжлэг үзүүлэх мэдээллийн технологийг боловсруулсан.


Энэхүү мэдээллийн технологийг Англи, Австрали, Канад, Япон, Солонгос гэх мэт томоохон улс орнууд хэрэглэдэг боловч Тасманиас бусад улс орнуудын программ хангамжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл олдоогүй болно. Харин Тасманийн Засгийн газраас хууль тогтоомжийн мэдээллийн үйлчилгээг олон нийтэд хүргэх үйлчилгээг сайжруулах, хууль тогтоомж боловсруулах, удирдан зохион байгуулах системийг бий болгох зорилгоор төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүний үр дүнд Тимоти Арнольд-Мур-ийн мэдээллийн технологид сууриссан EnAct программыг боловсруулж нэвтрүүлсэн. Судалгаанд энэхүү программ хангамжийн талаар дэлгэрүүлэн тайлбарласан болно.

Энэхүү программыг хэрэгжүүлж эхлэхээс өмнө Тасманийн хууль тогтоомжийн удирдлага зохион байгуулалт хямралын түвшинд хүрээд байсан. Үсэг хэвлэдэг даруул (Tapper) нь хуулийн заалтад орсон нэмэлт, өөрчлөлтийг тэмдэглэдэг байсан бөгөөд нэмэлт, өөрчлөлт бүрийг тусгасан хуулийн эхийг Тасманийн хэвлэлийн газар болон Парламентын зөвлөх алба нь хэвлэн нийтэлдэг. 1959 он хүртэл хууль тогтоомжийн энэхүү нэгтгэл бүрэн явагдаж байсан бөгөөд 1970 оны дундуур шинэ хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Гэвч хөрөнгө

²⁰⁷Доктор Тимоти Арнольд-Мур (Timothy Arnold-Moore) нь Шинэ Зеланд, Канадын Онтарио муж, АНУ-ын Төлөөлөгчдийн танхимд редакцын албандаа зөвлөх үйлчилгээ үзүүлж, Вашингтон, Хобарт, Сидней, Чикаго, Оттава, Ром, Токио, Веллингтон, Киото, Мельбурн, Гаага, Брюссель, Бостон, Кардифф, Канберра, Сөүл зэрэг хотуудад зохион байгуулагдсан хуульчдын зөвлөгөөнд илтгэл тавьж хэлэлцүүлсан байсан. Одоогийн байдлаар доктор Арнольд-Мур нь дэлхийд томоохон тооцогдог Австралийн технологийн Leidos, Inc. компанийн охин компани болох Leidos Pty Ltd-ад ажиллаж байна.

санхүүгийн улмаас хэрэгжих боломжгүй болж хууль тогтоомжийн нэгтгэл, баталгаажуулалтад алдаа гарч зогсонги байдалд хүрсэн. Тухайлбал, 1952 оны Хурдан морины уралдаан болон тоглоомын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг 1978 он хүртэл бүрэн нэгтгэж байсан боловч түүнээс хойш 400 удаа нэмэлт, өөрчлөлт орсон боловч үүнээс 50 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг хуулийн эхэд тусгасан байсан. Энэ нь хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт нь бүрэн гүйцэд эсэхийг шалгах боломжгүй болгосон.

Ийнхүү хууль тогтоомжийн нэгтгэл алдагдаж зохих тэмдэглэгээг хийж чадахгүй байгаагаа тус улсын Засгийн газар хүлээн зөвшөөрч, эдгээр асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор хууль тогтоомжийг боловсруулах, удирдан зохион байгуулах, олон нийтэд хүртээмжтэй болгох төслийг эхлүүлсэн нь амжилттай хэрэгжсэн. Зураг 1-д цахим систем нэвтрүүлэхээс өмнө хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг тэмдэглэсэн байдлыг харуулав.



Зураг-1.

Энэхүү программ хангамж нь хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг, хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх албаны ажилд дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд программыг хэрэглэх болсноор зөвхөн хууль тогтоомжийг нэгтгэхээс гадна хууль тогтоомж боловсруулахад нэгдсэн нэг форматтай болгож программчилсан. 1997 онд Хууль тогтоомжийг хэвлэн нийтлэх тухай хуулийг баталсан бөгөөд энэ хуулиар Парламентын зөвлөх алба хууль тогтоомжийг албан ёсоор хэвлэх, цахим архив үүсгэн нэгтгэх болсон.

Нэг. ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ ҮЙЛ ЯВЦАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ЗОРИЛГО

a) Цаг хугацааны хүчин зүйлс

Урт настай эрх зүйн баримт бичиг: Хэдэн зуун жилийн өмнө боловсруулж баталсан зарим эрх зүйн баримт бичгийг өнөөдөр ч дагаж мөрдөж байна. Тухайлбал, Магна Хартагийн (1215) зарим хэсэг нь англи хэлээр яригч орнуудад хуулийн бүрэлдэхүүн хэсэг болон хүчин төгөлдөр үйлчилсээр байна. Гэтэл зарим эрх зүйн баримт бичгийн хувьд эсрэгээрээ богино хугацаанд харилцааг зохицуулж байна.

Олон удаагийн нэмэлт, өөрчлөлтүүд: Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад олон удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулах явдал гардаг. Хэдийгээр оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтүүд нь хуулийг сайжруулах зорилготой боловч хуульд текст нэмж оруулах, эсхүл текстийг өөрчлөх гэхээсээ илүү тэрхүү текстийг энгийн иргэдэд илүү ойлгомжтой байх талаас нь ажиллах шаардлагатай байдаг. Хууль хэрэглэгчид нь нэмэлт, өөрчлөлт орсон хамгийн сүүлийн хувилбарыг нэн даруй авахыг хүсдэг, тэдэнд эрх зүйн зөвлөгөө өгөх, эсхүл нэмэлт, өөрчлөлт орохоос өмнөх хувилбар хэрэгтэй болох зэрэг хуулийн хүчинтэй байсан бүх хувилбарууд хэрэгтэй болох тохиолдол гардаг.

б) Баримт бичгийн шинж чанар

Зөвшөөрөгдсөн нэр томьёо, формат: Хуулийг агуулгаар нь зохих журмын дагуу зүйл, дэд зүйл, догол мөр, дэд догол мөр тус бүрийг ялгахуйц дугаарлах бөгөөд бүлгүүд, дэд бүлгүүд, хэсгүүд, дэд хэсгүүдэд бүлэглэсэн байдаг.

Баримт бичгийн ач холбогдол: Хууль нь хамгийн чухал баримт бичиг бөгөөд энэ утгаараа түүнийг хэвлэн нийтлэхэд анхаарах нь мөн л чухал асуудал юм. Хуулийн форматад тавигдах шаардлагад анхаарал хандуулах нь чухал байдаг. Хуулийн төсөл батлуулах процесс дахь цаг хугацааны дарамт: Хууль тогтоомжийг хэлэлцүүлэгт бэлтгэх алба хуулийн төсөл дээр богино хугацаанд ажиллаж хэлэлцүүлэгт бэлтгэх шаардлага байнга үүсдэг. Өөрөөр хэлбэл, гарсан саналуудыг хуулийн төсөлд нэгтгэн тусгах, дараагийн хэлэлцүүлэгт маш хурдан бэлтгэх, мөн батлагдсан хуулийг богино хугацаанд олон нийтэд түгээх үүрэгтэй. Ийнхүү тус албанд хуулийн төслийг бэлтгэхэд хугацаа бага өгөх нь тэдэнд ихээхэн дарамт болдог байна.

в) Хууль тогтоох процесс

Хууль батлах дэг: Дэлхийн улсуудын хууль батлах дэг нь тэдний засаглалын хэлбэр, хууль тогтоох байгууллагын бүтэц, уламжлал зэргээс хамааран харилцан адилгүй байдаг ч бүгд тодорхой дэгээр баталдаг нийтлэг шинжтэй. Хуулийн төслийг өргөн барихаас өмнө түүний чанарыг шалгаж баталгаажуулдаг дотоод журам ихэнх улсын редакцын албанд байдаг байна.

Хууль боловсруулах үйл явц: Зарим улс орнуудад хуулийн төсөл санаачлан боловсруулах үйл явц нь албан бус байдлаар эхэлдэг. Вестминстерийн загварын засгийн газруудад ихэвчлэн Сайд нарын танхимаас хуулийн төсөл боловсруулах зөвшөөрөл авахыг шаарддаг байна.

Хуулийн төсөл санаачлагч хуулийн төсөл боловсруулахдаа өмнө боловсруулагдаж байсан хувилбар болон хуулийн төслүүдийг нягтлах, судлах асуудал гарч ирдэг. Иймд хууль санаачлан боловсруулах болон батлах процесийн бүртгэлийг уян хатан хийх шаардлагатай байдаг.

Хууль тогтоомжийг хэлэлцүүлэгт бэлтгэх албаны чиг үүрэг: Тус алба нь хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үндсэн чиг үүргийнхээ зэрэгцээ хууль тогтоомжийг албан ёсоор хэвлэн нийтлэх үүргийг хэрэгжүүлдэг.

ПРОГРАММ ХАНГАМЖИЙН АЧ ХОЛБОГДОЛ

a) Дотоод ач холбогдол


Цаг хугацаа, урсгал зардлыг хэмнэнэ: Хууль тогтоох байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд цаг хугацаа төдийгүй түүний урсгал зардлыг хэмнэнэ. Энэ нь хэмнэгдсэн цаг хугацаандаа өөр ашигтай төсөл хэрэгжүүлэх боломжтой болно. Үүний тулд хууль тогтоох процесийг дэмжиж хууль тогтоомж, холбогдох материалыг цаг тухайд нь аль болох олон иргэдэд хүргэх программ хангамж хэрэгтэй.

Удирдлагын үр дүнтэй тогтолцоо: Хуулийн олон төсөл дээр нэгэн зэрэг ажилладаг редакцын алба нь хууль тогтоох процесийн үе шатуудад хуулиар тогтоосон бүх ажилбаруудыг гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр ажилбаруудыг хуулийн дагуу гүйцэтгэснийг нотлох шаардлагатай байдаг. Энэ бүгдийг удирдан зохион байгуулах үр дүнтэй тогтолцоо нь парламентын ажлын албаны үйл ажиллагааны өртгийг тодорхой хувиар бууруулна.

Мөн парламентын ажлын албанаас үйл явц бүрийг хянах нь удирдлагыг илүү сайжруулна. Энэ нь ажилтнуудынхаа ажлын ачааллыг хялбархан хянаж, ажлыг зөв хуваарилах боломжтой болох бөгөөд эцэст нь тэдний парламентад үзүүлэх үйлчилгээ илүү үр дүнтэй болгох ач холбогдолтой.

б) Гадаад ач холбогдол

Засаглалын түвшинд хууль тогтоох процесийг хянах боломжтой: Хууль тогтоох байгууллагын хувьд тэдний баталсан хууль нь зөв зүйтэй эсэх, цагаа олсон эсэхийг мэдэхэд тусална. Мөн хуулийн төсөл санаачлан боловсруулах болон тэдгээрийг хэлэлцүүлэх зэрэг процессыг хуулийн дагуу явагдсаныг нотлох боломжтой болох нь зөвхөн парламентын ажлын албаны үйл ажиллагаанаас илүү өргөн хүрээний ач холбогдолтой юм.




Эцсийн хэрэглэгчдийн хүсэлт: Эцсийн хэрэглэгчид хуулийн төсөлтэй холбоотой нэмэлт формат, мэдээлэл, мета өгөгдлийг хүсдэг (эсхүл шаарддаг). Энэ нь эрх зүйн баримт бичгийн үндсэн форматыг шилжүүлэх ажил хийгдэнэ. Ийнхүү форматыг шилжүүлсний дараа түүний үр дүнг заавал шалгах бөгөөд тухайн форматаас хамаарч шалгалтын зардал шууд хамаарна. Microsoft Word-ын форматаас нөгөө рүү шилжүүлэх тохиолдолд баримт бичгийг шалгахад бага ажиллагаа орно, харин макро (macros) болон бусад формат руу шилжүүлэх тохиолдолд шалгахад ихээхэн ажиллагаа орж болзошгүй. Цаасан дээрх хувилбар, эсхүл өмнөх үеийн цахим хэлбэрээс XML формат руу шилжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гарах боловч ойрын ирээдүйд нэмэлт шилжүүлэг хийх шаардлагагүй давуу талтай. Эрх зүйн баримт бичгүүдийг XML форматад шилжүүлбэл программ хангамжийн хувилбар, эсхүл программ хангамжийн бүрэлдэхүүнээс үл хамааран ашиглаж болох давуу талтай. Форматыг өөрчлөхөд багц загварын хуудас (stylesheet)-ны (хуулийн багцын хүрээнд тодорхой бүтцийн хэлбэрийг тодорхойлно) тусламжтайгаар ихэвчлэн удирдан зохицуулж болно.

Эрх зүйн баримт бичгүүдийг ангилах нь хууль хэрэглэгчдэд хуулийн хайлтыг хөнгөвчлөх давуу талтай. Эрх зүйн болон бусад баримт бичгүүдийг солбицуулан холбоос үүсгэх ба холбоосыг үндсэн баримт бичигт холбогдох тэмдэглэгээгээр тэмдэглэж өгсөн байна.

Хоёр. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАЛТАД АШИГЛАГДАХ МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН СИСТЕМИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хууль боловсруулах, удирдан зохион байгуулах, хэвлэн нийтлэх систем (EnAct)-ийн бүтцийн талаар авч үзье.



Зураг 1. Хуулийн төсөл бэлтгэх, хэвлэх системийн ердийн загвар

Зураг 1 дэх бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг дэлгэрэнгүй тайлбарлавал:

- Засвар хийх хэрэгсэл /**Editing Tool**/: Хууль тогтоомжийн шинэ төсөл боловсруулах, одоо байгаа хууль тогтоомжийг нэгтгэсэн материал (дахин хэвлэх)-д өөрчлөлт оруулах боломжтой төсөл санаачлагч болон ажилтнуудад зориулсан хэрэгсэл²⁰⁸.
- Баримт бичгийн удирдлагын систем /Document Management System (DMS)/: DMS дараах хэсгүүдээс бүрдэнэ:
 - **Workflow Enactment**: Энэхүү дэд бүтэц нь ажлын процесс (төсөл боловсруулах)-ийн албан ёсны тодорхойлолтыг ашигладаг ба төслийн статус дээр үндэслэн төсөл боловсруулагч болон бусад хүмүүст статус тус бүрээр нь харуулна. Үүнээс гадна явцын тайлан гаргах (статик), хяналт хийх (динамик) функцууд, дуусах хугацааны сануулга, бүртгэлийн удирдлага, архив зэрэг функцууд байдаг.
 - Баримт бичгийн хувилбар гаргах /Document Versioning/: Энэ процесийн явцад баримт бичгүүд маш олон хувилбараар бэлтгэгдэж, эцсийн хувилбар болтлоо хянагдаж, сайжруулалт хийгддэг.

Ерөнхийдөө DMS нь хуулийн төсөл боловсруулах шатуудын тодорхой ўе шатанд шаардагдах хувилбараудын удирдлага, ажлын үйл явцын тодорхойлолтыг маш нарийн харуулдаг. Тухайлбал, эхний хувилбар, хэлэлцүүлэгдсэн хувилбар, санал нэгтгэх хувилбар гэх мэт. Энэ орчинд ашиглагддаг програмууд нь Documentum®^{vi}-ийн PTC Arbortet Adapter®, TeraText®^{vii} DMS, Microsoft SharePoint®^{viii} зэрэг болно.

- **Аппликэшн сервер /Application Server (Вэбсайт)/**: Хуулийн төсөл боловсруулах, хэвлэн нийтлэх боломжтой дотооддоо болон олон нийт ашиглаж боломжтой вэбсайт байдаг²⁰⁹.
- **Датабааз систем /Database System/**: Ихэнх бичиг баримт удирдлагын системүүд Oracle®, DB2®, SQL Server ® зэрэг уламжлалт дата (өгөгдлийн) баазын системээс гадна TeraText, SOLR™ зэрэг NoSQL суурьтай бааз дээр тулгуурласан байдаг. Зарим тохиолдолд файлын сервер нь түлхүүр үгийн хайлт хийх боломжтой **Search Engine** нэмэлт функц бүхий датабааз системтэй байдаг. Ерөнхий системийн бүрдэл хэсгүүд дор бүрнээ өөр, өөр бааз ашигладаг. **Workflow Enactment** одоо хийгдэж буй болон бүрэн хийгдсэн төслийдийн талаар мэдээлэл хадгалах датабазтай байхыг шаарддаг. **Document Versioning** документийн метадата, үүн дотор хувилбарын мэдээлэл, хувилбурууд хоорондын хамаарал мөн документийн агуулга (заримдаа файл систем дээр тусдаа хадгалагддаг) зэрэг мэдээллийг хадгалах хэрэгтэй болдог. **Website Application Server** олон нийтэд хүргэх өгөгдлүүдийн сантай байх шаардлагатай бөгөөд тэрхүү өгөгдлүүд нь баримт бичгийн

²⁰⁸XML орчинд энэ хэсэг нь энгийн бүтэцтэй PTC Arbortext® Editor (Шинэ Зеланд, Канад, АНУ-ын зарим мужуудад хэрэглэгддэг), JustSystems XMetal®^{ix} (Өмнөд Австрали, АНУ-ын Их хурлын дэд танхим, Канад, АНУ-ын зарим мужуудад ашиглагддаг), Adobe® FrameMaker®^x (Австралийн Шинэ Өмнөд Уэльс, Күйінслэнд мужуудад хэрэглэгддэг), эсхүл <oXygen/>^y (АНУ-ын зарим мужуудад хэрэглэгддэг) зэрэг тодорхой бүтэцтэй засвар хийгч (editor) юм.

²⁰⁹Өргөн хэрэглэгдэгээс Microsoft IIS, эсхүл Java® суурилсан JBOSS®^{xix}, WebLogic®^{xv}, эсхүл WebSphere®^{xvi} гэх мэт серверүүдийг нэрлэж болох ч, эдгээрээс хууль эрх зүйн вэб сайтуудад TeraText –ын сервер түгээмэл ашиглагддаг.

хувилбарын сан руу шууд ханддаг байж болно. Гэхдээ энэ нь гол төлөв вэб ачаалах зориулалттай тусдаа сан, эсхүл файлын систем дээр суурилсан сан байж болно.

- **Render Service:** XML орчинд, мөн бусад орчинд нэмэлт форматуудыг гаргаж авахын тулд хуулийн төслийн үндсэн форматыг (source format) авах үйлчилгээ үзүүлэх шаардлагатай. XML²¹⁰ орчинд материалын хэвлэх хувилбарыг гаргаж авах (зөвхөн хуулийн төслийн боловсруулалтын явцад)-ын тулд PDF хөрвүүлэг хийх нь чухал.
- **Засвар хийх хэрэгсэл [/Editing Tool/** болон Аппликэшн сервер [Application Server] бол салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд юм.

Зураг 2-т EnAct системд одоо холбогдоод байгаа хэрэглэгчид хуваарилтагдсан хуулийн төслүүдийн жагсаалтыг үзүүлэв. Хуулийн төсөл бичиж эхлэх шат болох төслийн нэр гарчиг болон тухайн ажил дээр хамгийн сүүлд өөрчлөлт оруулсан өдөр, цагийг харуулдаг. Энэ жагсаалт нь хамгийн эхэнд өөрчлөлт хийгдсэн файл хамгийн түрүүнд харагдах байдлаар эрэмбэлэгдсэн байна.

The screenshot shows a Microsoft Internet Explorer window displaying the EnAct 4.3 Drafting Environment. The title bar reads "EnAct 4.3 Drafting Environment - Microsoft Internet Explorer". The address bar shows the URL "http://localhost:9080/drafting/ashow.w3p;pat=;sa1=2a". The main content area displays a table titled "Activities for David Lane". The table has three columns: "Drafting File", "Drafting Stage", and "Date". The data in the table is as follows:

Drafting File	Drafting Stage	Date
Tiger Rules 2004	Open File	14/12/2004 10:33
TeraText Implementation Bill 2004	Open File	14/12/2004 10:35
Mount Mole-hill Reservation Order 2004	Open File	14/12/2004 10:38
Weed Control Bill 2004	Create Private Members Draft	14/12/2004 10:41
Criminal Code Amendment Bill 2004	Create Government Draft	14/12/2004 10:42
Aardvark Protection Bill 2004	Camera Ready Bill	14/12/2004 11:51
Test Amendment Vording Bill 2004	Record Certificates	21/12/2004 10:17
Workflow Definition Bill 2004	Create Government Draft	21/12/2004 10:58
Test Workflow Bill 2004	Save Legislation	21/12/2004 12:29
WF_2 Test Bill 2004	Save Legislation	21/12/2004 12:34
WF_3 Test Bill 2004	Save Legislation	21/12/2004 12:36
Test Commencements Bill 2004	Open File	21/12/2004 15:15
Test Commerce Refs Bill 2005	Create Draft Bill	19/01/2005 15:39

Зураг 2. EnAct систем дэх хэрэглэгчийн ажлын жагсаалт

Зураг 3-т тухайн төслийн агуулгаас гадна бусад мэдээллийг шинэчлэх хуудсыг үзүүлэв. Энэ хуудсанд харагдах материал нь тухайн төсөл ямар шатанд байгаагаас хамаарч хаалттай, эсхүл засвар хийх боломжтой байдлаар харагдана. Энд үзүүлсэн төсөл нь Засгийн газрын хэвлэх (Тасманийн Хэвлэлийн Газар) -руу илгээхэд бэлэн болсон дотоод журмын төсөл байна.

²¹⁰XML файлыг PDF болгоход зах зээл дэх PTC Arbortext Advanced Print Published (APP), Antenna House, Inc-ийн Formatter, эсхүл RenderX, Inc-ийн XEP Engine зэрэг ашиглагддаг.

The screenshot shows the EnAct 4.3 Drafting Environment interface in Microsoft Internet Explorer. The title bar reads "EnAct 4.3 Drafting Environment - Microsoft Internet Explorer". The menu bar includes File, Edit, View, Favorites, Tools, and Help. The address bar shows a complex URL related to a drafting file. The toolbar includes Back, Forward, Stop, Refresh, Search, Favorites, Media, and other standard browser icons.

The main content area displays the "EnAct 4.3" logo and version information ("Version: 4.3.2 Logged on as: David Lane"). A navigation menu at the top includes "Drafting Files", "Search", "Administration", "Logout", "Help", and "Tasmania". Below the menu, a message says "Drafting File Name: Bovine Rules 2004 (Statutory Rule - Governor)".

The "Activity Name" is listed as "Prepare for Printing Authority". There is a "Check Notes (2)" button with a bell icon. Below the activity name, there are tabs: "Documents", "File Details" (which is selected), "Notes", and "Next Drafting Stage".


The "Drafting File Data" section contains the following fields:

- Drafting File Name: Bovine Rules 2004
- Statutory Rule Name: Bovine Rules
- Statutory Rule Year: 2004
- Legislation Type: Principal Amending
- Statutory Rule Type: Direction
- Administrative Department: Department of Industry
- Governor Position: Governor
- Version Number: 1
- Minister Portfolio: Minister for Business
- QA Check (Draft): 25/01/2005
- Statutory Rule Number:
- Date of making:
- Governor's Signature: RICHARD BUTLER
- Minister's Signature:
- Gazette Date:

A "Save" button is located at the bottom left of the data entry area.

Зураг 3. EnAct системд төслийн файлын мэдээллийг шинэчилж байгаа нь.

Зураг 4-т тусгайлан бэлтгэсэн ажлын даалгавартай холбоотой баримт бичгүүд болон тэдгээрийн хувилбаруудыг нэгтгэсэн хуудсыг үзүүлэв. Энэ хуудсанд хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн Microsoft Word болон SGML хувилбаруудын өөрчлөлт нь тэмдэглэгдсэн. Эх хууль (нэмэлт өөрчлөлт оруулж буй хууль)-ийн хамтаар харуулсан байна. EnAct системийн онцлог нь баримт бичгүүдийг бүлэглэн харуулсан, задгай **Change Description Document** (төсөл дэх нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг автоматаар үүсгэх) болон **cross-reference collection** (хуулийн төсөлд хамаарах баримт бичигт стандартчилагдсан давхар лавлагаа оруулахад ашигладаг) байна.




Зураг 4. EnAct системд боловсруулагдаж буй хуулийн төслийн файл хувилбарууд.

Хуулийн төсөл боловсруулахад хэрэглэх программууд (Example custom tools for authoring and editing)²¹¹

Ихэнх тохиолдолд хууль боловсруулах ажлын алба болон байгууллагын онцлог, хэрэгцээнд тохируулан хууль боловсруулахад ашиглаж буй программд нэмэлт функцуудыг суулгадаг. Тухайлбал, XML стандартчилсан орчны хувьд хуулийн төсөл боловсруулахад хэлбэржүүлэх тохиргоогоор хангах нь чухал юм. Харин Word программын хувьд хуулийн төслийг хэлбэржүүлэхэд ашиглах нэмэлт командуудыг суулгах шаардлагатай байдаг.

Хуулийн төсөл боловсруулахад хэрэглэж буй аль ч программын хувьд эрх бүхий хэрэглэгчид тухайн файлд нэвтрэх эрхийг үүсгэдэг.


²¹¹Timothy Arnold-Moore, Innovation of Legislative Process: 01. Advanced tools for legislation, page 19
<https://ial-online.org/wp-content/uploads/2019/01/1.-Advanced-tools-for-legislationTimothy-Arnold-Moore.pdf>



[Figure 5] Login from Microsoft Word in EnAct system

Зураг 5-д Enact системтэй ажиллахад MS Word программд хэрэглэгчийн эрхээр нэвтрэх байдлыг харуулсан байна.

Хуулийн төслийн хувилбаруудыг зохион байгуулах (Editor customization for version management)²¹²



[Figure 6] Save options from Microsoft Word in EnAct system

Зураг 6-д EnAct системтэй ажиллах үед MS Word программын файл (хуулийн төслийг) хадгалах хэлбэрүүдийг үзүүлсэн байна.

²¹²Timothy Arnold-Moore, Innovation of Legislative Process: 01. Advanced tools for legislation, page 22
<https://ial-online.org/wp-content/uploads/2019/01/1.-Advanced-tools-for-legislationTimothy-Arnold-Moore.pdf>


EnAct системд MS word программтай ажиллахад файлаа дараах хэлбэрээр хадгалах боломжтой.

- *Save as SGML* - EnAct системийн хувьд MS word программд Save as SGML гэсэн стандарт бус комманд байдаг. Энэ нь MS word программд боловсруулсан файлыг XML хэлбэрт хөрвүүлэх ба EnAct системийн документ хэлбэрт (document type definition DTD) оруулж хадгална.
- *Save Version* - Энгийн хадгалах комманд.
- *Save as New Version* - Тухайн файлын (хуулийн төслийн) засвар өөрчлөлт хийсэн хувилбарыг шинээр хадгална.

Хуулийн төсөл боловсруулахад ашиглаж буй бусад төрлийн программуудад (Editing Tool) мөн адил файлыг тухайн программын үндсэн хэлбэрээс гадна өөр хэлбэрээр хадгалдаг. Тухайлбал, Adobe FrameMaker программд өөрийн үндсэн форматаас гадна PDF болон XML хэлбэрээр хадгалах боломжтой. Эдгээр боломжийг хуулийн төсөл боловсруулах явцад төслийн танилцуулга хийх, өөрчлөлт оруулах зэрэг үйлдлийг хийхэд хэрэглэнэ.

Тусгай холбоосуудыг зохион байгуулах (Editor customization for specialized link management)²¹³

XML орчны хувьд *cross reference* (иш татах) тэмдэглэгээг зохион байгуулах энгийн арга нь холбогч өгөгдлүүдийг гараар тохируулж өгөх юм. Ингэснээр хуулийн төсөл боловсруулах явцад нэг хууль дотор өөр хуулиас иш татах тохиолдолд эдгээр холбоос үгийн тусламжтайгаар хамааралтай файл (хууль), эсхүл зүйл заалтыг холбох үйлдэл хийгдэнэ.



[Figure 7] Manual insertion of cross-reference markup

Зураг 7-д хуулийн төсөл боловсруулахад Adobe FrameMaker программын *cross reference* функциг ашиглан тухайн файлыг, эсхүл зүйл заалтыг өөр файлтай холбох үйлдлийг харуулсан байна. Энд тухайн программын үндсэн командыг ашигласан. Үүний адил ихэнх стандартчилагдсан программын хувьд (structured authoring environment) өгөгдлүүдийг хооронд нь холбоход ямар нэг нэмэлт функци суулгахгүйгээр тухайн программын стандарт командыг шууд ашигладаг.

²¹³Timothy Arnold-Moore, Innovation of Legislative Process: 01. Advanced tools for legislation, page 23
<https://ial-online.org/wp-content/uploads/2019/01/1.-Advanced-tools-for-legislationTimothy-Arnold-Moore.pdf>

Title	Add Reference	Add File	Refile Received	Comments	Camera Ready	Published
Colonial Courts of Admiralty Act 1890 (Adopted) [No. 27 of 1890]						
Schedule 2- Enactments Repealed						
Companies Rules (Chapter 146)						
Schedule 2- FORMS						
Schedule 1- LIST OF FORMS						
113 Dispensing with taxation of small bills						
110 Liquidator's certificate as to special terms of remuneration to employees						
109 Issue of allowance or certificate of taxation						
108 Supply of copy of bill of costs to liquidator						
106 Submission of bill of costs by employees to liquidator for taxation						
Constitution of the Independent State of Papua New Guinea (Chapter 1)						
187C Constitution, functions, etc., of Provincial Governments and Local-level Governments						
208 Parliamentary responsibility						

[Figure 8] Using the legislation repository for link target identification in EnAct

Харин EnAct систем нь холбоос үүсгэхэд тусгай вэб интерфейс ашигладаг (Энд хуулийн санг хэрэглэдэг). Зураг 8-д EnAct системд хайлтын үр дүнд гарч ирсэн хуулиудын жагсаалтыг харуулсан байна. Эндээс тухайн хуулийн нэр, эсхүл зүйл заалтад дараахад түүнийг дэлгэцэнд харуулах юм. Үүнийг Зураг 9-д үзүүлсэн байна. Тухайн зүйл заалтын өмнөх улаан өнгийн үсгэн дугаарыг дарснаар түүнийг зорилтот (иш татах) зүйл заалтын жагсаалтад оруулна.

Print View	Lookup Component	Lookup Legislation	Turn History Notes on
Electricity Commission Act 1961 (Chapter 78)			
Requested:	28/01/2005 13h		
Consolidated as at:	28/01/2005 13h Bookmark this page		
Previous Version	Next Version		
Valid for:	01/07/2001 00h-		

7. Vacation of office

The office of a member of the Commission becomes vacant—

- (a) if he becomes bankrupt, applies to take the benefit of a law for the relief of bankrupt or insolvent debtors, compounds with his creditors or makes an assignment of his remuneration for their benefit; or
- (b) if he resigns his office by writing under his hand addressed to the Minister, and the resignation is accepted; or
- (c) if he is absent, except on leave granted by the Minister, from all meetings of the Commission held during a period of three months;
- (d) if in any way, otherwise than with the approval of the Minister or as a member, and in common with the other members, of an incorporated company consisting of not less than 25 persons, he—
- (i) is concerned or interested in a contract or agreement entered into by or on behalf of the Commission; or
- (ii) participates or claims to participate in the profit of any such contract or agreement or in a benefit or emolument arising from any such contract or agreement;


[Figure 9] Identification of individual provisions for link generation

Calculate References	View References
Calculate Cross References	
Return to Document List	
Title: Cross Reference Collection - dave	
Add the references you wish to calculate: <i>Note: the reference wording generated will contain the references in the order which they are added</i>	
Electricity Commission Act 1961 : Section 7 (a) Electricity Commission Act 1961 : Section 7 (b) Electricity Commission Act 1961 : Section 7 (d)	Add >> Clear Delete Items Delete All Items
Reference Wording <input type="checkbox"/> Without Title <input checked="" type="checkbox"/> With Title <input type="checkbox"/> Full Reference <input type="checkbox"/> Use "or" instead of "and" <input checked="" type="checkbox"/> Make first letter upper case Calculate	
Reference Text Sections 7(a) and (b) of the Electricity Commission Act 1961 Add Reference To Collection Clear	

[Figure 10] Turning identified provisions into standardized reference wording with markup


Зураг 9,10-т харуулсан цонхноос (a), (b), (d)-г сонгосон үр дүнг харуулж байна. Хэрэглэгч эдгээрээс зөвхөн *reference wording* буюу иш татах (нэг хууль дотор өөр хуулиас иш татах) сонголтоо хийж *Add* товчуур дээр дарна. Цонхны доод талд буй *Reference wording* хэсэгт тухайн хуулийн нэрийг оруулах эсэх болон бусад тохиргоог хийх боломжтой.

Эдгээр үйлдлийг Сингапур, Квинслендэд өөр аргаар хийдэг (MS Word программыг хэрэглэнэ). Үүнийг Зураг 11-ээс харж болно.



[Figure 11] Automatically recognizing reference text – Part 1

Зураг 11-д MS Word программын *cross-references* (иш татах) командыг ашиглан нэг хууль дотор өөр хуулиас иш татах үйлдлийг харуулсан. Энд *cross-references* (иш татах) хийх текстийг тодруулж ялгасан байна. Үүний дараа *Tag Cross References* товчийг дарснаар ишлэл хийгдэх бөгөөд үүний цаана тухайн файлын хуулбарыг сервер рүү илгээх үйлдэл хийгдэнэ.



[Figure 12] Automatically recognizing reference text – part 2

Дээрх үйлдлийн үр дүнд тодруулж ялгасан текст ногоон ёнгөтэй болж харагдах (зөвхөн хуулийг боловсруулж буй үед) бөгөөд энэ нь холбоос амжилттай үүссэнийг илэрхийлнэ. Үүнийг Зураг 12-т үзүүлсэн байна.

Энэ арга нь бүрэн төгс биш боловч практикт 99 хувийн амжилттай хэрэгжиж байна. Хууль боловсруулах явцад *reference* (иш татах) үйлдлийг зөв хийх нь чухал байдаг.

Энэхүү автоматчилсан үйлдэл нь хуулийн төсөл боловсруулах албаны механик үйл ажиллагааг хөнгөвчилсөөрөө ихээхэн ач холбогдолтой. Түүнчлэн хууль тогтоомжийг хэрэглэхэд хүнд илүү ойлгомжтой, амар хялбар нөхцөл бүрдүүлснээрээ онцлог юм.

Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн найруулгыг хийх тохиргоонууд (Editor customization for automatic amendment wording)²¹⁴

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (*amendment wording*) үйлдлийг автоматчилах нь холбоос үүсгэхээс илүү нарийн ажиллагаатай байдаг. Нэмэлт өөрчлөлт оруулах нь шинэ хууль боловсруулахаас илүү түгээмэл байх ба үүнтэй холбоотой функцууд ч илүү их потенциал шаардана.

Obligations of licensees

74F. A licensee -

- (a) must not make bets except in accordance with the licence; and
- (b) must not, as a licensee, make bets on horse races or greyhound races; and
- (c) must not conduct betting or business under the licence on Good Friday or Christmas day or at other times notified to the licensee in writing by the Supervising Agency; and
- (d) must, for verification purposes, make a recording of all bets made by telephone under the licence in such manner as the Supervising Agency from time to time directs, the costs of such verification to be at the expense of the licensee; and
- (e) must keep such betting, accounting and other records in respect of the licensee's betting and business under the licence as the Supervising Agency from time to time directs; and
- (f) must furnish to the Supervising Agency such returns in respect of the licensee's betting and business under the licence as the Supervising Agency from time to time directs.

[Figure 13] Principal Act before amendment

Зураг 13-д нэмэлт өөрчлөлтийг оруулахаас өмнөх байдлыг харуулсан байна.

Obligations of licensees


74F. A licensee -

- (a) must not make bets except in accordance with the licence; and
- (b) must not, as a licensee, make bets on horse races or greyhound races; and
- (c) must not conduct betting or business under the licence ~~on Good Friday or Christmas day or at other times~~ at any time notified to the licensee in writing by the Supervising Agency; and
- (d) ~~must, for verification purposes, make a recording of all bets made by telephone under the licence in such manner as the Supervising Agency from time to time directs, the costs of such verification to be at the expense of the licensee; and~~
- (d) in respect of any bet made other than in person, must electronically record the bet for verification purposes -
 - (i) by a device approved by the Supervising Agency; and
 - (ii) in a manner directed by the Supervising Agency; and
- (e) must keep such betting, accounting and other records in respect of the licensee's betting and business under the licence as the Supervising Agency from time to time directs; and
- (f) must furnish to the Supervising Agency such returns in respect of the licensee's betting and business under the licence as the Supervising Agency from time to time directs.

[Figure 14] Principal Act with change-tracked amendments

²¹⁴Timothy Arnold-Moore, Innovation of Legislative Process: 01. Advanced tools for legislation, page 28
<https://ial-online.org/wp-content/uploads/2019/01/1.-Advanced-tools-for-legislationTimothy-Arnold-Moore.pdf>

Зураг 14-д хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулсны дараах байдлыг үзүүлсэн. Энд тухайн хуульд оруулж буй 2 янзын нэмэлт өөрчлөлтийг харуулсан. Нэг нь хуучин томьёоллыг шинэ томьёоллоор сольж өөрчилсөн, харин хоёр дахь нь бүтэн параграфыг (зүйл заалтыг) сольж өөрчилсөн байна.



[Figure 15] Marking changes using custom buttons in EnAct

Зураг 15-д Enact системд MS Word программын хуулийн төсөл боловсруулахад хэрэглэх нэмэлт функцуудыг харуулав:


- *Add text* – текст нэмэх;
- *Omit text* – текст хасах;
- *Replace text* – хуучин текстийг шинэ текстээр сольж оруулах;
- *Rereverse highlighted amendment* - тодруулж ялгасан нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгох зэрэг болно.

Шинэ элемент оруулах тохиргоонууд:

- 1.- *new section* – шинэ бүлэг;
- (2)-*new sub-section* – шинэ дэд бүлэг;
- (c)-*new paragraph* – шинэ параграф;
- (iv)-*new sub-paragraph* – шинэ дэд параграф зэрэг болно.

Зарим улсын хувьд хуулийн төсөлд текст болон зүйл заалт нэмэх, хасах тохиолдолд, тухайлбал, Сингапурт MS Word программын стандарт команд болох *change tracking* командыг шууд ашигладаг.

Хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах үйлдлийн процессийг Зураг 16-д харуулсан байна.



[Figure 16] Generating the amendment wording

Зураг 16-д харуулснаар, эхлээд тухайн хуулийн XML хувилбарыг хуулийн сангаас хайж олох ба дараа нь түүнийг MS word программ руу хөрвүүлж засвар өөрчлөлт хийгдэнэ. Хэрэглэгч MS Word программд хуулийн төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ нэмэлт функц, эсхүл стандарт командыг ашиглана. Үүний дараа систем эдгээр засвар өөрчлөлтийг тусгасан Change Description Document (CDD) файлыг үүсгэдэг. CDD нь XML кодчилсон файл юм. Энэ нь шаардлагатай үед хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор тухайн файлын XML хувилбарыг үүсгэх ба цааш нь MS Word программын документ хэлбэрийг үүсгэнэ.


Тасманид хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг харуулахдаа MS Word программын *strike through*, *underline* командыг, Сингапурт *change tracking* командыг хэрэглэдэг.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйлдлийг автоматжуулсны давуу тал нь хуулийн төсөл боловсруулах үед зөвхөн хуулийн агуулгад илүү төвлөрч ажиллах боломж бүрдүүлэх юм. Түүнээс гадна хууль тогтоомжийг хэрэглэж буй хүнд нэмэлт, өөрчлөлтийг харж ойлгоход илүү амар хялбар байх болно.

Нэмэлт, өөрчлөлтийг автоматаар оруулах (Automatically applying amendments)


Зураг 17-д хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг автоматаар эх хуульд нь оруулах функцийн талаар харуулав.

Хуулийн төсөлд оруулж буй нэмэлт, өөрчлөлтийн засвар бүрэн хийж дууссаны дараа CDD-ээс XML форматаар эх хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулах автомат горимыг идэвхжүүлснээр хуулийн нэмэлт, өөрчлөлт эх хуульд тусгагдаж хууль тогтоомжийн мэдээллийн нэгдсэн санд ордог.



[Figure 17] Applying marked changes to produce new versions of the Principal Act

Зураг 18-д хууль тогтоомжийг хэвлэх функцийг харуулав. Системийг ашиглаж буй этгээд нь хууль тогтоомжийн төсөлтэй холбоотой олон янзын өргөтгөл болон формат бүхий файлыг системд оруулж болох бөгөөд үүнийг төсөл боловсруулж буй этгээд DOC, XML, PDF форматаар хүлээн авна. Үүнийг мэдээллийн нэгдсэн сан XML, PDF гэсэн 2 төрлийн форматаар хүлээн авах бөгөөд эцсийн хэрэглэгч буюу олон нийтэд зөвхөн PDF форматаар хүрч, шууд хэвлэн авах боломжтой байдаг.



[Figure 18] Managing and creating various formats for publishing

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://ial-online.org/wp-content/uploads/2019/01/1.-Advanced-tools-for-legislationTimothy-Arnold-Moore.pdf> Advanced tools for legislation
- file:///Users/narantuya.o/Zotero/storage/7VZ7WIY8/enact.html Tasmania's consolidated legislation online
- https://www.researchgate.net/publication/220668245_Connected_to_the_Law_Tasmanian_Legislation_Using_EnAct Connected to the Law: Tasmanian legislation using EnAct



ДЭЛХИЙН УЛС ОРNUУДЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР СОНГОГДОХ НАСНЫ ДООД ХЯЗГААР

(Мэдээлэл, лавлагаа)

Д.Халиун

Энэхүү мэдээлэл, лавлагаанд гадаадын улс орнуудын Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн насын дээд хязгаарыг хэрхэн тогтоосныг судалсан болно.

Улс орнуудын Үндсэн хуулийг судлан үзэхэд²¹⁵ Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн насын хязгаарыг тогтоосон 121 улс байна. Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавигдах насын доод хязгаарын хувьд хамгийн бага буюу 18 нас гэж тогтоосон 3 улс (Гайана, Монтенегро, Швейцар) байгаа бол доод хязгаарыг хамгийн өндөрөөр тогтоож өгсөн 1 улс байгаа нь (Итали Улс) 50 наснаас дээш гэж тогтоосон байна.

Нэр дэвшигчдэд тавигдах насын доод хязгаараас гадна зарим улс орнууд (7 улс) нэр дэвшигчдэд тавигдах насын дээд хязгаарыг зааж өгсөн байна. Тухайлбал: Жибути, Мавритани, Буркина Фасо, Сенегалд 75 нас, Гамбид 65 нас, Бенинд 70 наснаас доош байна гэж тус тус тогтоосон байна. (Дэлгэрүүлж Хүснэгт 1, 2-оос үзнэ үү.) Харин Азербайжан Улсын хувьд Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн насын хязгаарыг 35 нас гэж тогтоосон байсныг 2016 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хассан байна.

Хүснэгт 1. Ерөнхийлөгчөөр сонгогдох насын доод хязгаарыг тогтоосон байдал

Насны доод хязгаар	Улс орны тоо	Нийт орноос эзлэх хувь	Улс орнууд
50 нас	1	1	Итали
45 нас	5	4	БНХАУ, Мьянмар, Непал, Пакистан, Сингапур
40 нас	39	32	Афганистан, Албани, Алжир, Армен, Бенин (40-өөс дээш, 70-аас доош), Болгар, Габон, Гана, Гватемал, Герман, Грек, Доминика, Египет, Жибути, Зимбабве, Ирак, Йемен, Казахстан, Латви, Литва, Македон, Мавритани, Маврикий, Молдова, Нигери, Өмнөд Солонгос, Өмнөд Судан, Сърра Леон, Сири, Словак, Сомали, Судан, Танзани, Турк, Туркменистан, Филиппин, Чех, Экваторийн Гвиней, Эстони
35 нас	52	43	Австри, АНУ, Ангол, Бангладеш, Беларусь, Бразил, Бурунди, Буркина Фасо (35-аас дээш, 75-аас доош), Гайти, Гвиней, Гвиней Бисау, Гурж, Замби, Зүүн Тимор, Ирланд, Испанд, Кабо Верде, Камерун, Кипр, Косово, Кот Д'Ивуар, Киргиз, Либери, Мадагаскар, Малави, Мальдив, Мексик, Мозамбик, Намиби, Нигер, ОХУ, Палау, Панам, Перу, Польш, Португал, Румын, Руанда, Сан Томе ба Принсип, Сенегал (35-аас дээш, 75-аас доош), Тажикистан, Того, Төв Африкийн БНУ, Тринидад ба Тобаго, Тунис, Узбекистан, Украина, Унгар, Уругвай, Чили, Шри Ланк, Энэтхэг

²¹⁵Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Техасын Их Сургууль, Чикаогийн Их Сургууль, Лондонгийн Их Сургууль, АНУ-ын Энх тайвны институтаас хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бий болгосон олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу www.constituteproject.org цахим хуудас дахь эх сурвалжийг ашиглав.

32 нас	1	1	Эквадор
34 нас	1	1	Микронез (Парламентын гишүүнээр сонгогдох насны доод хязгаар 30 нас, Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь парламентын гишүүнээр нэг бүрэн эрхийн хугацаанд (бүрэн эрхийн хугацаа 4 жил)
30 нас	14	12	Аргентин, Боливи, Ботсвана, Венесуэл, Гамби (30-аас дээш, 65-аас доош), Гондурас, Доминиканы БНУ, Колумби, Конго, Коста Рика, Парагвай, Суринаам, Эквадор, Эль Сальвадор
25 нас	3	2	Вануату, Никарагуа, Сан Марино
21 нас	1	1	Кирибати
20 нас	1	1	Науру
18 нас	3	2	Гайана, Монтенегро (Черна Гора), Швейцар

Хүснэгт 2. Ерөнхийлөгчөөр сонгогдох насны доод хязгаарыг тогтоосон байдал (улс тус бүрээр)

№	Улсын нэр	Нас	Тайлбар
1.	Афганистан	40	Үндсэн хуулийн 62-р зүйл
2.	Австри	35	Үндсэн хуулийн 60-р зүйл
3.	Азербайжан ²¹⁶	- (35 нас байсныг хассан)	
4.	Албани	40	Үндсэн хуулийн 86-р зүйл
5.	Алжир	40	Үндсэн хуулийн 87-р зүйл
6.	Ангол	35	Үндсэн хуулийн 110-р зүйл
7.	АНУ	35	Үндсэн хуулийн 2.1-р зүйл
8.	Аргентин	30	Үндсэн хуулийн 55, 89-р зүйл
9.	Армен	40	Үндсэн хуулийн 124-р зүйл
10.	Бангладеш	35	Үндсэн хуулийн 48-р зүйл
11.	Беларусь	35	Үндсэн хуулийн 80-р зүйл
12.	Бенин	40-өөс дээш 70-аас доош	Үндсэн хуулийн 44-р зүйл
13.	БНХАУ	45	Үндсэн хуулийн 79-р зүйл
14.	Болгар	40	Үндсэн хуулийн 93-р зүйл
15.	Боливи	30	Үндсэн хуулийн 167-р зүйл
16.	Босни Герцеговин	30	Үндсэн хуулийн 33-р зүйл
17.	Ботсвана	35	Үндсэн хуулийн 14-р зүйл
18.	Бразил	35	Үндсэн хуулийн 97-р зүйл
19.	Бурунди	35-аас дээш 75-аас доош	Үндсэн хуулийн 38-р зүйл
20.	Буркина Фасо	25	Үндсэн хуулийн 17, 35-р зүйл
21.	Венесуэл	30	Үндсэн хуулийн 227-р зүйл
22.	Вьетнам	40	Үндсэн хуулийн 10-р зүйл
23.	Гамби	30-аас дээш 65-аас доош	Үндсэн хуулийн 62-р зүйл
24.	Гана	40	Үндсэн хуулийн 62-р зүйл

²¹⁶<https://www.loc.gov/law/foreign-news/article/azerbaijan-president-appointed-his-wife-as-first-vice-president/>
<http://www.meclis.gov.az/?az/topcontent/2>

25.	Гайана	18	Үндсэн хуулийн 53, 90-р зүйл
26.	Гайти	35	Үндсэн хуулийн 135-р зүйл
27.	Гватемал	40	Үндсэн хуулийн 185-р зүйл
28.	Гвиней	35	Үндсэн хуулийн 29-р зүйл
29.	Гвиней Бисау	35	Үндсэн хуулийн 63-р зүйл
30.	Герман	40	Үндсэн хуулийн 54-р зүйл
31.	Гондурас	30	Үндсэн хуулийн 238-р зүйл
32.	Грек	40	Үндсэн хуулийн 31-р зүйл
33.	Гүрж	35	Үндсэн хуулийн 70-р зүйл
34.	Доминиканы БНУ	30	Үндсэн хуулийн 123-р зүйл
35.	Доминика	40	Үндсэн хуулийн 20-р зүйл
36.	Египет	40	Үндсэн хуулийн 141-р зүйл
37.	Жибути	40-өөс дээш 75-аас доош	Үндсэн хуулийн 23-р зүйл
38.	Замби	35	Үндсэн хуулийн 100-р зүйл
39.	Зүүн Тимор	35	Үндсэн хуулийн 75-р зүйл
40.	Зимбабве	40	Үндсэн хуулийн 91-р зүйл
41.	Ирак	40	Үндсэн хуулийн 68-р зүйл
42.	Ирланд	35	Үндсэн хуулийн 124-р зүйл
43.	Исланд	35	Үндсэн хуулийн 4-р зүйл
44.	Итали	50	Үндсэн хуулийн 84-р зүйл
45.	Йемен	40	Үндсэн хуулийн 107-р зүйл
46.	Кабо Верде	35	Үндсэн хуулийн 118-р зүйл
47.	Казахстан	40	Үндсэн хуулийн 41-р зүйл
48.	Камерун	35	Үндсэн хуулийн 6-р зүйл
49.	Кипр	35	Үндсэн хуулийн 40-р зүйл
50.	Кирибати	21	Үндсэн хуулийн 55-р зүйл
51.	Колумбии	30	Үндсэн хуулийн 191-р зүйл
52.	Конго	30	Үндсэн хуулийн 72-р зүйл
53.	Косово	35	Үндсэн хуулийн 85-р зүйл
54.	Коста Рика	30	Үндсэн хуулийн 131-р зүйл
55.	Кот Д'Ивуар	35	Үндсэн хуулийн 55-р зүйл
56.	Куба ²¹⁷	18*	Үндсэн хуулийн 74,133-р зүйл
57.	Киргиз	35	Үндсэн хуулийн 62-р зүйл
58.	Латви	40	Үндсэн хуулийн 37-р зүйл
59.	Либери	35	Үндсэн хуулийн 52-р зүйл
60.	Литва	40	Үндсэн хуулийн 78-р зүйл
61.	Македон	40	Үндсэн хуулийн 80-р зүйл
62.	Мадагаскар	35	Үндсэн хуулийн 46-р зүйл
63.	Малави	35	Үндсэн хуулийн 80-р зүйл

²¹⁷(2018 оны Үндсэн хуулийн төслийн 122,127-р зүйлд заасны дагуу 35-аас дээш, 60-аас доош гэж тусгасан)

64.	Мальдив	35	Үндсэн хуулийн 109-р зүйл
65.	Мавритани	40-өөс дээш 75-аас доош	Үндсэн хуулийн 26-р зүйл
66.	Маврикий	40	Үндсэн хуулийн 28-р зүйл
67.	Мексик	35	Үндсэн хуулийн 82-р зүйл
68.	Микронез	34	Үндсэн хуулийн 9.9, 10.4-р зүйл (30+4)
69.	Мозамбик	35	Үндсэн хуулийн 147-р зүйл
70.	Молдова	40	Үндсэн хуулийн 78-р зүйл
71.	Монголия (Черна Гора)	18	Үндсэн хуулийн 45-р зүйл
72.	Мьянмар	45	Үндсэн хуулийн 59-р зүйл
73.	Намиби	35	Үндсэн хуулийн 28-р зүйл
74.	Науру	20	Үндсэн хуулийн 16,30-р зүйл
75.	Непал	45	Үндсэн хуулийн 64-р зүйл
76.	Нигер	35	Үндсэн хуулийн 47-р зүйл
77.	Нигери	40	Үндсэн хуулийн 131-р зүйл
78.	Никарагуа	25	Үндсэн хуулийн 147-р зүйл
79.	ОХУ	35	Үндсэн хуулийн 81-р зүйл
80.	Өмнөд Солонгос	40	Үндсэн хуулийн 67-р зүйл
81.	Өмнөд Судан	40	Үндсэн хуулийн 98-р зүйл
82.	Пакистан	45	Үндсэн хуулийн 41-р зүйл
83.	Палау	35	Үндсэн хуулийн 8-р зүйл
84.	Панам	35	Үндсэн хуулийн 179-р зүйл
85.	Парагвай	30	Үндсэн хуулийн 228-р зүйл
86.	Перу	35	Үндсэн хуулийн 110-р зүйл
87.	Польш	35	Үндсэн хуулийн 127-р зүйл
88.	Португал	35	Үндсэн хуулийн 122-р зүйл
89.	Румын	35	Үндсэн хуулийн 37-р зүйл
90.	Руанда	35	Үндсэн хуулийн 99-р зүйл
91.	Сан Томе ба Принсип	35	Үндсэн хуулийн 78-р зүйл
92.	Сенегал	35-аас дээш 75-аас доош	Үндсэн хуулийн 28-р зүйл
93.	Сьерра Леон	40	Үндсэн хуулийн 41-р зүйл
94.	Сан Марино	25	
95.	Сингапур	45	Үндсэн хуулийн 19-р зүйл
96.	Сири*	40	Үндсэн хуулийн 84-р зүйл
97.	Словак	40	Үндсэн хуулийн 103-р зүйл
98.	Сомали	40	Үндсэн хуулийн 88-р зүйл
99.	Судан	40	Үндсэн хуулийн 53-р зүйл
100.	Суринам	30	Үндсэн хуулийн 92-р зүйл
101.	Тажикистан	35	Үндсэн хуулийн 65-р зүйл
102.	Танзани	40	Үндсэн хуулийн 39-р зүйл

103.	Того	35	Үндсэн хуулийн 62-р зүйл
104.	Төв Африкийн БНУ	35	Үндсэн хуулийн 36-р зүйл
105.	Тринидад ба Тобаго	35	Үндсэн хуулийн 23-р зүйл
106.	Тунис	35	Үндсэн хуулийн 74-р зүйл
107.	Турк	40	Үндсэн хуулийн 101-р зүйл
108.	Туркменистан	40	Үндсэн хуулийн 69-р зүйл
109.	Узбекистан	35	Үндсэн хуулийн 90-р зүйл
110.	Украин	35	Үндсэн хуулийн 103-р зүйл
111.	Унгар	35	Үндсэн хуулийн 10-р зүйл
112.	Уругвай	35	Үндсэн хуулийн 151-р зүйл
113.	Филиппин	40	Үндсэн хуулийн 7.2-р зүйл
114.	Чех	40	Үндсэн хуулийн 19, 57-р зүйл
115.	Чили	35	Үндсэн хуулийн 25-р зүйл
116.	Швейцар	18	Үндсэн хуулийн 136-р зүйл
117.	Шри Ланк	35	Үндсэн хуулийн 92-р зүйл
118.	Эквадор	30	Үндсэн хуулийн 142-р зүйл
119.	Эль Сальвадор	30	Үндсэн хуулийн 151-р зүйл
120.	Экваторын Гвиней	40	Үндсэн хуулийн 35-р зүйл
121.	Энэтхэг	35	Үндсэн хуулийн 58-р зүйл
122.	Эстони	40	Үндсэн хуулийн 79-р зүйл

ДЭЛХИЙН УЛС ОРNUУДЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА

(Мэдээлэл, лавлагаа)

Д.Халиун

Судалгаанд гадаадын улс орнуудын Үндсэн хуульд²¹⁸ Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг хэрхэн тогтоосныг судалсан болно.

Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг Үндсэн хуульдаа заасан 133 улс байна. Үүнээс хамгийн бага буюу 3 жилээр Фижи Улс тогтоосон бол хамгийн өндөр нь Ботсвана Улс 10 жилээс дээшгүй байна гэж заасан байна.

Ерөнхийлөгчөөр дахин сонгогдох давтамжийн хувьд:

Дахин сонгогдох давтамж	Улс орны тоо	Улс орнууд
Дахин сонгогдож болохгүй буюу зөвхөн 1 удаа сонгогдох	9 улс	Гондурас, Израил, Колумби, Киргиз, Мексик, Өмнөд Солонгос, Парагвай, Филиппин, Чили Үүнээс: - 4 жилээр зөвхөн нэг удаа сонгох 3 улс (Гондурас, Колумби, Чили) - 5 жилээр зөвхөн нэг удаа сонгох 2 улс (Өмнөд Солонгос, Парагвай) - 6 жилээр зөвхөн нэг удаа сонгох 3 улс (Киргиз, Мексик, Филиппин) - 7 жилээр зөвхөн нэг удаа сонгох 1 улс (Израил)

Дэлгэрүүлж Хүснэгт 2-оос үзнэ үү.

Хүснэгт 1. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг тогтоосон байдал

Бүрэн эрхийн хугацаа	Улс орны тоо	Нийт орноос эзлэх хувь	Улс орнууд
10 жилээс дээшгүй	1	1	Ботсвана
7 жил	12	9	Азербайжан, Армен, Габон, Ирланд, Итали, Израил, Йемен, Камерун, Тажикистан, Туркменистан, Экваторын Гвиней, Этиоп
6 жил	11	8	Австри, Венесуэл, Киргиз, Ливан, Либери, Мексик, ОХУ, Сингапур, Тунис, Филиппин, Финланд

²¹⁸Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Техасын Их Сургууль, Чикагогийн Их Сургууль, Лондонгийн Их Сургууль, АНУ-ын Энх тайвны институтаас хамтран хэрэгжүүлсэн төслийн хурээнд бий болгосон олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу www.constituteproject.org цахим хуудас дахь эх сурвалжийг ашиглав.

5 жил	85	64	Афганистан, Албани, Алжир, Ангол, Бангладеш, Беларусь, Бенин, БНХАУ, Боливи, Бурунди, Буркина Фасо, Вьетнам, Гамби, Гайти, Гвиней, Гвиней Бисау, Герман, Грек, Гүрж, Доминика, Жибути, Замби, Зүүн Тимор, Зимбабве, Индонез, Кабо Верде, Казахстан, Кени, Кипр, Конго (БНАКУ), Конго (БНКУ), Косов, Кот Д'Ивуар, Лаос, Литва, Македон, Мадагаскар, Малави, Мальдив, Мали, Мальта, Мавритани, Маврикий, Мозамбик, Монтенегро, Мьянмар, Намиби, Непал, Нигер, Никарагуа, Өмнөд Солонгос, Өмнөд Судан, Пакистан, Панам, Парагвай, Перу, Польш, Португал, Румын, Руанда, Сан Томе ба Принсип, Сенегал, Серби, Съерра Леон, Словак, Словени, Судан, Суриналам, Танзани, Того, Төв Африкийн БНУ, Тринидад ба Тобаго, Турк, Уганда, Узбекистан, Украина, Унгар, Уругвай, Франц, Хорват, Чех, Шри Ланк, Энэтхэг, Эстони, Эритри
4 жил	23	17	АНУ, Аргентин, Болгар, Босни Херцеговин, Бразил, Гана, Гватемал, Гондурас, Доминиканы БНУ, Египет, Ирак, Исланд, Колумби, Исланд, Коста Рика, Латви, Микронез, Молдова, Нигери, Палау, Сомали, Чили, Эквадор, Эль Сальвадор
3 жил	1	1	Фижи

Хүснэгт 2. Ерөнхийлөгчөөр сонгогдох насын доод хязгаарыг тоогтоосон байдал (улс тус бүрээр)

№	Улсын нэр	Бүрэн эрхийн хугацаа	Дахин сонгогдох давтамж	Тайлбар
1.	Афганистан	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 61, 62-р зүйл
2.	Австри	6 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 60-р зүйл
3.	Азербайжан	7 жил	тусгаагүй	Үндсэн хуулийн 101-р зүйл
4.	Албани	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 88-р зүйл
5.	Алжир	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 88-р зүйл
6.	Ангол	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 113-р зүйл
7.	АНУ	4 жил	1 удаа	Үндсэн хуулийн II.1, XII.1-р зүйл
8.	Аргентин	4 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 90-р зүйл
9.	Армен	7 жил	1 удаа	Үндсэн хуулийн 124-р зүйл
10.	Бангладеш	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 50-р зүйл
11.	Беларусь	5 жил	тусгаагүй	Үндсэн хуулийн 81-р зүйл
12.	Бенин	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 42-р зүйл
13.	БНХАУ	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 79-р зүйл
14.	Болгар	4 жил	1 удаа	Үндсэн хуулийн 93, 95-р зүйл
15.	Боливи	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 168-р зүйл
16.	Босни Херцеговин	4 жил	1 удаа	Үндсэн хуулийн 5-р зүйл

17.	Ботсвана	10 жилээс дээшгүй	-	Үндсэн хуулийн 34-р зүйл
18.	Бразил	4 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 82-р зүйл
19.	Бурунди	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 96-р зүйл
20.	Буркина Фасо	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 37-р зүйл
21.	Венесуэл	6 жил	болно	Үндсэн хуулийн 230-р зүйл
22.	Вьетнам	5 жил	-	Үндсэн хуулийн 87-р зүйл
23.	Габон	7 жил	болно	Үндсэн хуулийн II.9-р зүйл
24.	Гамби	5 жил	-	Үндсэн хуулийн 63-р зүйл
25.	Гана	4 жил	1 удаа	Үндсэн хуулийн 66-р зүйл
26.	Гайти	5 жил	Бүрэн эрх дууссанаас 5 жилийн дараа дахин 1 удаа сонгогдох эрхтэй	Үндсэн хуулийн 134-1,134-3-р зүйл
27.	Гватемал ²¹⁹	4 жил	2 жилээс дээш ерөнхийлөгчийн алба хашсан бол дахин хা�шихгүй	Үндсэн хуулийн 184, 187-р зүйл
28.	Гвиней	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 27-р зүйл
29.	Гвиней Бисау	5 жил	1 удаа (улируулан), 2 дахь бүрэн эрх дууссанаас 5 жилийн дотор дахин нэр дэвшихгүй	Үндсэн хуулийн 66-р зүйл
30.	Герман	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 54-р зүйл
31.	Гондурас	4 жил	бoloхгүй	Үндсэн хуулийн 237, 239-р зүйл
32.	Грек	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 30-р зүйл
33.	Гүрж	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 70-р зүйл
34.	Доминиканы БНУ	4 жил	1 удаа	Үндсэн хуулийн 124-р зүйл
35.	Доминика	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 18, 21-р зүйл
36.	Египет	4 жил	1 удаа	Үндсэн хуулийн 140-р зүйл
37.	Жибути	5 жил	болно	Үндсэн хуулийн 23, 24-р зүйл
38.	Замби	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 106-р зүйл
39.	Зүүн Тимор	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 75-р зүйл
40.	Зимбабве	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 95-р зүйл
41.	Ирак	4 жил	1 удаа	Үндсэн хуулийн 72-р зүйл
42.	Ирланд	7 жил	1 удаа	Үндсэн хуулийн 12-р зүйл
43.	Исланд	4 жил	-	Үндсэн хуулийн II.2-р зүйл
44.	Итали	7 жил	-	Үндсэн хуулийн 85-р зүйл
45.	Индонез	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн III.7-р зүйл
46.	Израил	7 жил	бoloхгүй	Үндсэн хуулийн 3 а,б-р зүйл
47.	Йемен	7 жил	1 удаа	Үндсэн хуулийн 112-р зүйл

²¹⁹The person who has held for any time the office of [the] President of the Republic through a popular election, or the one who has exercised it for more than two years, may not perform the office again in any case.

48.	Кабо Верде ²²⁰	5 жил	Улиран сонгогдоноос хойш 5 жилийн дотор дахин нэр дэвшихгүй	Үндсэн хуулийн 138, 146-р зүйл
49.	Казахстан	5 жил	1 удаа (анхны ерөнхийлөгчид хамаарахгүй)	Үндсэн хуулийн 42-р зүйл
50.	Камерун	7 жил	1 удаа	Үндсэн хуулийн II.6-р зүйл
51.	Кени	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 136, 142-р зүйл
52.	Кипр	5 жил	-	Үндсэн хуулийн 43-р зүйл
53.	Колумби	4 жил	боловхгүй	Үндсэн хуулийн 190, 197-р зүйл
54.	Конго (БНАКУ)	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 70-р зүйл
55.	Конго (БНКУ)	5 жил	2 удаа	Үндсэн хуулийн 65-р зүйл
56.	Косово	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 87-р зүйл
57.	Коста Рика	4 жил	8 жилийн дотор дахин нэр дэвшихгүй	Үндсэн хуулийн 132, 134-р зүйл
58.	Кот Д'Ивуар	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 55-р зүйл
59.	Киргиз	6 жил	боловхгүй	Үндсэн хуулийн 61-р зүйл
60.	Лаос	5 жил	-	Үндсэн хуулийн 66-р зүйл
61.	Латви	4 жил	1 удаа	Үндсэн хуулийн 35-р зүйл
62.	Ливан	6 жил	Бүрэн эрхийн хугацаа дууссанас хойш 6 жилийн дараа дахин нэр дэвшиж болно	Үндсэн хуулийн 49-р зүйл
63.	Либери	6 жил	1 удаа	Үндсэн хуулийн 50-р зүйл
64.	Литва	5 жил	Улиран сонгогдож боловхгүй	Үндсэн хуулийн 78-р зүйл
65.	Македон	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 80-р зүйл
66.	Мадагаскар	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 45-р зүйл
67.	Малави	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 83-р зүйл
68.	Мальдив ²²¹	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 107-р зүйл
69.	Мали	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 30-р зүйл
70.	Мальта	5 жил	-	Үндсэн хуулийн 48-р зүйл
71.	Мавритани	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 26, 28-р зүйл
72.	Маврикий	5 жил	болно	Үндсэн хуулийн 28-р зүйл
73.	Мексик	6 жил	боловхгүй	Үндсэн хуулийн 83-р зүйл
74.	Микронез	4 жил	1 удаа	Үндсэн хуулийн 10-р зүйл
75.	Мозамбик	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 147-р зүйл
76.	Молдова	4 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 80-р зүйл
77.	Монтенегро (Черна Гора)	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 97-р зүйл
78.	Мьянмар	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 61-р зүйл
79.	Намиби	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 29-р зүйл

²²⁰The President of the Republic may not be a candidate for a third term within five years immediately following the end of his second consecutive term.

²²¹The President shall hold office for a term of five years and no person elected as President pursuant to this Constitution shall serve for more than two terms in office, whether consecutive or otherwise.

80.	Непал	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 63, 64-р зүйл
81.	Нигер	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 47-р зүйл
82.	Нигери	4 жил	1 удаа	Үндсэн хуулийн 135, 137-р зүйл
83.	Никарагуа	5 жил	-	Үндсэн хуулийн 148-р зүйл
84.	ОХУ	6 жил	1 удаа	Үндсэн хуулийн 81-р зүйл
85.	Өмнөд Солонгос	5 жил	боловхгүй	Үндсэн хуулийн 70-р зүйл
86.	Өмнөд Судан	5 жил	-	Үндсэн хуулийн 100-р зүйл
87.	Пакистан	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 44-р зүйл
88.	Палау	4 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 8.4-р зүйл
89.	Панам	5 жил	2 бүрэн эрхийн хугацаа өнгөрсний дараа нэр дэвшиж болно	Үндсэн хуулийн 177,178-р зүйл
90.	Парагвай	5 жил	боловхгүй	Үндсэн хуулийн 229-р зүйл
91.	Перу	5 жил	1 бүрэн эрхийн хугацаа өнгөрсний дараа нэр дэвшиж болно	Үндсэн хуулийн 112-р зүйл
92.	Польш	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 127-р зүйл
93.	Португал	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 123,128-р зүйл
94.	Румын	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 81,82-р зүйл
95.	Руанда	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 101-р зүйл
96.	Сан Томе ба Принсип ²²²	5 жил	Улиран сонгогдсоо ос хойш 5 жилийн дотор дахин нэр дэвшихгүй	Үндсэн хуулийн 79-р зүйл
97.	Сенегал	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 27-р зүйл
98.	Серби	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 116-р зүйл
99.	Сьерра Леон	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 46-р зүйл
100.	Сингапур	6 жил	-	Үндсэн хуулийн 20-р зүйл
101.	Словак	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 101, 103-р зүйл
102.	Словени	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 103-р зүйл
103.	Сомали	4 жил	-	Үндсэн хуулийн 91-р зүйл
104.	Судан	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 57-р зүйл
105.	Суринаам	5 жил	-	Үндсэн хуулийн 91-р зүйл
106.	Тажикистан	7 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 65-р зүйл
107.	Танзани	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 42-р зүйл
108.	Того	5 жил	болно	Үндсэн хуулийн 59-р зүйл
109.	Төв Африкийн БНУ	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 35-р зүйл
110.	Тринидад ба Тобаго	5 жил	-	Үндсэн хуулийн 33-р зүйл
111.	Тунис	6 жил	1 удаа	Үндсэн хуулийн 75-р зүйл
112.	Турк	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 101-р зүйл
113.	Туркменистан	7 жил	-	Үндсэн хуулийн 70-р зүйл

²²²Re-election for a third consecutive term of office, or during the five-year period immediately following the end of the second consecutive mandate, is not permitted.

114.	Уганда	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 105-р зүйл
115.	Узбекистан	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 90-р зүйл
116.	Украин	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 103-р зүйл
117.	Унгар	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 10-р зүйл
118.	Уругвай	5 жил	5 жилийн дотор дахин нэр дэвшихгүй	Үндсэн хуулийн 152-р зүйл
119.	Филиппин	6 жил	боловхгүй	Үндсэн хуулийн 7.4-р зүйл
120.	Фиджи	3 жил	1 удаа	Үндсэн хуулийн 85-р зүйл
121.	Финланд	6 жил	1 удаа	Үндсэн хуулийн 54-р зүйл
122.	Франц	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн II.6-р зүйл
123.	Хорват	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 95-р зүйл
124.	Чех	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 55, 57-р зүйл
125.	Чили	4 жил	боловхгүй	Үндсэн хуулийн 25-р зүйл
126.	Шри Ланк	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 31-р зүйл
127.	Эквадор	4 жил	болно	Үндсэн хуулийн 144-р зүйл
128.	Эль Сальвадор ²²³	4 жил	6 сараас дээш өрөнхийлөгчийн алба хашсан бол дахин нэр дэвшихгүй	Үндсэн хуулийн 152, 154-р зүйл
129.	Экваторын Гвиней	7 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 36-р зүйл
130.	Энэтхэг	5 жил	-	Үндсэн хуулийн 56-р зүйл
131.	Эстони	5 жил	1 удаа (улируулан)	Үндсэн хуулийн 80-р зүйл
132.	Эритри	5 жил	1 удаа	Үндсэн хуулийн 41-р зүйл
133.	Этиоп	7 жил	1 удаа	Үндсэн хуулийн 70-р зүйл



²²³[The following] shall not be candidates for the President of the Republic:

1.1st. He who has filled the Presidency of the Republic for more than six months, consecutive or not, during the period immediately prior to or within the last six months prior to the beginning of the presidential period;

**ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛЬД
БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ХУВААРИЛАЛТАЙ ХОЛБООТОЙ
АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ**

(Мэдээлэл, лавлагаа)

Д.Халиун

Энэхүү мэдээлэл, лавлагаанд гадаадын зарим улс орнууд Үндсэн хуульдаа²²⁴ байгалийн баялгийн хуваарилалттай холбоотой асуудлыг хэрхэн тусгасныг судалсан болно.

Хүснэгт 1. Үндсэн хуульд байгалийн баялгийн хуваарилалттай холбоотой асуудлыг тусгасан байдал

№	Улсын нэр	Тайлбар
1.	Албани	<p>Үндсэн хуулийн 5 дугаар бүлэг. Нийгмийн зорилтууд 59 дугаар зүйлийн 59.1-д</p> <p>1. Төр нь (...): dh. ой, ус, бэлчээр болон бусад байгалийн баялгийг зохистой ашиглахаа тогтвортой хөгжлийн зарчмыг үндэс болгоно;</p>
2.	Ангол	<p>Үндсэн хуулийн 21 дүгээр зүйл Анголын төрийн үндсэн зорилт нь: т. Улсын нутаг дэвсгэр даяар эвтэй, тогтвортой хөгжлийг дэмжиж, байгаль орчин, байгалийн баялаг болон үндэсний түүх, соёл, урлагийн өвийг хамгаалах; Үндсэн хуулийн 39 дүгээр зүйл</p> <p>1. Хүн бүр эрүүл, цэвэр орчинд амьдрах эрхтэй байх ба түүнийг хамгаалах, хадгалах үүрэгтэй. 2. Төрөөс нутаг дэвсгэр даяар байгаль орчин, ургамал, амьтны төрөл зүйлийг хамгаалах, экологийн тэнцвэрийг хадгалах, эдийн засгийн үйл ажиллагааны зохистой байршлыг хангах, бүхий л байгалийн баялгийг тогтвортой хөгжлийн хүрээнд зохистойгоор ашиглах, ирээдүй хойч үеийнхний эрхийг хүндэтгэх, төрөл зүйлийн хадгалалтад хүндэтгэлтэй хандахад шаардагдах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. 3. Байгаль орчныг хамгаалахад аюул учруулах, гэмтээх үйлдлийг хуулиар шийтгэнэ.</p>
3.	Бахрейн	<p>Үндсэн хуулийн 11 дүгээр зүйл Байгалийн баялаг ба нөөц баялаг нь төрийн өмч мөн. Төрөөс улсын аюулгүй байдал болон үндэсний эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг харгалзан тэдгээрийг хамгаалж, зохистойгоор ашиглана.</p>
4.	БНСУ	<p>Үндсэн хуулийн 120 дугаар зүйл</p> <p>1. Эрдэс болон газар доорх баялаг, далайн баялаг, усан цахилгаан станц ба ашиглаж болох байгалийн нөөц баялгийг хуульд заасны дагуу тодорхой хугацаанд олборлох, сайжруулах, ашиглах зөвшөөрлийг өгч болно. 2. Газар ба байгалийн баялаг нь улсын хамгаалалтад байх ба улсаас түүнийг тэнцвэртэй байдлаар ашиглах үүднээс шаардлагатай төлөвлөгөө батална.</p>
5.	Индонез	<p>Үндсэн хуулийн 33 дугаар зүйл Улсын хувьд чухал ач холбогдол бүхий ард түмний амьдралд нөлөөлөх үйлдвэрлэлийн салбар нь төрийн эрх мэдэлд байна. Газар, ус, байгалийн баялаг нь төрийн эрх мэдэлд байх бөгөөд ард түмний хамгийн их ашиг тусын тулд ашиглгадана. Үндэсний эдийн засгийн зохион байгуулалтыг нэгдмэл байдал, шударга ёс, тогтвортой байдал, хүрээлэн буй орчны хэтийн төлөв, бие даасан байдал, үндэсний эдийн засгийн хөгжил дэвшил, нэгдмэл байдлыг тэнцвэржүүлэх зарчмыг баримтлан ардчилсан эдийн засгийн үндсэн дээр явуулна. Энэ зүйлийн хэрэгжилтэй холбоотой асуудлыг хуулиар зохицуулна.</p>

²²⁴Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгээдээ Техасын Их Сургууль, Чикагогийн Их Сургууль, Лондонгийн Их Сургууль, АНУ-ын Энхтайвны институтаас хамтран хэрэгжүүлсэн теслийн хүрээнд бий болгосон олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу www.constituteproject.org цахим хуудас дахь эх сурвалжийг ашиглав.

6.	Иран	Үндсэн хуулийн 153 дугаар зүйл Улс орны байгалийн нөөц баялаг, эдийн засаг, зэвсэгт хүчин, соёл түүнчлэн үндэсний амьдралын бусад асуудалд гадаадын хяналт тавих аливаа хэлбэрийн гэрээ хэлэлцээрийг хориглоно.
7.	Киргиз	Үндсэн хуулийн 12 дугаар зүйл 5. Газар, түүний нөөц, агаарын зайн, ус, ой, ургамал, амьтны аймаг, болон байгалийн бусад баялаг нь Киргиз Улсын онцгой өмч мөн. Эдгээрийг Киргизийн ард түмний амьдрал, үйл ажиллагааны үндэс суурь болгон байгаль орчны нэгдмэл тогтолцоог хамгаалах зорилгоор ашиглах бөгөөд төрийн тусгай хамгаалалтад байна. Хувийн өмч байж болохгүй бэлчээрийн газраас бусад газар нь хувийн, орон нутгийн болон бусад өмчийн хэлбэртэй байж болно.
8.	Кувейт	Үндсэн хуулийн 21 дүгээр зүйл Байгалийн баялаг, нөөц нь төрийн өмч мөн. Төрийн зүгээс эдгээр нөөцийг өөрийн аюулгүй байдал, үндэсний эдийн засгийн зайлшгүй хэрэгцээ шаардлагыг харгалзан хадгалж, зохистойгоор ашиглана.
9.	Норвег	Үндсэн хуулийн 112 дугаар зүйл Хүн бүр эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй, түүний бүтээмж, төрөл зүйлийг хадгасан орчинд амьдрах эрхтэй. Байгалийн баялгийг ирээдүй хойч үеийнхэндээ хадгалан хамгаалах, урт хугацааны цогц бодлогын хүрээнд байгалийн нөөцийг ашиглана.
10.	Оман	Үндсэн хуулийн 11 дүгээр зүйл Эдийн засгийн зарчмууд Байгалийн бүх баялаг, нөөц нь төрийн өмч мөн бөгөөд тэдгээрийг улсын аюулгүй байдал, үндэсний эдийн засгийн эрх ашгийн шаардлагад нийцүүлэн хамгийн тохиромжтой байдлаар хадгалж, ашиглана. Аливаа концесс, эсхүл улсын нөөцийн хөрөнгө оруулалтыг гагцхүү хууль тогтоомжкор, хязгаарлагдмал хугацаагаар, үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан байдлаар олгоно.
11.	ӨАБНУ	Үндсэн хуулийн 224 дүгээр зүйл Хүн бүр: б. одоогийн болон ирээдүйн ашиг тусын тулд зохистой хууль тогтоомж болон бусад арга хэмжээгээр байгаль орчноо хамгаалуулах эрхтэй. Тэдгээр нь: iii. экологийн тогтвортой хөгжлийг хангах, байгалийн баялгийг ашиглалт эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглэсэн зөв зохистой хөгжлийг дэмжихэд чиглэсэн байна.
12.	Тунис	Үндсэн хуулийн 13 дугаар зүйл Байгалийн баялаг нь Тунисийн ард түмний мэдэлд байна. Төр засаг ард түмний нэрийн өмнөөс түүнийн захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлнэ. Эдгээр нөөцтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээг Төлөөлөгчдийн Ассамблей дахь эрх бүхий хороонд танилцуулна. Байгуулсан гэрээ хэлэлцээрийг Ассамблейд батлуулахаар хүргүүлнэ.
13.	Чех	Үндсэн хуулийн 7 дугаар зүйл Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах болон байгалийн баялгийг хамгаалах асуудлыг төр хариуцна. Үндсэн хуулийн 35.2-т заасны дагуу: Хүн бүр байгаль орчин, байгалийн баялгийн нөхцөл байдлын талаар цаг тухайд нь бүрэн дүүрэн мэдээлэл авах эрхтэй байна. Аливаа этгээд эрхээс хэрэгжүүлэхдээ хүрээлэн буй орчин, байгалийн баялаг, байгалийн төрөл зүйлийн баялаг, эсхүл соёлын дурсгалт зүйлсэд хуулиар тогтоосон хэмжээнээс давсан хохирол учруулахыг хориглоно.
14.	Эстони	Үндсэн хуулийн 5 дугаар зүйл Эстонийн байгалийн баялаг, нөөц баялаг нь үндэсний баялаг мөн бөгөөд тэдгээрийг арвич хямгач зарцуулна.

ХАВСРАЛТ**(Ownership over natural resources)**

Albania 1998 (rev. 2016)

PART TWOCHAPTER VARTICLE 591

1. The state, within its constitutional powers and the means at its disposal, aims to supplement private initiative and responsibility with:

[...]

dh.rational exploitation of forests, waters, pastures and other natural resources on the basis of the principle of sustainable development;

Angola 2010

TITLE IARTICLE 21

The fundamental tasks of the Angolan state shall be:

[...]

m.To promote harmonious and sustainable development throughout national territory, protecting the environment, natural resources and the historic, cultural and artistic heritage of the nation;

TITLE IICHAPTER IISECTION IARTICLE 39(ENVIRONMENTAL RIGHTS)

1. Everyone has the right to live in a healthy and unpolluted environment and the duty to defend and preserve it.

2. The state shall take the requisite measures to protect the environment and species of flora and fauna throughout national territory, maintain the ecological balance, ensure the correct location of economic activities and the rational development and use of all natural resources, within the context of sustainable development, respect for the rights of future generations and the preservation of species.

3. Acts that endanger or damage conservation of the environment shall be punishable by law.

Bahrain 2002 (rev. 2017)


CHAPTER IIARTICLE 11

All natural wealth and resources are State property. The State shall safeguard them and exploit them properly, while observing the requirements of the security of the State and of the national economy.

Czech Republic 1993 (rev. 2013)

CHAPTER IARTICLE 7

The state shall concern itself with the prudent use of its natural resources and the protection of its natural wealth.



**CHARTER OF FUNDAMENTAL RIGHTS AND BASIC FREEDOMSCHAPTER
4ARTICLE 352**

Everyone has the right to timely and complete information about the state of the environment and natural resources.

[...]

No one may, in exercising her rights, endanger or cause damage to the environment, natural resources, the wealth of natural species, or cultural monuments beyond the extent designated by law

Estonia 1992 (rev. 2015)

CHAPTER I ARTICLE 5

The natural wealth and resources of Estonia are national riches which shall be used economically.

Iran (Islamic Republic of) 1979 (rev. 1989)

CHAPTER IV ARTICLE 45

Public wealth and property, such as uncultivated or abandoned land, mineral deposits, seas, lakes, rivers and other public water-ways, mountains, valleys, forests, marshland, natural forests, unenclosed pastureland, legacies without heirs, property of undetermined ownership, and public property recovered from usurpers, shall be at the disposal of the Islamic government for it to utilize in accordance with the public interest. Law will specify detailed procedures for the utilization of each of the foregoing items.

CHAPTER X ARTICLE 153

Any form of agreement resulting in foreign control over the natural resources, economy, army, or culture of the country, as well as other aspects of the national life, is forbidden.

Iraq 2005

SECTION FOUR ARTICLE 111

Oil and gas are owned by all the people of Iraq in all the regions and governorates.

SECTION FOUR ARTICLE 112**SECTION FOUR ARTICLE 112 FIRST**

The federal government, with the producing governorates and regional governments, shall undertake the management of oil and gas extracted from present fields, provided that it distributes its revenues in a fair manner in proportion to the population distribution in all parts of the country, specifying an allotment for a specified period for the damaged regions which were unjustly deprived of them by the former regime, and the regions that were damaged afterwards in a way that ensures balanced development in different areas of the country, and this shall be regulated by a law.

SECTION FOUR ARTICLE 112 SECOND

The federal government, with the producing regional and governorate governments, shall together formulate the necessary strategic policies to develop the oil and gas wealth in a way that achieves the highest benefit to the Iraqi people using the most advanced techniques of the market principles and encouraging investment.

Korea (Republic of) 1948 (rev. 1987)

CHAPTER IX ARTICLE 120

1. Licenses to exploit, develop or utilize minerals and all other important underground resources, marine resources, water power, and natural powers available for economic use may be granted for a period of time as prescribed by law.
2. The land and natural resources shall be protected by the State, and the State shall establish a plan necessary for their balanced development and utilization.

CHAPTER IX ARTICLE 121

1. The State shall endeavor to realize the land-to-the-tillers principle with respect to agricultural land. Tenant farming shall be prohibited.
2. The leasing of agricultural land and the consignment management of agricultural land to increase agricultural productivity and to ensure the rational utilization of agricultural land or due to unavoidable circumstances, shall be recognized as prescribed by law.

Kuwait 1962 (reinst. 1992)

PART II ARTICLE 21

All of the natural wealth and resources are the property of the State. The State shall preserve and properly exploit those resources, heedful of its own security and national economy requisites.

Kyrgyzstan 2010 (rev. 2016)

SECTION I ARTICLE 12

5. The land, its resources, airspace, waters, forests, flora and fauna, as well as other natural resources shall be the exclusive property of the Kyrgyz Republic; these shall be used for the purpose of preserving a unified environmental system as the basis of life and activity of the people of Kyrgyzstan and shall enjoy special protection from the State.

Land may also be in private, municipal and other forms of ownership except for pastures which may not be in private property

Norway 1814 (rev. 2016)

EARTICLE 112

Every person has a right to an environment that is conducive to health and to natural surroundings whose productivity and diversity are preserved. Natural resources should be made use of on the basis of comprehensive long-term considerations whereby this right will be safeguarded for future generations as well.

Oman 1996 (rev. 2011)

CHAPTER TWO ARTICLE 11

The Economic Principles

[...]

•All natural wealth and resources thereof are the property of the State, which shall preserve and utilise them in the best manner taking into consideration the requirements of the security of the State and the interests of the national economy. No concession or investment of any public resource of the Country shall be granted except by virtue of a law, for a limited period of time, and in a manner that preserves national interests.

South Africa 1996 (rev. 2012)

CHAPTER 224

Everyone has the right-[...]

b.to have the environment protected, for the benefit of present and future generations, through reasonable legislative and other measures that-

[...]

iii.secure ecologically sustainable development and use of natural resources while promoting justifiable economic and social development.

Timor-Leste 2002

PART IV TITLE I ARTICLE 139 NATURAL RESOURCES

1. The resources of the soil, the subsoil, the territorial waters, the continental shelf and the exclusive economic zone, which are essential to the economy, shall be owned by the State and must be used in a just and equitable (iqualit&ia) manner in accordance with national interests.

2. The conditions for the exploitation of the natural resources referred to in number 1 above must lend themselves to the establishment of obligatory financial reserves, in accordance with the law.

3. The exploitation of the natural resources shall preserve the ecological balance and prevent destruction of ecosystems.

Tunisia 2014

TITLE ONE ARTICLE 13

Natural resources belong to the people of Tunisia. The state exercises sovereignty over them in the name of the people. Investment contracts related to these resources shall be presented to the competent committee in the Assembly of the Representatives of the People. The agreements concluded shall be submitted to the Assembly for approval.

Indonesia 1945 (reinst. 1959, rev. 2002)

CHAPTER XIV ARTICLE 33

The economy shall be organized as a common endeavour based upon the principles of the family system.

Sectors of production which are important for the country and affect the life of the people shall be under the powers of the State.

The land, the waters and the natural resources within shall be under the powers of the State and shall be used to the greatest benefit of the people.

The organisation of the national economy shall be conducted on the basis of economic democracy upholding the principles of togetherness, efficiency with justice, continuity, environmental perspective, self-sufficiency, and keeping a balance in the progress and unity of the national economy.

Further provisions relating to the implementation of this article shall be regulated by law.



ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛЬД ТӨРИЙН АУДИТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛЫГ ХЭРХЭН ТУСГАСАН ТАЛААРХ ЛАВЛАГАА

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ

Мэдээлэл, лавлагаанд гадаадын улс орнууд Үндсэн хууль²²⁵-даа Төрийн аудиттай холбоотой асуудлыг хэрхэн зохицуулсныг судалсан болно.

Хүснэгт 1. Төрийн аудиттай холбоотой асуудлыг тусгасан байдал

№	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1	Дани	<p>47.1. Төрийн тооцоог санхүүгийн жил дуусгавар болсноос хойш 6 сарын дотор Фолкетингт танилцуулна.</p> <p>47.2. Фолкетинг аудиторуудыг сонгоно. Аудиторууд нь жилийн Төрийн тооцоог хянан шалгана. Төрийн тооцоонд улсын бүх орлогыг тусгасан байх ба Сангийн тухай болон Төсвийн тухай хуулиудад заагаагүй зардлыг санхүүжүүлэхгүй. Аудиторууд шаардлагатай мэдээллийг шаардах болон шаардлагатай баримт бичгийг авах эрхтэй. Аудиторуудын бүрэлдэхүүний тоог тогтоох, тэдний эрх, үүргийг журмаар тогтооно.</p> <p>47.3. Төрийн тооцоог аудитын тайлангийн хамт Фолкетингээр шийдвэрлүүлэхээр хүргүүлнэ.</p>
2	ХБНГУ	<p>114 дүгээр зүйл. Тооцоог танилцуулах ба хянан шалгах</p> <p>1. Холбооны Засгийн газрын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор холбооны Сангийн сайд жил бүр Бундестаг болон Бундесратад өмнөх жилийн төсвийн бүх орлого, зарлага, актив, ерийн тайланг танилцуулна.</p> <p>2. Холбооны Аудитын танхим нь бие даасан байгууллага ба данс бүртгэлийг шалгаж, төрийн санхүүг зохиц ёсоор үр ашигтай зарцуулсан эсэхийг тодорхойлно. Танхим нь жилийн тайланг Бундестаг, Бундестрат болон холбооны Засгийн газарт хүргүүлнэ. Бусад тохиолдолд холбооны Аудитын танхимын эрх, үүргийг холбооны хууль тогтоомжоор зохицуулна.</p>
3	Бельги	<p>180 дугаар зүйл.</p> <p>Аудитын танхимын гишүүдийг Төлөөлөгчдийн танхимаас хуульд заасан хугацаагаар томилино.</p> <p>Аудитын танхим нь захиргааны нэгдсэн тооцоо болон төрийн сангийн дансны хариуцлагатай нягтлан бодох бүртгэлийг шалгах, баталгаажуулах үүрэгтэй. Танхим нь төсөө хэтрүүлсэн ямар нэгэн шилжүүлэг хийгдсэн эсэхийг хянана. Танхим нь улсын төсвийн зарлага, татварын болон бусад орлогод тавихиийн хяналтыг тавина. Энэ танхим нь төрийн бүх байгууллагын дансанд клеринг хийх ба үүний тулд шаардлагатай бүх мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн баримтыг цуглуулах үүрэгтэй. Нэгдсэн тооцоог Аудитын танхимын хийсэн шинжилгээний хамт Төлөөлөгчдийн танхимд танилцуулна.</p> <p>Аудитын танхимын үйл ажиллагааг хуулиар зохицуулна.</p> <p>Аудитын танхимын олон нийт, орон нутаг, мөн тэднээс хамааралтай нийтийн ашиг сонирхлын байгууллагуудын төсөө, нягтлан бодох бүртгэлд хяналт тавихыг хуулиар зохицуулна. Хуулиар мөн Танхимын хяналтын чиг үүргийг холбооны хууль, эсхүл энэ хуулийн 134 дүгээр зүйлд заасан журмаар зохицуулна. Герман хэлээр яригчдын нийгэмлэгт хамаатайгаас бусад тохиолдолд хуулийг энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу олонхын саналаар батална.</p> <p>Хууль, холбооны хууль, эсхүл энэ хуулийн 134 дүгээр зүйлд заасан журмын дагуу Аудитын танхимд нэмэлт даалгавар өгч болно. Хэрэв Танхим нь холбооны хууль, энэ хуулийн 134 дүгээр зүйлд заасан журмыг биелүүлэхийг зөвшөөрсөн бол Танхим энэ даалгаврын төлбөрийн хэмжээг тогтооно.</p> <p>Энэ заалтыг хүчин төгөлдөр болохоос өмнө олон нийт, орон нутагт зориулж биелүүлсэн даалгаврын хөлсийг Танхимд төлөхгүй.</p>

²²⁵Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Техасын Их Сургууль, Чикагогийн Их Сургууль, Лондонгийн Их Сургууль, АНУ-ын Энх тайвны институтаас хамтран хэрэгжүүлсэн төслийн хэрээнд бий болгосон олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу www.constituteproject.org цахим хуудас дахь эх сурвалжийг ашиглав.

4	Финланд	<p>90 дүгээр зүйл. Улсын санхүүгийн хяналт ба аудит</p> <p>Парламент нь улсын санхүү, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих ба энэ зорилгоор Парламент Аудитын хороотой байна. Аудитын хороо нь хяналтын аливаа чухал дүгнэлтийг Парламентад тайлагнана.</p> <p>Улсын санхүү, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор Парламентын дэргэд бие даасан Үндэсний аудитын газартай байна. Үндэсний аудитын газрын эрх зүйн байдал, эрх, үүргийг хуулиар нарийвчлан тогтооно.</p> <p>Аудитын хороо болон Үндэсний аудитын газар нь өөрсдийн хяналтад байдаг төрийн болон бусад байгууллагаас эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг авах эрхтэй.</p>
5	Франц	<p>47-2 дугаар зүйл.</p> <p>Тооцооны танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавихад Парламентад туслалцаа үзүүлнэ. Танхим нь Санхүүгийн тухай болон Нийгмийн даатгалын сангийн тухай хуулиудын хэрэгжилтэд хяналт тавиж Парламент болон Засгийн газарт туслалцаа үзүүлнэ. Танхим нь иргэдийг мэдээллээр хангана.</p> <p>Төрийн захиргааны данс нь хууль ёсны бөгөөд баталгаатай байна. Тэдгээр нь төрийн өмчийн удирдлага, хөрөнгө, санхүүгийн үр дүнгийн талаар үнэн зөв, шударга төсөөллийг хангана.</p>
6	Литва	<p>12 дугаар бүлэг. Төрийн хяналт</p> <p>133 дугаар зүйл.</p> <p>Төрийн хяналтыг гүйцэтгэх тогтолцоо, эрх, үүргийг хуулиар тогтооно.</p> <p>Төрийн хяналтын удирдлагыг Төрийн хянач хэрэгжүүлэх ба түүнийг Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгчийн танилцуулснаар Сейм 5 жилийн хугацаатай томилно.</p> <p>Төрийн хянач нь албан үүргээ хүлээн авахдаа тангарраг өргөнө. Тангаргийг хуулиар зохицуулна.</p> <p>134 дүгээр зүйл.</p> <p>Төрийн хяналт нь төрийн өмчийн удирдлага, ашиглалт, улсын төсвийн гүйцэтгэлийн хууль ёсны байдалд хяналт тавина.</p> <p>Төрийн хянач нь жилийн төсвийн гүйцэтгэлийн талаарх дүгнэлтээ Сеймд танилцуулна.</p>
7	Эстони	<p>11 дүгээр бүлэг. Төрийн аудитын газар</p> <p>132 дугаар зүйл.</p> <p>Төрийн аудитын газар нь өөрийн үйл ажиллагааны чиглэлд бие даасан төрийн байгууллага бөгөөд эдийн засгийн хяналтыг хэрэгжүүлнэ.</p> <p>133 дугаар зүйл.</p> <p>Төрийн аудитын газар дор дурдсан асуудлыг хянана:</p> <ol style="list-style-type: none"> 1) төрийн байгууллага, төрийн үйлдвэрийн газар болон бусад төрийн байгууллагын эдийн засгийн үйл ажиллагаа; 2) төрийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт; 3) орон нутгийн засаг захиргааны хяналтад шилжүүлсэн төрийн хөрөнгийг ашиглалт, удирдлага; 4) төр 50-аас дээш хувийн саналын эрх, эсхүл хувьцаа эзэмшиж байгаа хуулийн этгээдийн буюу төрөөс баталгаа гаргаж зээл авсан, эсхүл гарээний үүргийг биелүүлж байгаа хуулийн этгээдийн эдийн засгийн үйл ажиллагаа. <p>134 дүгээр зүйл.</p> <p>Төрийн аудитын газрыг Ерөнхий аудитор удирдана. Ерөнхий аудиторыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Рийгикогу (Төрийн зөвлөл) томилох ба чөлөөлнө.</p> <p>Ерөнхий аудиторын бүрэн эрхийн хугацаа нь 5 жил байна.</p> <p>135 дугаар зүйл.</p> <p>Ерөнхий аудитор нь өмнөх төсвийн жилд төрийн өмчийн ашиглалт, хадгалалтын талаарх тоймыг улсын төсвийн хэрэгжилтийн тайлланг хэлэлцүүлэхтэй нэгэн зэрэг Рийгикогу (Төрийн зөвлөл)-д танилцуулна.</p> <p>136 дугаар зүйл.</p> <p>Ерөнхий аудитор нь Бүгд найрамдах улсын Засгийн газрын хуралдаанд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар уг хэлэх эрхтэйгээр оролцож болно.</p> <p>Ерөнхий аудитор нь Төрийн аудитын газрын удирдах албан тушаалтны хувьд сайдтай адил эрх эдэлнэ.</p> <p>137 дугаар зүйл.</p> <p>Төрийн аудитын газрын зохион байгуулалтыг хуулиар тогтооно.</p> <p>138 дугаар зүйл.</p> <p>Ерөнхий аудиторыг гагчхүү Хууль зүйн сайдын саналын дагуу Рийгикогу (Төрийн зөвлөл)-ийн гишүүдийн олонхын саналаар эрүүгийн хариуцлагад татаж болно.</p>

8	Унгар	<p>43 дугаар зүйл.</p> <p>1. Төрийн аудитын газар нь Үндэсний Ассамблейн харьяа санхуу, эдийн засгийн аудитын асуудал эрхэлсэн байгууллага байна. Төрийн аудитын газар нь хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төвлөрсөн төсвийн хэрэгжилт, төсвийн санхүүжилтийн удирдлага, ашиглалт, үндэсний хөрөнгийн удирдлагад хяналт тавина. Төрийн аудитын газар нь хяналтыг хэрэгжүүлэхдээ хууль ёс, зорилгод тулгуурласан, үр нөлөөтэй байх шалгуурт нийцүүлнэ.</p> <p>2. Төрийн аудитын газрын Ерөнхийлөгчийг Үндэсний Ассамблейн гишүүдийн 2/3-ын саналаар 12 жилийн хугацаатайгаар сонгоно.</p> <p>3. Төрийн аудитын газрын Ерөнхийлөгч нь жил бүр үйл ажиллагааныхаа тайланг Үндэсний Ассамблейд тайлагнаан.</p> <p>4. Төрийн аудитын газрын зохион байгуулалт, үйл ажиллагааны нарийвчилсан журмыг хуулиар тогтооно.</p>
9	Чех	<p>62 дугаар зүйл.</p> <p>Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч нь:</p> <p>j. Аудитын ерөнхий газрын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг томилно;</p> <p>5 дугаар бүлэг. Аудитын ерөнхий газар</p> <p>97 дугаар зүйл.</p> <p>1. Аудитын ерөнхий газар нь бие даасан байгууллага байна. Тус газар төрийн өмчийн удирдлага, улсын төсвийн гүйцэтгэлд аудит хийнэ.</p> <p>2. Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч нь Аудитын ерөнхий газрын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг Депутатуудын Ассамблейгаас нэр дэвшүүлсний дагуу томилно.</p> <p>3. Аудитын ерөнхий газрын эрх зүйн байдал, эрх, үүрэг, зохион байгуулалтын бүтэц, түүнчлэн илүү нарийвчилсан зохицуулалтыг хуулиар тогтооно.</p>
10	Польш	<p>9 дүгээр хэсэг. Төрийн хяналтын байгууллага ба Хяналтын дээд танхимын эрхийг хамгаалах</p> <p>202 дугаар зүйл.</p> <p>1. Хяналтын дээд танхим нь төрийн хяналтын дээд байгууллага байна.</p> <p>2. Хяналтын дээд танхим Сеймд захирагдана.</p> <p>3. Хяналтын дээд танхим нь үйл ажиллагаагаа хамтын зарчимд нийцүүлж явуулна.</p> <p>203 дугаар зүйл.</p> <p>1. Хяналтын дээд танхим нь Засгийн газрын байгууллагууд, Польшийн Үндэсний банк, улсын хуулийн этгээд болон төрийн бусад байгууллагуудын үйл ажиллагааны хуульт ёс, эдийн засгийн үр ашиг, чиг үүрэгт хяналт тавина.</p> <p>2. Хяналтын дээд танхим нь нутгийн өөрөө удирдах байгууллага, олон нийтийн байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагааны хуульт ёс, эдийн засгийн хэмнэлт, үр ашигт хяналт тавина.</p> <p>3. Хяналтын дээд танхим нь төрийн болон нийтийн өмч буюу нөөцийг ашигладаг байгууллагууд, эдийн засгийн субъектүүдийн үйл ажиллагааны хуульт ёс, эдийн засгийн үр ашиг болон төрд ашигтай байх санхүүгийн зорилтын биелэлтэд хяналт тавина.</p> <p>204 дүгээр зүйл.</p> <p>1. Хяналтын дээд танхим Сеймд тайлагнана:</p> <p>1) улсын төсвийн гүйцэтгэл, мөнгөний бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ;</p> <p>2) өмнөх жилийн улсын төсвийн гүйцэтгэлийн талаарх Сайд нарын Зөвлөлийн тайланг батлах тухай шийдвэрийн дүгнэлт;</p> <p>3) хуульд заасан хяналт шалгалт, дүгнэлт, саналын талаар мэдээлэл.</p> <p>2. Хяналтын дээд танхим нь жил бүр үйл ажиллагаагаа Сеймд тайлагнана.</p> <p>205 дугаар зүйл.</p> <p>1. Хяналтын дээд танхимын Ерөнхийлөгчийг Сейм Сенаттай зөвшилцсөний дараа 6 жилийн хугацаагаар томилох ба зөвхөн нэг удаа улируулан томилж болно.</p> <p>2. Хяналтын дээд танхимын Ерөнхийлөгч нь дээд боловсролын байгууллагын профессороос бусад албан тушаал болон аливаа мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж болохгүй.</p> <p>3. Хяналтын дээд танхимын Ерөнхийлөгч нь улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, өөрийн албан үүрэгт нийцэхгүй олон нийтийн үйл ажиллагаанд хамаарч болохгүй.</p> <p>206 дугаар зүйл.</p> <p>Хяналтын дээд танхимын Ерөнхийлөгчийг Сеймийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн харцуулагад татах буюу эрх чөлөөг хасаж болохгүй. Хяналтын дээд танхимын Ерөнхийлөгчийг гэмт хэргийн газарт нотлох баримттай нь саатуулахаас бусад тохиолдолд саатуулах, эсхүл баривчилж болохгүй. Ийм саатуулах ажиллагааны талаар Сеймийн Маршалд нэн даруй мэдэгдэх ба тэрээр саатуулагдсан Ерөнхийлөгчийн нэн даруй чөлөөлөхийг шаардаж болно.</p> <p>207 дугаар зүйл.</p> <p>Хяналтын дээд танхимын бүтэц, үйл ажиллагааг хуулиар тогтооно.</p>

11	Словак	<p>2 дугаар хэсэг. Бүгд найрамдах Словак Улсын Аудитын ерөнхий газар 60 дугаар зүйл.</p> <p>1.Бүгд найрамдах Словак Улсын Аудитын ерөнхий газар нь дараах асуудалд хяналтыг хэрэгжүүлэх бие даасан байгууллага болно:</p> <p>а.Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний зөвлөл, эсхүл Засгийн газраас баталсан төсвийн нөөц;</p> <p>б.төр, төрийн байгууллага, Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний өмчийн сан, орон нутгийн болон нутаг дэвсгэрийн этгээд, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, орон нутгийн болон нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, орон нутгийн болон нутаг дэвсгэрийн нэгжийн байгууллагын байгуулсан хуулийн этгээдийн өмч, өмчийн эрхүүд, сангүүд, үүргүүд, нэхэмжлэлүүд;</p> <p>с.Хөгжлийн хөтөлбөр хүрээнд, эсхүл бусад төстэй шалтгаанаар гадаадын орноос хуулийн этгээд, эсхүл хувь хүн Бүгд найрамдах Словак Улсад шилжүүлсэн өмч, өмчийн эрхүүд, сангүүд, нэхэмжлэлүүд;</p> <p>д.Бүгд найрамдах Словак Улс баталгааг нь гаргасан өмч, өмчийн эрхүүд, сангүүд, үүргүүд, нэхэмжлэлүүд;</p> <p>е.нийтийн ашиг сонирхлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн өмч, өмчийн эрхүүд, сангүүд, үүргүүд, нэхэмжлэлүүд.</p> <p>2.Аудитын ерөнхий газар нь дараах байгууллагуудад энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүрээнд хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлнэ:</p> <p>а.Бүгд найрамдах Словак Улсын Засгийн газар, яамд, Бүгд найрамдах Словак Улсын төрийн захиргааны төв байгууллагууд болон түүний харьяа байгууллагууд;</p> <p>б.төрийн байгууллагууд, мөн төрийн захиргааны төв байгууллагууд, эсхүл тэдгээрийн байгуулсан хуулийн этгээд;</p> <p>с.орон нутгийн болон нутаг дэвсгэрийн нэгжийн байгууллагууд, орон нутгийн байгууллагын болон нутаг дэвсгэрийн нэгжийн байгууллагын байгуулсан хуулийн этгээд, орон нутгийн болон нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;</p> <p>д.тусгай зориулалтын төрийн сангүүд, хуулиар байгуулагдсан төрийн байгууллагууд, төрийн байгууллагын өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;</p> <p>е.Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний өмчийн сан болон түүний өмчийн оролцоотой хуулийн этгээд;</p> <p>ф.хувь хүн, хуулийн этгээд.</p> <p>61 дүгээр зүйл.</p> <p>1.Аудитын ерөнхий газрыг дарга удирдана. Аудитын ерөнхий газрын дарга, орлогч даргыг Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний зөвлөлөөс сонгох ба эзгуулэн татна.</p> <p>2.Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний Зөвлөлд сонгогдох эрхтэй Бүгд найрамдах Словак Улсын аливаа иргэн Аудитын ерөнхий газрын дарга, орлогч даргаар сонгогдож болно.</p> <p>3.Аудитын ерөнхий газрын дарга, орлогч даргаар 7 жилийн хугацаатайгаар сонгогдох ба дараалан хоёр удаа сонгогдож болно.</p> <p>4.Аудитын ерөнхий газрын дарга, орлогч даргын албан тушаал нь өөрийн өмчийг удирдах, шинжлэх ухаан, боловсрол, утга зохиол, урлагийн үйл ажиллагаанаас бусад төрийн захиргааны ямар ч байгууллагад, бизнесийн үйл ажиллагаанад ажил эрхээх, түүнтэй адилтгах хөдөлмөрийн харилцаанд орох, бизнесийн, эсхүл эдийн засаг, арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн удирдлага, эсхүл хяналтын байгууллагын гишүүнчлэлийг хавсрان хийхгүй.</p> <p>62 дугаар зүйл.</p> <p>Аудитын ерөнхий газар нь хяналт шалгалтын үр дүнгийн тайланг Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний зөвлөлд жилд 1-ээс доошгүй удаа, мөн Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний зөвлөлийн хүссэн тохиолдол бүрт гаргана.</p> <p>63 дугаар зүйл.</p> <p>Аудитын ерөнхий газрын эрх зүйн байдал, эрх, үүрэг, дотоод зохион байгуулалтын бүтэц, хяналт хийх үндсэн журмыг хуулиар тогтооно.</p>
----	--------	--

12	Словени	<p>150 дугаар зүйл. Аудит Аудит нь төрийн данс, улсын төсөв, улсын бүх төрлийн зардалд хяналт шалглалт хийх дээд байгууллага байна. Аудитын зохион байгуулалт, эрх, үүргийг хуулиар тогтооно. Аудит нь чиг үүргээ бие даан хэрэгжүүлэх ба Үндсэн хууль болон бусад хуульд захирагдана.</p> <p>151 дүгээр зүйл. Аудитын гишүүдийг томилох Аудитын гишүүдийг Үндэсний Ассамблейгаас томилно.</p>
13	БНСУ	<p>4 дүгээр дэд бүлэг. Хянан шалгах зөвлөл 97 дугаар зүйл. Хянан шалгах зөвлөл нь Ерөнхийлөгчийн шууд мэдэлд байгуулагдах ба улсын төсөв, хууль тогтоомжоор байгуулсан төрийн байгууллага, гүйцэтгэх байгуулагын албан тушаалтны төсвийн удирдлагыг хянан шалгана.</p> <p>98 дугаар зүйл. 1) Хянан шалгах зөвлөл нь даргыг оролцуулан 5-аас доошгүй, 11-ээс дээшгүй гишүүнээс бүрдэнэ. 2) Зөвлөлийн даргыг Үндэсний Ассамблейн зөвшөөрлөөр Ерөнхийлөгч томилно. Зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба түүнийг нэг удаа улиран томилж болно. 3) Зөвлөлийн гишүүдийг Зөвлөлийн даргын зөвлөсний дагуу Ерөнхийлөгч томилно. Гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба тэдгээрийг нэг удаа улиран томилж болно.</p> <p>99 дүгээр зүйл. Хянан шалгах зөвлөл нь жил бүр орлого, зарлагын дансны хаалтын дунд хяналт шалглалт хийж, тайланг дараа жил Ерөнхийлөгч, Үндэсний Ассамблейд тайлагнана.</p> <p>100 дугаар зүйл. Хянан шалгах зөвлөлийн зохион байгуулалт, эрх, үүрэг, түүний гишүүдийн мэргэшил, хяналт шалгалтад хамрагдах төрийн албан тушаалтны хүрээ, бусад шаардлагатай зохицуулалтыг хуулиар тогтооно.</p>

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН ХУУЛЬД ЗАСАГ ЗАХИРГАА,
НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГАТАЙ
ХОЛБООТОЙ АСУУДЛЫГ ТУСГАСАН БАЙДАЛ**

(Мэдээлэл, лавлагаа)

Д.Халиун, Д.Жигсваагүнсэл,
Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа

Энэхүү лавлагаанд гадаадын зарим улс орнууд Үндсэн хуульдаа²²⁶ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагатай холбоотой асуудлыг хэрхэн тусгасныг судалсан болно.

*Хүснэгт 1. Гадаадын зарим орнуудын Үндсэн хуульд засаг захиргааны
нэгжийн удирдлагатай холбоотой асуудлыг тусгасан байдал*

№	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1	Албани	<p>6-р бүлэг. Орон нутгийн засаг захиргаа 108 дугаар зүйл</p> <p>1. Орон нутгийн засаг захиргааны нэгж нь коммун, муниципалитет болон бус нутагт хуваагдана. Орон нутгийн засаг захиргааны бусад нэгжийг хуулиар зохицуулна.</p> <p>2. Орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг эдийн засгийн хэрэгцээ, ашиг сонирхол, түүхэн уламжлал дээр тулгуурлан хуулиар тогтооно. Тэдгээрийн хил, хязгаарыг тухайн газар нутгийн оршин суучдын санал бодлыг авалгүйгээр өөрчилж болохгүй.</p> <p>3. Коммун болон муниципалитет нь нь орон нутгийн засаг захиргааны үндсэн нэгж байна. Тэдгээр нь орон нутгийн засаг захиргааны бусад нэгжүүдэд хуулиар олгогдсон эрхээс бусад нутгийн өөрөө удирдах байгууллагын бүх эрх, үүргийг гүйцэтгэнэ.</p> <p>4. Орон нутгийн нэгжүүдэд нутгийн өөрөө удирдах эрхийг тэдгээрийн төлөөллийн байгууллага болон орон нутгийн санал асуугаар дамжуулан хэрэгжүүлнэ. Орон нутгийн санал асуулыг зохион байгуулах зарчим, процедурыг 151.2-т заасны дагуу хуулиар тогтооно.</p> <p>109 дүгээр зүйл</p> <p>1. Орон нутгийн үндсэн засаглалын төлөөлөх эрх мэдлийн байгууллага нь ерөнхий, шууд, нууц санал хураалтаар дөрвөн жил тутам сонгогддог зөвлөлүүд юм.</p> <p>2. Муниципалитет, эсхүл коммуны удирдлага нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шууд сонгогдсон Дарга байна.</p> <p>3. Гагцхүү тухайн орон нутгийн нутаг дэвсгэрт байнга оршин судаг иргэд тухайн орон нутгийн зөвлөл болон муниципалитет, эсхүл коммуны даргаар сонгогдох эрхтэй байна.</p> <p>110 дугаар зүйл</p> <p>1. Бус нутаг нь уламжлал, эдийн засаг, нийгмийн харилцааны хувь холбоотой, нэгдмэл ашиг сонирхол бүхий орон нутгийн засаг захиргааны хэд хэдэн үндсэн нэгжээс бүрдэнэ.</p> <p>2. Бус нутаг нь бус нутгийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, төрийн бодлоготой уялдуулах нэгж байна.</p>

²²⁶Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Техасын Их Сургууль, Чикагогийн Их Сургууль, Лондонгийн Их Сургууль, АНУ-ын Энх тайвны институтаас хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бий болгосон олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу www.constituteproject.org цахим хуудас дахь эх сурвалжийг ашиглав.

		<p>3. Бүс нутгийн төлөөллийн байгууллага нь Бүсийн Зөвлөл байна. Муниципалитет болон коммунууд нь Бүсийн зөвлөлд өөрсдийн хүн амын тоонд хувь тэнцүүлж, хамгийн багадаа нэг гишүүнийг томилно. Муниципалитет болон коммуны дарга нар нь Бүсийн зөвлөлийн гишүүд байна. Бусад гишүүдийг нь муниципалитет болон коммуны зөвлөл өөрсдийн гишүүд дундаас пропорциональ жагсаалтаар сонгоно. (...)</p> <p>114 дүгээр зүйл Сайд нарын Зөвлөл нь бүс нутаг бүрт Прэфект (Төлөөлөгч)-ийг томилно. Префектийн бүрэн эрхийг хуулиар тогтооно.</p>
2	Болгар	<p>135 дугаар зүйл 1. Болгар Улсын нутаг дэвсгэр хот болон бүсүүдэд хуваагдана.</p> <p>136 дугаар зүйл 1. Хөтөн нь орон нутгийн өөрөө удирдах байгууллага эрх мэдлээ хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн суурь нэгж байна. Иргэд орон нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгох болон шууд байдлаар, эсхүл санал өгөх болон орон нутгийн нийтийн хуралд оролцох байдлаар хотын засаг захиргааны үйл ажиллагаанд оролцно.</p> <p>138 дугаар зүйл Орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь Хотын зөвлөл байх ба зөвлөл нь 4 жилийн хугацаатай хотын иргэдээс сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.</p> <p>139 дүгээр зүйл 1. Хотын дарга нь хотын гүйцэтгэх удирдлага байна. Хотын дарга хуулийн дагуу 4 жилийн хугацаа гар Хотын зөвлөл, эсхүл орон нутгийн иргэдээс сонгогдоно.</p> <p>140 дүгээр зүйл Хот тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн ашиг сонирхлын төлөө зарцууллагдах өөрийн төсөвтэй байна.</p> <p>142 дугаар зүйл Бүсийн захиргаа нь үндэсний болон орон нутгийн ашиг сонирхлыг нийцүүлэх, орон нутагт Засгийн газрын үүргийг гүйцэтгэх, бүсийн бодлогыг удирдах үүрэгтэй нутаг дэвсгэрийн нэгж байна.</p> <p>143 дугаар зүйл 1. Бүсийн захиргааг бүсийн захирагч/засаг дарга удирдана. 2. Бүсийн захирагчийг Сайд нарын Зөвлөлөөс томилно. 3. Бүсийн захирагчид улсын бодлогыг хэрэгжүүлнэ. Тэд дүрэм, журам болон хуулийн дагуу үндэсний ашиг сонирхлыг хамгаалж хариуцах бөгөөд захиргааны хяналт тавина.</p>
3	Грек	<p>IV хэсэг. Засаг захиргаа</p> <p>Бүлэг 1. Засаг захиргааны байгууллага</p> <p>101 дүгээр зүйл.</p> <p>1. Төрийн захиргааны нэгжүүдийг төвлөрлийг сааруулах зарчим дээр үндэслэн зохион байгуулна.</p> <p>2. Нутгийн засаг захиргааны нэгжийг гео-эдийн засаг, нийгэм, зам тээврийн нөхцөл байдал дээр тулгуурлаж тогтооно.</p> <p>102 дугаар зүйл.</p> <p>1. Нутгийн захиргааны үйл ажиллагааг орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын I, II түвшинд хэлэлцэж шийдвэрлэнэ. Орон нутгийн үйл ажиллагааны төрөл, цар хүрээ, аль түвшинд хамаарах зэргийг хуулиар тогтооно. Тухайн орон нутгийн байгууллагуудад төрөөс олгосон эрх мэдэл, оногдуулсан үүрэг, хариуцлагыг хуулиар тогтооно.</p> <p>2. Нутгийн захиргааны байгууллагууд нь засаг захиргааны болон санхүүгийн хувьд бие даасан байна. Хуульд зааснаар орон нутгийн захиргааны удирдлагуудыг бүх нийтийн нууц санал хураалтаар сонгоно.</p>

		<p>3. Нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албыг хэрэгжүүлэх болон олон нийтэд үйлчилгээ үзүүлэхэд баримтлах эрх хэмжээ, зайлшгүй болон сайн дурын үндсэн дээр гүйцэтгэх үйл ажиллагаа зэргийг хуулиар тогтооно.</p> <p>Төрөөс нутгийн захиргааны байгууллагуудын санал санаачилга, үйл ажиллагааны эрх чөлөөнд халдахгүйгээр хяналт тавина. Тус хяналт нь онцгойлон тухайн байгууллагуудын үйл ажиллагаанд тавих эрх зүйн хяналтаас бүрдэнэ. Эрх зүйн хяналтыг хуулийн дагуу хэрэгжүүлнэ. Гэмт хэрэгт холбогдоноос бусад тохиолдолд нутгийн захиргааны удирдлагуудыг албан тушаалаас чөлөөлөх, огцруулах, сахилгын шийтгэл ногдуулахдаа зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын саналыг харгалзана.</p>
4	Люксембург	<p>Бүлэг 9. Коммун 107 дугаар зүйл.</p> <p>1. Коммун нь өөрийн газар нутаг болон өөрсдийн үзэл бодол, ашиг сонирхлоо хамгаалах байгууллага бүхий хараат бус нэгдэл юм.</p> <p>2. Коммун бүр оршин суугчдаасаа шууд сонгогддог коммуны зөвлөлтэй байна. Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч болон тавигдах шаардлагыг хуулиар тогтооно.</p> <p>3. Зөвлөл нь жил бүр коммуны төсвийг тогтооно. Коммун нь өөрийн журмыг боловсруулж болно. Гранд Дюкийн зөвшөөрөлтэйгээр коммун нь татвар тогтоох эрхтэй. Гранд Дюк нь коммуны зөвлөлийг тараах эрхтэй.</p> <p>4. Коммуныг зөвлөлийн дарга болон гишүүдээс бүрдсэн тэргүүлэгчид удирдана.</p> <p>5. Коммуны харьяа байгууллагуудын бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг, ажилтан, албан хаагчдын эрх хэмжээг хуулиар тогтооно.</p> <p>Коммуны захиргааны үйл ажиллагаанд хуулиар хяналт тавина.</p>
5	Молдова	<p>110 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт</p> <p>1. Молдова Улсын нутаг дэвсгэрийг засаг захиргааны хувьд тосгон, хот, дүүргэ болон Гагаузийн автономит нутаг дэвсгэрт хуваагдана. Хуульд заасны дагуу зарим хотыг муниципалитет гэж зарлаж болно.</p> <p>112 дугаар зүйл. Тосгон, хотын удирдлага</p> <p>1. Орон нутгийн бие даасан байдлыг тосгон, хотод хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага нь орон нутгаас сонгогдсон зөвлөл, мэруүд байна.</p> <p>2. Орон нутгийн зөвлөл, мэр нь хууль тогтоомжийн дагуу бие даасан засаг захиргааны эрх мэдлийг хэрэгжүүлж, төрийн үйл ажиллагааг тосгон, хотод эрхлэн явуулна.</p> <p>3. Орон нутгийн зөвлөл, мэрийг сонгох, тэдгээрийн бүрэн эрх, үүргийг хуулиар тогтооно.</p> <p>113 дугаар зүйл</p> <p>1. Дүүргийн зөвлөл нь тосгон, хотын зөвлөлийн үйл ажиллагааг дүүргийн түвшинд төрийн үйлчилгээг үр дүнтэй хургэх зорилгоор зохицуулна.</p> <p>2. Дүүргийн зөвлөл хууль тогтоомжийн дагуу сонгогдож, үйл ажиллагаагаа явуулна.</p> <p>3. Орон нутгийн төрийн байгууллагуудын хоорондын харилцаа нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд бие даасан, хууль ёсны, хамтын ажиллагааны зарчимд үндэслэгдэнэ.</p>

6	Серби	<p>176 дугаар зүйл. Иргэд шууд болон сонгууль өгөх замаар эрх мэдлээ хэрэгжүүлэх орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон автономит аймгийн эрхтэй.</p> <p>Орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон автономит аймаг хуулийн этгээдийн эрхтэй байна.</p> <p>180 дугаар зүйл. Ассамблей (Хурал) нь орон нутгийн өөрөө удирдах нэгжийн зөвлөлийн гишүүдээс бүрдэнэ.</p> <p>Зөвлөлийн гишүүн болон депутатууд хуулийн дагуу Зөвлөл болон автономит аймгийн их хурлын шийдвэрийн дагуу нэрээр, нууц, шууд сонгуулаа 4 жилийн хугацаатай сонгогдоно.</p> <p>Хуулийн дагуу үндэсний цөөнх Ассамблейд пропорциональ байдлаар суух эрх хангагдана.</p> <p>188 дугаар зүйл. Орон нутгийн өөрөө удирдах нэгж Белград хот болон хот, тосгонд байна.</p> <p>Орон нутгийн өөрөө удирдах нэгжийн суудал болон нутаг дэвсгэр хуулиар тодорхойлгодно.</p> <p>191 дүгээр зүйл. Хотын хурал (Ассамблей) хуулийн дагуу хотын гүйцэтгэх удирдлагыг сонгуулиар шийдвэрлэнэ.</p> <p>Белград хотын болон тосгоны гүйцэтгэх удирдлагын сонгууль хуулиар зохицуулагдана.</p>
7	Словак	<p>64 дүгээр зүйл. Нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага</p> <p>Муниципалитет нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн нэгж байна. Нутаг дэвсгэрийн өөрөө удирдах байгууллага нь муниципалитет болон дээд шатны нутаг дэвсгэрийн нэгжээс бүрдэнэ.</p> <p>64.а. Муниципалитет болон дээд шатны нутаг дэвсгэрийн нэгж нь тухайн нутаг дэвсгэртээ байнга оршин суудаг хумуссээс бүрдсэн Словак Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэр, засаг захиргааны бие даасан нэгж юм. Дэлгэрэнгүй зохицуулалтыг хуулиар тогтооно.</p> <p>65 дугаар зүйл</p> <p>1. Муниципалитет болон дээд шатны нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн өмч, санхүүгийн нөөцийг бие даан удирдан зохион байгуулах эрх бүхий хуулийн этгээд юм.</p> <p>2. Муниципалитет болон дээд шатны нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн орлога болон төрийн татаасаар санхүүжилдэнэ. Аль татвар, хураамжийг муниципалитет, аль татвар, хураамжийг дээд шатны нутаг дэвсгэрийн нэгж ногдуулахыг хуулиар тогтооно. Төрийн татаасыг зөвхөн хуульд заасан хязгаарын хүрээнд олгож болно.</p> <p>69 дүгээр зүйл</p> <p>1. Муниципалитетын байгууллагууд нь:</p> <p>а.Муниципалитетын зөвлөл,</p> <p>б.Муниципалитетын мэр.</p> <p>2. Муниципалитетын зөвлөл нь Муниципалитетын зөвлөлийн төлөөлөгчдөөс бүрдэнэ. Төлөөлөгчдийг тухайн нутаг дэвсгэрт байнгын оршин суух зөвшөөрөлтэй орон нутгийн иргэд дэрвэн жилийн хугацаагаар сонгоно. Сонгуулийг ерөнхий, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар явуулна.</p> <p>3. Муниципалитетын мэрийг тухайн нутаг дэвсгэрт байнгын оршин суух зөвшөөрөлтэй орон нутгийн иргэд дэрвэн жилийн хугацаагаар ерөнхий, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгоно. Муниципалитетын удирдлага нь мэр байна. Тэрбээр хотын захиргааны ажлыг гүйцэтгэж, муниципалитетыг гадаадад төлөөлнэ. Мэрийн бүрэн эрхийн хугацаа дусахаас өмнө огцруулах үндэслэл, нөхцөлийг хуулиар тогтооно.</p>

8	Унгар	<p>41 дүгээр зүйл. Унгарын нутаг дэвсгэр нийслэл хот, мукууд, хотууд болон орон нутаг гэх засаг захиргааны нэгжид хуваагдана.</p> <p>42 дугаар зүйл. Мужууд, нийслэл хот болон түүний дүүргүүд, хотууд, орон нутгийн эрх бүхий сонгогчид орон нутгийн удирдлагын эрхтэй байна. Орон нутгийн удирдлага тухайн орон нутгийнхаа хүн амын ашиг сонирхлын дагуу нийтийн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд орон нутгийн байгууллагын бие даасан ардчилсан байдлыг илэрхийлнэ.</p> <p>44 дүгээр зүйл.</p> <ol style="list-style-type: none"> Орон нутгийн эрх бүхий сонгогчид санал өгөх замаар өөрсдийн төлөөлөгчдийг орон нутгийн удирдлагад сонгох эрхтэй байна. Дунд хугацааны сонгуулийг тооцохгүйгээр, хотын дарга болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын гишүүдийг өмнөх ерөнхий сонгуулийн дараагийн 4 дэх жилийн 10 сард сонгоно. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх нь ерөнхий орон нутгийн сонгуулийн өдөр дуусна. Хэрэв сонгууль нэр дэвшигчид дутагдалтай байдлаар болохгүй бол орон нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх нь дунд хугацааны сонгууль хүртэл сунгагдана. Хотын даргын эрх шинэ хотын даргын сонгуулиар дуусгавар болно. Орон нутгийн өөрөө удирдах байгууллага орон нутгийн засаг захиргааны хуульд заасан нэхцэлийн дагуу болон түүний эрхийн хугацаа өнгөрсөн бол татан буугдаахаа зарлаж болно. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын татан буугсаны дагуу хотын даргын эрх бас дуусгавар болно. <p>44/Б.1. Хотын дарга орон нутгийн өөрөө удирдах байгууллагын даргаар ажилана. Өөрөө удирдах байгууллага дэд даргыг даргын орлогч байдлаар томилж болно. Дэд дарга нь өөрөө удирдах байгууллагын гишүүн байх албагүй боловч орон нутгийн өөрөө удирдах байгууллагын даргыг орлох учир гишүүн байх шаардлагатай.</p>
9	Хорват	<p>4-р зүйл. БНХУ-д төрийн эрх мэдлийн хуваарилалт нь хууль тогтоо, гүйцэтгэх, шүүх гэсэн эрх мэдлийн хуваарилалтын зарчимд үндэслэх ба энэ нь энэхүү Үндсэн хуулиар баталгаажсан бүсийн болон нутгийн өөрөө удирдах ёсны эрхээр хязгаарлагдана.</p> <p>6-р бүлэг. Бүсийн болон нутгийн өөрөө удирдах ёс</p> <p>128 дугаар зүйл. Иргэд бүсийн болон нутгийн өөрөө удирдах ёсны эрхтэй байна.</p> <p>Энэхүү эрхээ чөлөөт, шууд, тэгш, нууц санал хураалт бүхий сонгуулиар сонсогдсон төлөөлөгчдөөс бүрдсэн бүсийн болон орон нутгийн төлөөлөгчдийн байгууллагаараа дамжуулан эзлэнэ.</p> <p>Иргэд нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хурал цуглаан болон шийдвэр гаргах бусад хэлбэрээр хууль тогтоомжид заасны дагуу оролцно.</p> <p>Энэ зүйлд заасан эрхийг Европын холбооны иргэд эдэлнэ.</p> <p>129 дүгээр зүйл. Хот, тосгон нь орон нутгийн засаг захиргааны нэгж бөгөөд нутаг дэвсгэрийн хэмжээг хуулиар тогтооно. Орон нутгийн засаг захиргааны бусад нэгжийг хуулиар тогтоож болно.</p> <p>Мужууд нь бүсийн засаг захиргааны нэгж мөн бөгөөд нутаг дэвсгэрийн хэмжээг хуулиар тогтооно.</p> <p>Нийслэл хот болон бусад томоохон хотуудыг хуулиар мужид тооцож болно.</p> <p>129А зүйл. Орон нутгийн засаг захиргааны нэгж нь иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангах болон орон нутгийн байгууллага, орон сууц, хот төлөвлөлт, олон нийтийн байгууламжууд, хүүхэд асрах, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, бага сургууль, соёл, спорт, галын аюулгүй байдал, хүрээлэн буй орчны хамгаалалт, сайжруулалттай холбогдох өөрийн эрх хэмжээний хүрээний асуудлыг шийдвэрлэнэ.</p>

		<p>Бүсийн өөрөө удирдах байгууллага нь бус нутгийн ач холбогдол бүхий асуудал, ялангуяа боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, газар, хот төлөвлөлт, эдийн засгийн хөгжил, зам тээвэр, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагуудын хөгжилтэй холбогдох асуудлуудыг хариуцан шийдвэрлэнэ.</p> <p>129Б зүйл. Бүсийн болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд нь хуулиар тогтоосон хүрээнд өөрийн байгууллага, тэдгээрийн эрх хэмжээг иргэдийн хэрэгцээ, шаардлага болон орон нутгийн холбогдох дүрэм, журамд нийцүүлэн тогтоох, зохицуулах эрхтэй.</p> <p>130 дугаар зүйл. Бүсийн болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлыг бие даан шийдвэрлэх бөгөөд Үндсэн хуулийн болон хууль ёсны асуудлаар териин эрх бүхий байгууллагын хяналтад хамаарна.</p> <p>131 дүгээр зүйл. Бүсийн болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд нь орон нутгийн орлогыг өөртөө, төвлөрүүлж, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах эрхтэй.</p> <p>Улсаас нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.</p>
10	Чех	<p>101 дүгээр зүйл</p> <p>1.Муниципалитетуудын удирдлагыг холбогдох төлөөллийг байгууллага нь бие даан хэрэгжүүлнэ.</p> <p>2.Дээд шатны бүс нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагыг тэдгээрийн төлөөллийн байгууллага бие даан хэрэгжүүлнэ.</p> <p>3.Нутаг дэвсгэрийн өөрөө удирдах нэгжүүд нь эд хөрөнгө өмчлөх эрхтэй, өөрийн төсвийн үндсэн дээр үйл ажиллагаагаа удирдан явуулах нийтийн эрх зүйн хуулийн этгээд юм.</p> <p>4.Нутаг дэвсгэрийн өөрөө удирдах нэгжийн үйл ажиллагаанд гагцхүү хуулийг сахин хамгаалах шаардлага гарсан тохиолдолд хуульд заасан журмын дагуу төр оролцох боломжтой.</p> <p>102 дугаар зүйл</p> <p>1. Төлөөллийн байгууллагын гишүүдийг ерөнхий, тэгш, шууд зарчмыг баримтлан нууц санал хураалтаар сонгоно.</p> <p>2. Төлөөллийн байгууллагын сонгуулийн хугацаа дөрвөн жил байна. Төлөөллийн байгууллагын бүрэн эрхийн хугацаанаас өмнө сонгууль явуулах асуудлыг хуулиар тогтооно.</p>
11	Польш	<p>15 дугаар зүйл. Нутаг дэвсгэрийн нэгжийг хуулиар тогтооно.</p> <p>16 дугаар зүйл. Нутаг дэвсгэрийн нэгжид оршин суугчид нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу нутгийн өөрөө удирдах байгууллагыг байгуулна.</p> <p>Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь тэрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцно. Хуулиар олгогдсон чиг үүргээ өөрийн нэрийн өмнөөс гүйцэтгэж, хариуцлага хүлээнэ. 7-р бүлэг. Нутгийн өөрөө удирдах байгууллага.</p> <p>163 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь Үндсэн хууль болон бусад хуулиар териин бусад байгууллагад олгогдоогүй тэрийн чиг үүргийг гүйцэтгэнэ.</p> <p>164 дүгээр зүйл. Коммун нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үндсэн нэгж мөн. Бүсийн болон орон нутгийн удирдах ёсны байгууллагын бусад нэгжийг хуулиар тогтоож болно. Коммун нь бусад орон нутгийн удирдах байгууллагад олгогдоогүй нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бүхий л чиг үүргийг гүйцэтгэнэ.</p> <p>165 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь эрх зүйн этгээд байх ба өмчлөх болон түүнтэй холбогдох бусад эрхийг эдэлнэ.</p> <p>169 дүгээр зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь үүсгэн байгуулсан болон гүйцэтгэх эрх бүхий байгууллагаар дамжуулан чиг үүргээ гүйцэтгэнэ.</p>

		<p>Үүсгэн байгуулах байгууллага нь бүх нийтийн шууд, тэгш, нууц санал хураалт бүхий сонгуулийн дунд байгуулагдана. Нэр дэвшигчийг сонгох, сонгууль явуулах зарчим, журам, сонгууль хүчин төгөлдөр болоход тавигдах шаардлага, журмыг хуулиар тогтооно.</p> <p>Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гүйцэтгэх байгууллагыг сонгох, чөлөөлөх зарчим, журмыг хуулиар тогтооно.</p> <p>Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын дотоод бүтцийг үүсгэн байгуулсан байгууллагын шийдвэрээр тогтооно.</p>
12	Португал	<p>Хэсэг 8. Орон нутгийн засаг захиргаа</p> <p>235 дугаар зүйл. 1. Орон нутгийн засаг захиргаа нь тодорхой нутаг дэвсгэр, тухайн нутаг дэвсгэрийн иргэдийг төлөөлөлөх төлөөлөлтэй байна.</p> <p>236 дугаар зүйл. Орон нутгийн засаг захиргааны хуваарилалт</p> <ol style="list-style-type: none"> 1. Эх газрын орон нутгийн захиргаа нь сум (parish), аймаг (municipality), захиргааны бүсүүдээс бүрдэнэ. <p>237 дугаар зүйл. Төвлөрлийг сааруулах</p> <ol style="list-style-type: none"> 2. Орон нутгийн ассамблей нь тухайн нутаг орноо хөгжүүлэх төлөвлөгөө, төсвийг батлах зэрэг хуулиар ногдуулсан эрх мэдлийг хэрэгжүүлнэ. <p>238 дугаар зүйл. Орон нутгийн хөрөнгө болон санхүү</p> <ol style="list-style-type: none"> 1. Нутгийн захиргаа нь өөрийн хөрөнгө болон санхүүжилттэй байна. 2. Нутгийн захиргааны байгууллага нь өөрийн хөрөнгийг захиран зарцуулсны үндсэн дээр орлогоо бүрдүүлж, үйлчилгээндээ зарцуулах үүрэгтэй. 3. Нутгийн захиргаа нь хуульд заасан нөхцөлийн дагуу татвар тогтоох эрхтэй. <p>239 дүгээр зүйл. Шийдвэр гаргах байгууллага болон түүний удирдах зөвлөл</p> <ol style="list-style-type: none"> 1. Нутгийн захиргаа нь шийдвэр гаргах эрх бүхий иргэдээс сонгогдсон ассамблей болон ассамблейд тайлагнах үүрэг бүхий удирдах зөвлөлөөс бүрдэнэ. 2. Ассамблей нь тухайн нутгийн захиргааны байгууллагад санал хураалтад оролцохор бүртгэгдсэн нийт иргэдийн шууд, нууц санал хураалтаар пропорциональ буюу хувь тэнцүүлэх системийн дагуу сонгогдоно. 3. Хуульд зааснаар хамгийн олон санал авсан нэр дэвшигч ассемлейн ерөнхийлөгчөөр сонгогдоно. Мөн түүнчлэн ассамблей сонгох сонгуулийн үйл явц, ассамблей болон удирдах зөвлөлийг бүрдүүлэх хийгээд татан буулгах үндэслэлүүд, хэрэгжүүлэх үйл ажиллагаа зэргийг хуулиар зохицуулна. 4. Хуульд заасны дагуу орон нутгийн сонгуульд улс төрийн нам, дангаар буюу эвсэл байгуулан, түүнчлэн иргэд бие даан нэр дэвших боломжтой. <p>240 дүгээр зүйл. Орон нутаг дахь ард нийтийн санал асуулга</p> <ol style="list-style-type: none"> 1. Хуульд заасан нөхцөлийн дагуу нутгийн захиргааны байгууллага нь өөрийн эрхлэх хүрээний асуудлаар сонгууль өгөх бүртгэлтэй иргэдийн дунд ард нийтийн санал асуулга зохион байгуулж болно. 2. Сонгууль өгөх эрх бүхий иргэд ард нийтийн санал асуулга зохион байгуулах эрхийг хуулиар олгоно. <p>242 дугаар зүйл. Захиргааны хяналт</p> <ol style="list-style-type: none"> 1. Хуульд заасны дагуу нутгийн захиргааны байгууллагын дараах шатны байгууллага нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллана. <p>Нутгийн захиргааны байгууллагыг хууль ноцтой зөрчсөн тохиолдолд тараана.</p>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- http://www.ccre.org/docs/Local_and_Regional_Government_in_Europe.EN.pdf
- www.constituteproject.org



**ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ (СОНГОХ),
ТЭДНИЙ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА, ХАВСРАН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН
ТАЛААРХ БҮГД НАЙРАМДАХ УЛСУУДЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЗОХИЦУУЛАЛТ**

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ, О.Нарантуяа

	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1.	Австри	<p>Б.Үндсэн хуулийн шүүх</p> <p>147.1.Үндсэн хуулийн шүүх нь Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, 12 гишүүн, 6 орлогч гишүүнээс бүрдэнэ.</p> <p>147.2.Холбооны Ерөнхийлөгч нь Холбооны Засгийн газрын зөвлөсний дагуу Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, 6 гишүүн, 3 орлогч гишүүнийг томилно. Эдгээр гишүүд болон орлогч гишүүдийг шүүгчид, Захиргааны албан тушаалтнууд, хууль зүйн профессоруудаас сонгоно. Бусад 3 гишүүн, 2 орлогч гишүүнийг Үндсний зөвлөл (Парламентын доод танхим)-ийн санал болгосноор, 3 гишүүн, 1 орлогч гишүүнийг Холбооны зөвлөл (Парламентын дээд танхим)-ийн санал болгосноор Холбооны Ерөнхийлөгч томилно. 3 гишүүн, 2 орлогч гишүүний оршин суух газар нь Холбооны нийслэл Вена хотын гадна байна...</p> <p>147.3.Үндсэн хуулийн шүүхийн гишүүд, орлогч гишүүд нь хууль зүй, эсхүл хууль зүй, улс төрийн шинжлэх ухааны сургалт дүүргэх бөгөөд мэргэжлээрээ 10 жил ажилласан байна.</p> <p>147.6...12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гишүүн, эсхүл орлогч гишүүн нь 70 нас хүрсэн бол түүний бүрэн эрхийн хугацаа дууссан гэж үзэ.</p>
оруулалт оруулах тохиолдолд өрийг хөнгөлөх тохиролцоонууд хийгдэж ирсэн бөгөөд зээлдэгч нараас хүлээн авагч орнуудад ядуурлыг бууруулах стратеги, ядуурлын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ, хөрөнгө оруулалт болон ядуурлын хэмжээг үнэлэх, тооцох арга хэрэгсэлтэй байхыг шаардлага болгосон байна. Мөн үеэс Дэлхийн банк (Ерөнхийлөгч Жеймс Вулфенсон)-ны зүгээс хөгжиж буй орнуудад Comprehensive development framework-тай байхыг уриалж эхэлсэн бөгөөд үр дүнд нь 2001 он гэхэд Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг (PRSP) 63 улс баталсан байна. Дээрх Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг нь нийгмийн салбаруудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, орц, гарц, үр дүнгийн матриц зэрэг олон талаар хуучны загварын үндэсний хөгжлийн төлөвлөгөөтэй төстэй байсан ба төлөвлөлтийг “сайн засаглалтай” уялдуулах зорилгоор оролцооны үнэлгээг нэвтрүүлсэн байна. Улс орнууд PRSP-г боловсруулсны дараагаар (Бангладеш, Бенин, Гана, Малави, Того, Уганда, Вьетнам, Замби зэрэг) Мянганы хөгжлийн зорилт болон бусад зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үндэсний төлөвлөгөөтэй болж эхэлсэн байна. Тус үеэс эхлэн “asymmetric information” мэдээллийн тэгш бус байдал (Barr, 1992), “behavioural economics” зан төлөвийн эдийн засаг зэрэг нь (Kahneman, 2011, Thaler and Sunstein, 2009) зах зээлийн өөрийгөө зохицуулах механизмын алдаа дутагдалтай талуудыг ил гаргаж, хөгжлийн төлөвлөлт дахин сэргэх хандлагууд ажиглагдаж ирсэн байна.

2007 онд Дэлхийн банкнаас гаргасан судалгаанд дэлхийн 62 улс орон үндэсний хөгжлийн төлөвлөгөө (National Development Plan)-тэй байсан бол 2016-2017 онд давтан явуулсан судалгаагаар дээрх тоо хоёр дахин буюу 134 улс болж нэмэгдсэн байна.

Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн дахин сэргэлтийн шалтгаан нь юу вэ?

Үндэсний хөгжлийн төлөвлөлтийг улс орнууд дахин сэргээх болсон шалтгааныг судалж үзэхэд дараах байдалтай байна. Нэгдүгээрт, Ядуурлыг бууруулах бичиг баримтыг баталсан хөгжиж буй дийлэнх улс орнууд үндэсний хөгжлийн төлөвлөлттэй болсон байна. Дээр дурдсан 63 улсаас 52 нь “ядуурлыг бууруулах” үндсэн чиглэлээс давсан үндэсний хөгжлийн төлөвлөгөөтэй болсон бол 11 улс нь шинэ загварын/үеийн Ядуурлыг бууруулах бичиг баримттай болсон байна. Гана, Уганда, Бенин болон Того зэрэг улсын Ядуурлыг бууруулах бичиг баримтыг хэрэгжүүлсэн туршлага нь төрийн төлөвлөлтийн чадавхыг нэмэгдүүлж, төлөвлөлт, төлөвлөгөөний ач холбогдлыг мэдрүүлж, ядуурал болон хүний хөгжлийн асуудлыг салбарын асуудал хариуцсан яам дангаараа бус, харин сангийн яамтай хамтран хариуцахын ач холбогдлыг харуулсан байна. Хоёрдугаарт, 2000 оны МХЗ болон 2015 оны ТХЗ зэрэг хөгжлийн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхэд төлөвлөлт, хяналт шинжилгээний механизмууд хэрэгтэй болсон байна.

Хоёр. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГЫГ ҮНДСЭН ХУУЛИАР ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан байгууллагыг Үндсэн хуулиар хуульчилсан улс орнуудаас 13 улс орны зохицуулалтыг байгууллагын харьяалал, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, удирдлага болон гишүүдийг томилдог субъект, удирдлага болон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа зэргээр багцалбал дараах байдалтай байна:

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн институц нь:

- Ерөнхийлөгчийн харьанд: Гана, Уругвай, Намиби;
- Парламентаас шийдвэрлэх: Лесото;
- Хараат бус, бие даасан агентлаг: Филиппин.

Тус байгууллагын удирдлага болон гишүүдийг томилох, сонгох субъект:

- Ерөнхийлөгч томилдог: Гана, Колумб, Уругвай, Йемен, Намиби;
- Орон нутгийн иргэдийн хурлаас сонгодог: Кабо-Вerde.

Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг Үндсэн хуульдаа тусгасан:

- Гана, Колумб, Уругвай, Эквадор, Кабо-Вerde.

Байгууллагын чиг үүргийг нарийвчлан зохицуулсан:

- Гана, Колумб, Уругвай, Эквадор, Йемен.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн институцтай байна гэж заасан:

- Турк, Намиби, Португал, Уганда, Испани.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан улс орнуудын засаглалын хэлбэр

<i>Төрийн удирдлагын хэлбэр</i>	<i>Улсын тоо</i>	<i>Улс орны нэр</i>
Ерөнхийлөгчийн засагтай	6 улс	Гана, Колумби, Турк, Уругвай, Филиппин Эквадор
Хагас Ерөнхийлөгчийн засагтай	5 улс	Кабо-Вerde, Йемен, Намиби, Португал Уганда
Парламентын хаант засагтай	2 улс	Испани, Лесото

**Хүснэгт 2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн институцийн талаарх
Үндсэн хуулийн зүйл, заалт**

Д/д	Улсын нэр	Үндсэн хуулийн заалт
Ерөнхийлөгчийн засаглалтай		
1.	Гана	<p>86 дугаар зүйл. <u>Үндэсний хөгжил, төлөвлөлтийн хороо</u>. 2. Ерөнхийлөгч нь Төрийн зөвлөлтэй зөвлөлдсөнөөр тус хорооны даргыг томилно. Хорооны гишүүд нь Сангийн сайд болон Ерөнхийлөгчийн санал болгосон бусад сайд нар, Засгийн газрын статистикч, Гана улсын банкны захирагч, Бүс нутгийн зохицуулах зөвлөлөөс санал болгосон бүс нутаг бүрийн төлөөллүүд болон Ерөнхийлөгчийн санал болгосон эдийн засаг, нийгэм, хүрээнд буй орчны хөгжил, төлөвлөлтийн асуудлаар мэргэшсэн хүмүүсээс бүрдэнэ. 3. Хороо нь Ерөнхийлөгчийн харьяанд байна.</p> <p>87 дугаар зүйл.</p> <ul style="list-style-type: none"> Хороо нь Ерөнхийлөгчид хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар зөвлөх үүрэгтэй. Хороо нь Ерөнхийлөгч, парламент болон ёрийн санаачилгаар хөгжлийн бодлого, хэтийн төлөвийг тандсан судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт гаргана. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслүүдэд хяналт тавьж, үнэлгээ хийнэ.
2.	Колумб	<p>340 дүгээр зүйл. Тус улс нь <u>Үндэсний төлөвлөлтийн зөвлөлтэй</u> байна. Үндэсний төлөвлөлтийн зөвлөл нь нутаг дэвсгэрийн нэгжүүд болон эдийн засаг, нийгэм, соёл, байгаль экологийн салбаруудын төлөөллүүдээс бүрдсэн бүтэцтэй байна. Тус зөвлөл нь Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэлэлцэн, зөвлөх чиг үүрэгтэй байна. Салбар бүрээс нэр дэвшүүлсэн Үндэсний төлөвлөлтийн зөвлөлийн гишүүдийг Ерөнхийлөгч томилно. Гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 8 жил байх бөгөөд хуульд зааснаар 4 жилд 1 удаа гишүүдийг хэсэгчлэн шинээр томилж байна. Хуульд зааснаар орон нутгийн захиргааны нэгжүүд нь төлөвлөлтийн зөвлөлүүдтэй байна. Үндэсний төлөвлөлтийн зөвлөл болон орон нутаг дахь төлөвлөлтийн зөвлөлүүд нь Үндэсний төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлнэ.</p>
3.	Турк	<p>166 дугаар зүйл. Хөгжлийн төлөвлөлт, хэрэгжүүлэх зарчим, үйл ажиллагааг Турк улсын Үндэсний Ассамблей батална. Хөгжлийн төлөвлөлтийн хэрэгжилт, хяналтыг хуулиар тогтооно. Эдийн засаг болон нийгмийн бодлогыг тодорхойлох, Ерөнхийлөгчид зөвлөх үүрэг бүхий <u>Эдийн засаг болон Нийгмийн Зөвлөлийн</u> бүтэц, чиг үүргийг хуулиар тогтооно.</p>
4.	Уругвай	<p>230 дугаар зүйл. <u>Төлөвлөлт болон төсвийн алба</u> нь Ерөнхийлөгчийн шууд харьяан дор үйл ажиллагаагаа явуулна. Тус албаны даргыг Ерөнхийлөгч томилно. Алба нь хөгжлийн бодлоготой холбоо бүхий салбарын сайд нараас бүрдсэн хороотой байна. Төлөвлөлт болон төсвийн алба нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ яамд болон төрийн бусад байгууллагатай шууд харьцана. Төлөвлөлт болон төсвийн алба нь ажилчид, төрийн бусад байгууллага болон хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн Хэсгийн хороодтой байна. Тус алба нь хөгжлийн төлөвлөгөө болон хөтөлбөрүүдийг боловсруулж, хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.</p>

5.	Филиппин	12 дугаар хэсэг. 9 дүгээр зүйл. Эдийн засаг болон үндэсний баялаг Конгресс нь Ерөнхийлөгчөөр удирдуулсан эдийн засаг, төлөвлөлтийн бие даасан агентлагийг байгуулж болно. Тус агентлаг нь төрийн бусад агентлагууд, орон нутгийн засаг захирагааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр Үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Конгресс өөрөөр заагаагүй бол Үндэсний эдийн засаг, хөгжлийн газар нь засгийн газрын бие даасан агентлаг байж, чиг үүргээ хэрэгжүүлнэ.
6.	Эквадор	279 дүгээр зүйл. <u>Үндэсний төлөвлөлтийн зөвлөл</u> нь шат шатны нутгийн захирагааны нэгжийн төлөөллүүд, ард иргэдийн төлөөллөөс бүрдэнэ. Тус зөвлөл нь өөрийн ажлын албатай байна. Тус зөвлөл нь Үндэсний хөгжлийн бодлогыг батлах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн системийг удирдах, чиглүүлэх чиг үүрэгтэй. Зөвлөлийг Ерөнхийлөгч даргална.

Хагас Ерөнхийлөгчийн засаглалтай

7.	Кабо-Верде	2 дугаар бүлэг. <u>Бус нутгийн асуудал хариуцсан зөвлөл</u> 281 дүгээр зүйл. Бүтэц1.Зөвлөл нь орон нутгийн иргэдийн хурлаас сонгогдсон арал тус бүрийн 2 төлөөлөгчөөс бүрдэнэ. 2. Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. 282 дугаар зүйл. 1.Зөвлөл нь өөрийн гишүүдийн болон Үндэсний Ассамблей, Ерөнхийлөгч, Засгийн газрын санаачилсан бус нутгийн хөгжилтэй холбоотой бүхий л асуудалд зөвлөх үүрэгтэй байна. 2.Зөвлөл нь Үндэсний хөгжлийн бодлого, Бус нутгийн хөгжлийн бодлого болон орон нутгийн хөгжил, санхүүтэй холбоотой Засгийн газрын төсөл, баримт бичигт зайлшгүй өөрийн саналыг тусгасан байна. 3.Зөвлөлийн эрх мэдэл, чиг үүрэг, дотоод үйл ажиллагааг хуулиар тогтооно.
8.	Йемен	125 дугаар зүйл. <u>Зөвлөлдөх зөвлөл</u> Зөвлөлдөх зөвлөлийг Ерөнхийлөгчийн зарлигаар байгуулна. Зөвлөл нь Үндсэн хуульд заасан эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. 126 дугаар зүйл. Зөвлөл нь (111) гишүүнээс бүрдэнэ. Зөвлөлийн гишүүдийг Ерөнхийлөгч шууд томилно. Гишүүдийг эдийн засаг, нийгмийн салбарын мэдлэг, туршлага бүхий хүмүүсээс бүрдүүлнэ. Зөвлөлдөх зөвлөлд Төлөөлөгчдийн танхимын гишүүд болон орон нутгийн зөвлөлийн гишүүдийг орохыг хориглоно. Зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүрэг, хариуцлага, эрх мэдлийн хүрээ, гишүүдийн ажиллах нэхцэл зэргийг хуулиар тогтооно. Зөвлөл нь өөрийн дотоод журмыг боловсруулж, мөрдөж ажиллана.
9.	Намиби	129 дүгээр зүйл. <u>Үндэсний төлөвлөлтийн хороо</u> 1.Тус хороо нь Ерөнхийлөгчийн харьяанд байна. Төлөвлөлтийн хороо нь үндэсний хөгжлийн бодлогын чиглэл болон тэргүүлэх асуудлыг төлөвлөнэ. 2.Хороог Ерөнхийлөгчийн томилгоогоор Ерөнхий захирал тэргүүлнэ. Ерөнхий захирал нь эдийн засгийн төлөвлөлтэй холбоотой бүхий л асуудалд Ерөнхийлөгчийн ерөнхий зөвлөх байна. 3.Үндэсний төлөвлөлтийн хорооны гишүүд, эрх мэдэл, чиг үүрэг болон ажлын албыг Парламентын тухай хуулиар зохицуулна.
10.	Португал	92 дугаар зүйл. <u>Эдийн засаг, нийгмийн зөвлөл</u> Зөвлөл нь эдийн засаг, нийгмийн бодлогыг хэлэлцэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлт болон хэрэгжүүлэх үйл явцыг тодорхойлох Үндсэн үүрэг бүхий байгууллага болно. Хуульд заасан бусад үүргийг мэн хэрэгжүүлнэ. 2.Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн нь хуульд заасны дагуу Засгийн газар болон төрийн бусад байгууллагын төлөөллөөс бүрдэнэ. 3.Зөвлөлийн бүрэн эрх, чиг үүргийг хуулиар тогтооно.

11.	Уганда	125 дугаар зүйл. Тус улс нь <u>Үндэсний төлөвлөлтийн газартай</u> байна. Үндэсний төлөвлөлтийн газрын бүтэц, чиг үүргийг парламентаас тогтооно.
Парламентын хаант засаглалтай		
12.	Испани	131 дүгээр хэсэг. 2. Засгийн газар нь Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас гаргасан урьдчилсан тооцон дээр үндэслэн төлөвлөлтийн хөтөлбөрийн төслийг боловсруулна. Төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэх зөвлөлийг байгуулж ажиллана. Зөвлөлийн гишүүнчлэл болон чиг үүргийг хуулиар тогтооно.
13.	Лесото	105 дугаар зүйл <u>Үндэсний зөвлөх төлөвлөлтийн хороо</u> . Хороо нь нийт 18 гишүүнээс бүрдэнэ. Хороо нь тухайн салбарын сайд нарт хөгжлийн бодлогын талаар зөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Үндэсний зөвлөх төлөвлөлтийн хорооны даргын сонгууль, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа, хорооны чиг үүргийг парламентаас тогтооно.

Хүснэгт 3. Зарим орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн удирдлагын тогтолцооны зарим байгууллагуудын үндсэн чиг үүрэг

Улсын нэр	Байгууллагын нэр	Тодорхойлох	Төлөвлөх/ Болоесруулах	Хяналт тавих/ Үнэлгээ хийх	Тайлбар
1.Латви улс	Тогтвортой хөгжлийн байнгын хороо (Парламент)			✓	Нийгмийн хамтрагчдын үйл ажиллагаа ба ТББ зэрэг нийгмийн оролцоотой хяналтыг хэрэгжүүлнэ
	Хөгжлийн үндэсний зөвлөл (Засгийн газар)			✓	
	Тогтвортой хөгжлийн институт “Латви-2030”			✓	
	Сайд нарын танхим, Яамд, Бус нутаг болон нутгийн өөрөө удирдах байгууллага		✓		
2.Малайз лс	Үндэсний төлөвлөлтийн зөвлөл	✓	✓	✓	Шийдвэр гаргах түвшинд
	Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн хороо	✓	✓	✓	
	Эдийн засгийн төлөвлөлтийн товчоо	✓	✓	✓	Судалгаа хийх, бэлтгэл ажлыг хангах, удирдан чиглүүлнэ
3.Солонгос улс	Ерөнхийлөгчийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн комисс		✓	✓	
4.Турк	Хөгжлийн яам				

Хүснэгт 4. Зарим орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцооны зарим байгууллагуудын үндсэн чиг үүрэг, харьялах субъект, бүтэц зохион байгуулалт

Байгууллагын нэр	Үндсэн чиг үүрэг	Харьялах субъект	Бүтэц, зохион байгуулалт
1.ЛАТВИ УЛС			
1) Тогтвортой хөгжлийн хороо (Sustainable Development Commission)	<ul style="list-style-type: none"> - Тус улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 2009.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Сеймээс “Латви-2030” тогтвортой хөгжлийн стратегийг 2010.06.10-ны өдөр баталсан. - 2014 онд Латвийн Сейм (Парламент) нь үндэсний стратегийн төлөвлөлтийн хүрээг тогтоох парламентын хяналт бүхий Тогтвортой хөгжлийн хороог байгуулсан. - Тус Хороо нь “Латви-2030” тогтвортой хөгжлийн стратеги, Үндэсний хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Засгийн газрын бодлогын дунд, урт хугацааны үр нөлөө, Засгийн газрын төсвийн бодлогын тогтвортой байдлыг хангахад хяналт тавина. - Сейм 2 жил тутамд нэг удаа “Латвия-2030” тогтвортой хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх Сайд нарын танхимын илтгэлийг хэлэлцүүлнэ. Мэдээллийн үндсэн дээр Сейм стратегийн зорилтуудад зарим өөрчлөлт оруулах талаар шийдвэрийг гаргаж болно. 	Сейм (Парламент)	Хорооны бүрэлдэхүүнд 17 Сеймийн гишүүн багтана.



2) Хөгжлийн үндэсний зөвлөл (National Development Council)	<ul style="list-style-type: none"> - Энэхүү хамтарсан зөвлөх эрх бүхий байгууллага нь улс орны урт хугацааны хөгжлийн төлөвлөлт, үнэлгээг хийхдээ төсөв, бодлогын төлөвлөлтийг зохицуулах бүтцийн шинэчлэлийг санаачилж, түүнчлэн үндэсний болон орон нутгийн төрийн бодлогын уялдаа холбоог хангана. - Төлөвлөлт хэрэгжилтэд хяналт тавина. 	Ерөнхий сайд	<p>Ерөнхий сайд даргална. Зөвлөлийн гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Эко-эдийн засгийн сайд, - Байгаль орчныг хамгаалах болон Бүс нутгийн хөгжлийн сайд, - Сангиин сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, - ажил олгогч, үйлдвэрчний эвлэл, - Латви Улсын орон нутгийн засаг захиргааны холбооны дарга, - Латви Улсын Ерөнхийлөгчийн төлөөлөгч
3) Тогтвортой хөгжлийн институт “Латви-2030” (Sustainable Development Institute “Latvia 2030”)	<p>Үндсэн зорилт: Сайд нарын танхим, Сеймд танилцуулах улс орны тогтвортой хөгжил, “Латвия-2030” стратегийн хөгжлийн хөтөлбөрийн талаарх илтгэлийг бэлтгэх явдал юм. Түүнээс гадна тус институт нь улс төрийн хариуцлагатай шийдвэр гаргахад шаардлагатай төрийн стратегийн чухал асуудлуудыг судалж, үндэслэлтэй зөвлөмж гаргах судалгааны найдвартай базыг бий болгох, төрийн мөнгөний бодлого нь батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө, тогтвортой хөгжлийн зарчимд нийцэж буй эсэхэд үнэлгээ хийх, нийтийн удирдлагын байгууллагууд, иргэний нийгэм, эрдэмтэд, судлаачдын хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг зорилготой.</p>		

2.МАЛАЙЗ УЛС			
1) Үндэсний төлөвлөлтийн зөвлөл (National Planning Council)	Хөгжлийн төлөвлөлтийн асуудал эрхэлсэн дээд түвшний байгууллага	Ерөнхий сайд	Зөвлөлийн гишүүд: <ul style="list-style-type: none"> - сангийн сайд - олон улсын худалдаа, аж үйлдвэрийн сайд - дотоод худалдааны сайд - бизнесийн хөгжлийн сайд - бараа таваар, хөдөө аж ахуйн сайд
2) Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн хороо (National Development Planning Committee)	1)Хөгжлийн төлөвлөлтийн бодлогыг тодорхойлох, нарийвчлан хэлэлцэх дээд байгууллага 2)Хөгжлийн төлөвлөгөөг <ul style="list-style-type: none"> - боловсруулах - хэрэгжүүлэх - хянаж үнэлэх - тодруулах - хэрэгжилтэнд хяналт тавих - нөөцийг хуваарилах талаар зөвлөмж гаргана. 	Ерөнхий сайд	<ul style="list-style-type: none"> - Хороо нь Засгийн газрын ахлах албан тушаалтуудаас бүрдэх ба Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга тэргүүлнэ <p>Хорооны гишүүд нь эдийн засгийн хөгжлийн чиглэлийн бүх яамдын сайд нар, Төв банкны ерөнхийлөгч байна.</p>
3) Эдийн засгийн төлөвлөлтийн товчоо (Economic Planning Unit)	<p>Чиг үүрэг:</p> <p>1) Төлөвлөлт <ul style="list-style-type: none"> - нийгэм-эдийн засгийн судалгаа, анализ - хөгжлийн бодлого - макро эдийн засгийн загварчлал, тогтолцоо - хөгжлийн төлөвлөгөө </p> <p>2) Нөөцийн хуваарилалт <ul style="list-style-type: none"> - төсвийн удирдлага, төслийн үнэлгээ </p> <p>3) Хяналт-шинжилгээ <ul style="list-style-type: none"> - үндэсний хөтөлбөрүүдийн хяналт-шинжилгээ - санал, санаачлагын хяналт-үнэлгээ - төслийн хяналт-үнэлгээ </p> <p>Үйл ажиллагаа:</p> <ul style="list-style-type: none"> - Нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, стратегийг томьёолох - Дунд болон урт хугацааны төлөвлөгөөг бэлтгэх - Хөгжлийн хөтөлбөр, төслийдийн төсвийг бэлтгэх - Хөгжлийн хөтөлбөр, төслийдийн хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийх - Засгийн газарт эдийн засгийн асуудлаар зөвлөлгөө өгөх 	Ерөнхий сайд	<ul style="list-style-type: none"> - Ерөнхий сайдын өмнө ажлаа шууд хариуцан тайлагнана - Үдирдлагын бүтэц: ерөнхий захирагч, түүний З орлогч - Удирдлагад нь Малайзын хөгжлийн хүрээлэн (Malaysian Development Institute) ажиллана - Үйл ажиллагаанд нь Ерөнхий сайдын дэргэдэх төв агентлаг болох Хэрэгжилт, зохицуулалтын товчоо (Implementation and Coordination Unit), Малайзын засаг захирагаа, шинэчлэлийн товчоо (Malaysian Administrative and Modernization Planning Unit) дэмжиж ажиллана.

	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай эдийн засгийн судалгааны ажлыг санаачлах, гүйцэтгэх - Хувьчлалын хөтөлбөрүүдийг төвлөвлөх, зохицуулах, хэрэгжилтэнд нь үнэлгээ хийх - Олон талт хөгжлийн хөтөлбөр дээ Малайзын оролцоог хангах 		
3. СОЛОНГОС УЛС			
1) Ерөнхийлөгчийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн комисс (Presidential Commission on Sustainable Development)	<p>Чиг үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> - тогтвортой хөгжлийн зорилго, бодлого стратегийг боловсруулах - Ерөнхийлөгчийг бодлогын зөвлөгөөгөөр хангах, санамж бичгүүдийг боловсруулах - Тогтвортой хөгжилтэй холбоотой нийгмийн зөрчил маргааныг шийдвэрлэх, хяналтын менежментийн тогтолцоог бий болгох <p>Үйл ажиллагаа:</p> <ul style="list-style-type: none"> - салбарын асуудлуудтай холбоотой бодлого боловсруулж Ерөнхийлөгчид өргөн барих - чухал ач холбогдолтой үндэстний урт, дунд хугацааны төлөвлөгөөг улсын бодлогын тогтвортой байдлын үүднээс нь урьдчилан нягтлаж үзэх - зөрчлийн менежмент, урьдчилан сэргийлэх тогтолцоог хөгжүүлэх, цаг үеийн олон нийтийн элдэв зөрчилдөөний үед Ерөнхийлөгчид нийгмийн эв зэййтгэх хэрхэн хангах тухайд зөвлөх. <p>Хяналт, үнэлгээ-мониторинг: Улсын тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг гурван түвшний схемээр хянаж үнэлгээ хийнэ:</p>	<p>Ерөнхийлөгч</p>	<p>2000 онд Ерөнхийлөгчийн зарлигаар байгуулагдсан. Удирдах хороо - 35 гишүүнтэй. Мэргэжлийн хороод, судалгааны багуудын бодлогын саналыг нягтлан үзэх, Ерөнхийлөгчид зөвлөх үүрэгтэй.</p> <p>Зөрчлийг зохицуулах тусгай хороо - 50 гишүүнтэй: Удирдах Хорооноос томилогдсон болон муж улсууд, ТББ-уудаас санал боловсон бусад гишүүд багтана. Зөрчлийн менежмент, урьдчилан сэргийлэх тогтолцоог боловсруулан хөгжүүлж, Удирдах хорооноос цаг үеийн олон нийтийн зөрчлийн асуудлаар өгсөн даалгаврын дагуу Ерөнхийлөгчид зөвлнө.</p> <p>Мэргэжлийн 4 хороо (МХ) - Удирдах хорооны тодорхой хувь болон холбогдох мэргэжилтнүүдээс бүрдэнэ. Судалгааны багуудыг ажиллуулна. Салбар судлагдахуун тус бүр дээр бодлогын санал боловсруулна.</p> <ul style="list-style-type: none"> - Нийгэм, эрүүл мэндийн МХ; - Байгаль орчин, дэд бүтцийн МХ; - Эрчим хүч, үйлдвэрлэлийн МХ; - Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийн МХ. <p>Төлөвлөлтийн менежментийн газар - удирдах хорооны гишүүд байна.</p>

	<p>1/ сайн дурын үндсэн дээр;</p> <p>2/ Засгийн газраас Ерөнхий сайдын дэргэдэх Засгийн газрын бодлого зохицуулалтын газартай зөвлөлдөн тодорхой төлөвлөгөөний дагуу 2 дугаар түвшний буюу төв Засгийн газрын түвшний мониторингийг хэрэгжүүлнэ.</p> <p>3/ Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг түүний индикаторын дагуу хянаж үнэлгээ хийнэ.</p>		
--	--	--	--

2.ТУРК УЛС

1) Хөгжлийн яам	<p>Үндсэн хууль болон бусад хуулиар хулээсэн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - эдийн засаг, нийгэм, хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлоход Засгийн газарт мэргэжлийн зөвлөгөө өгөх - бусад яамдын бодлого, үйл ажиллагааны хамтын ажиллагаа, уялдааг зохицуулах - хөгжлийн төлөвлөгөө, дунд болон богино хугацааны хетөлбөр, хөрөнгө оруулалтын хетөлбөр боловсруулах - макро түвшний салбарын, бусийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах - улсын хөрөнгө оруулалтад сууринсан стратегийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох - бодлогын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх; - төрийн байгууллагын стратегийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих - олон талт хамтын ажиллагааны хетөлбөр, төслүүд хэрэгжүүлэх - хөгжлийн чиг хандлага, шилжилтийг чиглүүлсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх 	<p>Ерөнхий сайд, Шадар сайд</p>	<p>Төлөвлөлтийн дээд шатны удирдлага:</p> <ul style="list-style-type: none"> - Төлөвлөлтийн дээд зөвлөл (Higher Planning Council) <ul style="list-style-type: none"> ○ Дарга: Ерөнхий сайд ○ Гишүүд: хөгжлийн, сангийн, эдийн засгийн болон бусад сайд нар (тодорхой) - Мөнгө, зээлийн зохицуулалтын зөвлөл (Money-Credit Coordination Council) <ul style="list-style-type: none"> ○ Дарга: Шадар сайд ○ Гишүүд: хөгжлийн, сангийн, эдийн засгийн болон бусад сайд нар (тодорхой) - Эдийн засаг, нийгмийн зөвлөл (Economic and Social Council) <ul style="list-style-type: none"> ○ Төлөөлөгчид: төрийн байгууллагууд, ажил олгогчид, ажилчид, танхим, холбоод. <p>Хөгжлийн яамны бүтэц</p> <ul style="list-style-type: none"> - Макро эдийн засгийн нэгж - Орон нутгийн хөгжлийн бодлого зохицуулалт, удирдлагын 4 газар - 81 мужийг хамарсан Бусийн хөгжлийн 26 агентлаг
------------------------	---	-------------------------------------	--

	<ul style="list-style-type: none"> - бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагууд, агентлагуудын хамтын ўйл ажиллагааг хангах - хөгжлийн асуудлаарх судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах <p>Хяналт, шинжилгээ-үнэлгээ:</p> <ul style="list-style-type: none"> - бодлогын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ-үнэлгээний ажлыг удирдан зохион байгуулна - мөн бодлого боловсруулах үе шатанд ч хийнэ. 	<ul style="list-style-type: none"> - Салбар төлөвлөлтийг хариуцсан газар <ul style="list-style-type: none"> ○ Нийгмийн хөгжлийн салбарын удирдах газар ○ Эдийн засгийн салбарын удирдах газар
--	---	---

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- The 'New' national development planning and global development goals: Processes and partnerships, IAdmos O.Chimhowu^aDavidHulme^bLauchlan T.Munro^c <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0305750X19300713>
- <http://www.nationalplanning.org>
- https://www.unpei.org/sites/default/files/publications/Chapter-4_0.pdf
- <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0305750X19300713?via%3Dihub>
- <https://www.constituteproject.org/search?lang=en>



НАМЫН БҮРТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГАД ГИШҮҮНЧЛЭЛИЙН ДООД ХЯЗГААРЫГ ТУСГАСАН БАЙДАЛ: ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Мэдээлэл, лавлагаа)

Д.Халиун

АГУУЛГА

- Европын зөвлөлийн Венецийн комиссын Улс төрийн намуудын талаарх тайлан;
- Гадаадын зарим орны Үндсэн хуульд холбогдох асуудлыг тусгасан байдал;
- Европын холбооны зарим гишүүн орнуудын улс төрийн намын тухай хууль тогтоомжид холбогдох асуудлыг тусгасан байдал.

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Battulgaas 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн Arvan ec¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий тавин мянга нэгээс доошгүй тооны иргэн нэгдэж байгуулах бөгөөд гишүүний бүртгэл, өөрчлөлтийг сонгуулийн төв байгууллага хөтөлнө.” гэж нэмэхээр тусгасан. Үүнтэй холбогдуулан дэлхийн улс орнуудын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжид дээр дурдсан асуудлыг хэрхэн зохицуулсан талаар судалгаанд авч үзсэн болно.

*Европын зөвлөлийн Венецийн комиссын Улс төрийн намуудын талаарх тайлан*²⁵⁵ -д Азербайжан, Босни Херцеговин, Канад, Хорват, Чех, Эстони, Гүрж, ХБНГУ, Грек, Киргиз, Латви, Литва, Молдова, ОХУ (500)²⁵⁶, Словак, Турк зэрэг улсад²⁵⁷ улс төрийн намын гишүүнчлэлийн доод хэмжээг 50, 500, 5000 зэрээр

²⁵⁵EUROPEAN COMMISSION FOR DEMOCRACY THROUGH LAW (VENICE COMMISSION) COMPILATION OF VENICE COMMISSION OPINIONS AND REPORTS CONCERNING POLITICAL PARTIES, 2016 [https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-PI\(2016\)003-e](https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-PI(2016)003-e)

²⁵⁶Федеральным законом «О политических партиях» (пункт 2 статьи 3) определены требования, предъявляемые к политической партии для ее государственной регистрации, в том числе численность, которая с 4 апреля 2012 года должна составлять – не менее 500 членов политической партии с учетом требований, которые предусмотрены пунктом 6 статьи 23 Федерального закона «О политических партиях». Уставом политической партии могут быть установлены требования к минимальной численности членов политической партии в ее региональных отделениях. Политическая партия должна иметь региональные отделения не менее чем в половине субъектов Российской Федерации, при этом в субъекте Российской Федерации может быть создано только одно региональное отделение данной политической партии. <https://minjust.ru/ru/node/202387>

²⁵⁷B. Minimal membership requirement

... However, some pre- conditions for registration of political parties existing in several Council of Europe Member States requiring a certain territorial representation and a minimal number of members for their registration could be problematic in the light of the principle of free association in political parties."

"It is true that minimal membership requirements do exist in a number of States (Azerbaijan, Bosnia and Herzegovina, Canada, Croatia, Czech Republic, Estonia, Georgia, Germany, Greece, Kyrgyzstan, Latvia, Lithuania, Moldova, Russian Federation, Slovakia and Turkey). At first glance the sequence of thresholds of not fewer than 50, 500 and 5000 individuals may appear as good as any other. However, closer inspection reveals, that these thresholds will be obstacles which would be very difficult or simply impossible to overcome.

Ordinary citizens, who want to found a new party – maybe at first for political work in a municipality and later development into a nationwide active political party –, cannot be expected to overcome these obstacles without active support of an existing organisation with ample administrative resources. If the goal is to found a party for political on the level of a municipality there may not even be 5000 inhabitants in the municipality, in which the future political party is supposed to be active. The thresholds of 50 and 500 should also be related to the number of individuals, which are necessary to found an association or similar legal person; founding a political party should not be more difficult than founding an ordinary association or company.

тогтоосон байдаг гэж дурдсан бөгөөд энэ асуудлаарх Комиссын байр суурийг илэрхийлсэн байна. Тухайлбал, Азербайжаны холбогдох хууль тогтоомжид намын гишүүнчлэлийн доод хэмжээг 1000-аас 5000 болгон өөрчлөлт оруулах асуудлаар: 8 сая гаруй хүн амтай улсад 1000 гэсэн тоо нь үндэслэлтэй юм. Харин хязгаарыг 5000 гэж нэмэх нь Европын хүний эрхийн конвенцын 11-р зүйлд заасан иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг ханган хэрэгжүүлэхэд саад учруулах, хязгаарлаж болзошгүй, мөн шинээр нам байгуулахад дээрх босго нь өндөр байна гэж үзжээ.

Гадаадын зарим улс орнуудын Үндсэн хуулиас шүүн үзэхэд улс төрийн нам байгуулахтай холбоотой гишүүнчлэлийн тоо хэмжээ, доод хязгаартай холбоотой асуудлыг тусгасан цөөн улс байна. Тэдгээрээс дурдвал:

In this context the question could be asked, whether and to which extent there will be public support for a newly founded political party. But to find an answer to this question should not be a matter for a court of law in registration proceedings. Instead it should be left to the electorate to decide, whether public support is forthcoming.

Therefore, thresholds of not fewer than 50, 500 and 5000 individuals are questionable. Probably they are far too high and should be reconsidered.

In some of its previous opinions the Venice Commission has expressed doubts as to the necessity to establish minimal membership for parties. In its opinion on the Law on political parties in Moldova the Commission considers that: "A State may be entitled to insist on certain minimum standards of size, organization and democratic standards as a condition of registering a party but it seems [...] doubtful that it can be regarded as necessary in a democratic society to prescribe the precise manner in which a political party is to be founded once the party's programme does not represent a danger to the free and democratic order or to the rights of individuals."

CDL-AD(2008)034 Opinion on the Draft Amendments to the Law on Political Parties of Bulgaria, adopted by the Venice Commission at its 77th Plenary Session (Venice, 12-13 December 2008), §14-19.

"In Western states there are often multiplicities of small political parties. They may be too small to be registered where registration requirements are in place, but that does not make their existence unlawful or prevent them from continuing to strive to organize and grow. It seems [...], for example, indefensible to require a party to dissolve itself when its membership falls below a certain threshold. [...] this is contrary to the right of freedom of association and cannot be regarded as necessary in a democratic society. Nor would such a forced dissolution appear to be consistent with the provisions of the European Convention on Human Rights and the Venice Commission's guidelines."

CDL-AD(2002)028 Opinion on the draft law on political parties and Socio-Political organisations of the Republic of Moldova, endorsed by the Venice Commission at its 52nd Plenary Session (Venice, 18-19 October 2002), §28.

"[Concerning a legislative amendment which proposes to increase the minimum membership of a political party from 1,000 to 5,000] In its previous opinion the Venice Commission expressed the view that a figure of 1,000 in a country of a population of eight million was a reasonable number. The new threshold seems to be formidably high and put a burden on citizens trying to exercise their rights under Article 11 of the ECHR which is potentially restrictive and as such would be disproportionate and not necessary in a democratic society. It seems a large threshold particularly for a new party."

CDL-AD(2011)046 Opinion on the Draft Law on Amendments to the Law on political parties of the Republic of Azerbaijan, adopted by the Venice Commission at its 89th Plenary Session (Venice, 16-17 December 2011), §18.

Замби Улсын Үндсэн хуулийн 1991 (2016)-ийн 21-р зүйлд:²⁵⁸

2. Nothing contained in or done under the authority of any law shall be held to be inconsistent with or in contravention of this Article to the extent that it is shown that the law in question makes provision—

d for the registration of political parties or trade unions in a register established by or under a law and for imposing reasonable conditions relating to the procedure for entry on such register including conditions as to the minimum number of persons necessary to constitute a trade union qualified for registration;

and except so far as that provision or, the thing done under the authority thereof as the case may be, is shown not to be reasonably justifiable in a democratic society.

Шинэ Зеланд Улсын Үндсэн хуулийн 1852 (2014)-ийн 63-р зүйлд:²⁵⁹

Улс төрийн намын бүртгүүлэхэд:

vii нам нь доод тал нь 500 гишүүнээр сонгогдох боломжтой, татвар төлөгч гишүүдтэй болохыг нотлох баримт болох Сонгуулийн хорооноос баталсан маягтыг хасаргасан байх;

Эквадор Улсын Үндсэн хуулийн 2008 (2015)-ийн 109-р зүйлд:²⁶⁰

Гишүүдийн бүртгэлд өнгөрсөн сонгуульд бүртгүүлсэн сонгогчдын нэг аравны таван хувь (1.5%)-иас бага гишүүдтэй байж болохгүй.

Европын Холбооны зарим гишүүн орнуудын Улс төрийн намын тухай хууль тогтоомжид намыг бүртгүүлэхэд гишүүнчлэлийн доод хязгаартай холбоотой асуудлыг хэрхэн зохицуулсныг доорх Хүснэгтээс үзнэ үү.

²⁵⁸Zambia 1991 (rev. 2016) PART III > Article 21

Protection of Freedom of Assembly and Association

2. Nothing contained in or done under the authority of any law shall be held to be inconsistent with or in contravention of this Article to the extent that it is shown that the law in question makes provision—
 a that is reasonably required in the interests of defence, public safety, public order, public morality or public health;
 b that is reasonably required for the purpose of protecting the rights or freedoms of other persons;
 c that imposes restrictions upon public officers; or
 d for the registration of political parties or trade unions in a register established by or under a law and for imposing reasonable conditions relating to the procedure for entry on such register including conditions as to the minimum number of persons necessary to constitute a trade union qualified for registration;
 and except so far as that provision or, the thing done under the authority thereof as the case may be, is shown not to be reasonably justifiable in a democratic society.

²⁵⁹New Zealand 1852 (rev. 2014) Electoral Act 1993 > Part 4 > Subpart 1 > 63 > 2

2. An application for the registration of an eligible political party— c must—
 vi be accompanied by evidence, in a form approved by the Electoral Commission, that the party has at least 500 current financial members who are eligible to enrol as electors; and
 vii be accompanied by a declaration, made by the secretary of the party in the manner provided by section 9 of the Oaths and Declarations Act 1957 that the party has at least 500 current financial members who are eligible to enrol as electors;

²⁶⁰Ecuador 2008 (rev. 2015) Article 109

Political parties shall be national in nature, shall be governed by their principles and bylaws, shall propose a government platform and shall keep a record of their members. Political movements may pertain to any level of government or the district of Ecuadorians living abroad. The law shall set the requirements and conditions for the democratic organization, permanence and actions of political movements, as well as incentives for them to forge alliances.

Political parties must submit their statement of ideological principles, government platform setting forth the basic actions they propose to carry out, bylaws, symbols, emblems, logos, list of governing board members. Parties must have a national structure, which shall cover at least 50% of the country's provinces, two of which must pertain to the three provinces with the largest population. The registry of members cannot have a number accounting for less than one point five percent (1.5%) of the persons on the voter registration list used in the last election.

Political movements must submit a statement of principles, government platform, symbols, acronyms, emblems, logos and registry of members or followers, with a number accounting for no less than one point five percent (1.5%) of the voter registration list used in the last election.

Хүснэгт 1. Европын Холбооны зарим гишүүн орнуудын Улс төрийн намын тухай хууль тоогтоомжид улс төрийн намыг бүртгэхэд гишүүнчлэлийн доод хязгаарыг тоогтоосон байдал²⁶¹

№/№	Улсын нэр	Намыг бүртгүүлэх бичиг баримтын жагсаалтад гишүүнчлэлийн доод хязгаартай холбоотой зохицуулалт байгаа эсэх	Гарын үсэг/гишүүн
1	Бельги	-	-
2	Болгар (2009)	2500 намын гишүүний жагсаалт	50 иргэн (500 үүсгэн байгуулагч гишүүн)
3	Чех	-	1000 иргэн (өргөдөл)
4	Дани	-	өмнөх сонгуульд санал өгсөн иргэдийн 1/175-тай тэнцэх
5	Эстони (2010)	-	-
6	Испани (2002)	-	-
7	Франц	-	-
8	Итали (2005)	-	Гарын үсэг (тоо-дүүргээрээ ялгаатай)
9	Кипр (2011)	-	-
10	Латви (2006)	-	200 үүсгэн байгуулагч гишүүн (насанд хүрсэн)
11	Литва (2004)	1000 үүсгэн байгуулагч гишүүн	1000 үүсгэн байгуулагч гишүүн (насанд хүрсэн, Литва Улсын иргэн)
12	Люксембург (2008)	-	-
13	Мальта (2009)	-	-
14	Нидерланд (2011)	-	-
15	Австри	-	-
16	Польш (2008)	-	1000 үүсгэн байгуулагч гишүүн (насанд хүрсэн)
17	Португал (2003)	-	7500 бүртгэлтэй сонгогч
18	Румын (2003)	-	25 000 үүсгэн байгуулагч гишүүн (18-аас доoshгүй тойрог)
19	Словак (2005)	-	-
20	Швед (2005)	-	1500 сонгогчийн гарын үсэг
21	Их Британи (1998)	-	-

²⁶¹Criteria, conditions, and procedures for establishing a political party in the Member States of the EU, Policy Department C: Citizens' Rights and Constitutional Affairs European Parliament, 2012 [http://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2012/462512/IPOL-AFCO_ET\(2012\)462512_EN.pdf](http://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2012/462512/IPOL-AFCO_ET(2012)462512_EN.pdf)

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Criteria, conditions, and procedures for establishing a political party in the Member States of the EU, Policy Department C: Citizens' Rights and Constitutional Affairs European Parliament, 2012 [http://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2012/462512/IPOL-AFCO_ET\(2012\)462512_EN.pdf](http://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2012/462512/IPOL-AFCO_ET(2012)462512_EN.pdf)
- European Commission for Democracy Through Law (Venice Commission) Compilation of Venice Commission opinions and reports concerning political parties, 2016
- [https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-PI\(2016\)003-e](https://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-PI(2016)003-e)
- [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD\(2010\)024-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD(2010)024-e) (guidelines)
- <http://aceproject.org/ace-en/topics/pc/pca/pca01/pca01b>
- Үндсэн хуулиуд, <https://www.constituteproject.org>



ИХ БРИТАНИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА

Г.Билгээ, Р.Нургул, Ц.Элбээзаяа

ИХ БРИТАНИЙН ЗАСГИЙН ГАЗАР²⁶²

Засгийн газрын кабинет нь сонгуульд ялалт байгуулсан намын гишүүдээс бүрдэх ба Парламентын доод танхимд үйл ажиллагаагаа тайлагнана.

Кабинетийн дотоод бүтцийн хувьд Ерөнхий сайд болон бусад гишүүдийг салгаж ойлгоно. Ерөнхий сайд Засгийн газрын үйл ажиллагааг удирдан, Кабинетийн бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, сайд нарыг сонгох, цаашлаад шаардлагатай тохиолдолд Кабинетийг тараах эрхтэй цорын ганц улс төрийн субъект юм.

Парламентын сонгуулийн дараах үйл явц²⁶³

Хэрэв сонгуулийн дараа эрх барьж байсан нам нь бусад намуудын нийт суудлын тооноос илүү суудал авч парламентад дахин олонхыг (majority) бүрдүүлсэн бол одоогийн Засгийн газар үйл ажиллагаагаа хэвийн явуулна.

Хэрэв өөр нам олонхын суудал авсан бол Ерөнхий сайд, Засгийн газар нэн даруй огцрох ба Хатан хаан нь сонгуульд ялсан намын даргатай Засгийн газар байгуулах талаар зөвшилцөнө.

Хэрэв сонгуульд нэг нам олонхын саналыг авч чадаагүй бол шинэ Ерөнхий сайдыг томилж Засгийн газрыг бүрдүүлэх хүртэл одоогийн Ерөнхий сайд, Засгийн газар хэвээр ажиллана.

Аль нэг нам олонхыг бүрдүүлж чадаагүй тохиолдолд улс төрийн намууд хэн нь Нийтийн танхимын итгэлийг хамгийн сайн хүлээх болон Засгийн газраа бүрдүүлж чадах талаар хэлэлцүүлэг явуулахыг хүсч болно. Энэ тохиолдолд Хатан хаан ямар нэгэн хэлэлцээрт оролцохгүй.

Хэрэв аливаа хэлэлцээрт оролцсон улс төрийн намуудын удирдагчид Төрийн албаны дэмжлэг авах хүсэлтэй бол түүнийг зөвхөн Ерөнхий сайдын зөвшөөрлөөр Засгийн газрын танхимын ажлын алба (Cabinet Secretary with the authorisation of the Prime Minister) зохион байгуулна. Төрийн алба нь зохих журмын дагуу зөвлөгөө өгнө.

Сонгуулийн дараа Засгийн газрын танхим нь итгэл даах чадвартай эсэх талаар эргэлзээтэй байгаа бол Засгийн газрын үйл ажиллагаанд тодорхой хязгаарлалт тавина.

²⁶²Ч.Энхбаатар, С.Зульфикар. Гадаад оруудын төрийн байгуулалт. УБ., 2014 он.

²⁶³The Cabinet Manual (A guide to laws, conventions and rules on the operation of government). Cabinet Office 70 Whitehall London. 1st edition October 2011. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/60641/cabinet-manual.pdf

Засгийн газрын нөхцөл байдал улс төрийн намуудын хэлэлцээрээс хамаарна. Аль нэг нам олонхыг бүрдүүлж чадаагүй тохиолдолд Засгийн газрыг байгуулах үндсэн 3 хэлбэр байдаг:

- нэг намын, цөнхийн засгийн газар
- намуудын албан ёсны хэлэлцээрээр
- эвслийн засгийн газар.

Ерөнхий сайдыг томилох

Ерөнхий сайдыг Хатан хаан томилоходоо дараах шалгуурыг баримтлана.²⁶⁴

Үүнд:

- Ерөнхий сайдад нэр дэвшигч нь Парламентын Доод танхимын гишүүн байх;
- нэр дэвшигчийг Парламентын сонгуульд ялалт байгуулсан намын дарга мөн болохыг намын удирдах зөвлөл албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байх (энэ нь гол шалгуур байна);
- улс төрийн үйл ажиллагаа явуулах нөхцлөөр бүрэн хангагдсан байх.

Хатан хаан өөрийн гол зөвлөхийн хувьд одоогийн Ерөнхий сайдаас дараагийн Ерөнхий сайдад хэнийг нэр дэвшүүлэх, хэн Нийтийн Танхимын итгэлийг хүлээх талаар зөвлөмж авч болно.²⁶⁵

Засгийн газрыг бүрдүүлэх

Ерөнхий сайд нь бүрэн эрхийнхээ дагуу Засгийн газраа бие даан бүрдүүлнэ.²⁶⁶ Засгийн газрыг бүрдүүлэх асуудлаар Хатан хаан нь сонгуульд ялалт байгуулсан намын даргатай зөвшилцнө.

Ерөнхий сайд болон Засгийн газар огцрох

Хэрэв Ерөнхий сайд нь Засгийн газрын нэрийн өмнөөс огцорвол, Хатан хаан Төлөөлөгдийн Танхимын итгэлийг хамгийн ихээр хүлээж чадах хүнийг Ерөнхий сайдаа ажиллахыг урина.²⁶⁷

Хэрэв Ерөнхий сайд өөрийн хүсэлтээр албан үүргээсээ чөлөөлөгддэж байгаа бол нам, эсхүл засгийн эрхийг барьж буй намууд залгамжлагчийг тодорхойлно. Парламентын доод танхим буюу Нийтийн Танхим нь Засгийн газарт итгэл үзүүлээгүй тохиолдолд Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорно.²⁶⁸

²⁶⁴Ч.Энхбаатар, С.Зульфикар. Гадаад орнуудын төрийн байгуулалт. УБ., 2014 он.

²⁶⁵The Cabinet Manual (A guide to laws, conventions and rules on the operation of government). Cabinet Office 70 Whitehall London. 1st edition October 2011. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/60641/cabinet-manual.pdf

²⁶⁶Ч.Энхбаатар, С.Зульфикар. Гадаад орнуудын төрийн байгуулалт. УБ., 2014 он.

²⁶⁷The Cabinet Manual (A guide to laws, conventions and rules on the operation of government). Cabinet Office 70 Whitehall London. 1st edition October 2011. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/60641/cabinet-manual.pdf

²⁶⁸Ч.Энхбаатар, С.Зульфикар. Гадаад орнуудын төрийн байгуулалт. УБ., 2014 он.

Мөн Ерөнхий сайд нь бүрэн эрхийнхээ дагуу Засгийн газрын гишүүдийг албан үүргээс нь чөлөөлнө.²⁶⁹

Хэрэв Засгийн газар нь итгэл үзүүлээгүй бол 14 хоногийн дотор Нийтийн Танхимаас үүрэг гүйцэтгэж байгаа Засгийн газартай ижил бүтэц, бүрэлдэхүүнтэй альтернатив Засгийн газрыг байгуулж болно. Эсхүл үүрэг гүйцэтгэж байгаа Засгийн газар нь Нийтийн Танхимаас дахин итгэл хүлээлгэх талаар ажиллаж болно.

Хэрэв энэ хугацаанд Нийтийн Танхимаас дээрх Засгийн газруудын альд нь ч итгэл хүлээлгэхгүй бол бүх нийтийн сонгууль болно.

Хэрэв Нийтийн танхим нь Ерөнхий сайдад итгэл үзүүлэхгүй, альтернатив Засгийн газарт итгэл үзүүлсэн тохиолдолд Ерөнхий сайд ажлаа өгнө.



²⁶⁹Ч.Энхбаатар, С.Зүльфикар. Гадаад орнуудын төрийн байгуулалт. УБ., 2014 он. –